МОНГОЛ УЛС
ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛЬ

ХУУЛЬ САХИУЛАХУЙ

ОНОЛ, АРГА ЗҮЙН
УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ

2025
№03 (43)

Улаанбаатар хот

UNIVERSITY OF INTERNAL AFFAIRS,
MONGOLIA

LAW ENFORCEMENT

THEORETICAL AND METHODOLOGICAL
QUARTERLY JOURNAL

2025
№03 (44)

Ulaanbaatar

СЭТГҮҮЛИЙН РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

Сэтгүүлийн эрхлэгч:
С.Гантулга Доктор, дэд профессор

Ерөнхий редактор:
Д.Энхтөр Доктор, дэд профессор

Нарийн бичгийн дарга:
Л.Одхүү

Гишүүд:

Ж.Амарсанаа Академич

О.Үржин Шинжлэх ухааны доктор, профессор

Б.Бат-Эрдэнэ Доктор, профессор

Д.Зүмбэрэллхам Доктор, профессор

И Габ Хван Доктор, профессор

Хармаев Юрий Владимирович Доктор, дэд профессор

Б.Энхболд Доктор, дэд профессор

Б.Мөнхдорж Доктор, дэд профессор

Ц.Одбаяр Доктор, дэд профессор

Н.Угтахбаяр Доктор, дэд профессор

Г.Буянтогтох Доктор, дэд профессор

Ц.Очгэрэл Доктор

П.Чимэдцэрэн Доктор

JOURNAL EDITORIAL BOARD

Editor of the journal:
Erdenebaatar D, Ph.D., Associate professor

First Secretary:
Enkhtor D, Ph.D., Associate professor

Secretary:
Odkhuu L,

Members:

Amarsanaa J, Academician

Urjin O, Sc.D., Professor

Bat-Erdene B, Ph.D., Professor

Zumberellkham D, Ph.D., Professor

Eui Gab Hwang, Ph.D., Professor

Kharmaev Yuri Vladimirovich, Ph.D, Associate professor

Enkhbold B, Ph.D., Associate professor

Munkhdorj B, Ph.D., Associate professor

Odbayar Ts, Ph.D., Associate professor

Ugtakhbayar N. Ph.D., Associate professor

Buyantogtokh G, Ph.D., Associate professor

Ochgerel Ts, Ph.D.

Chimedtseren P, Ph.D.

ГАРЧИГ–TITLE

ХУУЛЬ САХИУЛАХЫН УДИРДЛАГА
LAW ENFORCEMENT MANAGEMENT

ХУУЛЬ САХИУЛАХ САЛБАРЫН УДИРДЛАГЫН ШИЙДВЭР ГАРГАЛТАД ХИЙМЭЛ ОЮУН НӨЛӨӨЛӨХ НЬ

THE INFLUENCE OF ARTIFICIAL INTELLIGENCE ON DECISION-MAKING IN LAW ENFORCEMENT LEADERSHIP

Н.Өсөхжаргал
Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээ, инновацын газрын төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн, дэслэгч
Usukhjargal N.
Officer in charge of planning at Research and Innovation Department, University of Internal Affairs, Mongolia, Lieutenant
С.Солонго
Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээ, инновацын газрын Эрдэм шинжилгээ, инновацын бодлого хариуцсан ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахлах дэслэгч
Solongo S.
Senior Officer in charge of Research and Innovation Policy at Research and Innovation Department, University of Internal Affairs, Mongolia, Police first Lieutenant

7

ЗАЛГАМЖ ҮЕИЙГ СУРГАН ДАДЛАГАЖУУЛАХАД УДИРДАХ БҮРЭЛДЭХҮҮНИЙ МАНЛАЙЛАЛ

LEADERSHIP OF MANAGEMENT IN TRAINING AND DEVELOPING THE NEXT GENERATION

Д.Мөнхтөр
Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн удирдлага, стратегийн 8023 дугаар дамжааны суралцагч, хошууч
Munkhtur D.
Major, student of Class No. 8023, Management and Strategy Program in Judicial Enforcement, Management Academy, University of Internal Affairs
М.Баяндүүрэн
Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн удирдлага, стратегийн 8023 дугаар дамжааны суралцагч, хошууч
Baynduuren M.
Major, student of Class No. 8023, Management and Strategy Program in Judicial Enforcement, Management Academy, University of Internal Affairs

14

ГЭМТ ЯВДАЛ СУДЛАЛ
CRIMINOLOGY

ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ОНОЛД СУУРИЛАН ХӨГЖҮҮЛЭХ НЬ

DEVELOPING CRIME PREVENTION WORK ON A THEORETICAL BASIS

Д.Зүмбэрэллхам
Хуулъ зүйн доктор, профессор
Zumberellkham D.
Ph.D in Law, professor

22

МОНГОЛ УЛСЫН ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ТУХАЙ ХУУЛИЙГ ЗАРИМ УЛСЫН ИЖИЛ ТӨСТЭЙ ХУУЛЬТАЙ ХАРЬЦУУЛСАН ҮР ДҮН

MONGOLIAN LAW "ON EXECUTIVE WORK" RESULTS

Ү.Хосбаяр
Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн Гүйцэтгэх ажлын тэнхимийн эрхлэгч, доктор (Ph.D), цагдаагийн хурандаа
Hosbayar U.
University of Internal Affairs, Head of the Criminal intelligence Department of the Police school Doctor (Ph.D), Police colonel
Б.Ган-Өсөх
Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн Гүйцэтгэх ажлын тэнхимийн магистрант цагдаагийн ахмад
Gan-Usukh B.
Head of the police intelligence Department of Police School, master's sdutent, Police capitan

32

КИБЕР ОРЧИНД ТЕЛЕГРАМ ПЛАТФОРМ АШИГЛАН ҮЙЛДЭЖ БУЙ ЗАЛИЛАХ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

THE SITUATION OF FRAUD CRIMES USING THE TELEGRAM PLATFORM IN THE CYBER ENVIRONMENT

Б.Хатанзориг
Эрүүгийн цагдаагийн албаны Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газрын Цахим мэдээлэл, дүн шинжилгээний хэлтсийн эрүүгийн ахлах мөрдөгч
Khatanzorig B.
Senior Criminal detective, Department of Digital Information & Analysis, Cybercrime Division, Criminal Police Agency

40

МОНГОЛ УЛС ДАХЬ ЦАХИМ ХЭРЭГСЭЛ АШИГЛАЖ ҮЙЛДСЭН ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ЧИГ ХАНДЛАГА

THE SITUATION AND TRENDS OF HUMAN TRAFFICKING VIA DIGITAL PLATFORMS IN MONGOLIA

Х.Баатарбилэг
Дотоод хэргийн их сургуулийн докторант
Kh. Baatarbileg
Doctoral student, University of Internal Affairs, Mongolia

48

ЦАГДАА СУДЛАЛ
POLICE STUDIES

УЛСЫН ОНЦ ЧУХАЛ ОБЪЕКТЫГ ХАМГААЛЖ ИРСЭН ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ, УЛСЫН ОНЦ ЧУХАЛ ОБЪЕКТЫН НЭРШЛИЙН ТУХАЙ

THE HISTORICAL TRADITION OF GUARDING STATE STRATEGIC FACILITIES

Т.Хүрэлбаатар
Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Гэмт явдал, цагдаа, дотоодын цэрэг судлалын төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан-багш, бригадын генерал
T.Khurelbaatar
Senior researcher of institute of Ceiminology and Police Studies, United Research Institute, University of the Internal Affairs, Mongolia, brigader general
Э.Хандармаа
Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Гэмт явдал, цагдаа, дотоодын цэрэг судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан-багш, цагдаагийн дэслэгч
Khandarmaa Erdenebayar
Researcher-teacher of Criminology, Police and Internal Troops Studies Center, Police lieutenant

63

ХИЛ СУДЛАЛ
LIMNOLOGY

БҮС НУТАГ ТҮҮНИЙ ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ОПЕРАТИВЫН БАЙГУУЛАМЖ

Н.Наранжамц
Удирдлагын академийн хилийн албаны удирдлага-стратегийн тэнхимийн ахлах багш, доктор, профессор (Ph.D), хурандаа
Naranjamts N.
Senior Lecturer, Doctor, Professor (Ph.D.), Colonel, Department of Management and Strategy of the Border Service of the Academy of Management
Г.Содбаяр
Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн суралцагч, хошууч
Sodbayar G.
Student, Master's student, Major of the Management Academy of the University of Internal Affairs
Ц.Баяндалай
Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн суралцагч, хошууч
Bayandalai Ts.
Student, Master's student, Major of the Management Academy of the University of Internal Affairs

72

ХИЛИЙН БООМТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭДИЙН ЗАСАГ ДАХЬ НӨЛӨӨЛЛИЙН СУДАЛГАА

STUDY OF THE ECONOMIC IMPACT OF BORDER PORT ACTIVITIES

Г.Галбадрах
Дотоод хэргийн их сургуулийн Хилийн албаны сургуулийн захирал, докторант
Galbadrakh.G
Ph.D candidate, Director at the School of Border Service, University of Internal Affairs, Mongolia

82

ХИЛИЙН БООМТОД ОНЦГОЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ ҮҮССЭН ҮЕИЙН ХАРИЛЦАН АЖИЛЛАГАА

COOPERATION DURING EMERGENCIES AT BORDER CROSSING POINTS

Д.Ариунболд
Удирдлагын академийн суралцагч, хошууч
D. Ariunbold
Student of the Leadership Academy, Major
90

ЦЭРГИЙН ӨНГӨЛӨН ДАЛДЛАЛТЫН ХУВЦАСНЫ ТҮҮХ, ЗОРИУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА

HISTORY, PURPOSE, AND DEVELOPMENTAL TRENDS OF MILITARY COLORED CAMOUFLAGE

Э.Гүнчинлхам
Дотоод хэргийн их сургуулийн Хилийн аюулгүй байдал судлалын төвийн докторант, ахмад
Enkhtuya G.
Doctoral student at the Center for Border Security Studies, Captain
99

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛ СУДЛАЛ
COURT DECISION EXECUTION STUDIES

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА

CURRENT SITUATION AND DEVELOPMENT TRENDS IN HUMAN RESOURCES OF COURT DECISIONS AGENCY

П.Баярбаатар
Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Ял эдлүүлэх эрх зүйн тэнхимийн ахлах багш, доктор (Ph.D), дэд хурандаа
P.Bayarbaatar
Ph.D, Lieutenant colonel, Senior Lecturer at the Department of Law in Sentencing of Court decision execution school, University of Internal Affairs
Б.Уянга
Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Ял эдлүүлэх эрх зүйн тэнхимийн багш, дэслэгч
B. Uyanga
Lecturer in Department of Penal Law of the School of Court decision of UIA, leuitenant
107

ГАМШИГ СУДЛАЛ
DISASTER STUDIES

ЗУДЫН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРИМ АСУУДАЛ, ШИЙДЭЛ

SOME PROBLEMS AND SOLUTIONS TO RISK MITIGATION OF ZUD

Б.Саранцэцэг
Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн профессор, доктор (Ph.D), дэд профессор, дэд хурандаа
Sarantsetsteg B.
Professor of Academy of Management, Institute of University of Internal Affairs, Ph.D, lieutenant Colonel
Н.Одмаа
Дотоод хэргийн их сургуулийн докторант, ахмад
Odmaa N.
Doctoral student, University of Internal Affairs, senior
118

ДОРНОД АЙМАГТ 2021-2022 ОНД БҮРТГЭГДСЭН ҮХРИЙН АРЬС ТОВРУУТАХ ӨВЧНИЙГ СУДАЛСАН ДҮН

STUDY RESULTS ON LUMPY SKIN DISEASE IN CATTLE REPORTED IN DORNOD PROVINCE DURING 2021–2022

М.Мөнгөнбаръяа
Дотоод хэргийн их сургуулийн магистрант, хошууч
Mungunbariya M.
MA scholar, major, University of Internal Affairs
Н.Батсайхан
Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургуулийн захирал, доктор (Ph.D), дэд профессор, хурандаа
Col. Batsaikhan N.
Assoc.Prof, Ph.D, Director, Colonel, School of Emergency Management, University of Internal Affairs
131

ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

ANALYSIS OF THE EARTHQUAKE DISASTER PROTECTION PLAN

Г.Батмөнх 139
Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн магистрант, дэд хурандаа
Batmunkh.G
Graduate student at the Institute of Management Academy, the University of Internal Affairs, lieutenant colonel

ЭРХ ЗҮЙ СУДЛАЛ
LEGAL STUDIES

ДААТГАЛЫН ГЭРЭЭНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ

SOME ISSUES OF THE LEGAL REGULATION OF INSURANCE CONTRACTS IN JAPAN

Т.Наранцогт 152
СЭЗИС-ын Эрх зүйн тэнхимийн ахлах багш, хууль зүйн магистр /LL.M/
Narantsogt T.
Senior Lecturer of the Department of Law, UFE, Master of Laws (LL.M)

ХУУЛЬ САХИУЛАХУЙН БОЛОВСРОЛ СУДЛАЛ
LAW ENFORCEMENT EDUCATION STUDIES

ИХ, ДЭЭД СУРГУУЛИУДЫН ХУУЛЬ САХИУЛАХ БОЛОВСРОЛ ОЛГОХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР: ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА, ЧИГ ХАНДЛАГА

Б.Энхболд 158
Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, доктор, дэд профессор
B.Enkhbold
Commissioner, The National Human Rights Commission of Mongolia, Doctor, associate Professor

РОЛЬ ИНОСТРАННОЙ ТЕРМИНОЛОГИИ В ПРОЦЕССЕ РЕАЛИЗАЦИИ ПРОФИЛЬНО-ОРИЕНТИРОВАННОГО ОБУЧЕНИЯ ПО ЮРИДИЧЕСКИМ СПЕЦИАЛЬНОСТЯМ THE ROLE OF

FOREIGN TERMINOLOGY IN THE PROCESS OF IMPLEMENTING PROFILE-ORIENTED TRAINING IN LEGAL SPECIALTIES

Нестерова Валерия Евгеньевна 176
Доцент кафедры иностранных языков Уральского юридического института МВД России, кандидат филологических наук
Nesterova Valeria Evgen'evna
Associate professor of the Department of Foreign Languages of the Ural Law Institute of the Ministry of the Interior of the Russian Federation, Candidate of Philology

МЭРГЭШСЭН ХИЛЧИН ИНЖЕНЕР БЭЛТГЭХ СУРГАЛТЫН ТОГТОЛЦООГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗАРИМ АСУУДАЛ

SOME ISSUES IN FORMING THE TRAINING SYSTEM FOR TRAINING QUALIFIED BORDER ENGINEERS

Г.Ган-Эрдэнэ 181
Дотоод хэргийн их сургуулийн Хил судлалын докторант, хурандаа
G.Gan-Erdene
Colonel, Ph.D. candidate in Border Studies, University of Internal Affairs

ХУУЛЬ САХИУЛАХ САЛБАРЫН УДИРДЛАГЫН ШИЙДВЭР ГАРГАЛТАД ХИЙМЭЛ ОЮУН НӨЛӨӨЛӨХ НЬ

THE INFLUENCE OF ARTIFICIAL INTELLIGENCE ON DECISION-MAKING IN LAW ENFORCEMENT LEADERSHIP

Н.Өсөхжаргал
Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээ, инновацын газрын төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн, дэслэгч
N. Usukhjargal
Officer in charge of planning at Research and Innovation Department, University of Internal Affairs, Mongolia, Lieutenant
С.Солонго
Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээ, инновацын газрын Эрдэм шинжилгээ, инновацын бодлого хариуцсан ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахлах дэслэгч
S. Solongo
Senior Officer in charge of Research and Innovation Policy at Research and Innovation Department, University of Internal Affairs, Mongolia, Police first Lieutenant

*хариуцлагатай зохиогч: az.usuhjargal@gmail.com

Хураангуй: Хууль сахиулах байгууллагад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэгтэй тэмцэх, иргэн, хуулийн этгээдийн эрхийг хамгаалах үүднээс тодорхой шийдвэрүүдийг гаргах хэрэгцээ, шаардлага алхам тутамдаа тулгарсаар ирсэн.

Эдгээр салбарын өдөр тутмын үйл ажиллагаанд хиймэл оюун ухаан, дижитал программууд нэвтэрч эхэлснээр удирдлагын шийдвэрт тодорхой нөлөөг үзүүлж эхэллээ. Хамгийн гол нь бодит байдлыг үнэлсэн, тодорхой шинжлэх ухаанд суурилсан, богино хугацаанаас илүү урт хугацааны явцад үр дүнтэй байж болох шийдвэр гаргаж чадаж байгаа эсэх судлаачдийн анхаарлыг татсан хэвээр байна.

Шинэчлэлтэд бид дасан зохицож ирээдүйн үйл ажиллагааг хэрхэн уялдуулж, цаашдын стратеги, хөгжлийн загварчлалыг боловсруулж, тодорхой алхмуудыг хийх шаардлагатай нөхцөл байдал үүссэнийг хүлээн зөвшөөрөх ёстой.

Иймд бусад улс орны хууль сахиулах байгууллага үйл ажиллагаандаа нэвтрүүлээд буй санал санаачилгаас Монгол Улсын хэмжээнд нийтлэг байдлаар хэрэгжүүлж болох хамгийн тохиромжтой хувилбараар санал дэвшүүлэхийг зорилоо.

Abstract: Law enforcement agencies have been faced with the need and requirement to make specific decisions at every step to implement laws, maintain public order, ensure public safety, fight crime, and protect the rights of citizens and legal entities.

As artificial intelligence and digital applications have begun to penetrate the daily operations of these industries, they are beginning to have a significant impact on management decisions. Most importantly, researchers are still concerned about whether they can make decisions that are based on reality, based on clear science, and that can be effective in the long term rather than the short term.

We must recognize that the situation has arisen that requires us to adapt to the changes and coordinate future activities, develop further strategies and development models, and take specific steps.

Therefore, we aim to propose the most suitable alternative that can be implemented universally across Mongolia, based on the initiatives that law enforcement agencies in other countries have implemented.

Түлхүүр үгс: Хууль сахиулагч, шийдвэр гаргалт, судалгаанд суурилсан шийдвэр гаргалт, төрийн тусгай албаны шийдвэр гаргалт, асуудлыг таамаглах дүн шинжилгээний арга зүй, мэдээлэлд суурилсан стратеги.

This article is published under the Creative Commons BY-NC-SA License by 4.0, ©2025 University of Internal Affairs, Mongolia

Keywords: Law enforcement, decision-making, research-based decision-making, decision-making in government agencies, problem analysis methodology, data-driven strategies.

Үндсэн хэсэг

Байгууллагын удирдлагын шийдвэрт нөлөөлөх хүчин зүйлсэд ялангуяа 2020 оноос хойших судалгаануудад дижитал шинжилгээний үр дүнг ашиглах чадварын тухай ойлголтууд хүч түрэн орж ирсэн.

Технологийн сэтгүүлээс 2025 онд шийдвэр гаргалтын чиг хандлагад уламжлалт технологиос хүн болон хиймэл оюун ухаан хоорондын хил хязгаар ойртож, илүү боловсронгуй, бие даасан систем рүү шилжих байгааг дурдаж, 2025 онд л байгууллагууд шийдвэрийнхээ 15 хувийг хиймэл оюун ухаанд захирагдаж гаргана гэж онцолжээ. Үүнд дараах таамаглалуудыг дэвшүүлсэн. (Technology magazine, 2025)

1. Хиймэл оюун ухааны шийдвэр гаргалт 15 хувьд хүрнэ. Хиймэл оюун ухаан нь 2025 оны удирдлагын шийдвэр гаргалтын 15 хувийг, 2028 он гэхэд өдөр тутмын ажлын шийдвэр гаргалтын 15 хувийг эзэлнэ.

2. AI засаглалын платформууд. AI засаглалын платформууд нь хиймэл оюун ухааныг хариуцлагатай хэрэгжүүлэх хэрэгцээ өсөн нэмэгдэж, 2028 он гэхэд хиймэл оюун ухаантай холбоотой ёс зүйн зөрчил 40%-р буурна.

3. Хуурамч мэдээллийг илрүүлэх технологи. Дээрх аюул заналхийллийг илрүүлж, бууруулахад хиймэл оюун ухааныг ашиглаж, худал мэдээлэл тархахтай тэмцэж эхэллээ.

4. Квантад тэсвэртэй алгоритмуудыг боловсруулж байна. Google, IBM, Microsoft компаниуд квантад тэсвэртэй алгоритмуудыг боловсруулж байгаа бөгөөд АНУ-ын Үндэсний Стандарт, Технологийн Хүрээлэн (NIST) 2024 оны 8-р сард шинэ PQC стандартаа зарлаж, салбарын шилжилтийг удирдан чиглүүлэв.

5. Хиймэл оюун ухаанд суурилсан дуут туслахууд. Гэмт хэргийн байцаалт, мэдүүлэгт ашиглаад эхэлсэн. Мөн сэтгэцийн эрүүл мэндийг нүүрний хувирлаар тогтоох боломжтой болсон.

6. Эрчим хүчний хэмнэлттэй тооцоолол. Мэдээж мэдээллийг боловсруулах гэдэг бол эрчих хүчийг маш ихээр зарцуулж буй Microsoft дата төвүүдээ 100% сэргээгдэх эрчим хүчээр хангах үүрэг хүлээсэн. АНУ-ын Эрчим хүчний яамны Үндэсний эрчим хүчний судалгааны шинжлэх ухааны тооцооллын төв нь GPU хурдасгасан кластерууд нь зөвхөн CPU-тэй харьцуулахад эрчим хүчний үр ашгийг 5 дахин сайжруулах боломжтойг харуулсан. Ийм мэт эрсдэл арилах тусам салбарын хөгжил илүү нэмэгдэж, орон зайгаа тэлэх зүй тогтолтой байдаг.

7. Гибрид тооцоолол нь инновацын үр ашигтай орчныг бий болгоно. Асуудалд олон арга, программуудын нэгтгэн шинжилгээ хийх.

8. Орон зайн тооцоолол. Орон зайн тооцоолол нь ойрын 5-7 жилийн хугацаанд “хялбаршуулсан ажлын урсгал болон сайжруулсан хамтын ажиллагаа”-аар байгууллагын үр нөлөөг мэдэгдэхүйц нэмэгдүүлэх болно.

9. Олон үйлдэлт роботууд. 2030 он гэхэд хүмүүсийн 80% нь ухаалаг роботтой өдөр бүр холбогдох болно гэдгийг онцоллоо.

10. Хүмүүс өөрсдийн бодлоор төхөөрөмж удирддаг болно. Элон Маск хүний сэтгэхүйгээр дамжуулан төхөөрөмжийг удирдах тархины суулгацыг шинэчлэх төслийг хэрэгжүүлж байна.

Энэ үзүүлэлтийг харахад бодит бус зүйл мэт боловч магадгүй цаг хугацааг эргэн санахад хууль сахиулах салбарын тогтолцоо нь 2000 оныг хүртэл ихэвчлэн захиргааны шинж чанартай буюу осол гарсны дараа бүртгэл эхлэх, хулгай гарсны дараа арга хэмжээ авах, гал гарсны дараа эсхүл үер болсны дараа, хилийн зөрчил гарсны дараа мэдээлэх зэрэг цаасан дээр суурилсан ажлын урсгалыг тойрон эргэлдэж магадгүй илрүүлэх биш баримтжуулахад гол анхаарлаа хандуулж байсан гэхэд хилсдэхгүй.

Гэвч орчин үеийн хууль сахиулах орчин эрс өөрчлөгдсөн.

Гэмт хэрэг дангаараа гарахаа больж, харилцаа холбооны сүлжээ, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, төхөөрөмж, хяналтын системд дижитал ул мөр үлдээдэг. Энэхүү ул мөр нь өөрөө нотлох баримт, сэрэмжлүүлэг болж, хохирогчдод хохирохгүй байх сонголт байсныг, аюул эрсдэлийг тооцох боломж байсныг, мэдээллийн үнэн зөвийг нягтлах боломж байсныг сануулах бараг л хиймэл ухаан, дижитал программд суурилсан урьдчилан сэргийлэлт ч болж байна.

Мөн хиймэл оюун ухаанд суурилсан программ хангамж нь өнөөдрийг хүрсэн хууль сахиулах салбарын хөгжлийн хамгийн хурдацтай үсрэлтийг харуулж мөрдөн байцаалт, тандалт, шүүх шинжилгээ, зөрчлийг илрүүлэх, гэмт хэрэгтний сэтгэл зүйн шинжилгээ зэрэг танин мэдэхүйн системийн хэрэглээнд тодорхой байр, суурийг эзэлжээ.

Тухайлбал: Хууль сахиулах салбарын удирдлагын шийдвэрт

1. Өгөгдлийг шинжилж, орхигдуулсан сэжүүрийг таамаглах процесс;
2. Цахим сүлжээнд дуудлагын бичлэг, мессеж, камерын бичлэгээс нүүрний хэлбэрт үндэслэн хайлт хийх;
3. Шүүх эмнэлгийн өгөгдөл нэгтгэх зэрэг шинэ технологиуд нөлөөлж эхэллээ.

Үүний үр дүнд шинээр гарч ирж буй аюул заналыг урьд өмнө хэзээ ч байгаагүйгээр урьдчилан харж, илрүүлж, хариу арга хэмжээ авах боломжийг бүрдүүлж, зөвхөн урьдчилан таамаглаад зогсохгүй шийдвэр гаргах бүх шатанд үйл ажиллагаа хэрхэн явахыг төсөөлөх боломжтой болсон.

Магадгүй цаашид хууль сахиулах салбараар ч тогтохгүй бүхий л байгууллагын шийдвэр автоматчилагдаж, ганцхан товчлуураар асуудлын учрыг олдог болох хөгжил рүү хурдацтайгаар шилжиж байж ч болох.

Гэхдээ судлаачдын зүгээс шийдвэр гаргалтад нөлөөлж буй хамгийн чухал хүчин зүйл болох хүний ёс зүйн төлөвшил орхигдоод байгааг анзаарахгүй өнгөрөөж болохгүй бөгөөд удирдлагууд дижитал программ болон технологийн дэвшлүүдийг ашиглахдаа болгоомжтой байхыг ахин дахин сануулсаар байна.

Байгууллагын Удирдлага болон удирдах зөвлөлийг томоохон дата станц дээрээс үйл ажиллагааг хараад сууж байгаа аварга AI боловсруулагч гэж ойлгож болох юм. Асар их мэдээлэлд автсан эдгээр хүмүүс шийдвэр гаргахын тулд энэхүү мэдээллийг үр дүнтэй ашиглах л тулгамдсан асуудал нь болоод байгаа. Гэвч хэн ч ирээдүйг нарийн тооцож чадахгүй. Харин ирээдүйг таамаглаж, бодит байдалд илүү ойрхноор төсөөлж болох бүх боломж тэдэнд байна. Байгууллага доторх шийдвэр гаргах үйл явцыг оновчтой болгосноор мэдээллийн нарийн төвөгтэй байдал, хэмжээ нь шийдвэр гаргагчдын чадварыг хойш нь татах бус бусад саадыг даван туулах, тодорхой арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх боломжийг бий болгох юм.

Үүнийг олон улсад Management information буюу удирдлагын мэдээлэл гэх ойлголтоор судалгаанд түлхүү ашиглаж, мэдээллийг стратеги, үйл ажиллагаа, тактикийн шийдвэрүүдийг удирдах ач холбогдолтой тагнуул (Erica, Gantari, Olivia , Asher , & Omar , 2024) гэж хүртэл тодорхойлсон.

Сүүлийн жилүүдэд байгууллагын Дата шинжээч гэсэн мэргэжил хүртэл ажлын байранд хүч түрэн орж ирэхээс гадна, янз бүрийн программ хангамжууд хурдацтайгаар хөгжиж байна. Магадгүй таны ажлыг хөнгөвчлөх нарийн үйл ажиллагаатай зөвлөх үйлчилгээ ч байгааг үгүйсгэхгүй. Гэхдээ шийдвэр гаргалт бүрд эдгээрийг ашиглаад байх нь оновчтой бус бөгөөд хөрөнгө, цаг хугацааны хувьд ч харилцан үр ашиггүй байна.


Үүнийг дэлхий дахинд хэрхэн шийдвэрлэхээр зорьсон бэ? Хэд хэдэн боломжит хувилбаруудыг санал болгосоор байна.


1. Удирдагч бэлтгэх сургалт: Сургалтын хөтөлбөрт энэхүү хөтөлбөрийг тусгаж эхэлсэн. Тухайлбал Харвардын их сургуулийн Бизнесийн сургуулийн Манлайлал хөгжүүлэх хөтөлбөрийн дижитал хувиргалтын хөтөлбөр. Тус хөтөлбөрийн зорилго нь “Хөгжиж буй

технологийг ашиглаж таны үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөнд дүн шинжилгээ хийж, статистикийн муруйг түрүүлж хараарай" (Harvard , 2025), Манчестарын Их сургуулийн Бизнесийн сургуулийн Манлайллын 4 өдрийн сургалтын зорилго нь "Байгууллагын гүйцэтгэл, зах зээлийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх бизнесийн шинэлэг стратегийг хэрэгжүүлэхэд технологийг ашигла" (The University of Manchester).

2. Байгууллагын үйл ажиллагааг нэгдсэн системд холбож, алба хаагчдын өгөгдлийг удирдах албан тушаалтан ганц дэлгэцээр харах боломжтой хувилбар. Тухайлбал: Олон улсын цагдаагийн дарга нарын холбоо (IACP-International association of chiefs of police)-нооc "Хиймэл оюун ухааны эрин ба орчин үеийн цагдаагийн программ хангамж: өгөгдөл боловсруулалт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх боломжийг нэмэгдүүлэх эсэх" (Policing Software in the Age of AI: From Reactive Reports to Proactive Crime Prevention, 2025) тайланг танилцуулсан.

Тайланд олон сайн чанар, хэрэгжүүлэх боломж, цаг хугацаа болон эдийн засгийн үр нөлөөг тайлбарласан ч хүний ёс зүйд нийцэх өгөгдөл одоогоор программчлах боломжгүй тухай дурдсан. Энэ арга бол хамгийн энгийн боловч үүнийг дагаад сул талууд байх магадлалтайг зарим судлаачид хүлээн зөвшөөрсөн байна.





3. Ажлын байрны шаардлагад тавих: Өөрөөр хэлбэл удирдах албан тушаалтаас энэхүү ур чадвар заавал буйг шаардах бөгөөд байгууллагын онцлогоос хамаарч тоон болон чанарын судалгааны ур чадваруудыг эсхүл бүр холимог байдлаар ашиглах боломжтойг давуу тал болгож байна.

Энэ төрлийн ур чадвар нь статистикийн онол, эдийн засгийн мэдрэмжид ихээхэн суурилж буй тул ирээдүйд математикч, эдийн засагчид илүү удирдах албан тушаалыг эрхлэх байх гэсэн таамаглалыг дэвшүүлсэн судалгаа байна (Kumar, 2024). Үүнээс харахад бусад мэргэжлийн болон бусад салбарын удирдах албан тушаалтнууд энэхүү чадварт суралцах нь зайлшгүй болсон мэт.

Иймд удирдлага бүхэнд хамгийн ихээр тулгарч болох тулгарснаас үүсээд шийдвэрээ өөр хүчин зүйлсийн нөлөөнд автан гаргах нөхцөлийг үүсгэх эхний асуудал бол та асуудалд чанарын аргыг үндэслэн хандах уу? Эсхүл тоон шинжилгээнд үндэслэн хандах уу? гэх сонголттой нүүр тулах, дагаад программын сонголтыг ч хариулахад нөлөөлнө.

Судлаачдын зүгээс удирдах албан тушаалтан шийдвэр гаргахдаа өөрт буй мэдээллээсээ хамааран дээрх 2 аргаас аль тохиромжтойг сонгох боломжтойгоор төрийн тусгай албаны үйл ажиллагааны жишээн дээр эрэмбэлэн санал болгож байна.

Төрийн тусгай албаны өдөр тутмын үйл ажиллагаа нь нийтлэг байдлаар удирдлагын процесс, үндсэн үйл ажиллагааны процесс, дэмжих үйл ажиллагааны процесс гэсэн 3 хэсэгт тодорхой асуудлыг шийдвэрлэн, шийдвэрийг хэрэгжүүлэн зохион байгуулагддаг.

1.Удирдлагын процесс бол зохион байгуулалт, үнэлгээ, цалин, урамшуулал гэх мэт алба хаагчдад чиглэсэн үйл ажиллагаанууд байх бөгөөд илүү чанарын шинжилгээ тохиромжтой.

Жишээлбэл: Алба хаагчийн ажлын ачааллыг тодорхойлох судалгаа, сэтгэл ханамжийн судалгаа, урамшууллын систем болон төлөвлөлт зохион байгуулахад программд суурилсан судалгаа үр дүнгүй бөгөөд судалгааны асуулгад алба хаагч цөөн үгээр илэрхийлэх боломжгүй нөхцөл байдлууд орхигдоод байх тал ажиглагддаг бөгөөд буруу хувьсагчийн гажуудлаас үүсэн судалгааны үр дүн бодит байдалд нийцэхгүй байдал үүсгэдэг.

Иймд энэ төрлийн судалгааг фокус бүлгийн ярилцлага, ганцаарчилсан ярилцлага, нээлттэй санал асуулга гэх мэт илүү харилцаанд тулгуурласан шинжилгээ тохиромжтой ба MAXQDA, NVIVO программууд илүү тохиромжтой.

2.Үндсэн үйл ажиллагаа бол иргэдийг аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахад чиглэсэн байх тул үйл ажиллагаа улс орны хэмжээнд ерөнхийлөн шийдвэр гаргалдаг тул тоон шинжилгээний аргууд тохиромжтой.

Жишээлбэл: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хоригдлыг нийгэмшүүлэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ, хил орчмын харуул хамгаалалт, гал түймрээс урьдчилан сэргийлэх гэх зэрэг хугацаан цувааны өгөгдөл их, жилийн болон сар, улирлын байдлаас харгалзан өсөх буурах үзүүлэлтүүд гаргаж байдаг, үзүүлэлтийн ажиглалтаас үүсэх давтамжийг тодорхойлох, шийдвэрт ерөнхийлөн ашиглах боломжтой.

Хэрэгжилт үр дүнд хүрэх магадлал аль ч салбарт өндөр хувийг хамрах тул нэг байгууллагын загварыг нөгөө байгууллага шилжүүлэн ашиглах ч боломжтойгоороо онцлог ба SPSS, R хэрэглээний хувьд хамгийн нөхөрсөг сонголт байна.

3.Дэмжих үйл ажиллагаа бол алба хаагчдын ажлын ачаалал, нийгмийн баталгаа, эрүүл мэнд гэх мэт хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэсэн үйл ажиллагаа тул тоон болон чанарын шинжилгээ аль аль нь тохиромжтой байна.

Жишээлбэл: Үйл ажиллагааны шинж чанарын хувьд ажил олгогч ба ажилтан хоёрын эрх ашгийг нэгэн зэрэг хамгаалдаг процессууд хамаарах тул тоон болон чанарын судалгааг хослуулан хэрэглэснээр илүү нарийн шийдвэрүүдийг гаргахад тань тусална.

Удирдлагын аливаа шийдвэрийн гол зорилго бол тодорхой асуудлыг шийдвэрлэх. Асуудлын цаана алба хаагчид, үүнээс гадна гадаад, дотоод харилцагчид бий. Эдгээрийн хүсэл зоригийг 100 хувийн тааламжтайгаар хангах боломжгүй. Мэдээж дундаж буюу 60 хувиас их бүрэлдэхүүний асуудлыг шийдэж чадвал шийдвэр хамгийн оновчтой болох магадлалтай. Үлдсэн хэсэг асуудлыг хэрхэн шийдвэрлэснийг нээлттэйгээр мэдэж буй тул хүсээгүй үр дүн ч хамгийн шударга хэмжүүр гэхтэй санал нийлдэг.

Иймд магадгүй бид аливаа асуудалд практик туршлага, дүрэм журамд нийцүүлэн шийдвэрлэлээ гэхээс бодит шинжлэх ухааны нотолгоо илүү итгэл төрүүлдэг ч байж магадгүй байх нь.

Хууль сахиулах байгууллагын удирдлагын шийдвэрт хиймэл оюун ухаан, дижитал программ хангамжийг ашиглаж буй өнөөгийн байдалд ***“SWOT”, “TOWS”*** шинжилгээ хийж үзье.

	Давуу тал-S	***Сул тал-W***
Дотоод хүчин зүйл	- Мэдээллийн шуурхай боловсруулна. - Эрсдэлт хүчин зүйл бага. - Бусад улсын туршлагаас судлах боломж их.	- Эрх зүйн зохицуулалтын хэрэгжилт сул. - Байгууллагын санхүүгийн чадамж сул тул худалдан авалт шуурхай бус.
Гадаад хүчин зүйл	- Бүх шатны сургалтын хөтөлбөрт энэхүү сургалтын загварыг нэвтрүүлэх боломжтой.	- Сургагч багшийн нөөцгүй. - Алба хаагч, сургалтын байгууллагын уялдаа сул.

	- Суралцах орчин хангалттай.	- Ажлын ачаалал их тул алба хаагчид шинэ зүйлийг турших мотивац сул.
Боломж-О	**OS стратеги**	**OW стратеги**
- Үйл ажиллагааны журмуудад нэмэлт өөрчлөлт оруулах боломжтой. - Гадаадын байгууллагуудтай хамтарч сургалт, бэлтгэлийг зохион байгуулах боломжтой. - Ахисан түвшний хөтөлбөрт хамрагдах боломжтой.	- Эрх зүйн орчныг бий болгоход чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх, - Урт болон богино хугацааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, - Хууль сахиулагчийг бэлтгэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй сургалтын байгууллагын сургалтын хөтөлбөрт тусгаж, сургалт зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх.	- Ажлын байранд хөгжих уялдаа холбоог хангасан тогтолцооны загварт оруулах. - Хууль сахиулагчийн ажлын байрны сургалтын ангиллыг шинэчлэх. - Сургалтын үр дүнгээр ахиж, дэвших боломжийг тогтоох.
Эрсдэл /Аюул занал/ -Т	ST стратеги	WT стратеги
- Ашиглах арга технологийг бүрэн эзэмших хүртэл үйл ажиллагааны хурд удаашрах эрсдэлтэй. - Ажлын байранд хүний нөөцийн хомсдол бий болох эрсдэл үүсэх.	- Сургалтын орчин, анги танхим хүрэлцээтэй тул давтан сургах, нэмэлт төхөөрөмжүүдийг холбох дэд бүтцийн нөөц сайтай.	- Санхүүгийн нөөц нь давтан сургах, гэрээ, лицензийг сунгах үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх.

Хүснэгт 1. **“SWOT”, “TOWS”** шинжилгээ

“SWOT”, “TOWS” шинжилгээнээс үзэхэд, Монгол Улсын хувьд эрх зүйн орчин сул, санхүүгийн болон хүний нөөцийн хомсдол их байгаа нь урт хугацааны хөтөлбөрүүдэд одоогоос анхаар ажиллах шаардлагатайг илтгэж байна.

Гэвч боломжийг ашиглаж асуудалд бодит дүгнэлт хийж, бүх шатны байгууллага аажмаар нэвтрүүлэхэд анхаарч сул талаа арилгах, давуу талаараа аюулаас зайлсхийх боломжтой гэж үзэж байна.

Санал, дүгнэлт

Нийгэм, эдийн засаг, техник технологийн хөгжил, хөдөлмөрийн зах зээл өөрчлөгдөх үйл явцын үр дүнд хууль сахиулах байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгоход иргэдийн оролцоо, олон нийтийн боловсролыг дэмжих чиг хандлагыг баримталхаас гадна бодит өгөгдөлд суурилж асуудлыг шийдвэрлэхэд анхаарч байгаа ч ялагуяа аль ч төрлийн урьдчилан сэргийлэх үйл ажиллагаандаа хийсэл оюуны ухаан болон дижитал программыг ашиглах хэрэгцээ үүссэнийг ухаарч Хууль сахиулах байгууллага удирдах албан хаагчдаас эхлээд бүхий л түвшний алба хаагчдыг сургаж, бэлтгэх, технологийн нөөцийг бүрдүүлэх хэрэгцээ ихээхэн байна.

Монгол Улсын хууль сахиулах байгууллагын хувьд санхүүжилтийн байдал нь эрсдэлт хүчин зүйл байх тул өнөөгийн үйл ажиллагаанаас эхлэн аажмаар шилжих стратеги хэрэгжүүлж эхэлж байх нь хамгийн тохиромжтой сонголт тул хүний нөөцийг бэлтгэх асуудалд анхаарч байхад ирээдүйд ирэх зарим үр дагавраас зайлсхийх боломжтой байна.

Удирдлагууд шийдвэр гаргалтдаа хиймэл оюун ухаан, дижитал программ хангамжийг ашиглаж хэвшсэнээр дан ганц шийдвэрийн алдааг багасгах бус байгууллагын үйл ажиллагааг энэ чиглэлд бэлтгэх бас нэг суурь хүчин зүйл болж байгааг анхаарч байгууллагын соёлыг тогтоож эхлэх шаардлагатай байна.

Эх сурвалжийн жагсаалт

Erica, A., Gantari, L., Olivia , Q., Asher , N., & Omar , S. (2024). Optimizing Decision-Making: Data Analytics Applications. APTISI Transactions on Management (ATM), E-ISSN: 2622-6804 P-ISSN: 2622-6812, https://pdfs.semanticscholar.org/e491/a5802756f1ebca816fd0e460ca5c3c8c5f1c.pdf. doi:DOI:10.33050

Harvard . (2025). Harvard Business School. Retrieved from https://www.exed.hbs.edu/programs/learning-tracks, https://www.exed.hbs.edu/programs/learning-tracks/digital-transformation-certificate.

IACP (International Association of Chiefs of Police). (2025). Policing Software in the Age of AI: From Reactive Reports to Proactive Crime Prevention. USA: IACP. Retrieved from Policing Software in the Age of AI: From Reactive Reports to Proactive Crime Prevention.

Kumar, R. (2024). California School of Management and Leadership. Retrieved from https://www.alliant.edu/blog/what-are-most-common-management-careers.

Technology magazine. (2025). Retrieved from https://technologymagazine.com/articles/top-10-trends-of-2025.

The University of Manchester . (n.d.). Alliance Manchester Business School. Retrieved from https://www.alliancembs.manchester.ac.uk/go/short-courses-greater-manchester/?gad_source=1&gad_campaignid=22291749757&gbraid=0AAAADCTIFoSjIyfzbFWdfiNsK6mm4ahV&gclid=CjwKCAiAlrXJBhBAEiwA-5pgwlLa-F5CLyRG9_NSOG9pvBD4l-Xf_wXU01XPR7I5T_TMKkyUymYR2BoCj1kQAvD_B.

ЗАЛГАМЖ ҮЕИЙГ СУРГАН ДАДЛАГАЖУУЛАХАД УДИРДАХ БҮРЭЛДЭХҮҮНИЙ МАНЛАЙЛАЛ

LEADERSHIP OF MANAGEMENT IN TRAINING AND DEVELOPING THE NEXT GENERATION

Д.Мөнхтөр
Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн удирдлага, стратегийн 8023 дугаар дамжааны суралцагч, хошууч
Munkhtur D.
Major, student of Class No. 8023, Management and Strategy Program in Judicial Enforcement, Management Academy, University of Internal Affairs.
М.Баяндүүрэн
Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн удирдлага, стратегийн 8023 дугаар дамжааны суралцагч, хошууч
Baynduuren M.
Major, student of Class No. 8023, Management and Strategy Program in Judicial Enforcement, Management Academy, University of Internal Affairs

*Хариуцлагатай зохиогч: Bayka7235@gmail.com

Хураангуй: Орчин үеийн Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын хөгжлийн гол үндэс нь хүний нөөцийн тогтвортой хөгжил, алба хаагчдыг төлөвшүүлэх, сурган дадлагажуулах явдал юм. Алба хаагчдыг сурган дадлагажуулах, залгамж үеийг бэлтгэх үйл явц нь зөвхөн тухайн ажилтны мэргэжлийн чадавхыг дээшлүүлэхээс гадна байгууллагын соёлыг төлөвшүүлэх, ирээдүйн манлайлагчдыг бэлтгэх чухал ач холбогдолтой юм. Удирдах бүрэлдэхүүн бол байгууллагын туршлага, манлайлал, ёс зүй, үнэт зүйл, уламжлалыг залуу үедээ өвлүүлэх гол гүүр юм. Энэхүү илтгэлээр гадаадын зарим орны туршлагыг харьцуулан судалж, боломжит хувилбаруудыг санал болгохыг зорилоо.

Abstract:The foundation of modern state military and law enforcement development lies in the sustainable advancement of human resources and the systematic education and training of personnel. In this regard, the process of educating and mentoring officers, as well as preparing the next generation, not only enhances the professional competence of individual employees but also plays a vital role in fostering organizational culture and cultivating future leaders. The leadership and management teams serve as a crucial bridge for transmitting the organization's experience, leadership values, ethics, principles, and traditions to the younger gene. This paper seeks to examine and compare the experiences of selected foreign countries and to propose potential approaches and models applicable to this area.

Түлхүүр үг: Байгууллагын хөгжил, удирдах албан тушаалтан, туршлагатай алба хаагч, сурган дадлагажуулах, залгамж үеийг бэлдэх.

Key words: Organizational development, managerial leadership, experienced officers, training and mentoring, and preparing the next generation.

Удиртгал

Удирдлагын манлайллыг өргөн хүрээнд авч үзвэл улс, нийгэм байгууллага, тусгайлан авч үзвэл гэр бүл, хувь хүний хөгжил нь үе үеийн туршлагатай хүний нөөцийн залгамж холбоонд тулгуурладаг. Байгууллагын үнэт зүйл болсон алба хаагчийн үнэ цэнтэй мэргэжилтэн болгон хүмүүжүүлэх, найдвартай, итгэл даах алба хаагчийг тогтвор суурьшилтай ажиллуулах удирдах албан тушаалтны үүрэг оролцоо хамгаас чухал байдаг. Өөрөөр хэлбэл, удирдах ажилтны манлайлал, ёс зүй, ажлын арга барил, зөв үлгэр дуурайлал нь шинээр томилогдсон алба хаагчийн албандаа хандах хандлага, байнгын хөгжиж

This article is published under the Creative Commons BY-NC-SA License by 4.0, ©2025 University of Internal Affairs, Mongolia

мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэх, сахилга, ёс зүй, хариуцлагаа өндөржүүлэхэд харилцан хамааралтай хүчин зүйл болдог.

Эрх зүйн үндэслэлээс дурдвал “Алсын хараа-2050”-ын урт хугацааны хөгжлийн бодлогын 5.4-т “мэргэшсэн, чадварлаг, ухаалаг төрийн албыг төлөвшүүлэх”, 7.4-т мэргэшсэн чадварлаг хүний нөөцийг бэлтгэх талаар тус тус тусгагдсан бол төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын бодлогын баримт бичгүүдэд мэдлэг, чадвартай боловсон хүчнээр хангах, алба хаагчдын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл, сэтгэл ханамж, нийгмийн баталгааг сайжруулахад анхааран ажиллах талаар, Төрийн албаны тухай хуулийн чадахуйн болон шатлан дэвших зарчим зэрэг нь удирдах бүрэлдэхүүний ур чадварыг дээшлүүлэх эрх зүйн үндэслэл болж байна.

Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын хувьд залуу алба хаагчдыг ажилд суран дадлагажих, арга барил олох, мэдлэг, чадвар, хандлага нь цаашдын ажлын үр дүнг тодорхойлдог нь удирдлагын манлайлал, зааварчилгаа, зөв үлгэр дуурайлал голлох нөлөө үзүүлдэг. Тиймээс удирдах бүрэлдэхүүний манлайлал, үүрэг, оролцоо нь зөвхөн захиргааны албан тушаалтнаар буюу удирдах бүрэлдэхүүнээр хязгаарлагдахгүй, харин шинэ үеийн албаны үнэт зүйлийг төлөвшүүлэх, мэргэжлийн чадвар, ёс суртахууны дархлааг бий болгоход чиглэгдэж байвал илүү үр дүнтэй юм.

Судалгааны зорилго нь удирдах бүрэлдэхүүний манлайллын нөлөөллийг судалж, чадварлаг боловсон хүчин бэлтгэх, тэднийг сурган дадлагажуулахад чиглэсэн оролцоо гүйцэтгэх үүргийг тодорхойлох, бусад орны сайн туршлагыг судлах явдал юм.

Удирдах бүрэлдэхүүн, албан тушаалтны манлайллын мөн чанар. Орчин үед байгууллагын өмнө тавьсан зорилгод хүрэх, хамт олныг удирдан чиглүүлэх хийгээд байгууллагын хөгжилд удирдах ажилтны зүгээс бусад хүмүүст нөлөөлөх чадварыг манлайлал (Н.Батхүрэл, Г.Шуурав, 2006) гэж, “Монгол хэлний тайлбар толь бичиг”-т “Манлайлал нь алсын хараа, удирдан чиглүүлэх ухаан бусдын итгэл үнэмшлийг олж авах шид, байлдан дагуулах урлаг юм” (Я.Цэвэл, 2013), “Манлайлал бол бусдад нөлөөлөх чадвар, хүн, байгууллага, бүлгийн өмнө тавигдсан зорилго зорилтыг хэрэгжүүлэх хүсэл тэмүүллийг бий болгох урлаг” (Н.Батхүрэл, Г.Шуурав, 2006) гэж тус тус тодорхойлсон байна.

Удирдлагын манлайлал нь байгууллагын соёл, стратегийн зорилго, хүний нөөцийн хөгжилтэй нягт уялдаатай байдаг. Тэгвэл манлайлал гэдэг нь ёс зүй, итгэл үнэмшил, үнэнч шударга байдал, мэдлэг, шийдвэр гаргах чадвараар илэрч бусдыг зорьсондоо хүрэхэд нөлөөлөх үйл явц гэж болох юм.

Америкийн сэтгэл судлаач А.Бандурагийн “Social Learning Theory”–д хүмүүсийн зан үйлийн төлөвшил нь бусдын үйл хандлагыг ажиглаж, дуурайх, туршлагаас суралцах замаар бий болдог (A, Bandura, 1977) гэж үзсэн нь удирдах бүрэлдэхүүний үлгэр жишээ нь манлайллын ач холбогдлыг тодотгодог.

Түүнчлэн Д.Колбын “Experiential Learning Theory” буюу туршлагад суурилсан сургалтын онолоор суралцах үйл нь “туршлага – эргэцүүлэл – онолын ойлголт – туршилт” гэсэн дөрвөн үе шаттайгаар явагддаг гэж үздэг (D., Kolb; E, Wenger; J, Lave, 1991). Энэ нь шинээр томилогдсон алба хаагчдыг бодит нөхцөлд туршлагажуулах, удирдах бүрэлдэхүүний менторын үүргийг чухалчилдаг.

Чадварлаг хүний нөөц бэлтгэх шаардлага. Чадварлаг хүний нөөцийг бэлтгэх нь байгууллагын тогтвортой байдлын баталгаа юм. Хүний нөөцийн залгамж халааг бэлтгэхгүй бол хэвийн үйл ажиллагаа алдагдах улмаар байгууллагын туршлага, соёл, үнэт зүйл тасрах эрсдэлтэй байдаг. Хүний нөөц мэдлэг, чадвартай байхын зэрэгцээ хүмүүнлэг харилцаатай, мэргэжлийн ѐс зүйтэй, хувь хүний ѐс суртахуунтай байх асуудал ихээхэн чухлаар тавигдаж байна.

Жин Лаве, Этьен Венгер нарын “Situated Learning Theory”-д сургалт бол орчиндоо суурилсан, хамтын оролцоогоор

явгддаг (A, Bandura, 1977) гэж тодорхойлсон нь байгууллагын дотоод харилцаа орчны чухлыг харуулдаг.

Энэ утгаараа сурган дадлагажуулагч нь залуу алба хаагч нартай хамт үүрэг гүйцэтгэх, бодит нөхцөлд шийдвэр гаргах үйлд хамруулах замаар тэдний хөгжлийг дэмждэг.

Монголын судлаач Г.Батболд "Залуучуудын мэргэжлийн сургалт, дадлагажуулах чиг хандлага" бүтээлдээ дадлагын үйл ажиллагаа нь залуу ажилтны мэргэжлийн туршлагыг төлөвшүүлж, байгууллагын залгамж чанарыг хадгалахад чухал гэж үзсэн (Г.Батболд, 2021). Мөн Д.Нарантуяа "Сургалт, дадлагын гүүрэн үүрэг ба багшийн манлайлал" бүтээлдээ дадлага нь онол ба практикийн хоорондын гүүр болохын зэрэгцээ хүний төлөвшлийн орон зай (Д. Нарантуяа, 2020) гэж онцолсон.

Залуу үеийг төлөвшүүлэхэд, удирдах бүрэлдэхүүний үүрэг, оролцоо. Ёс зүй, үнэт зүйл дамжуулах нь удирдах бүрэлдэхүүний хамгийн чухал үүрэг бөгөөд эх оронч үзэл, тангарагтаа үнэнч байх, шударга ёсыг дээдлэх хандлагыг залуу үедээ төлөвшүүлэхэд оршдог. Энэ нь өөрийн үйл хандлагаар зөвхөн заавар, зөвлөгөө өгөх бус, үлгэр жишээ үзүүлэх замаар хэрэгждэг.

1. Удирдах бүрэлдэхүүн нь тухайн байгууллагын туршлагын сан бөгөөд тэд бодит нөхцөлд ажиллах арга барил, шийдвэр гаргах арга зүйг дадлагажуулж, алдаа онооны жишээгээр дамжуулан залгамж үеийг төлөвшүүлдэг.

2. Ментор буюу чиглүүлэгчийн үүрэг нь залуу алба хаагчдад зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх, чадвар хөгжүүлэх орчныг бүрдүүлэхэд чиглэнэ. Энэ нь "туршлагаас суралцах" орчинд хөтөлдөг.

3. Удирдлагын хандлага, зан төлөв нь хамт олны эерэг болон сөрөг уур амьсгалд хүчтэй нөлөөлдөг. Шударга, хариуцлагатай удирдлагын төлөв байдал нь залгамж үеийн итгэлцэл, идэвх санаачилгыг нэмэгдүүлдэг.

Сурган дадлагажуулах үйл ажиллагааны онол, арга зүй. Залгамж үеийг бэлтгэх, сурган дадлагажуулах үйл явц нь зөвхөн сургалтын хөтөлбөрөөр хязгаарлагдахгүй. Олон улсын судалгаагаар туршлагатай алба хаагч өөрөө мэргэжлийн туршлагаа хуваалцаж, өдөр тутмын ажлын орчинд залуу ажилтантай харилцах нь мэдлэгийг үр дүнтэйгээр дамжуулах, хандлага төлөвшүүлэх суурь болдог гэж үздэг (Max Mustermann, 2025).

Эндээс ментор буюу сурган дадлагажуулагч гэдэг нь туршлага мэдлэг хуримтлуулсан хүн өөрөөсөө залуу, туршлага дутуу хүнд зөвлөх, чиглүүлэх, сургах, дэмжих үүрэгтэй хүнийг хэлдэг. Туршлагатай алба хаагч, удирдах албан тушаалтан бүр ментор байж чаддаггүй. Учир нь "Ментор"-т дараах шаардлага тавигдах бөгөөд тухайн байгууллагын соёлоос хамааражаад бага зэрэг ялгаатай байдаг ч ерөнхийдөө дараах үндсэн шалгуурыг хангасан байвал зохистой гэж үздэг.

- мэргэжлийн мэдлэг туршлага;
- харилцааны ур чадвар;
- ёс зүй ба итгэлцэл;
- хөгжлийн сэтгэлгээ, манлайллын шаардлагыг бүрэн хангасан туршлагатай алба хаагч, удирдах албан тушаалтан байвал үр дүнтэй гэж үздэг.

Менторыг үр дүн, харилцаа, ѐс зүй, суралцагчийн сэтгэгдэл гэсэн 4-н багцаар үнэлэх нь хамгийн бодитой арга юм.

2024-2025 онд шинээр алба хаагчдаас авсан санал асуулга, ярилцлагаар дараах хүндрэлтэй асуудлууд илэрсэн. Үүнд:

- мэргэжлийн чадвартай алба хаагч нарыг сурган дадлагажуулагчаар томилдоггүй;
- зарим алба хаагчдын хувьд зан харилцааны соёл, хандлагын доголдолтой байдаг;
- залуу алба хаагчдад ментороо өөрсдөө сонгох боломж олгодоггүй;
- дадлагын эхний хугацаанд мэдлэггүй, 3 сарын хугацаанд ч ажлын талаар бага зэргийн ажлын дадал суудаг;
- ойлгомжгүй шаардлага тавих, загнах нь харилцааны зөрчил үүсгэж алба хаагчдын сэтгэл ханамжид сөргөөр нөлөөлж гэж хариулсан байна.

Үүнээс харахад Менти буюу залуу алба хаагч ментороо өөрөө сонгодог тогтолцоог бий болох зайлшгүй шаардлага үүсээд байна.

Эдгээр нь залуу алба хаагчдыг сурган дадлагажуулах үйл явцад тодорхой саад болж, хүний нөөцийн тогтвортой хөгжилд эрсдэл үүсгэж болохоор байна.

Менторын хамгийн гол асуудал нь ажилдаа дасан зохицох хугацаанд нь /хамгийн багадаа 3-6 сар/ зааж зөвлөх, дэмжлэг туслалцаа үзүүлэх нь хүний нөөцийг тогтвортой байдлыг хангах, хөгжүүлэх, байгууллагын соёлыг төлөвшүүлэх замаар залгамж үеийг бэлтгэх явдал юм.

Залуу алба хаагчдын сэтгэлгээний онцлог нь тэдний нас, хүйс, нийгмийн орчин, боловсролын түвшин, технологийн хөгжил, хувь хүний харилцааны хэв маяг зэрэг олон хүчин зүйлсээс хамаарч харилцан адилгүй байгаа боловч дараах нийтлэг шинжийг агуулж байна.

Шинэ санаа, өөрчлөлтөд нээлттэй байдал: Залуус шинэ технологи, арга барилд хурдан дасан зохицож, байгууллагын дотоод процессыг сайжруулах, шинэчлэл хийхэд санаачилгатай, хуучинсаг арга барил, тогтсон хэв маягийг шүүмжилж, илүү үр дүнтэй хувилбаруудыг эрэлхийлж байна.

Тусгаар тогтнол, эрх чөлөөг эрхэмлэх хандлага: Шийдвэр гаргах, өөрийн санаа бодлыг илэрхийлэхэд бие даасан байдлыг чухалчилж, захирагч төвтэй, тушаалын дагуу ажиллах соёлд шүүмжлэлтэй хандах тохиолдол гаргаж байна.

Харилцаанд шууд, илүү нээлттэй: Асуудлыг нээлттэй, шууд илэрхийлэх, санал солилцох соёлыг илүүд үзэж, дээд, доод шатны харилцаанд "албаны" гэхээс илүү "хамтрагч" маягийн хандлага гаргах нь түгээмэл байна.

Хурдан сэтгэх, хурдтай ажиллах эрмэлзэлтэй: Тэвчээр багасаж, хурдан үр дүн хүлээж, удаан процесс, шат дамжлагатай шийдвэр гаргалт тэдэнд саад болдог.

Ажлын ба хувийн амьдралын тэнцвэрт байдлыг чухалчлах. Илүү уян хатан цагийн хуваарь, алсын зайнаас ажиллах боломжийг хүсэж, ажлаас гадуурх хөгжил, амралтыг чухалчилдаг.

Үнэт зүйлд суурилсан хандлага: Байгууллагын үнэт зүйлс, нийгмийн хариуцлага, ил тод байдалд ач холбогдол өгч, зорилго, утга учиртай ажиллах хүсэлтэй.

Технологид түшиглэсэн сэтгэлгээ. Дижитал орчинд өссөн тул мэдээлэл боловсруулах, асуудал шийдэхэд технологийг идэвхтэй ашиглаж, гар утас, интернэт, программ хангамжийн хэрэглээ өндөр гэх зэрэг шинжийг агуулсан байдаг.

Удирдах албан тушаалтны үндсэн үүрэг нь зөвхөн ажлын гүйцэтгэлийг удирдах бус, залуу алба хаагчийг ажил мэргэжлийн болон èс зүйн хувьд төлөвшүүлэхэд оршдог.

Чиглүүлэх, зөвлөгөө, менторчлол, дадлагажуулах зэрэг олон талын үйл ажиллагаа нь тэдний ажлын ур чадварыг нэмэгдүүлж, байгууллагад хурдан уусах боломжийг бүрдүүлдэг.

Гадаад зарим орны залгамж үеийг бэлтгэж буй өнөөгийн нөхцөл байдал. ОХУ, БНХАУ, БНСУ, Япон улсын төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллага нь “залгамж үе” бэлдэхэд төрөл бүрийн механизм, институт ашиглаж байна. Тэдгээрийн зарим онцлог, арга замуудын харьцуулж үзвэл:

Оросын Холбооны Улс: Залуу үе бэлтгэхэд дараах гол механизм, институтүүдийг ашигладаг байна.

1. “Юнармия” 2015 онд анх байгуулагдсан бөгөөд залуучуудад эх орондоо хайртай байх, төр ард түмэндээ үнэнч байх, хүүхэд, өсвөр насныханд эх ороно үзэл, цэргийн соёл, төрийн үнэт зүйлийг төлөвшүүлэх байдлаар цэргийн хэрэглээний суурь чадвар олгохоор сургалтыг явуулж байна.

2. Кадет сургууль, кадет корпус гэсэн бүтэцтэй боловсролын тогтолцоог ашиглаж байна. Энэ тогтолцоо нь ирээдүйн, хууль сахиулагчид, төрийн алба хаагчдын урьдчилан бэлтгэдэг.

3. Сургуулийн хичээлийн системд эх орондоо хайртай байх, төр ард түмэндээ үнэнч байх үзэл, оюун санааны боловсрол,

цэрэг-спортын бэлтгэл зэрэг агуулга оруулдаг.

Эдгээр механизмуудыг ашиглан ОХУ залуучууд болон өсвөр насныханд төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын үйл ажиллагааны системд урьдаас таниулах, “соѐл, итгэл үнэмшил, сахилга бат” уламжлуулах замаар залгамж үе бэлтгэхийг эрмэлздэг.

Бүгд Найрамдах Хятад Ард Улс: Залуу үеийн бэлтгэлд цэрэг, хууль сахиулах чиглэлд бодлого, сургалт, байгууллагаар дамжуулан системтэй ажилладаг. Зарим гол арга, механизм:

1. Цэрэгжүүлсэн сургалттай бага, дунд их сургуулиудад сурагч, оюутнуудыг эхний жилд цэрэг-спортын бэлтгэл сургалтууд хийлгэх жишиг түгээмэл байдаг. Энэ нь сурагчдад эх оронч үзэл төрүүлэх, үндэсний батлан хамгаалах чадварын ойлголтыг багаас нь өгөх зорилготой.

2. Патриотизм, улс төрийн үзэл санаа, коммунист намын үзэл суртал, түүх заахыг чухалчилдаг.

3. Алба хаагчдыг мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэх, ахлах удирдах албанд бэлтгэхэд зориулсан хууль сахиулах болон армийн сургуульд суралцуулж байна. Олон улсад хууль сахиулахад мэргэшсэн албан тушаалтан бэлтгэх сургалтын төсөл хэрэгжүүлж байна.

4. Хятад улс бэлтгэл үзэл суртал мэргэжлийн сургууль, академи гэсэн гурван чигт төвлөрсөн бодлого, институтийн зохион байгуулалттай ажиллуулдаг.

Бүгд Найрамдах Солонгос Улс: Цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын залуу үе бэлтгэх систем тогтсон. Гол онцлогууд нь:

1. Korea Military Academy (KMA) нь БНСУ-ын армийн офицерын сургалтын гол академи юм. Korea Army Academy at Yeongcheon (KAAY), Удирдах албан тушаалд бэлтгэх академи, бакалаврын зэрэгтэйгээр офицерын зэрэг олгодог.

2. Korean National Police University (KNPU) хууль сахиулах салбарын удирдах албан хаагч бэлтгэхэд чиглэсэн их сургууль. Суралцагчид онол, практик, дадлага зэргүүдийг хослуулдаг.

3.Шинэ албан хаагчдыг “Central Police Academy” сургуулиар бэлтгэж, дараа нь албадын дэд ангиудаар дадлагажуулах системтэй.

4. Сурагчдад хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаа, хууль, ѐс зүйн ойлголтыг танилцуулах сургалтууд ерөнхий боловсролын сургуулийн түвшинд байдаг.

Япон Улс: Энгийн цэрэг хүчинтэй биш “Өөрийгөө хамгаалах хүчин” (Self-Defense Forces, SDF) тул түүний залгамж үе бэлтгэх арга барил нь зарим талаараа онцлогтой:

1. Төрийн сургууль, академи дотор цэргийн сургалт, офицерын сургалттай академитай бөгөөд сурагчид дөрвөн жил суралцаж, цэргийн болон академик сургалт авдаг. Академийн сургалтын хугацаанд долоо хоног бүр 2 цагийн анхан шатны талбайн сургалт (basic field training) заадаг. Мөн жилд 6 долоо хоногийн эрчимтэй сургууль (интенсив тренинг) явуулдаг.

2. Цэрэг-тусгай техник сургалтын программ Cadet-уудын хувьд бусад оюутнуудтай адил суралцаж байх үедээ цэрэг техникийн, командлах чадвар, тактикийн ойлголтуудыг суралцаж, практик дадлагатай болдог.

3. Бага түвшний “cadet” хөтөлбөр болон залуусын оролцоо Японд бага насны сурагчдад зориулсан “cadet-like” техник сургах хөтөлбөр эсвэл “junior survival school” зэрэг бүлэг, клуб маягийн ангиуд үйл ажиллагаа явуулдаг. Гэхдээ тэдгээр нь цэргийн албаны шууд бэлтгэл биш, сургах, сахилга бат, байлдааны чадвар биш ч зохион байгуулалттай сургалтууд юм.

4. Япон улсад сүүлийн жилүүдэд цэрэгт элсэх хүний тоо хангалттай биш байгааг хүлээн зөвшөөрч, элсэлтийн сурталчилгаа, нийгмийн хөнгөлөлт, ажиллах нөхцөлийг сайжруулах бодлого хэрэгжүүлж байна.

Монгол Улсад сайн туршлагыг нутагшуулах, санал боловсруулах

БНХАУ, БНСУ, ОХУ, Япон улсын залгамж үеийг бэлтгэх сайн туршлагыг нутагшуулснаар Монголын төрийн

цэргийн болон хууль сахиулах байгууллагын хүний нөөцийн чанар, манлайллын залгамж, байгууллагын соёлын тогтвортой байдал үлэмж хэмжээгээр сайжрах боломжтой гэж судлаачийн зүгээс үзэж байна. Үүнд:

Удирдлагын залгамж чанар, манлайллын тогтвортой байдал сайжирна.

Солонгос, Япон улсын адил шатлалтай академи, дадлага, мэргэжлийн сургалт бүхий систем нутагшвал:

Ахлагч, офицеруудын албан тушаал ахих, мэдлэгээ үе шаттай гүнзгийрүүлэх бүтэц бий болно.

Байгууллагын удирдлагаас гүйцэтгэх албан тушаалтан хүртэл нэг үзэл, нэг үнэт зүйлтэй манлайллын залгамж гинжин хэлхээ бүрэлдэнэ. Өөрөөр хэлбэл, удирдах ажилтнуудын шийдвэр гаргах чадвар, бодлогын нэгдэл бэхжиж, байгууллагын зорилго, соёл, үнэт зүйл үеэс үед тасралтгүй хадгалагдана. Мэргэжлийн ур чадвар, сахилга бат, ёс зүйн түвшин дээшилнэ.

Япон, Солонгосын сайн жишгээр академик, дадлагын хосолсон сургалт нэвтрүүлбэл: нэгдүгээрт, Алба хаагч бүр бодит нөхцөлд ажиллах чадварт сургалтын үеэс эзэмшинэ. Хоёрдугаарт, ёс зүй, сахилга бат, хамтын ажиллагааг төлөвшүүлэх боломж бүрдэнэ. Өөрөөр хэлбэл, алба хаагчдын ажлын гүйцэтгэл, хариуцлага, ёс суртахуун дээшилж, байгууллагын нэр хүнд, олон нийтэд итгэх итгэл нэмэгдэхээс гадна алба хаагчийн эх оронч үзэл, байгууллагын соёлын залгамж чанар бэхэжнэ.

Хятад, Оросын адил патриотизм, үндэсний үнэт зүйлийг багаас нь төлөвшүүлэх хөтөлбөр хэрэгжүүлбэл: Залуучууд төрийн тусгай албанд ажиллах итгэл, үнэмшилтэй болно. Мөн эх оронч, сахилга баттай, албан хаагчийн төлөвшил бий болно. Нөгөөтээгүүр, Төрийн байгууллагын дотоод үнэт зүйл, тангарагтаа үнэнч байх хандлага тогтвортой болж, шинэ үеийн албан хаагчид байгууллагыг үргэлжлүүлнэ.

Сургалт, дадлагын үр нөлөөтэй , бодит системтэй болох хүрээнд Японы National Defense Academy, Солонгосын KNPU, KMA шиг бүтэцтэй академийн сургалт нэвтрүүлснээр: нэгдүгээрт, онол ба дадлагын хослол, мэргэжлийн чиглэлээр тасралтгүй хөгжих сургалтын экосистем бүрдэнэ. Дараагийн дугаарт туршлагатай алба хаагч, залуу мэргэжилтэн хооронд менторшип, дадлага хөтөлбөр бий болно. Өөрөөр хэлбэл, шинэ үеийн ажилтнууд бодит нөхцөлд хурдан дасан зохицдог, сургагч багш, ахмад үеийн туршлага системтэйгээр дамжина.

Хүний нөөцийн сонгон шалгаруулалт, урамшуулал ил тод болгох хүрээнд Солонгосын карьерын шаталсан шалгалтын систем, Японы үнэлгээний ил тод загвар зэргийг хэрэгжүүлснээр: нэгдүгээрт, Залуу үе мэдлэг чадвар, үр дүнгээрээ өсөх боломжтой болно. Хоёрдугаарт, Танил тал, арын хаалга, албан тушаал наймаалахаас илүү мерит зарчим (чадвараар дэвших зарчим) хэрэгжих нөхцөл бүрдэнэ. Өөрөөр хэлбэл, шударга, тэгш, урамшуулалтай ажиллах орчин бүрдэж, залуучуудын төрийн албанд ажиллах сонирхол нэмэгдэнэ.

Олон улсын хамтын ажиллагаа, туршлага солилцох чадавх нэмэгдүүлэх хүрээнд Солонгос, Япон, Хятад улсын адил хамтарсан сургалт, солилцооны хөтөлбөрүүд хэрэгжүүлбэл нэгдүгээрт, Алба хаагчид дэлхийн түвшний стандартад нийцсэн мэдлэг, ур чадвартай болно. Нөгөөтээгүүр, бүс нутгийн аюулгүй байдал, хамтын ажиллагааны сүлжээнд нэвтрэх боломж, Монгол идэвхтэй оролцоно.

Дүгнэлт

Залуу үеийг бэлтгэх, сурган дадлагажуулах үйл явц нь байгууллага, хүний нөөцийн бодлого, соёл, цаашлаад улсын хөгжилд шууд хамааралтай стратегийн ач холбогдолтой асуудал юм.

Удирдах бүрэлдэхүүний манлайллын ур чадвар, харилцааны соёл, зөв үлгэрлэл нь залуу ажилтанд үзүүлэх дэмжлэг, чиглүүлэг нь тухайн алба хаагчийн ажил мэргэжлийн төлөвшил, ёс зүй, үнэт зүйл, урам зоригт шууд нөлөөлж байна.

Алба хаагчийг сурган дадлагажуулах нь институтийн бодлогоор дэмжигдэхгүй, ихэвчлэн удирдлагын санаачилга, хувийн туршлагаас хамаарч байгаа нь залуу ажилтны хөгжилд тогтворгүй байдал үүсгэж байна.

Удирдах бүрэлдэхүүний манлайлал нь мэдлэг, туршлагаа залуу алба хаагчтай хуваалцан, тэднийг төлөвшүүлэх, чиглүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

БНСУ, ОХУ, БНХАУ, Япон улсын туршлагаас харахад менторын тогтолцоо, сургалт, системтэй хөгжлийн арга барилуудыг Монгол улсад нутагшуулах шаардлагатай байна.

Залуу ажилтнууд зөвхөн мэргэжлийн мэдлэг төдийгүй ажлын уур амьсгал, итгэлцэл, хамт олны урамшуулалд өндөр ач холбогдол өгч байгаа тул удирдах бүрэлдэхүүн энэ тал дээр онцгойлон анхаарах шаардлагатай.

Иймд удирдлага, туршлагатай алба хаагчийг зөвхөн “ажлын чиглүүлэгч” бус, харин “сурган хүмүүжүүлэгч, манлайлагч” гэж үзэх нь зүйтэй. Тэд залуу алба хаагчдад мэргэжлийн чадвар, дадал, ѐс суртахуун, хамтын ажиллагааны соёлыг өвлүүлж өгснөөр байгууллагын тогтвортой хөгжил, цаашлаад улсын аюулгүй байдалд чухал хувь нэмэр оруулах боломжтой юм.

Санал

1. Алба хаагчдыг менторын сургалтад хамруулах, туршлага солилцох тогтолцоог бэхжүүлэх:

Удирдлага бол байгууллагын туршлага, мэдлэг, манлайллын үнэт нөөц юм. Тэдгээрийн хуримтлуулсан туршлага, удирдах арга барилыг залуу үеийн алба хаагчид хуваалцах нь мэдлэгийн үргэлжлэл, алдаа давтахгүй байх, байгууллагын соёл уламжлагдах үндэс суурь болдог.

Хэрэгжүүлэх арга зам:

• Менторшип хөтөлбөр бий болгох,

• Сарын болон улирлын туршлага хуваалцах уулзалт, цуврал лекц, кейс хэлэлцүүлгүүдийг зохион байгуулах.

• Менторын ур чадварын сургалт зохион байгуулж, туршлагатай алба хаагчийн багшлах, чиглүүлэх чадавхыг нэмэгдүүлэх.

Хүрэх үр дүн:

• Мэдлэг, туршлага үр дүн, хүний нөөц, тогтвор суурьшилтай алба хаагч төлөвшинө.

• Хамт олны уялдаа холбоо, байгууллагын эерэг уур амьсгал бүрдэнэ.

• Шинэ залуу алба хаагчдын төлөвшил, хандлага, сэтгэл ханамж нэмэгдэнэ.

2. Залуу үеийг төлөвшүүлэх бодлогыг байгууллагын стратеги төлөвлөгөөнд тусгах: Залуу үеийг зөв бэлтгэхгүй бол удирдлагын вакум үүсэж, байгууллагын үйл ажиллагаа тасалдах, хэвийн үйл ажиллагаа алдагдах, чанар буурах эрсдэлтэй. Тиймээс урт хугацааны хүний нөөцийн төлөвлөлт, залгамж үеийн хөгжлийг стратегийн түвшинд тусгах шаардлагатай.

Хэрэгжүүлэх арга зам:

• Тухайн албан тушаалын боловсруулах шугам (career path) гаргах.

• Ирээдүйн манлайлагчдыг тодорхойлох, тусгайлсан хөгжлийн хөтөлбөрт хамруулах.

• Манлайллын үнэлгээ, ур чадварын сорил ашиглан ирээдүйн удирдагчдыг илрүүлэх.

Хүрэх үр дүн:

• Удирдлагын залгамж тасалдахгүй.

• Чадварлаг боловсон хүчний ур чадвар, төлөвшил зорилготой хөгждөг.

• Байгууллагын стратеги хэрэгжилт тууштай, тогтвортой үргэлжилнэ.

3. Ёс зүй, эх оронч үзэл, байгууллагын үнэт зүйлсийг сургалтын агуулгад тусгах: Мэргэжлийн ур чадвар хангалттай ч ѐс зүй, хандлага, үнэт зүйлсгүй бол байгууллагын соёлд сөрөг нөлөө үзүүлдэг. Тиймээс сургалтын агуулгад зөвхөн техникийн биш, ѐс суртахуун, эх оронч үзэл, байгууллагын үнэт зүйлийг шингээх хэрэгтэй.

Хэрэгжүүлэх арга зам:

• Сургалтын хөтөлбөрт ѐс зүйн кейс, бодит жишээнүүд оруулах.

• Үнэт зүйлсийн сургалт, түүхэн бахархалт уламжлалыг сурталчлах, сургалтын агуулгад тусгах.

Хүрэх үр дүн:

• Алба хаагчдын èс зүйн хандлага сайжирна.

• Байгууллагын нэр хүнд нэмэгдэж, алба хаагчдын итгэл үнэмшил нэмэгдэнэ.

• Нэгдмэл үнэт зүйл, соёлт, ухамсартай хамт олон бүрэлдэнэ.

Хүний нөөцийн хөгжлийг цогцоор нь дэмжих, байгууллагын стратеги, соёлыг улам бататгах, үр өгөөжтэй тогтолцоог бий болгоход чухал үүрэгтэй юм. Хэрэгжилт нь зөвхөн сургалтаар хязгаарлагдахгүй бөгөөд манлайлал, үнэт зүйлс, системийн өөрчлөлт, урамшууллын бодлоготой уялдах шаардлагатай.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

A, B. (1977). Social Learning Theory. Englewood Cliffs, NJ: Prentice-Hall. .

A, Bandura. (1977). Social Learning Theory. Englewood Cliffs, NJ: Prentice-Hall.

D., Kolb; E, Wenger; J, Lave. (1991). Experiential Learning: Exerience as the Source of Learning and Development. Englewood Cliffs, : Prentice-Hall, Situated Learning: Legitimate Peripheral Participation. New Jersey: Cambridge University Press.

Max Mustermann. (2025, 11 10). researchgate. Retrieved from www.researchgate.net: www.researchgate.net

А.Ганбаатар, Я.Шуурав, Д.Сэржамц. (2017). Менежмент. Улаанбаатар.

Г.Батболд. (2021). Залуучуудын мэргэжлийн сургалт, дадлагажуулалтын чиг хандлага. Улаанбаатар.

Д. Нарантуяа. (2020). Сургалт, дадлагын гүүрэн үүрэг ба багшийн манлайлал. Улаанбаатар.

Н.Батхүрэл, Г.Шуурав. (2006). Менежмент. Улаанбаатар хот.

Я.Цэвэл. (2013). Монгол хэлний тайлбар толь. Улаанбаатар хот.

ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ОНОЛД СУУРИЛАН ХӨГЖҮҮЛЭХ НЬ

DEVELOPING CRIME PREVENTION WORK ON A THEORETICAL BASIS

Д.Зүмбэрэллхам
Хууль зүйн доктор, профессор
Zumberellkham D.
Ph.D in Law, professor

Хураангуй: Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагааг орчин үеийн чиг хандлагаар явуулж ирсэн түүхэн туршлагадаа ГХУСАЗЗ үүсэн байгуулагдсаны 60 жилийн ойг тэмдэглэх арга хэмжээг тохиолдуулан дүгнэлт хийж, цаашдын чиг хандлагаа тодорхойлох чухал арга хэмжээ болж байна. Манай улс коммунизмын үзэл суртлыг баримталж байсан социалист замналаас татгалзаж, ардчилсан хөгжлийн замыг сонгосноор хүн төрөлхтний хуримтлуулсан мэдлэг туршлагыг ямар нэгэн хязгаарлалт, хорио цээргүйгээр хуваалцах таатай боломж бүрдээд байна.

Abstract: In Mongolia, crime prevention activities have been implemented in accordance with modern trends, drawing upon accumulated historical experience. On the occasion of the 60th anniversary of the establishment of the Crime Prevention Council, this event constitutes a significant occasion to assess past achievements, draw conclusions, and determine future directions.

Following Mongolia's transition away from the socialist development path based on communist ideology and its choice of a democratic system, favorable conditions have been created for the unrestricted sharing and utilization of the knowledge and experience accumulated by humankind.

Түлхүүр үгс: Криминологи, онол, хөгжил, чиг хандлага, үзэл суртал, урьдчилан сэргийлэх.

Keywords: Criminology, theory, development, trends, ideology, prevention.

Марксизм ба радикал криминологийн онол

Энэ онол нь 20-р зууны ихэнх хугацаанд социалист орнуудын төрийн бодлогын үндэс суурь болж, хууль зүй, гэмт хэргийг тайлбарлах үндсэн арга барилыг тодорхойлж байв. Гэмт хэрэг бол зүгээр нэг гаж үзэгдэл бус, капиталист нийгэм дэх системчилсэн дарамт шахалтын эсрэг бодит хариу үйлдэл гэж үздэгээр марксизмын гол санаа илэрхийдэгддэг (Teng, 2025). Энэ онолд хуулийг капиталист нийгмийн дээд ангийн эрх ашгийг хамгаалдаг хэрэгсэл гэж үзэх бөгөөд хууль зөрчих нь заримдаа хувь хүний ёс суртахууны сул тал бус, харин системийн дарангуйллын эсрэг тэмцэл байдаг гэж үздэг. Ийм учир шалтгаанаар социалист хууль ёсны үүднээс хуулийг социалист төрийн бодлогын зэвсэг гэж тодорхойлж байв (Вышинский, 1948).

Социалист орнуудад, тэр дундаа ЗХУ болон түүний нөлөөллийн орнуудад Марксист онолыг хууль тогтоомж, шүүхийн тогтолцоо, гэмт хэрэг судлалд шууд тусган хэрэгжүүлж байсны нэг нь манай улс юм. Монгол Улс социалист нийгмийн тогтолцооны үед зөвхөн энэхүү үзэл баримтлалыг удирдамж болгон гэмт хэргийг хувь хүний асуудал гэхээс илүүтэй нийгмийн ангийн ялгаанаас шалтгаалах үзэл суртлын үүднээс судалж, ийм байдлаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлого, арга зүйгээ боловсруулж, хэрэгжүүлж ирсэн.

Коммунист үзэл суртал, түүнд нийцүүлсэн социалист эрх зүйн тогтолцооны үед хамгийн их хязгаарлагдмал ойлголтод хашигдаж байсан зүйлийн нэгэнд гэмт хэргийг ойлгох ойлголт, түүнээс урьдчилан сэргийлэх ажиллагаа тооцогдоно. Учир нь тэр үед

This article is published under the Creative Commons BY-NC-SA License by 4.0, ©2025 University of Internal Affairs, Mongolia

гэмт хэргийг марксизмд үндэслэсэн шүүмжлэлт радикал криминологийн онолыг дагнан судалж, энэ онолын үүднээс гэмт хэргийг тайлбарласан үзэл номлолоос өөр онолуудыг судалж, төрийн бодлого, үйл ажиллагаанд хэрэгжүүлэх явдал хориотой байсан. Хэдийгээр шинжлэх ухаанд криминологийн салбар үүсэж хөгжөөд маш олон онол, чиглэлүүд бий болсон байсан ч гэсэн тэдгээрийг зөвхөн капитализмыг зөвшөөрдөг нийгэмд зориулагдсан гэж үзэх, тэдгээрээс эрс татгалзах ёстой байлаа.

Тухайлбал, тэр үеийн МХЗЭ-ийн дүрэмд "...нийгмийн эрх ашгаас гажих, хэв журам зөрчих явдалтай эвлэршгүй тэмцэхийг залуу хүн нэг бүрийн үйл амьдралд мөрдлөг болгохыг зорьж, социализмд харш үзэл, зан заншил, хүмүүсийн ухамсар ахуйд үлдсэн бусдын хөдөлмөрийг завших, эд мөнгөнд шунах, амин хувиа бодох, эрх тушаал хөөцөлдөх, нүд хуурах зэрэг хуучин нийгмийн үлдэгдэл, хувийн өмчтөний үзэл санааны элдэв илрэлийн эсрэг эрс шийдвэртэй тэмцэх ажлыг бүхий л талаар өрнүүлэх" ёстойг онцлон дурдсан байдаг. Манай улсад гэмт хэргийг хуучин нийгмээс хүний ой ухамсарт үлдсэн бурангуй үзлээс үүдэлтэй гэж оношлоод социализм төгөлдөржихийн хэрээр үзэл алга болох ёстой, гэмт хэрэг ч байхгүй болно, тэр цагийг хурдан авчрахын тулд хамтаараа шийдвэртэй тэмцэх ёстой гэсэн үзэл, үүнд нийцсэн арга хэлбэрээр урьдчилан сэргийлэх ажлыг явуулж байсан түүх ард үлдээд 30 гаруй жил боллоо.

Гэхдээ 1970-аад оны дунд үе гэхэд радикал криминологи нь марксист, нийгмийн зөрчлийн болон шүүмжлэлт онолуудыг нэгтгэсэн онолын чиглэл болж төлөвшсөн бөгөөд нийгмийн бүтцийн шударга бус байдал, хууль тогтоох үйл явц дахь нийгмийн давхаргын давамгайлал, төрийн зохион байгуулалттай хүчирхийллийг гэмт хэргийн нэг хэлбэр гэж үздэг өнөөгийн шинэ чиглэл болон үргэлжилж байгааг тэмдэглэх нь зүйтэй (Reigel, 2025). Коммунизмын үзэл санааны улмаас хэт туйлшруулан удирдамжаа болгож байсан үзэл орчин үеийн нөхцөл байдалд нийсэн байдлаар шинэчлэгдэн хөгжих байгааг бид тооцохгүй байж болохгүй.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг орчин цагийн нөхцөл байдалд нийцүүлэн зохион байгуулж явуулахдаа энэ талаар хуримтлагдсан хүн төрөлхтний мэдлэгийн санг бүтээлчээр ажиглаж, криминологийн онол, чиглэлүүдийг системтэй судалж, үйл ажиллагаандаа өргөн хэрэглэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Криминологийн хөгжил ба гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга зүй

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудал нь криминологийн шинжлэх ухааны үндсэн судлагдахууны нэг билээ. Үүнийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд гэмт хэргийн үүсэлд нөлөөлөх шалтгаан, нөхцөлийг бодитой тодорхойлох нь туйлын чухал бөгөөд хүн төрөлхтөн энэ тухай ойлголтыг олон янзаар тайлбарлаж ирсэн нь өнөөдөр ч үргэлжилсээр байна.

Ойлголт нэг мөр бус байсны учир нь тухайн түүхэн цаг үеийн нийгмийн хөгжил, зохион байгуулалтын хэлбэр, амьдралын хэв загвар, нийтээр хүлээн зөвшөөрсөн соёл, эрх зүйн зохицуулалт зэрэг олон хүчин зүйлээс хамаарч байсан бөгөөд энэ нь криминологийн шинжлэх ухаанд өөр хоорондоо ялгаатай онол, чиглэлүүдийн бий болоход хүргэсэн. Гэсэн хэдий ч эдгээр ойлголтын зөрүү сүүлийн жилүүдэд багасах хандлагатай болж ирж байгаа нь гэмт явдлыг судлах эрдэм шинжилгээний үр дүнг даяаршлын орчинд өргөн хүрээнд хүртэх болсонтой холбоотой эерэг өөрчлөлт юм.

Криминологийн онолын уламжлалууд нь бүх цаг үед хуримтлагдсан мэдлэг дээр тулгуурлан үндсэндээ цөөн хэдэн асуудалд төвлөрдөг. Үүнд: гэмт хэрэг үйлдэгчид хууль зөрчихдөө өөрийн хүсэл зоригоос үл хамаарах хүчин зүйлийн нөлөөн дор үйлддэг үү; эсвэл нийгмийн зарим бүлэг хэсгүүд бүтэц, тогтолцооны хүчин зүйлээс шалтгаалан гэмт хэрэг үйлдэхэд түлхэгддэг үү; хүн ухамсарт чөлөөт сонголтоо хийсний үндсэн дээр өөрийн хүсэл зоригоор гэмт хэрэг үйлддэг үү; эсхүл төрийн эрх мэдэл, хууль

тогтоомжийн хүрээнээс тодорхой хэмжээнд хамаардаг уу гэх мэт асуултууд багтдаг.

Эдгээр асуултад олсон хариултын бодитой байдал нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын амжилтад шууд нөлөөлдөг учир энэхүү үзэгдлийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр судлах, олон улсын хэмжээнд хуримтлагдсан онолын мэдлэгийг практикт үр дүнтэй ашиглах нь улам чухал болсоор байна.

Иймд энэхүү илтгэлд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх онолын нийтлэг уламжлал, шинэчлэлийн чиг хандлага, Монгол Улсад авч хэрэглэх боломжийн талаар тусгахыг зорьсон болно.

I. Соён гэгээрлийн үе ба Сонгодог сургаал /XVIII зуун/

Европын соён гэгээрлийн үе нь хүний эрх, эрх чөлөө, байгалийн хууль болон рациональ үзэлд тулгуурласан эрх зүйн шинэчлэлийн эхлэлийг тавьсан эдийн засаг, улс төр, философийн өргөн өөрчлөлтийн зуун байв. Гэсэн хэдий ч энэ үед олон оронд абсолютизмын уламжлал, хатуу ял шийтгэл, тухайлбал шатаах, цаазлах, шоронгийн аймшигт нөхцөл зэрэг дундад зууны үлдэгдэл арга хэлбэрүүд хадгалагдсаар байсан бөгөөд эдгээрийг хүнлэг, хууль ёсны зарчимд нийцүүлэн шинэчлэх шаардлага тулгарчээ. Ийм нөхцөлд хүний эрх, эрх чөлөөний тухай философид тулгуурласан Беккариа, Бентам нарын үзэл санаа нь нийгмийн шинэчлэлийн онолын суурь болсон байна.

Сонгодог сургаалын гол төлөөлөгчдийн нэг Чезаре Беккариа /Итали/ өөрийн алдарт *“Гэмт хэрэг ба шийтгэл”* бүтээлдээ гэмт хэргийг хувь хүний рациональ сонголтын үр дүн гэж тайлбарлажээ. “Хэрэв гэмт хэргээс хүртэх ашиг нь шийтгэлийн цээрлүүлэлтээс их гэж тооцоолбол хүн түүнийг үйлдэхэд хүрнэ” (Beccaria, 1995) гэж тэрээр үзсэн байдаг. Тиймээс шийтгэлийн зорилго нь өшөө авах бус, харин нийгмийн гэрээг хамгаалах, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэх ёстой, шийтгэл хууль нийцсэн, зайлшгүй, зохистой байх ёстой, хууль тодорхой байх ёстой гэх зарчмууд нь хүний эрхийн олон улсын баримт бичгүүдэд тусгагдаж, өнөөгийн хууль тогтоомжийн үндсэн шаардлагуудын нэг болон төлөвшсөн.

Энэ сургаалын өөр нэг төлөөлөгч Иереми Бентам /Их Британи/ ютилитаризмын */utilitarianism/* үзлийг хөгжүүлсэн. Түүний онолын гол зарчим бол “хамгийн олон хүнд хамгийн их аз жаргалыг бий болгох” */“the greatest happiness of the greatest number”/* явдал (Bentham, 1907). Тэрээр хууль, бодлого, шийдвэр бүрийг гаргахдаа хүний амьдралд хэр их таашаал */pleasure/*, хэр их зовлон */pain/* авчрахыг тооцох ёстой гэж үзжээ. Хууль тогтоомж бол хүний зан үйлийг нийтлэг ашиг сонирхолд нийцүүлэх гол хэрэгсэл бөгөөд шийтгэл нь зөвхөн урьдчилан сэргийлэх, дахин гэмт хэрэг гарахаас хамгаалах зорилготой байх ёстой. Харин шийтгэл өөрөө нийгэмд илүү хор хохирол авчирвал ашиггүй, ёс суртахуунгүй гэж тэр дүгнэсэн нь өнөө цагт ч ач холбогдолтой хэвээр байна.

Ийнхүү Европын соён гэгээрлийн үеийн сэтгэгчид хууль цааз, шийтгэлийг хүний эрх ба байгалийн хуулийн зарчимд нийцүүлэхийг зорьсон нь тухайн үедээ орчин үеийн криминологийн суурь болсон сонгодог сургаалын */Classical School of Criminology/* эхлэлийг тавьсан бөгөөд энэ нь өнөөдөр дэлхийн олон улсын эрх зүйн тогтолцоонд уламжлал болон хөгжиж ирсэн.

II. Позитивизмын эрин /XIX зуун/

XIX зуунд позитивизм хүчээ авч гарч ирсэн нь тухайн үеийн нийгмийн хөгжлийн онцлогтой салшгүй холбоотой байлаа. Үйлдвэржилт, хотжилтын эрчимжилтээс улбаалан шинэ төрлийн гэмт хэрэг бий болж, шинжлэх ухаанд биологи, анагаах ухаан, статистикийн аргууд хүчтэй хөгжсөн бөгөөд социологийн шинжлэх ухааны суурь тавигдсан нь гэмт хэргийн судалгаанд шинэ эргэлт авчирсан байна.

Позитивизм гэмт хэргийг шалтгаант хамаарал бүхий нийгмийн бодит үзэгдэл гэж хүлээн зөвшөөрдөг. Энэ онолын үүднээс хүнийг зөвхөн рациональ сонголт хийдэг субъект гэж үзэхээс илүүтэйгээр, түүний зан авирыг биологийн, сэтгэлзүйн, нийгмийн хүчин зүйлсийн нийлбэр үр дүн

гэж тайлбарласан. Иймээс гэмт хэрэг нь хувь хүний ухамсраас гадна түүний бие махбодын онцлог, нийгмийн орчин, эдийн засгийн нөхцөл зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалдаг гэж үзсэн. Энэ утгаараа позитивизм нь сонгодог сургуулийн шууд эсрэг биш, харин түүнийг шүүмжлэн залгамжилсан шинжийг агуулдаг.

Чезаре Ломброзо /Итали/: хүний гавлын яс, нүүрний хэлбэр зэрэг биеийн онцлог шинжийг судлаад "Төрөлхийн гэмт хэрэгтэн бол эртний хүний болон доод амьтдын зэрлэг шинжийг өөртөө хадгалан илэрхийлж төрсөн оршихуй" (Lombroso, 1911) гэсэн дүгнэлтийг хийсний үндсэн дээр "Төрөлхийн гэмт хэрэгтэн" /born criminal/ гэдэг онолоо дэвшүүлсэн.

Раффаэле Гарафало /Итали/: Гэмт хэргийг "нийгмийн цээр /табу/ эвдсэн үйлдэл" гэж тодорхойлж, бүх нийгэмд хор уршигтай, нийтээр хориглодог үйлдэл /crimen naturale/ гэсэн ойлголтыг дэвшүүлсэн. Тэрээр гэмт хэргийг тухайн нийгмийн жирийн хүнд нийтлэг байдаг шударга ёс, энэрэн нигүүлсэхийн хүнлэг мэдрэмжийг доромжилдог ёс суртахуунд харш үйлдэл хэмээн тодорхойлсон (Garofalo, 1914).

Энрико Ферри /Итали/ бүтээлдээ гэмт хэрэг үйлдэгддэг учир шалтгааныг зөвхөн биологийн бус, эдийн засаг, нийгмийн хүчин зүйлсийн нийлбэрээр тайлбарласан. Тэрээр гэмт хэргийн шалтгааныг зөвхөн хувь хүний болон антропологийн бус, мөн байгалийн ба нийгмийн хүчин зүйлсээс хамааралтай бөгөөд гэмт хэргийн мөн чанарыг ойлгохын тулд эдгээрийг хамтад нь судлах шаардлагатай гэж тэмдэглэсэн (Ferri, 1917).

Эмиль Дюркхайм /Франц/ бүтээлдээ гэмт явдлыг нийгмийн зайлшгүй "хэвийн үзэгдэл" хэмээн тайлбарлаж, гэмт хэрэг бол хэвийн үзэгдэл, учир нь түүнээс ангид нийгэм оршин тогтнох боломжгүй...энэ нь зайлшгүй бөгөөд нийгмийн бүх амьдралын суурь нөхцөлтэй салшгүй холбоотой гэж дүгнэсэн (Durkheim, 1982).

Сонгодог сургаал "яагаад шийтгэх ёстой вэ?" гэсэн философийн асуултад төвлөрч байсан бол, позитивизм "яагаад гэмт хэрэг үйлдэгддэг вэ?" гэсэн шинжлэх ухааны асуултад хариулт хайсан юм. Позитивизм гэмт хэргийн тухай судалгааг философийн түвшнээс шинжлэх ухааны түвшинд авчирснаар орчин үеийн криминологийн судалгааны арга зүй, ялангуяа эмпирик судалгаа, статистик шинжилгээ, олон хүчин зүйлд тулгуурласан хандлагын үндэс суурийг тавьсан билээ.

III. Нийгмийн бүтцийн ба Шошгололын онол /XX зуун/

XX зууны дунд үеэс криминологийн онол нь хувь хүний зан чанар болон биологийн хүчин зүйлсийг онцлохоос гадна нийгмийн бүтцийн зохион байгуулалт, эрх мэдлийн харилцаа, нийгмийн хариу үйлдлийн механизмуудад төвлөрөх болжээ. Энэ чиглэлээр хоёр томоохон урсгал төлөвшсөн нь нийгмийн бүтцийн онолууд /*Social Structure Theories*/ болон шошгололын онол /*Labeling Theory*/ юм.

1. Нийгмийн бүтцийн онолууд

- **Нийгмийн дэг зохион байгуулалтын онол** /*Social Disorganization Theory*/: Клифорд Р. Шоу /АНУ/ болон Хенри Д. МакКей /АНУ/ нар Чикагогийн их сургуулийн судалгаагаар хотын тодорхой бүс нутагт гэмт хэрэг тогтвортой давтагддаг болохыг судалжээ. Тэдний дүгнэлтээр хөршийн хяналт буурах, гэр бүл, сургуулийн хүмүүжлийн нөлөө суларч, нийгмийн уялдаа алдагдсанаар гэмт хэрэг өсдөг гэсэн дүгнэлтэд хүрсэн байдаг (Clifford, 1942).
- **Нийгмийн зохион байгуулалт алдагдал ба нийгмийн дарамтын онол** /*Anomie/Strain Theory*/: Роберт К. Мертон /АНУ/ Дюркхаймын нийгмийн зохион байгуулалт алдагдлын улмаас гэмт хэрэг үйлдэх нөхцөл бүрддэг тухай "аномийн" ойлголтыг шинэчилж, нийгэм бүх хүнд ижил зорилго /жишээ нь эдийн засгийн амжилт/ тавьдаг ч түүнд хүрэх хууль ёсны боломжид тэгш бус байдал үүсэж боломж, зорилго хоёрын зөрчил үүссэнээс боломжгүй хэсэгт нийгмийн дарамт /страйн/ ирдэг тул зарим нь хууль бус аргыг сонгодог гэж тайлбарласан. Түүний бичсэнээр нийгэм нь зорилгод хүрэх хууль ёсны боломжийг тэгш олгохгүйгээр

амжилтыг дээдэлбэл зарим хэсэг нь гажуудлын шинжтэй шинэ арга замыг сонгодог байна (Robert, 1938).

- **Ерөнхий нийгмийн дарамтын онол** /*General Strain Theory*/: Роберт Агню /АНУ/ нийгмийн дарамтын эх үүсвэрийг зөвхөн зорилгод хүрэх боломжгүй байдалд бус, хүсэмж зорилгоос хоцрох, үнэ цэнтэй зүйлийг алдах, таагүй нөхцөлтэй нүүр тулах зэрэг гурван хүчин зүйлтэй холбон тайлбарлажээ. Энэ нь хувь хүний бухимдал, уур хилэнг нэмэгдүүлж гэмт хэрэг үйлдэх эрсдэлийг өсгөдөг гэж дүгнэсэн (Agnew, 1992).

- **Дэд соёлын онол** /*Subcultural Theories*/: Альберт К. Коэн /АНУ/ нийгмийн байр сууриас шалтгаалсан бухимдал /status frustration/ хэмээх ойлголтыг дэвшүүлж, боловсрол, ажил эрхлэлтийн боломж хязгаарлагдсан залуучууд өөрийн гэсэн дэд соёл бий болгож гэмт хэргийн замаар ордог гэж үзсэн (Cohen, 1955) бол Ричард А. Кловард /АНУ,/, Ллойд Э.Охлин /АНУ/ нар нийгмийн байр сууриас шалтгаалсан бухимдал тэр бүр гэмт хэрэг үйлдэх шалтгаан болохгүй, харин түүнээс гадна гэмт хэрэг үйлдэх боломж хаана их байгаа ялгаанаас хамааралтай байдаг гэсэн агуулгатай "боломжийн ялгаатай байдлын онол"-ыг /differential opportunity theory/ хөгжүүлж, гэмт хэргийн боломж хаана ямар байгаагаас шалтгаалсан дэд соёлын бүлэглэл үүсдэг гэж тайлбарласан (Cloward, 1960).

2. Шошгололын онол /*Labeling Theory*/

1960-аад оноос эхлэн криминологийн судалгаанд шошгололтын онол /*labeling theory*/ гэх шинэ чиглэл бий болсон. Энэ онол нь гэмт явдлыг зөвхөн хувь хүний зан чанар эсвэл нийгмийн бүтэц, эдийн засгийн хүчин зүйлсээр тайлбарлахад хангалтгүй бөгөөд харин нийгмийн хариу үйлдэл болон эрх мэдлийн хүрээнд гаргасан шийдвэрээр гэмтэн гэсэн зориудын нэршил бий болгон эд бараанд шошго хадах мэтээр хүнд албадан нялзаадаг /labeling/ нь гэмт явдал өсөхөд нөлөөлдөг гэсэн агуулгатай. Энэхүү онолд дараах чиглэлүүд гол байр суурь эзэлдэг.

- **Муугийн драматизаци /*Dramatization of Evil*/**

Фрэнк Танненбаумын /АНУ/ үзсэнээр өсвөр насныхны жижиг зөрчлийг олон нийтийн өмнө "муу хүн" гэж тодорхойлох нь тухайн хүнийг гэмт хэргийн замнал руу түлхдэг бөгөөд энэ нь "анхдагч" зөрчлийг "хоёрдогч" гэмт хэрэгт шилжүүлэх процессын эхлэл болдог байна (Tannenbaum, 1938).

- **Анхдагч ба хоёрдогч гажуудлын онол /*Primary and Secondary Deviance*/**

Эдвин Лемерт /АНУ/ шошгололын талаар гүнзгийрүүлэн судалж анхдагч гажуудлыг түр зуурын, нийгмийн ноцтой шошгололгүй үйлдэл; хоёрдогч гажуудлыг албан ёсны, нийгмийн шошголол дагалдсанаас хувь хүний өөрийн үнэлэжийн ухамсар /self-concept/ өөрчлөгдөх явдал гэж ялгаад ингэж шошголох нь гэмт хэрэгтэн болох үйл явцыг идэвхжүүлдэг гэж үзсэн (Lemert, 1951).

- **Шошгололтын үзэл баримтлал /*Labeling Perspective*/**

Ховард Беккер /АНУ/ гэмт зан үйлийн тухай ойлголтыг өөр талаас нь авч үзэж шинэчилсэн. Тэр бээр бүтээлдээ "Гаж авир гэдэг нь хүний үйлдлийн мөн чанарт бус, харин бусад хүмүүсийн бий болгосон дүрэм, хоригийг хэрэгжүүлж тухайн хүнд "гэмтэн" гэсэн шошгыг амжилттай наасны үр дүн юм" (Becker, 1963) гэсэн байдаг. Үүгээр гэмт хэрэгтэн болох үйл явц нь зөвхөн тухайн хүний үйлдэл бус, нийгмийн тодорхойлсон дүрэм, эрх мэдлийн тогтолцооны үр дүн гэдгийг Беккер дэвшүүлэн тавьсан бөгөөд гэмт хэрэг ба гаж авирын судалгааг хэм хэмжээ тогтоох эрх мэдэлтэй холбон тайлбарласан томоохон дэвшил байв.

- **Ялгаварлалын онол /*Stigma Theory*/**

Эрвинг Гофман /АНУ/ шошголол нь хувь хүний нийгмийн байр суурь, өдөр тутмын харилцаанд хэрхэн нөлөөлдгийг системтэйгээр судлаад "стигма" /*нийгмийн бүх төрлийн сөрөг үзэмж, ялгавартай хандлага*/ хэмээх ойлголтыг гаргаж, тодорхой нэг шинж /ял шийтгэлтэй байх, хөгжлийн бэрхшээл, угсаа гарал, бэлгийн

чиг баримжаа гэх мэт/ нь нийгмийн нүдэнд “сөрөг үзэмж” болон хувирч, тухайн хүнийг “ердийн” хүмүүсээс ялгавартай болгож харагдуулдаг гэж тайлбарласан (Goffman, 1963). Гофманы үзлээр ийм хүмүүс /stigmatized/ нийгмийн оролцоонд “адлагдах байдал”-тай /*spoiled identity*/ болж, ажил эрхлэлт, боловсрол, орон сууц зэрэг амьдралын чухал салбарт байнгын саад, ялгаварлалтай тулгардаг нь гэмт хэрэг үйлдэхэд бодитой нөлөөлдөг байна.

Ийнхүү XX зууны нийгмийн бүтцийн ба шошгололын онолууд нь гэмт хэргийг хувь хүний зан чанар, биологийн хүчин зүйлсээр бус, харин нийгмийн зохион байгуулалт, тэгш бус байдал, эрх мэдлийн бүтэц, нийгмийн хариу үйлдлээр тайлбарласан нь онолын шинэ дэвшил болжээ. Эдгээр онол нь орчин үеийн криминологийн онол, практикт нийгмийн илүү таатай орчин бүрдүүлэх, боловсрол, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, өсвөр үеийнхний ял шийтгэлийг аль болох багасгах, шүүхийн оролцоог хязгаарлах, шударга ёсыг нөхөн сэргээхэд /restorative justice/ чиглэгдсэн бодлогын үндэс суурь болж байна.

IV.Дижитал экосистем ба криминологийн шинэ чиглэлүүд /XXI зуун/

1970-аад оноос хойш криминологид хоёр гол чиг хандлага зэрэгцэн хөгжжээ. Нэг талаас сонгодог сургуульд тулгуурласан “рациональ сонголт” /Rational Choice/, “рутин үйл ажиллагаа” /Routine Activity/, “хагархай цонхны онол” /Broken Windows/ зэрэг шинэ сонгодог чиглэлийн онолууд /Neoclassical Perspectives/ хөгжиж, бодлого боловсруулахад шууд хэрэглэгдэх болсон. Нөгөө талаас хувь хүний хөгжлийн үзэл баримтлал бүхий “амьдралын замналын хандлага” /Life-Course Approach/, “өөрийгөө хянах чадварын онол” /Self-Control Theory/ нь гэмт зан авирыг хүний урт хугацааны хувьслын явцтай холбон судлах шинэ чиглэлийг нээсэн юм. Энэ хоёр чиглэл нийлж, өнөөгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлого, стратегийн онолын үндэс болсон гэж үздэг.

1990-ээд оноос хойш орчин үеийн нийгмийн шинэ сорилтод хариу өгөх зорилгоор криминологийн шинэчлэгдсэн чиглэлүүд төлөвшин хөгжиж, уламжлалт онолуудыг баяжуулж ирэв. Үүнд “Соёлын криминологи” /Cultural Criminology/, “Ногоон криминологи” /Green Criminology/, “Өмнөдийн криминологи” /Southern Criminology/, “Биосоциологийн криминологи” /Biosocial Criminology/, “Нотолгоонд суурилсан цагдаагийн үйл ажиллагаа” /Evidence-Based Policing/ зэрэг чиглэлүүдийг дурдаж болно.

• **Соёлын криминологи /*Cultural Criminology*/**

Гэмт хэрэг нь зөвхөн хууль зөрчих үйлдэл бус, харин тодорхой утга, мэдрэмж, тэмцлийг илэрхийлсэн соёлын үйлдэл гэж үзэх нь соёлын криминологийн онолын агуулга юм. Хүмүүсийн гэмт авирт зөвхөн рациональ тооцоо биш, харин сэтгэл хөөрөл, адреналин, уур хилэн, баяр хөөр зэрэг соёлын мэдрэмж нь нөлөөлдөг (Ferrell, 2008) гэж энэ чиглэлийн онолчид үздэг.

• **Ногоон криминологи /*Green Criminology*/**

Гэмт хэрэг зөвхөн хүмүүсийн хоорондын асуудал биш, байгаль орчин, амьтан, ирээдүй хойч үеийн эрх ашигт ч хамаатай, хүний үйл ажиллагаа нь экологийн тогтвортой байдалд заналхийлж, амьдралын чанарыг доройтуулах ёсгүй гэсэн байр сууринаас амьтан ба экосистемийн эрхийг хамгаалах үзэл санаагаар ногоон криминологийн онол тодорхойлогдоно. Ногоон криминологи гэмт хэргийн судалгааг өргөжүүлж, хуульд гэмт хэрэг гэж заасан эсэхээс үл хамааран байгаль орчин болон амьтанд учруулсан хор уршгийг хамруулан экологийн шударга ёсны үүднээс авч үздэг байх байр суурийг энэ чиглэлийн онолчид баримталдаг (Lynch, 2014). Уур амьсгалын өөрчлөлт, экосистемийн сүйтгэл улам нэмэгдэж буй өнөөгийн нөхцөлд ногоон криминологи нь байгаль орчин ба шударга ёсны огтлолцлыг нухацтай судлах шинэ чиглэл болоод байна.

• **Биосоциологийн криминологи /*Biosocial Criminology*/**

Биосоциологийн чиглэл нь өнгөрөгч зууны сүүл үеэс генетик, тархи судлал, зан

төлөвийн биологи хурдтай хөгжсөнтэй холбогдон шинэчлэгдсэн чиглэл юм. Энэ чиглэлийн үүднээс гэмт авир нь зөвхөн ядуурал, боловсролын дутагдал, гэр бүлийн орчин гэх мэт нийгмийн бүтцийн нөхцөлөөс шалтгаалахгүй, харин генетик, тархи, гормон, мэдрэлийн онцлогтой хамсаж гэмт хэрэг үйлдэхэд нь нөлөөлдөг гэсэн байр суурийг биосоциологийн криминологчид баримталдаг. Өрөөр хэлбэл гэмт хэргийн шалтгаан нь зөвхөн биологид эсвэл нийгэмд дагаараа биш, харин тэдгээрийн харилцан үйлчлэлд оршино (Walsh, 2007) гэсэн санааг эрдэмтэд дэвшүүлэн тавьсан байдаг.

• **Нотолгоонд суурилсан цагдаагийн үйл ажиллагаа /*Evidence-Based Policing*/**

Цагдаагийн практик үйл ажиллагаа, бодлого нь уламжлалт туршлага, улс төрийн шахалт, үүрэг даалгавраар бус, харин эмпирик нотолгоо, туршилтын үр дүн дээр суурилсан байх ёстой. Цагдаагийн байгууллагын өдөр тутмын шийдвэр, үйл ажиллагааны үр дүн, нөхцөл байдлын судалгааг шинжлэх ухааны үндэстэй байнга хийж, туршилт явуулж, зөв мэдээлэлд суурилсан хамгийн үр ашигтай үйл ажиллагаа явуулахад энэхүү онол чиглэгддэг. Санамсаргүй хяналттай туршилт /RCT/ явуулах, өмнөх мэдээллүүдийг нэгтгэн мета-шинжилгээ хийх, гэмт хэргийн зураглал үйлдэх /crime mapping/, эрсдэлтэй халуун цэгүүдийг олж тодорхойлж эргүүл хийх /hot spots analysis/ зэрэг аргуудыг энэхүү онолын үүднээс санал болгодог.

Ялангуяа эрсдэлтэй халуун цэгүүдийг олж тодорхойлж эргүүл хийх нь уламжлалт эргүүлээс илүү сайн үр дүнтэй бөгөөд гэмт хэргийг нийт хэмжээгээр мэдэгдэхүйц бууруулдгийг олон улсын 65 судалгааг хамруулан мета-шинжилгээ хийж баталсан туршлага байна (Braga, 2019).

• **Өмнөдийн криминологи /*Southern Criminology*/**

Олон арван жилийн турш “глобал хойд”-ын /Global North: Европ, АНУ/ онол, туршлага криминолгид давамгайлсан бол цаашид Латин Америк, Африк, Ази, Австрали, Номхон далайн орнуудын нийгмийн нөхцөл, түүхэн туршлага, колоничлолын өвийг харгалзан судлах шаардлагатай (Carrington, 2016) гэж өмнөдийн криминологийн онолчид байр суурыа тодорхойлсон байна. Ийнхүү одоо хойд ба өмнөд, цаашид олон төвтэй олон уугуул соёл, хүн зоны төрөлхийн ялгаа руу ойртсон криминологийн судалгааны чиг хандлага бий боллоо.

.

• **Дижитал экосистем ба кибер рутин үйл ажиллагаа**

XXI зуунд цахимжилт, хиймэл оюун, финтек, криптовалютын зах зээл, цахим платформууд, мөн төрийн болон хувийн хэвшлийн масс тандалтын систем зэрэг өргөн цар хүрээтэй өөрчлөлтүүд бий болж, уламжлалт гэмт хэргийн орон зай шинэ дижитал экосистемд шилжжээ. Энэ өөрчлөлт нь гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх арга замд ч цоо шинэ сорилт авчраад байна.

1. Дижитал экосистем

Дижитал экосистем нь олон нийтийн харилцааны цахим сүлжээ, худалдааны цахим талбар зэрэг онлайн платформ , финтек ба криптовалютын гүйлгээ, хиймэл оюунд суурилсан шийдлүүд, их өгөгдөл /big data/ болон кибер орчныг хамарсан өргөн хүрээтэй цахим орчныг илэрхийлдэг. XXI зуунд дижитал технологийн энэ үсрэнгүй хөгжил нэг талаас нийгмийн харилцааг хурдасгаж, эдийн засгийн шинэ боломжуудыг нээсэн бол нөгөө талаас кибер гэмт хэргийн шинэ хэлбэрүүдийг бий болгожээ.

Энэ орчинд цахим залилан, рансомвэр /ransomware/, ботнет /botnet/ халдлага, өгөгдлийн алдагдал, дийпфэйк /deepfake/ ашигласан хууран болон залилан мэхлэлт зэрэг шинэ төрлийн гэмт хэрэг улам бүр нэмэгдэж байна. Дижитал экосистемийг судлаачид “биологийн экосистемийн дижитал хувилбар бөгөөд өөрөө зохицох, өргөтгөх чадвартай архитектурын загвар” (Gerard, 2007) хэмээн тодорхойлдог бол, өөр нэгэн тайлбарт “хувь хүн, байгууллага, дижитал технологиуд хамтран болон өрсөлдөн харилцан үйлчлэлцэж, хэрэглэгчдэд үнэ

цэнийг бий болгодог нийгэм-техникийн орчин" (Benjamin, 2025) гэсэн байдаг.

Ингэснээр криминологид огт шинэ нөхцөл байдлыг бий болгож, уламжлалт гэмт хэргийн ойлголт ч, түүнээс урьдчилан сэргийлэх асуудал ч нэгэн адил цахим орчинд шилжиж байна.

2. Кибер рутин үйл ажиллагааны онол /Cyber Routine Activity Theory/

Лоуренс Коэн /АНУ/ болон Маркус Фелсон /АНУ/ нарын дэвшүүлсэн "Өдөр тутмын үйл ажиллагааны онол" /Routine Activity Theory/ нь гэмт хэргийн гарал үүслийг нийгмийн бүтцийн өөрчлөлт болон өдөр тутмын амьдралын хэв маягийн шилжилттэй холбон тайлбарладаг. Энэхүү онолын гол санаа нь гэмт хэрэг гарахад зайлшгүй гурван нөхцөл зэрэгцэн байх шаардлагатай гэсэн таамаглал дээр тулгуурладаг. Үүнд:

1.**Тохиромжтой зорилт /Suitable Target/:** Хүн, эд зүйл, мэдээлэл зэрэг гэмт этгээдэд өртөхөд хялбар гэж үнэлэгдэхээр байх.

2.**Зорьсон халдагч /Motivated Offender/:** Гэмт хэрэг үйлдэхээр төлөвлөж, зорьсон этгээд.

3.**Найдвартай хамгаалалт дутмаг байдал /Absence of Capable Guardian/:** Цагдаа, хөршийн хяналт, хамгаалалтын систем зэрэг хяналт сул байх.[1]

Эдгээр нөхцөл гурвын огтлолцол бий болсон нөхцөлд гэмт хэрэг гарах магадлал өндөр болдог гэж онол тайлбарладаг (Felson, 1980). Энэ онол нь гэмт хэрэг зөвхөн хувь хүний зан төлөв, нийгмийн томоохон бүтэцтэй холбогдоод зогсохгүй, харин өдөр тутмын амьдралын хэв маяг, хүмүүсийн хөдөлгөөн, хотжилтын загвар, технологийн хэрэглээ зэрэг бодит нөхцөл байдалд шууд хамааралтай гэдгийг харуулсан.

XXI зуунд энэ онолын загвар кибер орчинд хэрэглэгдэхдээ шинэ хэлбэрт шилжсэн. Жишээлбэл:

• **Зорилт /Target/:** Хувийн мэдээлэл, банкны данс, цахим гарын үсэг, криптовалютын түрийвч зэрэг кибер орчинд хадгалагдсан нөөц.

• **Халдагч /Offender/:** Рансомвэр /Ransomware/ оператор, ботнет /botnet/ удирдагч, цахим залилан хийдэг бүлэглэл, кибер халдагчид.

• **Хамгаалагч /Guardian/:** Firewall, олон давхар баталгаажуулалт /multi-factor authentication/, кибер хяналтын баг, хууль сахиулах байгууллагын кибер нэгж.

Кибер рутин үйл ажиллагааны онол нь гэмт хэргийг хувь хүний зан чанар болон эдийн засаг, нийгмийн орчноос гадна цахим төлбөр тооцоо, олон нийтийн харилцааны цахим сүлжээ ашиглалт, өгөгдөл солилцоо, цахим худалдаа зэрэг онлайн орчны өдөр тутмын хэрэглээний хэв маягтай салшгүй холбон өнөөгийн нөхцөл байдалд тохируулан тайлбарладгаараа онцлог юм.

Кибер рутин үйл ажиллагааны онолын ач холбогдол нь кибер гэмт хэрэгтэй тэмцэх бодлого боловсруулахад оршино. Тухайлбал, орчин үеийн кибер үйл ажиллагааг энэ онолын үүднээс дараах байдлаар зохион байгуулах боломжтой:

• **Зорилтыг илүү хамгаалах-** өгөгдлийг шифрлэх, цахим боловсрол олгох

• **Халдагчийн боломжийг бууруулах-** кибер хууль сахиулах хамтын ажиллагаа, олон улсын конвенц, Interpol-ын сүлжээ

• **Хамгаалагчийг хүчирхэгжүүлэх-** AI суурилсан илрүүлэлтийн систем, хяналт, хамгаалалт /real-time monitoring/ зэрэг.

Энэ бүхэн XXI зууны дижитал экосистемд гэмт хэрэг бууруулах шинэ онолын үндэс болон хөгжиж байна.

Дүгнэлт

Сүүлийн дөрвөн зууны турш хүн төрөлхтөн гэмт хэргийн мөн чанар, шалтгаан, нөхцөлийг шинжлэх ухааны үүднээс олон талаас нь судалж, урьдчилан сэргийлэх арга замыг эрэлхийлж иржээ. Энэ үйл явц нь нийгмийн хөгжлийн үе шаттай нягт холбоотойгоор тасралтгүй баяжиж, даяаршлын эрин үед дэлхий нийтийн хамтын мэдлэг болон төлөвшсөн байна.

Гэмт хэргийг зөвхөн эрх зүйн хүрээнд авч үздэг хандлага өөрчлөгдөж, нийгмийн шинжлэх ухааны хэмжээнд өргөжсөн нь урьдчилан сэргийлэх бодлогын онолын чухал чиг баримжаа

болжээ. Монгол Улсын хувьд социалист нийгмийн үед марксист криминологи болон социалист эрх зүйн үзэлд хэт туйлширсан байсан ч, сүүлийн 30 жилийн хугацаанд олон улсын онолын чиглэлүүдийг хүлээн авах боломж нээгдсэн. Гэсэн хэдий ч эдгээр онолыг системтэй судалж, бодлого, практикт өргөн хэрэглэх тал дээр дутмаг хэвээр байна.

Манай улсад урьдчилан сэргийлэх ажлыг ихэвчлэн ангийн тэмцэл, нийгмийн зөрчил, хувь хүний үзэл төлөвшилд төвлөрүүлж ирсэн бол цаашид хүн нийгмийн ердийн харилцаа, түүнээс үүдсэн н шалтгаан нөхцөлд илүү анхаарч, онолын олон чиглэлүүдийг хүлээн зөвшөөрч тулгуурласан бодлого боловсруулах шаардлага байна. Ялангуяа цагдаагийн байгууллага гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргээ зөвхөн үүрэг биелүүлэх хэмжээнд бус, нотолгоонд суурилсан үйл ажиллагааны онолыг хэрэгжүүлэх замаар шинэ түвшинд хүргэх шаардлагатай. Энэ нь эмпирик судалгаанд суурилсан бодлого боловсруулах, криминологийн шинжлэх ухааны ололтыг практикт нэвтрүүлэх боломжийг олгоно.

Орчин үеийн шинэ чиглэлүүд болох соёлын, ногоон, өмнөдийн криминологи нь нийгмийн соёл, байгаль орчин, эрх мэдлийн тэгш бус байдлын асуудлыг онцолж, биосоциологийн чиглэл нь хувь хүн ба нийгмийн харилцан хамаарлыг шинжлэх ухааны шинэ ололттой холбон тайлбарлаж байна. Дижитал экосистемийн нөхцөлд үйлдэгдэх шинэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг кибер рутин үйл ажиллагааны онол зэрэг цахим технологид тулгуурласан арга зүйгээр хөгжүүлэх шаардлага ч өсөн нэмэгдэж байна. Энэ шинэ чиглэлүүдийг хэрхэн соргогоор судлан хэрэгжүүлэхээс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр дүн шууд хамаарахаар байна.

Өмнөдийн криминологийн чиглэл нь Монгол Улсад хамгийн ойр хамаатай. Бид өөрийн орны түүх, соёл, уламжлал, нийгмийн нөхцөл, үндэсний онцлогийг харгалзсан судалгааг гүнзгийрүүлэх хэрэгтэй. Ингэснээр бүс нутаг болон дэлхийн криминологийн мэдлэгийн санд хувь нэмрээ оруулах, үндэсний онцлогт нийцсэн урьдчилан сэргийлэх бодлого, арга зүйг шинээр тодорхойлох боломж олдоно.

Эцэст нь, аливаа үйлдлийг Эрүүгийн хуульд гэмт хэрэг болгон тусгах нь урьдчилан сэргийлэх үр дүнд тэр болгон хүргэдэггүй, харин ч шошгололтын онолын үүднээс “гэмт хэрэгтэн” гэсэн шошгыг цөөн хүн амтайгаа үл харгалзан хавтгайруулан зүүх эрсдэлээс байнга болгоомжилж байх ёстой. Иймээс хууль тогтоох үйл ажиллагаанд гэмт хэрэгт хамааруулах үйлдлийн тодорхойлолтыг өргөтгөхөөс илүүтэйгээр түүний нийгмийн ашигт байдлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тооцоолж, криминологийн судалгаанд тулгуурлан оновчтой шийдвэр гаргаж байх, үүнд чиглэгдсэн зориудын арга хэмжээ авах шаардлага тулгарч байна.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт

1. Agnew, R. (1992). Foundation for a General Strain Theory of Crime and Delinquency. *Criminology*, 50–60.
2. Beccaria, C. (1995). On Crimes and Punishments and Other Writings, ed. Richard Bellamy, trans. Richard Davies. *Cambridge: Cambridge University Press*, 34.
3. Becker, H. S. (1963). Outsiders: Studies in the Sociology of Deviance. *New York: Free Press*, 8–10.
4. Benjamin, M. B. (2025). Digital Ecosystems: A Research Agenda for Innovation Management. *Review of Managerial Science*, 2.
5. Bentham, J. (1907). An Introduction to the Principles of Morals and Legislation. *Oxford: Clarendon Press*, 2.
6. Braga, A. A. (2019). Hot Spots Policing and Crime Reduction: An Updated Systematic Review and Meta-Analysis. *Campbell Systematic Reviews*, 1064.
7. Carrington, K. R. (2016). Southern Criminology. *London: Routledge*, 1–15.
8. Clifford, R. S. (1942). Juvenile Delinquency and Urban Areas. *Chicago: University of Chicago Press*, 20–35.
9. Cloward, R. A. (1960). Delinquency and Opportunity. *New York: Free Press*, 86–110.

10. Cohen, A. K. (1955). Delinquent Boys: The Culture of the Gang. *New York: Free Press*, 62–86.

11. Durkheim, É. (1982). The Rules of Sociological Method. *New York: Free Press*, 85.

12. Felson, M. a. (1980). Human Ecology and Crime: A Routine Activity Approach. *Human Ecology*, 389–406.

13. Ferrell, J. K. (2008). Cultural Criminology: An Invitation. *London: SAGE*, 15–40.

14. Ferri, E. (1917). Criminal Sociology. *Boston: Little, Brown*, 45.

15. Garofalo, R. (1914). Criminology . *Boston: Little, Brown*, 20.

16. Gerard, B. S. (2007). Digital Ecosystems. *ArXiv Preprint*, 3.

17. Goffman, E. (1963). Stigma: Notes on the Management of Spoiled Identity. *NJ: Prentice-Hall*, 3–12.

18. Lemert, E. M. (1951). Social Pathology. *New York: McGraw-Hill*, 75–83.

19. Lombroso, C. (1911). Criminal Man. *New York: Putnam*, 72.

20. Lynch, M. J. (2014). Exploring Green Criminology: Toward a Green Criminological Revolution. *Farnham: Ashgate*, 5.

21. Reigel, C. (2025). Radical Consent: The Origins of the Antioch College Sexual Offense Policy. *ProQuest*, 21.

22. Robert, K. M. (1938). Social Structure and Anomie. *American Sociological Review*, 672–682.

23. Tannenbaum, F. (1938). Crime and the Community. *New York: Columbia University Press*, 19–25.

24. Teng, L. (2025). Structural Inequality and Juvenile Delinquency: A Marxist Class Analysis. *Journal of Criminal Investigation and Criminology*, 14–15.

25. Walsh, A. a. (2007). Biosocial Criminology: New Directions in Theory and Research. *New York: Routledge*, 5.

26. Вышинский, А. Я. (1948). Право Советского государства. *Изд-во иностр. лит*, 45.

ЭРҮҮГИЙН ЯВДЛЫН СУДЛАЛ

МОНГОЛ УЛСЫН ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ТУХАЙ ХУУЛИЙГ ЗАРИМ УЛСЫН ИЖИЛ ТӨСТЭЙ ХУУЛЬТАЙ ХАРЬЦУУЛСАН ҮР ДҮН

MONGOLIAN LAW "ON EXECUTIVE WORK" RESULTS COMPARED TO SIMILAR LAWS IN SOME COUNTRIES

Ү.Хосбаяр
Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн Гүйцэтгэх ажлын тэнхимийн эрхлэгч, доктор (Ph.D), цагдаагийн хурандаа
Hosbayar U.
University of Internal Affairs, Head of the Criminal intelligence Department of the Police school Doctor (Ph.D), Police colonel
Б.Ган-Өсөх
Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн Гүйцэтгэх ажлын тэнхимийн магистрант цагдаагийн ахмад
Gan-Usukh B.
Head of the police intelligence Department of Police School, master's sdutent, Police capitan

*Хариуцлагатай зохиогч:kingmelice@gmail.com

Хураангуй: Монгол Улсын Гүйцэтгэх ажлын тухай хуулийг олон улсын жишигт ойртуулахын тулд хүний эрхийг хамгаалах, ил тод байдлыг хангах, технологийн зохицуулалтыг хөгжүүлэх, хяналтын тогтолцоог сайжруулах, болон олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд анхаарах нь чухал. Энэ нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, иргэдийн эрхийг хамгаалахад үр дүнтэй, олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн хууль эрх зүйн тогтолцоо бий болгох нөхцөлийг бүрдүүлнэ.

Abstract: To align Mongolia's Law on Executive Operations with international standards, it is essential to focus on protecting human rights, ensuring transparency, advancing technological regulations, strengthening oversight mechanisms, and expanding international cooperation. These efforts will enhance national security and safeguard citizens' rights while establishing a legal framework that meets globally recognized standards.

Түлхүүр үгс: Монгол Улс, Гүйцэтгэх ажлын тухай хууль, хүний эрх, ил тод байдал, технологийн зохицуулалт, хяналтын тогтолцоо, олон улсын хамтын ажиллагаа, үндэсний аюулгүй байдал, хууль эрх зүйн тогтолцоо.

Key Words: Mongolia, Law on Executive Operations, human rights, transparency, technological regulations, oversight mechanisms, international cooperation, national security, legal framework.

Монгол Улсын "Гүйцэтгэх ажлын тухай" хуулийг олон улсын стандартад нийцүүлэх шаардлага их бөгөөд хүний эрхийг хамгаалах, нууцлал ба ил тод байдлын тэнцвэрийг хангах, технологийн зохицуулалтыг сайжруулах, хяналтын механизмыг бэхжүүлэх, болон олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр шинэчлэл хийх нь чухал байна. Одоогийн хууль нь үндэсний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн боловч хүний эрхийн хамгаалалтыг бэхжүүлэх, орчин үеийн технологийг үр дүнтэй ашиглах, байгууллагуудын эрх мэдлийг оновчтой хуваарилах зэрэг олон улсын стандарт, үзэл баримтлалд бүрэн нийцээгүй байгаа нь сорилтууд үүсгэдэг.

Эдгээр шинэчлэл нь гүйцэтгэх ажлыг хүний эрхийг дээдэлсэн, ил тод, хариуцлагатай байдлаар зохион байгуулж, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, хяналтын байгууллагуудыг бие даасан, хараат бус ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд тусална. Мөн олон улсын туршлагыг судалж, Монгол Улсын онцлогт нийцүүлэн бодлого, зохицуулалтыг боловсронгуй болгох замаар хууль эрх зүйн тогтолцоог хүчирхэгжүүлэх, иргэдийн эрх ашгийг

This article is published under the Creative Commons BY-NC-SA License by 4.0, ©2025 University of Internal Affairs, Mongolia

хамгаалсан шударга, аюулгүй орчин бүрдүүлэхэд хувь нэмэр оруулах бөгөөд дараах үндсэн дэд хэсгүүдэд хуваагдана. Үүнд:

1. Тулгамдаж буй асуудлууд

1.1 Хүний эрхийн зөрчил

Монгол улсын нөхцөл байдал:

• Монгол Улсын хуульд гүйцэтгэх ажлыг хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх зарчимд тулгуурласан гэж заасан ч зарим тохиолдолд эрх мэдлээ хэтрүүлэн ашиглах эрсдэл бий.

• Нууц ажиллагааны үеэр иргэдийн мэдээлэл хууль бус аргаар цуглуулах, тагнах зэрэг асуудал гардаг.

Олон улсын жишиг:

• **Европын Холбоо (ЕХ):** Европын Нууцлалын тухай ерөнхий журам (GDPR)-аар хүний мэдээллийг хамгаалж, хууль бус ажиллагаанд хатуу хяналт тавьдаг.

• **АНУ:** Гүйцэтгэх ажилд оролцогчдыг шүүх, прокурорын дэргэд хянаж, хүний эрхийн зөрчил гарсан тохиолдолд хатуу арга хэмжээ авдаг.

Шийдэл:

• Бие даасан хяналтын байгууллага бий болгож, иргэдийн гомдлыг шийдвэрлэх үр дүнтэй систем нэвтрүүлэх.

• Гүйцэтгэх ажлын хуульд хүний эрхийг хамгаалах тодорхой заалтууд нэмж, хяналтын механизмын ажиллагааг сайжруулах.

1.2 Нууцлал ба ил тод байдлын зөрчил

Монголын нөхцөл:

• Нууцлалын шаардлагыг хэт их баримталснаас үүдэн олон нийтийн мэдээлэлд хүрэх эрх хязгаарлагдаж байна.

• Жишээ нь, гүйцэтгэх ажлын зарим мэдээлэл ил болбол хариуцлага тооцох, эрх мэдлийг хэтрүүлэхээс сэргийлэх боломжтой.

Олон улсын жишиг:

• **АНУ-ын Freedom of Information Act (FOIA):** Иргэд тодорхой мэдээллийг нээлттэй авах эрхтэй.

• **Швед:** Ил тод байдлын тухай хууль нь төрийн байгууллагын үйл ажиллагааг иргэд хянах боломжийг бүрдүүлдэг.

Шийдэл:

• Нууцлал, ил тод байдлын тэнцвэрийг хангахын тулд тодорхой мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох, гэхдээ үндэсний аюулгүй байдлыг хохироохгүй байх зохицуулалт хийх.

• Иргэд, байгууллагын хүсэлтээр гүйцэтгэх ажлын зарим хэсгийг шалгах боломжтой тогтолцоо бий болгох.

1.3 Технологийн хөгжилтэй уялдуулсан зохицуулалтын дутагдал

Монголын улсын нөхцөл байдал:

• Технологийн дэвшилтэй холбоотой гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэл, программ хангамжийн зохицуулалт хангалтгүй.

• Нууц техник хэрэгслийг хууль бусаар ашиглах эрсдэл их байна.

Олон улсын жишиг:

• **Израиль:** Кибер аюулгүй байдлын хууль тогтоомж маш нарийн зохицуулалттай.

• **Герман:** Шинэ технологи ашиглах эрх зүйн орчныг тогтмол шинэчилж, иргэдийн мэдээллийг хамгаалдаг.

Шийдэл:

• Технологийн шинэчлэлд нийцсэн тусгай заалтуудыг хуульд оруулах.

• Хяналтын байгууллагуудыг шинэ техник хэрэгсэл, программ хангамжаар хангаж, мэдээллийн аюулгүй байдлыг хангах.

1.4 Тусгай байгууллагуудын эрх мэдлийн хязгаар

Монголын улсын нөхцөл:

• Тагнуулын байгууллага, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудын эрх үүрэг хоорондын уялдаа дутмаг.

• Зохицуулалт тодорхойгүйгээс үүдэн эрх мэдлийн зөрчил үүсэх магадлалтай.

Олон улсын жишиг:

• **Англи:** Тусгай эрх бүхий байгууллагуудын ажлын заагийг тодорхой тогтоосон байдаг.

• **Канад:** Байгууллагуудын эрх үүргийг нэгдсэн заавар, журмаар зохицуулдаг.

Шийдэл:

• Байгууллагуудын эрх мэдлийг тодорхой зааглаж, хамтын ажиллагааны механизм бий болгох.

• Үндэсний аюулгүй байдлын хүрээнд ажиллах байгууллагуудад харилцан хяналт тавих тогтолцоог сайжруулах.

2. Сайжруулах санал

1.Хүний эрхийг хамгаалах бодлогыг бэхжүүлэх:

○ Иргэдийн гомдлыг түргэн шийдвэрлэх тусгай хороо байгуулах.

○ Хүний эрхийг зөрчсөн тохиолдолд албан хаагчдад хатуу хариуцлага тооцох.

2.Нууцлал ба ил тод байдлыг зохицуулах:

○ Гүйцэтгэх ажлын зарим хэсгийн талаар мэдээлэл нийтэд ил тод байх ёстойг хуульчлах.

○ Нууцлалыг баталгаажуулах, гэхдээ үндэслэлгүй хаалттай мэдээллээс зайлсхийх.

3.Шинэ технологид суурилсан гүйцэтгэх ажлыг дэмжих:

○ Мэдээлэл боловсруулах, хянах дэвшилтэт программ хангамж ашиглах.

○ Тусгай техник хэрэгсэл зохион бүтээх, ашиглах эрх зүйн орчныг бэхжүүлэх.

4.Байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах:

○ Хариуцлагын хуваарилалт, хамтын ажиллагааны журмыг шинэчлэх.

○ Гүйцэтгэх ажилд оролцогч байгууллагуудын нэгдсэн бодлого боловсруулж хэрэгжүүлэх.

5.Олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх:

○ Олон улсын жишгийг судлах, Монголын онцлогт тохируулах.

○ Гадаадын байгууллагуудтай туршлага солилцох.

Энэ нь хууль эрх зүйн тогтолцоог илүү найдвартай, шударга, үр ашигтай болгоно.

1.1 Хүний эрхийн зөрчлийн жишээ

Монгол Улсын нөхцөл

Монгол Улсад гүйцэтгэх ажлын хүрээнд хүний эрх зөрчигдсөн зарим тодорхой жишээг авч үзье:

1.**Тусгай хяналтын төхөөрөмжийг хэтрүүлэн ашиглах**:

○ Зарим тохиолдолд гүйцэтгэх ажил явуулахдаа хууль ёсны зөвшөөрөлгүйгээр хүмүүсийг хууль бус аргаар тагнах, бичлэг хийх, мэдээлэл цуглуулах зэрэг зөрчлүүд гардаг.

○ Жишээ нь, олон нийтийн хөдөлгөөн эсвэл сөрөг үзэл бодолтой иргэдийг хянах явцад тэдний хувийн мэдээлэлд халдах тохиолдол гардаг.

2.**Иргэдийн эрхийг хамгаалах механизм хангалтгүй**:

○ Гүйцэтгэх ажлын явцад иргэд гомдол гаргах эрхтэй боловч гомдлыг шийдвэрлэхэд хүнд суртал, хяналтгүй байдал ажиглагддаг.

○ Шаардлагатай хяналтын байгууллагын бие даасан байдлыг хангаагүйгээс болж, зөрчлийг илрүүлэх нь сул байна.

Олон улсын жишээ

1.**АНУ-ын PRISM хөтөлбөр (NSA-ийн хяналт)**:

○ АНУ-ын Үндэсний Аюулгүй Байдлын Агентлаг (NSA) нь PRISM гэх нууц ажиллагаа явуулж, хүмүүсийн онлайн харилцааг өргөн хүрээнд хянаж байсныг 2013 онд Эдвард Сноуден ил болгосон.

○ Энэ хөтөлбөрийн хүрээнд ямар ч шүүхийн шийдвэргүйгээр олон иргэний хувийн мэдээллийг цуглуулсан нь хүний эрхийн ноцтой зөрчилд тооцогдсон.

2.**Европын Холбооны "Privacy International" тайлан**:

○ Нууц ажиллагааны явцад хууль ёсны үндэслэлгүйгээр хүмүүсийн мэдээллийг цуглуулж, тагнасан зарим ЕХ-ны гишүүн улс орнуудын гүйцэтгэх ажил эрхэлсэн байгууллагуудыг "Privacy International" шүүмжилсэн байдаг.

○ Энэ явдал хүний эрхийн зөрчлийг бууруулах хяналтын механизм дутмаг байгааг харуулсан.

Сайжруулах боломжууд

• **Тусгай зөвшөөрөлтэй гүйцэтгэх ажил**: Монгол Улсад гүйцэтгэх ажил хийх

зөвшөөрлийг шүүх, прокуророор заавал баталгаажуулж, зөвшөөрөлгүй ажиллагааг хатуу хориглох.

• **Гомдлын системийг сайжруулах**: Иргэдийн гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх хугацааг товчлох, бие даасан хяналтын байгууллагуудыг чадавхжуулах.

• **Хяналтын бие даасан байдал**: Гүйцэтгэх ажлын үйл явцыг хянах шүүх, прокурор болон хүний эрхийн байгууллагуудыг бие даасан байдлаар ажиллуулах.

• **Олон нийтийн хяналт**: Ил тод байдлыг нэмэгдүүлэх замаар иргэдийн мэдээлэлд хандах эрхийг өргөжүүлэх.

Эдгээр арга хэмжээг нэвтрүүлснээр хүний эрхийг хамгаалахад томоохон ахиц гарна. Монгол Улсын гүйцэтгэх ажлын хуулийг олон улсын жишигт ойртуулахад эдгээр санаачилга чухал үүрэгтэй.

Монгол Улсын "Гүйцэтгэх ажлын тухай" хуулийг олон улсын жишигт ойртуулахын тулд дараах стратегиудыг хэрэгжүүлэх шаардлагатай. Эдгээр нь хүний эрхийг хамгаалах, ил тод байдлыг хангах, технологийн дэвшлийг ашиглах, болон хяналтын тогтолцоог сайжруулахад чиглэнэ:

1. Хүний эрхийг хамгаалах механизмыг сайжруулах

1.1 Хууль эрх зүйн зохицуулалтыг сайжруулах

• **Шүүхийн хяналтыг нэмэгдүүлэх**: Гүйцэтгэх ажлыг зөвхөн шүүх, прокурорын зөвшөөрөлтэйгөөр явуулдаг байхыг хуулиар тогтоох.

• **Гүйцэтгэх ажлын стандарт тогтоох**: Хүний эрхийг зөрчихгүй байх талаар дэлгэрэнгүй заавар, стандарт боловсруулж мөрдүүлэх.

• **Иргэдийн эрхийн хамгаалалт**: Иргэдийн эрх зөрчигдсөн тохиолдолд гомдол гаргах болон хохирлыг нөхөн төлүүлэх механизм бий болгох.

1.2 Бие даасан хяналтын байгууллага байгуулах

• Олон улсын жишгийн дагуу (жишээ нь, Нидерландын тусгай хяналтын зөвлөл), гүйцэтгэх ажлын хяналтыг бие даасан байгууллагад хариуцуулах.

• Иргэдийн мэдээлэл, гүйцэтгэх ажлын үйл явцыг үнэлэх, ил тод байдлыг хангах үүрэг бүхий зөвлөл ажиллуулах.

2. Ил тод байдлыг нэмэгдүүлэх

2.1 Нууцлал ба ил тод байдлын тэнцвэр

• **Олон нийтэд мэдээлэх систем**: Гүйцэтгэх ажлын ерөнхий мэдээлэл, статистик тайланг олон нийтэд тогтмол мэдээлж байх.

• **Тусгай зөвшөөрөлтэй мэдээллийг ил болгох**: Гүйцэтгэх ажлын явцад олсон нийтлэг мэдээллийг үндэсний аюулгүй байдлыг хохироохгүйгээр ил болгох журам гаргах.

2.2 Иргэдийн оролцоог хангах

• Иргэд болон иргэний нийгмийн байгууллагууд гүйцэтгэх ажлын хуулийг шинэчлэх, хэрэгжилтэд хяналт тавих үйл явцад оролцох боломж олгох.

• Иргэдийн мэдээлэл авах эрхийг баталгаажуулах.

3. Технологийн зохицуулалт ба дэвшлийг ашиглах

3.1 Тусгай техник хэрэгслийн зохицуулалт

• Гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэл, программ хангамжийг зохион бүтээх, ашиглах, импортлох, болон экспортлох үйл явцыг хуулиар тодорхой болгох.

• Технологийн хөгжилтэй нийцсэн, хүний эрхийг хамгаалах, нууцлалыг хангах шаардлагыг хуульд тусгах.

3.2 Кибер аюулгүй байдлыг сайжруулах

• Гүйцэтгэх ажлын явцад ашиглагддаг мэдээллийн сан, программ хангамжийг кибер халдлагаас хамгаалах дэд бүтцийг хөгжүүлэх.

• Олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж, кибер аюулгүй байдлын шилдэг туршлагыг нутагшуулах.

4. Байгууллагуудын эрх мэдэл, үүргийн заагийг тодорхой болгох

4.1 Үүрэг, эрх мэдлийн хуваарилалт

• Гүйцэтгэх ажлыг эрхлэх байгууллагуудын хоорондын эрх мэдэл, хариуцлагын заагийг тодорхой болгох.

• Байгууллагуудын хамтын ажиллагааг хангах хуулийн зохицуулалт бий болгох.

4.2 Хяналт, хариуцлагыг сайжруулах

• Байгууллагуудын үйл ажиллагааг шүүх, прокурор, болон хяналтын тусгай байгууллагаар хянуулах.

• Хяналтгүй ажиллагаа явуулсан албан тушаалтанд хариуцлага тооцох хатуу заалт оруулах.

5. Олон улсын хамтын жиллагааг өргөжүүлэх

5.1 Гадаад туршлагаас суралцах

• АНУ, ЕХ, Канад зэрэг орнуудын гүйцэтгэх ажил эрхлэх туршлагыг судалж, Монгол Улсын хууль тогтоомжид уялдуулах.

• НҮБ болон олон улсын хүний эрхийн байгууллагуудтай хамтран ажиллаж, хүний эрхийг хамгаалах чиглэлд хамтран ажиллах.

5.2 Гадаадын зөвлөх байгууллагуудтай хамтрах

• Гүйцэтгэх ажлын хууль тогтоомжийг боловсронгуй болгоход зориулж олон улсын зөвлөх байгууллагуудаас туслалцаа авах.

• Олон улсын түвшний сургалтаар албан хаагчдын мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх.

Монгол Улсын гүйцэтгэх ажлын хууль ба бусад улс орны гүйцэтгэх ажлын хуулийн ялгаатай ба ижил төстэй шинж

Ижил төстэй шинж

1.Үндэсний аюулгүй байдлыг хамгаалах зорилго:

○ Монгол Улсын гүйцэтгэх ажлын хууль нь үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, гэмт хэргийг урьдчилан сэргийлэх, илрүүлэхэд чиглэсэн байдаг. Энэ нь АНУ, ЕХ, Япон зэрэг олон улсын хуультай ижил байдаг.

2.Хүний эрхийг хүндэтгэх зарчим:

○ Монголын хуульд хүний эрхийг хамгаалахыг чухалчилсан. Энэ нь НҮБ-ын хүний эрхийн үндсэн зарчим болон Европын хүний эрхийн конвенц (ECHR)-ийн зарчимтай нийцдэг.

3.Нууц ажиллагааны арга хэрэгсэл:

○ Нууц ажиллагааны арга, хэрэгслийг ашиглахыг зөвшөөрдөг. Жишээ нь, АНУ-ын Patriot Act, Францын Gendarmes Act-д нууц арга хэрэгслийн талаар ижил төстэй зохицуулалт байдаг.

4.Хууль зүйн хяналт:

○ Монгол Улсад гүйцэтгэх ажилд шүүх болон прокурорын хяналт шаардлагатай. Энэ зарчим нь АНУ, Герман, Канадын хуультай ижил.

Ялгаатай шинж

1.**Хяналтын байгууллагын хараат байдал**:

○ **Монгол Улс:** Хяналтын байгууллагуудын хараат бус байдал сул. Ихэнхдээ гүйцэтгэх байгууллагууд өөрсдийн үйл ажиллагааг хянадаг.

○ **АНУ:** Бие даасан хяналтын байгууллага (Inspector General, Privacy and Civil Liberties Oversight Board) байдаг.

○ **Европын Холбоо:** Ил тод байдлыг хангах, хүний эрхийг хамгаалах олон улсын байгууллагын хяналт дор ажилладаг.

2.**Ил тод байдлын түвшин**:

○ **Монгол Улс:** Гүйцэтгэх ажлын үйл явц, тайлан нууцлагдмал, олон нийтэд мэдээлэл хүрэх боломж хязгаарлагдмал.

○ **Швед:** Ил тод байдлын хууль (Transparency Act)-аар төрийн бүх үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй байлгадаг.

○ **АНУ:** Freedom of Information Act (FOIA)-аар иргэд мэдээлэлд хандах эрхтэй.

3.**Технологийн дэвшилтэй уялдуулсан зохицуулалт**:

○ **Монгол Улс:** Технологийн шинэчлэлийг тусгасан тусгайлсан заалтууд дутмаг.

○ **Израиль:** Кибер аюулгүй байдлын тусгай хууль баталсан бөгөөд энэ нь орчин үеийн мэдээллийн технологийн асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн.

4.**Байгууллагуудын хамтын ажиллагаа**:

○ **Монгол Улс:** Байгууллагуудын ажлын уялдаа холбоо хангалтгүй.

○ **Канад:** Байгууллагуудын эрх мэдлийн хязгаарыг нарийн зааж, хамтын ажиллагааг дүрмээр зохицуулдаг.

○

Монгол Улсын гүйцэтгэх ажлын хуулийг олон улсын жишигт ойртуулах арга зам

1. Хүний эрхийг хамгаалах

• **Нэмэлт заалт оруулах**: Хүний эрхийн зөрчлийг илрүүлэх, хариуцлага тооцох механизмыг хуулинд тусгах.

• **Шүүхийн хяналт нэмэгдүүлэх**: Шүүхийн хяналтгүйгээр гүйцэтгэх ажил явуулахыг хориглох.

• **Гомдол шийдвэрлэх тогтолцоог хөгжүүлэх**: Гүйцэтгэх ажиллагаанд өртсөн иргэдийн гомдлыг шийдвэрлэх ил тод, түргэн шуурхай систем бий болгох.

2. Ил тод байдлыг хангах

• **Тайланг олон нийтэд мэдээлэх**: Гүйцэтгэх ажлын явцын ерөнхий мэдээллийг жил бүр олон нийтэд тайлагнах.

• **Мэдээлэлд хандах эрх**: FOIA шиг иргэдийн мэдээлэл авах эрхийг хуулиар баталгаажуулах.

3. Технологийн зохицуулалт

• **Орчин үеийн технологийг зохицуулах хууль батлах**: Кибер тагнуул, хиймэл оюун ухааны хэрэглээг зохицуулсан тусгай хууль батлах.

• **Мэдээллийн аюулгүй байдлыг хангах**: Гүйцэтгэх ажлын хүрээнд мэдээлэл алдагдахаас урьдчилан сэргийлэх систем хөгжүүлэх.

4. Хяналтын байгууллагыг бэхжүүлэх

• **Бие даасан хяналтын байгууллага байгуулах**: Олон улсын загвар дээр тулгуурлан хяналтын тусгай хороо эсвэл байгууллага ажиллуулах.

• **Хяналтын тогтолцоог өргөжүүлэх**: Гүйцэтгэх ажлын явцад хөндлөнгийн хяналт тавих иргэний болон мэргэжлийн байгууллагуудыг оролцуулах.

5. Байгууллагуудын хамтын ажиллагаа

• **Эрх мэдлийн хязгаарыг тодорхойлох**: Гүйцэтгэх ажлын чиг үүргийг хэт давхцуулахгүй, харин уялдаатай байхаар зохицуулах.

• **Нэгдсэн бодлого хэрэгжүүлэх**: Байгууллагуудын хамтын ажиллагааг нэгдсэн удирдамжаар зохицуулж, үүрэг, хариуцлагыг нарийвчлан заах.

6. Олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх

• **Туршлага солилцох**: АНУ, ЕХ, Канад зэрэг орны гүйцэтгэх ажлын хууль тогтоомжийг судлах, нутагшуулах.

• **Олон улсын гэрээ, конвенцод нэгдэх**: Хүний эрх, аюулгүй байдлыг хамгаалах чиглэлээр олон улсын гэрээ хэлэлцээрт нэгдэх.

7. Албан хаагчдын ур чадварыг нэмэгдүүлэх

• **Мэргэжил дээшлүүлэх сургалт**: Олон улсын хуулийн чиглэлээр гүйцэтгэх албан хаагчдад сургалт явуулах.

• **Технологийн сургалт**: Орчин үеийн техник хэрэгсэл ашиглах, мэдээллийн аюулгүй байдал хангах сургалтуудыг нэмэгдүүлэх.

Дүгнэлт

Монгол Улсын гүйцэтгэх ажлын хуулийг олон улсын жишигт ойртуулахын тулд хүний эрхийг хамгаалах, ил тод байдлыг хангах, технологийн зохицуулалтыг хөгжүүлэх, хяналтын тогтолцоог сайжруулах, болон олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд анхаарах нь чухал. Энэ нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, иргэдийн эрхийг хамгаалахад үр дүнтэй, олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн хууль эрх зүйн тогтолцоо бий болгох нөхцөлийг бүрдүүлнэ.

Монгол Улсын "Гүйцэтгэх ажлын тухай" хууль нь үндэсний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн ч олон улсын стандарт, хүний эрхийг хангах үзэл баримтлалд бүрэн нийцээгүй байгаагийн улмаас сорилтууд тулгарч байна. Тухайлбал:

1.Хүний эрхийн хамгаалалт сул:

○ Хүний хувийн нууцад халдах, хяналтгүй тагнаж чагнах зэрэг үйл ажиллагаанд хууль эрх зүйн зохицуулалт хангалтгүй байна.

○ Шүүхийн зөвшөөрөлгүйгээр гүйцэтгэх ажиллагаа явуулах нь хүний эрхийн зөрчлийг нэмэгдүүлэх эрсдэлтэй.

2.Нууцлал ба ил тод байдлын зөрчил:

○ Гүйцэтгэх ажлын явцад олж авсан мэдээлэл, тайланг олон нийтэд тайлагнах механизм дутмаг.

○ Иргэдийн мэдээлэлд хандах эрх хязгаарлагдмал байгаа нь төрд итгэх итгэлд сөргөөр нөлөөлж байна.

3.Технологийн дэвшилтэй нийцэхгүй байдал:

○ Орчин үеийн дэвшилтэт технологийг хууль ёсны дагуу ашиглах, хяналтын механизмыг зохицуулах хэрэгцээ шаардлага өндөр байна.

○ Кибер аюулгүй байдал, техник хэрэгслийн зохицуулалт сул байгаа нь гүйцэтгэх ажлын үр нөлөөг бууруулж байна.

4.Хяналтын тогтолцооны дутагдал:

○ Хяналтын байгууллагуудын хараат бус байдал хангалтгүй, ил тод хяналт, гомдол шийдвэрлэх тогтолцоо хангалтгүй.

Шийдвэрлэх шаардлагатай асуудлууд

• Хүний эрхийг хамгаалах чиглэлд шүүхийн хяналтыг нэмэгдүүлж, хууль эрх зүйн баталгааг бэхжүүлэх.

• Нууцлал болон ил тод байдлын тэнцвэрийг хангахуйц зохицуулалтыг хуульд тусгах.

• Технологийн дэвшилтэй уялдсан тусгайлсан зохицуулалт, кибер аюулгүй байдлыг хангах механизм хэрэгжүүлэх.

• Хяналтын байгууллагуудыг бие даасан, хараат бус болгох.

Олон улсын жишгийг нутагшуулах

• АНУ, ЕХ, Канад зэрэг орны хүний эрх, ил тод байдлын стандарт, хяналтын тогтолцоог Монгол Улсын нөхцөлд нийцүүлэн нутагшуулах.

• НҮБ болон олон улсын хүний эрхийн байгууллагуудын зөвлөмж, туршлагыг хуульд тусгах.

• Олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлж, дэвшилтэт техник, сургалт, мэдээлэл солилцоог нэмэгдүүлэх.

Ерөнхий дүгнэлт

Монгол Улсын "Гүйцэтгэх ажлын тухай" хуульд хүний эрхийг дээдлэх, нууцлал ба ил тод байдлыг тэнцвэржүүлэх, технологийн зохицуулалтыг хөгжүүлэх, хяналтын тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр олон улсын стандартад нийцсэн шинэчлэл хийх шаардлагатай. Энэ нь Монгол Улсын хууль зүйн тогтолцоог илүү үр нөлөөтэй, шударга, аюулгүй болгож, үндэсний болон олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдөх боломжийг нэмэгдүүлнэ.

Ашигласан материалын жагсаалт

1.Монгол Улсын хууль тогтоомж:

• Монгол Улсын "Гүйцэтгэх ажлын тухай" хууль

• Монгол Улсын Үндсэн хууль

• Хүний эрхийг хамгаалахтай холбоотой Монгол Улсын хуулиуд (жишээ нь, Хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль 2022 он)

2.Олон улсын баримт бичиг ба стандарт:

• НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглал

• Европын Холбооны Хүний эрхийн конвенц (ECHR)

• АНУ-ын Freedom of Information Act (FOIA)

• Inspector General Act (АНУ)

3.Судалгааны материал, тайлангууд:

• Privacy International болон Transparency International-ийн тайлангууд

• Хүний эрхийн үндэсний болон олон улсын байгууллагуудын судалгаанууд

• Монгол Улсын хууль эрх зүйн орчинд хяналт, хүний эрхийн талаар хийсэн дотоодын судалгаа, тайлангууд

4.Олон улсын туршлага:

• АНУ, ЕХ, Канад, Израиль зэрэг орнуудын хууль сахиулах, хяналтын тогтолцоо

• Олон улсын кибер аюулгүй байдлын зохицуулалтууд

5.Шинжээчдийн зөвлөмж, практик туршлага:

• Хууль зүйн салбарын мэргэжилтнүүдийн санал, зөвлөмж

• Монгол болон олон улсын практик үйл ажиллагааны хураангуй дүгнэлтүүд

1. Монгол Улсын хууль, баримт бичиг

1.Монгол Улсын "Гүйцэтгэх ажлын тухай" хууль (Хууль эрх зүйн тогтолцооны үндсэн баримт бичиг)

2.Монгол Улсын Үндсэн хууль (1992)

3."Хувийн мэдээллийг хамгаалах тухай" хууль (2021)

2. Олон улсын баримт бичиг

○НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглал (1948)Хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах суурь зарчим.

2.Европын Холбооны Хүний эрхийн конвенц (ECHR)

○Хүний эрхийг хангах, хяналтын тогтолцоог сайжруулах стандарт.

3.АНУ-ын Freedom of Information Act (FOIA)

○Мэдээллийн ил тод байдлыг хангах, иргэдийн мэдээлэл авах эрхийг хамгаалах хууль.

3. Судалгааны материал, тайлан

1.Privacy International-ийн судалгаанууд

○Нууц ажиллагаа ба хүний эрхийн талаар дэлгэрэнгүй судалгааны тайлан.

○"Surveillance and Human Rights in the Digital Age" (2020)

2.Transparency International-ийн тайлангууд

○Хяналтын ил тод байдлын үнэлгээ.

3.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тайлангууд

○Монгол Улс дахь хүний эрхийн нөхцөл байдал.

4.UNDP-ийн Монгол Улс дахь хууль зүйн салбарын үнэлгээ

○Олон улсын хүний эрхийн стандарт ба Монголын хууль зүйн орчны харьцуулалт.

4. Олон улсын туршлага

1.АНУ-ын Inspector General Act (1978)

○Хяналтын байгууллагын хараат бус байдлыг хангах хууль.

2.Израиль, Герман, Канадын кибер аюулгүй байдлын зохицуулалт

○Терроризм, кибер гэмт хэрэгтэй тэмцэх бодлого.

3.Шведийн Ил тод байдлын хууль (Transparency Act)

○Төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах.

5. Мэргэжилтнүүдийн зөвлөмж

1.Монгол Улсын хууль зүйн мэргэжилтнүүдийн судалгаанууд

○Жишээ: Цагдаагийн сургуулийн магистрын зэрэг хамгаалах ажлууд.

2.Олон улсын хууль зүйн шинжээчдийн дүгнэлтүүд

○НҮБ, Европын хүний эрхийн зөвлөлийн тайлангууд

КИБЕР ОРЧИНД ТЕЛЕГРАМ ПЛАТФОРМ АШИГЛАН ҮЙЛДЭЖ БУЙ ЗАЛИЛАХ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

THE SITUATION OF FRAUD CRIMES USING THE TELEGRAM PLATFORM IN THE CYBER ENVIRONMENT

Б.Хатанзориг
Эрүүгийн цагдаагийн албаны Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газрын Цахим мэдээлэл, дүн шинжилгээний хэлтсийн эрүүгийн ахлах мөрдөгч
Khatanzorig B.
Senior Criminal detective, Department of Digital Information & Analysis, Cybercrime Division, Criminal Police Agency

Хураангуй: Дэлхий дахинд орчин үеийн техник, технологи хөгжиж, нийгмийн бүхий л харилцаа цахим хэлбэрт шилжихийн хэрээр хүн төрөлхтөний цахим орчны хэрэглээ өсөн нэмэгдэж нийгэмд хөгжлийн шинэ боломж олгохын зэрэгцээ сөрөг үзэгдлүүдийг ч дагуулсаар байна. Үүний нэг илрэл нь кибер орчин ашиглан үйлдэгдэж буй гэмт хэрэг юм.

Кибер орчин ашиглан үйлдэгдэж буй гэмт хэрэг нь зах хязгааргүй интернэт орчноор дамжин үйлдэгддэг тул манай улсад мөн адил тус төрлийн гэмт хэрэг ихээр үйлдэгдэж, маш эрчимтэй хувьсан өөрчлөгдөж, шинэ үйлдлийн аргууд тогтмол илэрч байгаа билээ.

Сүүлийн үед Монгол улсад “Телеграм” платформ ашиглан үйлдэгдэж буй залилах гэмт хэрэг шинээр бий болж тус хэргийн гаралт эрс нэмэгдэж байгаа тул тус хэргийн шалтгаан нөхцлийг олж тогтоох, илрүүлэх, тэмцэх арга замыг эрэлхийлж дүн шинжилгээ хийж, санал дэвшүүлэх зорилгоор тухайн сэдвийг сонгосон нь уг сэдвийг судлах үндэслэл болно.

Эл судалгааны ажлыг шинжлэх ухааны судалгааны аргын нэг болох тоон судалгааны аргыг ашиглаж, тэр дундаа статистикийн арга, индукцийн арга зэргийг ашиглаж хийсэн болно. Судалгааны арга зүйн зарчмын хувьд бодитой хандах, тогтвортой байх, зохистой байх зарчмыг баримталсан.

Кибер гэмт хэрэг буюу цахим орчинд цахим хэрэгсэл ашиглан үйлдэгдэж буй гэмт хэргийн мөн чанар, ойлголт, өнөөгийн байдлын талаар эрдэм шинжилгээний цөөнгүй өгүүлэл нийтлэгдсэн. Тухайлбал, Л.Галбаатар "Кибер гэмт хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх нь" ном, Д.Булган "Кибер гэмт хэргийн мөн чанар, түүний шинжийг тодорхойлох нь", Б.Өнөрмаа "Цахим хэрэгсэл ашиглан үйлдэгдэж буй гэмт хэргийн шалтгаан нөхцөл, эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлага", Г.Мөнгөншагай "Цахим гэмт хэрэгтэй тэмцэж буй өнөөгийн байдал, эрх зүйн зохицуулалт", Д.Сумьяацэрэн "Монгол Улс дахь кибер гэмт хэргийн өнөөгийн байдал, дүгнэлт, санал", Б.Цэцэгмаа “Цахим гэмт хэрэгтэй тэмцэж буй өнөөгийн байдал, эрх зүйн зохицуулалт" зэрэг нэг сэдэвт бүтээлүүд гарч байсан байна.

Харин “Телеграм” платформ ашиглан үйлдэгдэж буй залилах гэмт хэргийн үйлдлийн арга, шалтгаан нөхцлийг урьд өмнө нь судалж байгаагүй тул энэхүү судалгааг хийснээр судалгааны үр дүнд үндэслэн практикт тухайн гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, таслан зогсоох арга замыг тодорхойлох ач холбогдолтой, цаг үеэ олсон шинэлэг судалгаа болсон.

Abstract: With the development of modern techniques and technology in the world and the transition of all social relations to electronic form, the increasing use of the electronic environment by human beings gives society new opportunities for development, but also brings negative phenomena. One of the manifestations of this is the crime committed using the cyber environment.

Crimes committed using the cyber environment are committed through the borderless Internet environment, so the same type of crimes are committed in our country, they are evolving very intensively, and new methods of operation are regularly appearing.

This article is published under the Creative Commons
BY-NC-SA License by 4.0, ©2025 University of Internal Affairs, Mongolia

Recently, fraud committed using the "Telegram" platform has been emerging in Mongolia, and the incidence of such cases has increased dramatically, so the subject was chosen for the purpose of analyzing and proposing ways to identify, detect, and combat the cause of the case.

This research work is done using quantitative research method, which is one of scientific research methods, including statistical method and induction method. In terms of research methodology, the principle of objectivity, stability, and appropriateness was followed.

Many academic articles have been published on the nature, concept, and current status of cybercrime, or crime committed using electronic tools in the online environment.

However, since the methods and causes of fraud committed using the "Telegram" platform have not been studied before, this research is useful and timely to determine ways to prevent, combat, and stop such crimes in practice based on the results of the research. innovative research.

Түлхүүр үгс: Телеграм платформ, кибер орчин, залилах гэмт хэрэг, дүн шинжилгээ.

Keywords: Telegram platform, cyber environment, fraud crimes, analysis.

Удиртгал

Олон улсын судалгааны “Datareportal” байгууллагаас жил бүр гаргадаг “DIGITAL 2024: MONGOLIA” судалгааны тайлангаар Монгол Улс 2024 оны эхний байдлаар 2.91 сая интернэт хэрэглэгчидтэй буюу нийт хүн амын 83.9 хувь нь интернэт ашигладаг гэх судалгаа гаргасан байна. (Simon, 2024) Энэ нь Монгол улсын хүн амын интернэтийн хэрэглээ хэр их байгааг харуулж байна.

Монгол улсын интернэт хэрэглэгчдийн тоо ихсэх тусам кибер орчинд үйлдэгдэж буй гэмт хэргийн гаралт ихсэх хандлагатай байх бөгөөд сүүлийн үед “Телеграм” платформыг ашиглан үйлдэгдэж буй залилах гэмт хэрэг эрс нэмэгдэж байна.

Иймд кибер орчин ашиглан үйлдэгдэж буй залилах гэмт хэргийн гаралт, шалтгаан нөхцлийг тодруулахаар телеграм платформ ашиглан үйлдэгдсэн залилах гэмт хэргүүдийн судалгааг гаргаж, дүн шинжилгээ хийхэд уг өгүүллэгийн зорилго оршино.

Дээрх судалгааны ажлыг хийхдээ төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсээс телеграмм платформ ашиглан үйлдэгдсэн хэргийн судалгаа авч, тоон өгөгдлийг боловсруулж, үр дүнг тоон үзүүлэлтээр илэрхийлж, тоон мэдээлэлд үндэслэн дүгнэлт хийж, таамаглал дэвшүүлсэн болно.

Үндсэн хэсэг

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт Монгол улсын иргэний өмчлөх эрхийг “...хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй...” гэж хуулиар баталгаажуулсан байдаг. (Монгол Улсын Үндсэн Хууль, 1992)

Дээрхээс бусад тохиолдлоор бусдын эзэмшил, өмчлөлд байгаа аливаа хөрөнгийг өөрт авахыг гэмт явдал гэж үзэж болох бөгөөд гэмт явдал үйлдсэн этгээдийн учруулсан хор уршгаас шалтгаалж тухайн харилцаа тохирсон салбар хуулиудаар зохицуулагдана.

Өмчлөх эрхийн эсрэг гэмт явдалд тодорхой төрлийн үйлдлүүд хамаарах ба үүний нэг нь Эрүүгийн хуулийн 17 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан “Залилах” гэмт хэрэг юм.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 17 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт залилах гэмт хэргийг “Хуурч, эсхүл баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглаж, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох, сүсэг бишрэлийг далимдуулах, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж, эсхүл нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглаж эзэмшигч, өмчлөгчийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авсан...” гэж хуульчилсан байдаг. (Монгол Улсын Эрүүгийн Хууль, 2015)

Залилах гэмт хэргийн талаарх ойлголтыг зарим эрдэмтэд өөр өөрсдийн байр суурьнаас залилах гэмт хэргийн хөгжлийн үе шат бүрд янз бүрээр дараах байдлаар тодорхойлсон байна.

Академич, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор С.Нарангэрэлийн тодорхойлсноор Залилан

мэхлэх гэж өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, хүч хэрэглээгүй ашиглан шамшигдуулах хэлбэр. Залилан мэхлэх нь бусдын эд хөрөнгө, эсхүл түүний өмчлөх эрхийг хуурч мэхлэх, итгэл эвдэх аргаар авах. (Нарангэрэл, 2008, х.202)

Хууль зүйн ухааны доктор Д.Адъяабазарын тодорхойлсноор залилан мэхлэх гэмт хэрэг гэдэг нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжоор хамгаалагдсан бусдын өмчлөх эрхэд хуурч мэхлэх буюу итгэл эвдэх аргаар халдаж хохирол учруулсан, ял шийтгэгдвэл зохих, гэм буруутай Эрүүгийн хуулийн тусгай ангийн 148 дугаар зүйлд хуульчлагдсан нийгэмд аюултай, үйлдэл, эс үйлдэхүй юм. (Адъяабазар, 2004, х.64)

Хууль зүйн ухааны доктор /Ph.D/ Б.Ганболдын тодорхойлсноор "Залилан мэхлэж авах" гэдэг нь эд хөрөнгө, мөнгө, үнэт зүйл, түүнийг өмчлөх эрхийг эзэмшиж, эрхлэн хариуцаж, харж хамгаалж байгаа этгээдийг хуурч мэхлэх буюу итгэлийг эвдэх замаар, шунахай сэдэлтээр авч буй идэвхитэй үйлдэл юм. Залилан мэхлэх буюу итгэл эвдэх замаар, шунахай сэдэлтээр авч буй идэвхитэй үйлдэл юм. (Ганболд, 2009, х.301)

Хууль зүйн ухааны доктор /Ph.D/ С.Гантулга, Б.Энхболд нарын тодорхойлсноор залилах гэмт хэрэг гэж бусдын өмчлөх эрхэд гэм буруугийн санаатай хэлбэрээр халдсан, Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйлд заасан нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл (Гантулга & Энхболд, 2018, х.161) гэж тус тус тодорхойлсон байна.

Дээрх эрдэмтдийн тодорхойлолтуудаас үзэхэд залилах гэмт хэргийн ойлголт, мөн чанар хүн төрөлхтөний хөгжил дэвшлийн аль ч үе шатад алдагдалгүй өнөө үед ирсэн байна. Гагцхүү хүн төрөлхтөний хөгжил дэвшилтэй шууд холбоо хамааралтайгаар залилах гэмт хэргийн үйлдлийн арга хувьсан өөрчлөгдсөн нь ажиглагдаж байна.

Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт залилах гэмт хэрэг үйлдэх үйлдлийн аргыг зааж өгсөн байдаг тул бусад аргаар бусдын эд хөрөнгийг авсан бол өмчлөх эрхийн эсрэг бусад гэмт хэргээр зүйлчлэгдэнэ.

Монгол Улсад үйлдэгдэж буй залилах гэмт хэргийг үйлдэгдэж буй арга хэлбэр талаас нь авч үзвэл:

- Урьдаас төлөвлөж иргэний эрх зүйн харилцааг ашиглан гэрээ, хэлцэл хийх замаар халхавчилж,
- Цахим хэлбэрээр буюу олон нийтийн сүлжээ ашиглаж улс дамнан;
- Өөрийн ажил, мэргэжил, авъяас чадвар, нэр хүндээ ашиглаж;
- Гадаадад ажиллах хүч гаргахад зуучлах нэрээр, мөн Монгол улсын цалин хангамж өндөртэй аж ахуй нэгж байгууллагуудад ажилд оруулж өгнө гэж амлаж;
- Урьдын харьцааг урвуулан шашин шүтлэг, сүсэг бишрэл, хобби, танил талын хүрээллийг ашиглаж;
- Олон шатлалт маркетинг, пирамид тогтолцооны луйврын аргаар;
- Эрх зүйн олон төрлийн харилцаа болон нийгэм, эдийн засгийн харилцааг холилдуулан гадаад дотоодын хөрөнгө оруулагч, гадаадын иргэн, харъяалалгүй хүнийг залилах ... гэх мэт олон төрлийн арга хэлбэрээр энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэж байна.

21-р зуунд хүн төрөлхтөний хамгийн том дэвшлийн нэг нь кибер орчны хэрэглээ бөгөөд үүнийгээ дагаад гэмт хэргүүд ч мөн адил цахим хэлбэр рүү шилжиж кибер гэмт хэргийн талаарх ойлголтууд бий болсон.

Дэлхийд хамгийн анх бүртгэгдсэн кибер гэмт хэрэг 1820 онд үйлдэгдсэн гэж үздэг. Францын нэхмэлийн үйлдвэрийн эзэн Жозеф Мари Жаккард нэхмэлийн суурь машин хийсэн нь ажилтнуудыг ажилгүй болгох эрсдлийг дагуулж байна гэж үзсэн зарим ажилтан уг төхөөрөмжийг ажиллагаагүй болгох гэмт хэрэг үйлдсэн нь анхны кибер гэмт хэрэг гэж тооцогддог. (Халтар, 2018)

"Кибер гэмт хэрэг" гэсэн нэр томьёо нь 1986 онд мэдээллийн системийн хөгжилтэй холбоотой үүссэн ч улс орнуудын эрх зүйн зохицуулалт, эрдэмтэн судлаачдын бүтээлд "Цахим гэмт хэрэг", "Компьютерын гэмт хэрэг", "Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг" гэх мэт

олон нэр томьёо хэрэглэдэг. Компьютерын гэмт хэрэг буюу хууль бус зорилгодоо хүрэхийн тулд компьютер, компьютерын сүлжээ, интернэт ашиглан үйлдэж буй хууль бус үйлдлийг хамтатган "Кибер гэмт хэрэг" гэж нэрлэх болсон. (Өмгөөллийн Фиделитас Партнерс ХХН, 2002, х.15)

Сүүлийн жилүүдэд кибер гэмт хэргүүд уламжлалт гэмт хэргээс тоо, хохирлын хувьд давж гарах болсон байна. Эрсдэл болон зардал бага, унац ихтэй тэр газарт түүнийг ашиглах гэсэн хүмүүс борооны дараах мөөг шиг олширдог. Яг энэ байдал кибер орон зай, Интернетийн орчинд үүсээд байна. Компьютер, мэдээллийн технологийн багахан ч гэсэн мэдлэг чадвартай, ашиг олохыг хүссэн, шударга бус хэн бүхэн энэ орон зайг ашиглан ашиг олохын төлөө улайран зүтгэх болсон. Түүнээс гадна энэ чиглэлийн эрх зүйн орчин сул, зарим улсад огт бүрэлдэн тогтоогүй, компьютер, тооцоолох төхөөрөмж, програм хангамжид эмзэг сул байдал, цоорхой их байдаг, байгууллага, хүмүүс мэдээллийн аюулгүй байдлаа хангах, сүлжээ, интернетэд зөв, зохистой ажиллах чадвар, мэдлэг, туршлага муутай, кибер орчинд ул мөр бага үлддэг, нотлох баримт нь тогтвортой бус, бэхжүүлж авахад хүндрэлтэй, хууль хяналтын байгууллагуудын чадвар төлөвшөөгүй, чадварлаг мэргэжилтэн ховор зэргээс илрэх магадлал нь уламжлалт гэмт хэргүүдээс хэд дахин бага байдаг нь кибер гэмт хэрэгтнүүдийн дураараа аашлах боломжийг олгож байна. (Халтар, 2018)

Будапештийн конвенцод компьютерын мэдээлэл, сүлжээний эсрэг гэмт хэрэг, компьютерын мэдээлэл, сүлжээний тусламжтай үйлдсэн гэмт хэрэг гэх хоёр шинжийг хамтатган кибер гэмт хэргийг тодорхойлж, түүнийг дөрвөн төрөлд ангилсан. Будапештийн конвенцын хоёрдугаар бүлгийн "Эрүүгийн материаллаг хууль" гэх нэгдүгээр хэсэгт 4 төрөл, нийт 9 гэмт хэргийг тусгасан. Үүний нэг нь кибер орчин ашиглаж үйлдсэн залилах гэмт хэрэг юм. (Өмгөөллийн Фиделитас Партнерс ХХН, 2002, х.17)

Манай улсын хувьд энэ оны эхний 09 сарын байдлаар цагдаагийн байгууллагад нийт 24,811 гэмт хэрэг бүртгэгдэн шалгагдаж байна. Залилах гэмт хэрэг 7063 буюу нийт гэмт хэргийн 28.5% хувийг эзэлж байгаа бол үүнээс 4095 буюу 58% хувь нь кибер орчинд үйлдэгдэж байна. (ЦЕГ-ын МДШШУА, 2024)

Дээрх судалгаанаас дүгнэхэд кибер орчинд үйлдэгдсэн залилах гэмт хэргийн үйлдлийн аргууд хурдацтай шинэчлэгдэн, хувьсаж тасралтгүй нэмэгдэж байгаа бөгөөд 2030 он гэхэд энэ төрлийн гэмт хэрэг 30,000 бүртгэгдэж оргил үедээ хүрэх эрсдэлтэй прогноз гарч байна.

Иймд сүүлийн үед кибер орчин ашиглан ихээр үйлдэгдэж байгаа залилах гэмт хэргийн нэгэн төрөл болох телеграм платформ ашиглан үйлдсэн залилах гэмт хэргийн гаралт, шалтгаан нөхцлийг судалж, таслан зогсоох шаардлага нэн тэргүүнд тулгараад байна.

“Телеграм” платформыг ОХУ-ын иргэн Павел Дуров, Николай Дуров нар 2013 онд үүсгэн байгуулсан. Телеграм платформ нь 950 сая гаруй идэвхтэй хэрэглэгчидтэй бөгөөд дэлхийн хүн амын хамгийн их ашигладаг программын нэг юм. Телеграм нь аюулгүй байдал, нууцлалыг нэгдүгээрт тавьдаг учраас энэ нь тус платформыг хэрэглэгчдийн тоог тасралтгүй нэмэх гол шалтгаан болдог байна.

Телеграм нь өөрийн өвөрмөц хамгаалалтын функцтэй бөгөөд телеграм дээрх бүх үйл ажиллагаа, түүний дотор хэрэглэгчдийн хооронд хуваалцсан чат, групп, медиа шифрлэгдсэн байдаг тул эхлээд шифрийг нь тайлахгүйгээр харагдахгүй гэсэн үг юм. (Telegram, 2013)

Монгол улсад телеграм платформ ашиглан үйлдэгдсэн залилах гэмт хэргийн судалгааг гаргахад цагдаагийн байгуулагад нийт 277 бүртгэгдэн, шалгагдаж байгаа бөгөөд нийт 277 хохирогчид 3,991,894,493 төгрөгний хохирол учруулсан нөхцөл байдалтай байна. Нутаг дэвсгэрээр задлан харуулбал:

Орон нутгийн хэмжээнд:

Телеграм платформд үйлдэгдсэн нийт залилах гэмт хэргийн 77 буюу 27.8% нь орон нутагт үйлдэгдсэн байх бөгөөд 1,435,009,822 төгрөгний хохирол учруулсан байна.




Зураг 1. Орон нутгийн хэмжээнд үйлдэгдсэн гэмт хэрэг

Нийслэлийн хэмжээнд:


Нийслэлийн хэмжээнд 200 буюу 72.2% нь үйлдэгдсэн байх бөгөөд 2,556,881,671 төгрөгний хохирол учруулсан байна.

Зураг 2. Нийслэлийн хэмжээнд үйлдэгдсэн гэмт хэрэг



Телеграм платформ ашиглан үйлдэгдсэн залилах гэмт хэргийн хохирогчдын талаар:

Цагдаагийн байгууллагад шалгагдаж байгаа нийт телеграм платформд үйлдэгдсэн залилангийн 65% буюу 3 хохирогч тутмын 2 нь эмэгтэй хүн байна. Мөн нийт хохирогчдын 69%-ийг 25-44 насны залуучууд эзэлж байна.



Зураг 3. Хохирогчдын нас, хүйс

Хохирогчдыг нийгмийн оролцоогоор нь ангилан авч үзвэл нийт хохирогчдын 45% хувь нь хувийн хэвшилд буюу /ченж, уурхайн оператор, мужаан, хүргэлтийн ажилтан, үсчин, менежер, засварчин, тогооч г.м/ ажил, хөдөлмөр эрхэлдэг хүмүүс эзэлж байна.



Зураг 4. Хохирогчдын нийгмийн байдал

Хохирогчдыг боловсролын түвшнээр нь ангилан авч үзбэл 14 буюу 5%-ийг бага дунд, 92 буюу 33%-ийг бүрэн дунд, 172 буюу 62%-ийг дээд боловсролтой хүмүүс эзэлж байна.



Зураг 5. Хохирогчдын боловсрол

Телеграм платформд үйлдэгдсэн хэргүүдийн үйлдлийн аргуудад дүн шинжилгээ хийхэд дараах **6** төрлийн аргаар гэмт хэрэг үйлдэж байгаа нь тогтоогдсон. Үүнд:

1. Бараа худалдан авч, борлуулалт нэмэгдүүлэх даалгавар **158 (57%/)**
2. Тик ток хаяг дагах, өгөгдсөн постод лайк дарж хандалт өсгөх даалгавар **44 (15.8%)**
3. Байгууллагын үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, зар сурталчилгаанд үнэлгээ өгөх даалгавар **39 (14%)**
4. Өгөгдсөн дансанд мөнгө байршуулаад өсгөж авах даалгавар **31 (11.1%)**
5. Зээл олгоход шаардлагатай материал бүрдүүлэх даалгавар **3 (1.08%)**
6. Өгөгдсөн интернэт банкаар нэвтэрч гүйлгээ хийх даалгавар **2 (1.02%)** тус тус эзэлж байна.

Дүгнэлт, санал

Цагдаагийн байгууллагад телеграм платформ ашиглан үйлдэгдсэн залилах гэмт хэрэг энэ оны 07 дугаар сараас хойш 277 бүртгэгдэн, шалгагдаж байгаа бөгөөд 3,991,894,493 төгрөгний хохирол учруулсан байгаагаас дүгнэхэд оны эцэст энэ төрлийн гэмт хэрэг 1000 гаруй бүртгэгдэж 12 тэрбум төгрөгний хохирол учруулж болзошгүй байна.

Иймд энэ төрлийн гэмт хэргийн гаралтыг бууруулах, иргэдэд кибер орчинд үйлдэгдэж буй залилах гэмт хэргийн талаарх ойлголтыг бий болгох, түүнээс урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээг зөв, оновчтой хэрэгжүүлэх зайлшгүй хэрэгцээ шаардлагатай гэж үзэж байна.

Энэ төрлийн гэмт хэргийн хохирогчид нь 25-44 насны залуучууд байх бөгөөд 3 хохирогч тутмын 2 нь эмэгтэй хүн байна. Гэмт этгээдүүдийн чиглэсэн сегмент нь амар хялбар аргаар санхүүгийн эх үүсвэр бүрдүүлэх гэсэн тогтвортой орлогогүй эмэгтэйчүүд тэр дундаа хүүхдээ гэртээ асардаг залуу ээжүүд байж болзошгүй нөхцөл байдал ажиглагдаж байна.

Мөн телеграм платформ хэрэглэгчдийг автоматаар групп чатанд нэмж, тухайн групп чатаараа дамжуулж иргэдийг төөрөгдөлд оруулсан амар хялбар аргаар мөнгө олох боломжтой мэт худал мэдээлэл дамжуулж итгэл үнэмшил төрүүлж байгаа нөхцөл байдал тогтоогдсон.

Олон улсад энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх технологийн шийдэл, арга замыг хараахан олж тогтоогоогүй байгаа ба одоогийн байдлаар иргэд олон нийт рүү чиглэсэн урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулан ажиллаж байна.

Үүний нэг илрэл нь телеграм платформ хэрэглэгчдэд танихгүй хэрэглэгчдээс зурвас, хүсэлт хүлээн авахгүй байх хувийн тохиргоо хийхийг зөвлөж байгаа явдал юм.

Иймд олон улсад телеграм платформ ашиглан үйлдэгдэж буй гэмт хэргээс

урьдчилан сэргийлэх зорилгоор ашиглаж буй тус аргыг ЦЕГ-ын Урьдчилан сэргийлэх газраар дамжуулан иргэд олон нийтэд сурталчилж урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах,

Телеграм платформ ашиглан үйлдэгдэж байгаа залилах гэмт хэрэгтэй тэмцэж буй гадаад улс орны туршлагыг судлан өөрийн оронд нэвтрүүлэх,

Гадаад улс орны туршлага дээр суурилж телеграм платформд үйлдэгдсэн залилах гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох дагнасан чиг үүрэг бүхий мэргэшсэн мөрдөгч бэлтгэх,

Мөрдөн шалгах ажиллагаанаас үүдэн гэмт этгээдүүд хууль бусаар олсон хөрөнгийг гадаад улс руу гаргасан бол эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээний дагуу тухайн улстай хамтран мөрдөн шалгах ажиллагааг үргэлжлүүлэх саналтай байна.

Эх сурвалж

Монгол Улсын Их Хурал. (1992). Монгол Улсын Үндсэн Хууль. Улаанбаатар.

Монгол Улсын Их Хурал. (2015). Монгол Улсын Эрүүгийн Хууль. Улаанбаатар.

Адъяабазар, Д. (2004). Монгол Улсад залилан мэхлэх гэмт хэрэгтэй хийх эрүүгийн эрх зүйн тэмцлийн тулгамдсан асуудал сэдэвт докторын зэрэг горилсон бүтээл. Улаанбаатар.

Ганболд, Б. (2009). Эрүүгийн эрх зүйн мэдлэг. Улаанбаатар.

Гантулга, С., & Энхболд, Б. (2018). Эрүүгийн эрх зүй тусгай анги. Улаанбаатар.

Нарангэрэл, С. (2008). Эрх зүйн эх толь бичиг. Улаанбаатар: Соёмбо принтинг.

Өмгөөллийн Фиделитас Партнерс ХХН. (2002). Кибер гэмт хэргийн зохицуулалтын талаарх харьцуулсан. Улаанбаатар.

Халтар, Т. (2018). Өмчлөх эрхийн эсрэг кибер гэмт хэрэг, урьдчилан сэргийлэх асуудлууд нэг сэдэвт бүтээл. Улаанбаатар.

ЦЕГ-ын МДШШУА. (2024). Гэмт хэргийн статистик. Улаанбаатар.

Simon, K. (2024). Digital 2024:Mongolia. Singapore.

Telegram. (2013, 8 14). Retrieved from https://telegram.org/

МОНГОЛ УЛС ДАХЬ ЦАХИМ ХЭРЭГСЭЛ АШИГЛАЖ ҮЙЛДСЭН ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ЧИГ ХАНДЛАГА

THE SITUATION AND TRENDS OF HUMAN TRAFFICKING VIA DIGITAL PLATFORMS IN MONGOLIA

Х.Баатарбилэг
Дотоод хэргийн их сургуулийн докторант
Kh. Baatarbileg
Doctoral student, University of Internal Affairs, Mongolia

*хариуцлагатай зохиогч: Baatarbileg.Kh@gmail.com

Хураангуй: Цахим шилжилтийн эрин үед гэмт хэргийн “ертөнц” ч техник, технологитой илүү салшгүй холбоотой болж, хүн худалдаалах гэмт хэргийн шинжтэй үйлдлүүд интернэт платформ, нийгмийн сүлжээгээр өргөн тархаж байна. Тодруулбал, сүүлийн жилүүдэд мэдээлэл, харилцаа холбооны технологийн хурдацтай хөгжил нь хүн худалдаалах гэмт хэргийн динамик, бүтэц, үйлдлийн арга хэлбэрт гүнзгий нөлөө үзүүлж байна. Цахим орчин, цахим хэрэгсэл, мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшилтэт тал нь гэмт этгээдүүдэд хохирогчийг элсүүлэх, албадлагаар ажиллуулах, мөлжих болон тэдгээрийн үүсгэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах, худалдаалах зэрэг гэмт хэргийн бүхий л үе шатанд ашиглах боломжийг олгож байна. Мөн олсон хууль бус орлогыг санхүүгийн системээр дамжуулан халхавчлах, далдлахад цахим технологийн тусгай аргуудыг ашиглаж буй нь мөрдөн шалгах, гэмт хэргийг нотлох, яллах ажиллагааг нарийн, төвөгтэй болгож байна.

Энэхүү өгүүлэлд цахим хэрэгсэл ашиглаж үйлдэгдсэн хүн худалдаалах гэмт хэрэг, мөн түүнтэй ижил төстэй гэмт явдлын чиг хандлагыг тодорхойлохыг зорьсон.

Abstract: In the era of digital transformation, the “world” of crime has become increasingly inseparable from technology, with human trafficking–related activities spreading widely through internet platforms and social networks. In recent years, the rapid development of information and communication technologies has profoundly influenced the dynamics, structure, and operational methods of human trafficking. The advancement of digital tools and communication technologies enables offenders to exploit victims at every stage of the crime—recruitment, coercion into labor or sexual exploitation, promotion, and commercialization of the products or services derived from exploitation. Moreover, offenders increasingly use sophisticated digital mechanisms to conceal and launder illicit proceeds through financial systems, thereby complicating investigation, evidence collection, and prosecution processes. This paper aims to analyze the current situation and trends of human trafficking crimes committed through the use of digital tools and electronic means, as well as similar criminal activities, in order to identify emerging patterns and challenges in this field.

Түлхүүр үгс: Хүн худалдаалах гэмт хэрэг, цахим орчин, цахим хэрэгсэл, гэмт хэрэг, бэлгийн мөлжлөг.

Keywords: Human trafficking, cyber environment, digital tools, crime, sexual exploitation.

Сүүлийн жилүүдэд дижитал технологи, цахим орчны хурдацтай хөгжил нь хүн худалдаалах гэмт хэргийн үйлдэл, зохион байгуулалт, арга хэлбэрийг эрс өөрчилж байна. Кибер орон зай нь гэмт этгээдүүдэд хохирогчийг элсүүлэх, хуурч мэхлэх, албадлагаар хөдөлмөр болон бэлгийн мөлжлөгт өртүүлэх, хууль бус ашиг олох зэрэг үйл ажиллагаагаа илүү нарийн төлөвлөгөөтэй, хяналт тавихад хүндрэлтэй орчинд хэрэгжүүлэх шинэ боломжийг олгожээ. Цахим платформ, нийгмийн сүлжээ, шуурхай зурвасын аппликэйшнүүд нь хохирогчийг энэ төрлийн гэмт хэрэгт татан оролцуулах, уруу татах, улмаар тэднийг хяналтдаа

This article is published under the Creative Commons BY-NC-SA License by 4.0, ©2025 University of Internal Affairs, Mongolia

байлгах гол хэрэгсэл болж хувирсан байна. Монгол Улсын хувьд цахим хэрэглээний түвшин хурдацтай өсөж, тэр дундаа өсвөр үе, залуусын нийгмийн сүлжээн дэх идэвхтэй байдлын түвшин өндөр байгаа нь кибер орчин дахь хүн худалдаалах гэмт хэргийн эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Цахим шилжилтийн прогресс нь зөвхөн эрсдэл төдийгүй мөрдөн шалгах, хэрэг хянан шийдвэрлэх, хохирогчийг хамгаалах үйл ажиллагаанд ч мөн шинэ боломжуудыг нээж өгч байна. Тухайлбал, мөрдөн шалгах, өгөгдөл задлан шинжлэх, геолокац, блокчэйн болон бусад цахим технологийн-сайн практикуудыг ашигласнаар гэмт бүлэглэлийн үйл ажиллагааг шуурхай илрүүлэх, нотлох баримтыг бэхжүүлэх ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэх боломжтой. Нөгөө талаас, олон нийтийн боловсрол, мэдээллийн түвшнийг дээшлүүлэхэд цахим платформууд чухал үүрэг гүйцэтгэж, хохирогчид, тэдний гэр бүл, нийгэмд сэрэмжлүүлэх, тусламжийн эх үүсвэр рүү чиглүүлэх мэдээллийг түргэн шуурхай хүргэх боломжтой.

Гэсэн хэдий ч, цахим орчны онцлогоос шалтгаалсан хүндрэл тулгарсаар байна. Тухайлбал, мөрдөгчдийн техник, технологи, эрх зүйн чиглэлийн ур чадварын хомсдол, олон улсын хил дамнасан цахим мөрдөх ажиллагааны зохицуулалт, түүний тодорхойгүй байдал, өгөгдөл хамгааллын шалтгаантай хязгаарлалт зэрэг нь гэмт хэргийн илрүүлэлт, баримт цуглуулалт, нотлох ажиллагааг хүндрүүлж байна. Эдгээр саад бэрхшээлийг даван туулахын тулд төрийн болон төрийн бус байгууллагууд, мөн олон улсын байгууллага, иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх, олон талт сургалт, мэдээлэл солилцох механизм, техникийн чадавхыг сайжруулах хэрэгцээ шаардлага байсаар байна.

Өөрөө хэлбэл, техник, технологийн хөгжил нь хүн худалдаалах гэмт хэргийн цар хүрээг тэлэх эрсдэлтэй хэдий ч, зөв зорилгоор, зохистой, ёс зүйн хүрээнд ашиглагдвал мөрдөн шалгах, хохирогчийг хамгаалах, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх зэрэг олон талын ашигтай үр нөлөөг бий болгох боломжтой. Иймд стратеги, бодлого, сургалт, олон салбарын хамтын ажиллагаанд төвлөрсөн иж бүрэн хандлагаар мэдээлэл, харилцаа холбооны технологийг гэмт хэрэгтэй тэмцэх, тэр дундаа энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд бүрэн ашиглах нь чухал байна. Энэ хүрээнд техникийн чадамжийг сайжруулах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, шинэчлэх, мэдээллийн бааз солилцоог олон улсын түвшинд зохицуулах, мөн иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх зэрэг практик алхмуудыг хэрэгжүүлэх нь зүйтэй.

Монгол Улсад 2015-2024 онд хүн худалдаалах гэмт хэрэг болон түүнтэй мөлжлөгийн хэлбэрээрээ төсөөтэй нийт 1089 гэмт хэрэг цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн байна. Тухайлбал, Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд заасан “Хүн худалдаалах” гэмт хэрэг 97, 12.3 дугаар зүйлд заасан “Бэлгийн мөлжлөг” 33, 12.5 зүйлд заасан “Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох” гэмт хэрэг 776, 16.8 дугаар зүйлд заасан “Хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах” гэмт хэрэг 161, 16.9 дүгээр зүйлд заасан хүүхэд ашиглаж садар, самууныг сурталчлах 44 гэмт хэрэг тус тус бүртгэгдсэн байна.

№	Гэмт хэргийн төрөл	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024
1	13.1 Хүн худалдаалах гэмт хэрэг	6	3	12	10	14	10	7	11	11	13

2	12.3 Бэлгийн мөлжлөг	-	-	2	7	6	3	3	2	3	7
3	12.5 Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох	30	28	40	83	118	69	75	85	130	118
4	16.8 Хүүхдэд садар, самууныг сурталчлах, уруу татах	1	-	-	8	16	8	16	40	40	32
5	16.9 Хүүхэд ашиглаж садар самууныг сурталчлах	-	-	-	-	-	2	6	8	6	-

Хүснэгт 1. Сүүлийн 10 жилийн хугацаанд бүртгэгдсэн хүн худалдаалах, түүнтэй ижил төстэй гэмт хэргийн тоо

Хүн худалдаалах гэмт хэргийг тодорхойлох нэг гол шинж нь хүнийг мөлжих буюу ашиг олох зорилгоор элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, орогнуулах буюу хүлээн авах үйлдлийн аль нэг нь хийгдсэн байх ёстой. Гэсэн хэдий ч, хүн худалдаалах гэмт хэргийг заавал нэг байршлаас нөгөөд шилжүүлэх, өөр орон нутгаас өөр орон нутаг руу, нэг улсаас нөгөө улс руу тээвэрлэж байж үйлдэгддэг гэж үзэхгүй бөгөөд нэг нутаг дэвсгэрт зорчих эрхийг хязгаарлаж болон хязгаарлахгүйгээр үйлдэгддэг онцлогтой.





График 1. Сүүлийн 10 жилийн хугацаанд бүртгэгдсэн хүн худалдаалах гэмт хэргийн тоо

Он	Хүн худалдаалах гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйл/				
	Хэрэг	Холбогдогч	Хохирогч		
			Нийт	Хүүхэд	Гадаад улсад хохирсон
2019	12	20	41	13	6
2020	5	8	33	10	5
2021	5	6	21	10	-
2022	6	10	31	15	-
2023	11	22	23	12	11
2024	13	8	12	1	1

Хүснэгт №2. Кибер орчныг ашиглаж үйлдсэн хүн худалдаалах, бэлгийн мөлжлөг гэмт хэргийн холбогдогч, хохирогчийн тоо

АНУ-ын Элчин сайдын яамнаас жил бүр эрхлэн гаргадаг “Хүн худалдаалах асуудлын төлөв байдлын тухай 2022 оны тайлан” (ЭСЯам, 2022) -д “Монголын эрэгтэй, эмэгтэй хүмүүс болон хүүхдүүдийг албадан хөдөлмөр эрхлүүлэхээр Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Бүгд Найрамдах Чех Улс, Унгар Улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улс, Бүгд Найрамдах Казакстан Улс, Норвегийн Хант Улс, Шведийн Хант Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Турк Улс болон Арабын Нэгдсэн Эмират улс, бэлгийн мөлжлөгийн зорилгоор Бельгийн Хаант Улс, Камбожийн Хаант Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Хонконг Улс, Япон Улс, Макао, Малайз, Филиппин, Бүгд Найрамдах Солонгос Улс, Шведийн Хант Улс, Бүгд Найрамдах Турк Улс, Америкийн Нэгдсэн Улс руу худалдаж байна. Монгол Улсын иргэд Бүгд Найрамдах Турк Улс руу визгүй зорчдог, шууд нислэгтэй, цар тахлын улмаас Бүгд Найрамдах Хятад Ард Улс хилээ хааснаар хүмүүсийн аялал, хөдөлгөөний чиглэл өөрчлөгдөн шинэчлэгдсэнтэй холбогдуулан БНТУ яваандаа хүлээн авагч орон болох магадлал байна” гэжээ.

Зураг 1. Монгол Улсын иргэд хүн худалдаалах гэмт хэрэгт өртөж буй зураглал (IRIM, 2021)



Мөн эцэг, эхийнх нь зөвшөөрөлтэйгээр байгуулсан гэрээний нэрийн дор ажиллуулж байсан Монгол Улсын уран нугараач өсвөр насныхан, залуухан эмэгтэйчүүдийг гол төлөв Турк Улсад, мөн Хонконг болон Сингапур зэрэг орнуудад хөдөлмөрийн мөлжлөгт өртүүлэх тохиолдол бүртгэгдсэн байна.

Үүнээс гадна Монгол охид, эмэгтэйчүүдийг “Монгол бариа” нэрийн дор үйл ажиллагаа явуулдаг газруудад болон хууль бус үйлчилгээний байгууллагуудад ажиллуулах замаар бие махбодын болон эдийн засгийн шахалт, дарамтад оруулж, бэлгийн мөлжлөгт өртөх эрсдэл өндөр байгааг судалгаанууд тэмдэглэж байна. Ийнхүү зочид буудал, баар, караоке, шөнийн цэнгээний газар зэрэг үйлчилгээний салбарт бүрэн эрхийн зөрчилтэй хөдөлмөр ашиглах нь хүний эрхийн ноцтой зөрчилд тооцогддог.




График 2. Сүүлийн 10 жилийн хугацаанд бүртгэгдсэн бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн тоо

Монгол Улсад үйлдэгдэж буй хүн худалдаалах гэмт хэргийг дараах 3 чиглэлд ангилж үзэж болохоор байна. Үүнд:

1.Монгол Улсаас гадаад улсын чиглэлд;

2.Гадаад улсаас Монгол Улсын чиглэлд;


3.Монгол Улс дотооддоо.

1.Монгол Улсаас гадаад улсын чиглэлд.

Монгол Улсаас гадагшаа улс хооронд үйлдэгдэж буй хүн худалдаалах гэмт хэргийн урсгал чиглэлийн хүрээ нь газар зүйн хувьд ойр Азийн улс орнуудад илүүтэй төвлөрч байгаа боловч дэлхийн маш олон оронд Монгол Улсын иргэд худалдаалагдаж хохирогч болсон тохиолдлууд бүртгэгдсэн байна.

Хүн худалдаалах гэмт хэргийн чиглэлээр хийгдсэн судалгааны тайлан, хохирогчдыг эгүүлэн татах үйл ажиллагаа зохион байгуулж, хамтарч ажилласан орнуудыг харгалзан үзвэл, хүн худалдаалах гэмт хэргийн төрөл хэлбэрээс хамааран зонхилж буй урсгал чиглэлд ялгаа ажиглагдаж байна. Энэ төрлийн гэмт хэрэг нь нууц далд, зохион байгуулалттай үйлдэгддэг тул мөрдөн шалгах ажиллагаа явуулахад цаг хугацаа, хүн хүч ихээр шаардагддаг төдийгүй хохирогч нь нэр төр, хувь хүний нууцтай холбоотой эмзэг асуудлаасаа болоод тэр бүр цагдаагийн байгууллагад ханддаггүй бусад төрлийн гэмт хэрэг шиг бүртгэгддэггүй мөрдөгчөөс илрүүлж бүртгүүлдэг онцлогтой юм.

Зураг 2. Бэлгийн мөлжлөгийн зорилгоор Монгол иргэдийг худалдаалж буй орнууд (IRM, Монгол Улс дахь хүний наймааны шалтгаан, нөхцөл, хүний наймаанд өртөмтгий болон тэсвэртэй байдлын суурь судалгааны тайлан, 2022)



Албадан хөдөлмөр эрхлүүлэх чиглэлд БНХАУ, БНЭнэтхэг, БНКазакстан, Норвеги, Швед, Турк болон Арабын Нэгдсэн Эмират улсуудад (Департамент, 2021) дурдагдсан байгаа бөгөөд сүүлийн 10 жилд ажил хөдөлмөр эрхлэх зорилгоор Монгол Улсаас гадагшаа чиглэсэн хөдөлмөрийн шилжилт хөдөлгөөний урсгал эрчимтэй нэмэгдэж байгаа нь энэ төрлийн гэмт хэрэгт өртөх эрсдэлийг улам нэмэгдүүлж байна.

Зураг 3. Хөдөлмөр мөлжлөгийн зорилгоор Монгол иргэдийг худалдаалж буй орнууд (IRM, Монгол Улс дахь хүний наймааны шалтгаан, нөхцөл, хүний наймаанд өртөмтгий болон тэсвэртэй байдлын суурь судалгааны тайлан, 2022)



Гадаад улсад биеэ үнэлдэг биеэ үнэлэгчид Зүүн Өмнөд азийн орнууд буюу Тайланд, Сингапур, Макао, Лаос зэрэг улсад өндөр цалинтай биеэ үнэлж гадны гэмт бүлэглэлд элсэн Монгол Улсаас охид эмэгтэйчүүдийг өндөр цалинтай ажилд зуучлах нэрээр бэлгийн мөлжлөг, хөдөлмөрийн мөлжлөгийн гэмт хэрэг үйлдэж байна.

Тухайлбал Малайз Улсын нийслэл Куала Лумпур хотод Монгол Улсын биеэ үнэлэгчдээс гадна Тайланд, Сингапур, Хятад, Орос, Вьетнам, Энэтхэг зэрэг улсаас охид, эмэгтэйчүүдээр ихээр очиж 1 удаагийн 800$, хоногийн 1000$ үнэ ханштайгаар биеэ үнэлүүлдэг ба Монгол Улсаас очсон охидыг эмнэлгийн шинжилгээнд хамруулж, зочид буудлын өрөөнд профайл зургийг нь авч өөрсдийн

албан ёсны сайтууд, вичат, телеграмм хуудсанд байршуулж зардаг байна.

Мөн Цахим орчинд нийтлэгдсэн “Вьетнам улсад өндөр цалинтай ажилд зуучилна” гэх зарын дагуу хууртагдан Камбож улсад бэлгийн мөлжлөг, цахим залилангийн гэмт хэрэг үйлддэг гэмт бүлэглэл нь Монгол Улсаас очсон иргэдийг өр авлагын дарамт, шахалтад оруулж, хүч хэрэглэн айлган сүрдүүлэн тусгай зэвсэглэсэн хамгаалалт дор бэлгийн мөлжлөг, албадан хөдөлмөр буюу Монгол Улс руу чиглэсэн “телеграм” цахим залилангийн гэмт хэрэг хүчээр үйлдүүлж хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болгож байна.

Он	Хохирогчийн тоо	Эргүүлэн авчирсан улс
2014	4	Филиппин улс - 1, БНХАУлс - 1
2015	1	БНТУлс - 1
2016	4	БНХАУлс – 2, Малайз Улс – 1, БНСУлс - 1
2017	7	БНХАУлс - 7
2018	23	БНХАУлс – 14, Мьянмар Улс - 3, Малайз Улс – 2, Камбож Улс - 4
2019	1	БНТУлс - 1
2020	15	Малайз Улс – 15
2021	-	-
2022	15	Мьянмар Улс - 15
2023	12	БНХАУлс – 1, БНАЛУлс – 11
2024	5	Тайландын Хант Улс – 3, БНХАУлс – 2
2025	6	Камбож Улс – 5, Тайландын Хант Улс - 1

Хүснэгт 3. Гадаад улсаас эх оронд нь эргүүлэн авчирсан хохирогчдын тоо (ЦЕГ, 2025)

Монгол Улс сүүлийн жилүүдэд гадаадын улс оронд хүн худалдаалах гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийг эх оронд нь эргэн авчрах, хамгаалж сэргээн нөхөн сэргээх ажиллагаанд онцгой ач холбогдол өгч байна. Сүүлийн гурван жилийн хугацаанд Зүүн болон Зүүн өмнөд Азийн хэд хэдэн орноос хохирогчдыг зохих журмын дагуу илрүүлэн шилжүүлэн авчирч, шаардлагатай тусламж, үйлчилгээ үзүүлсэн нь энэ чиглэлд авч хэрэгжүүлж буй бодлогын тодорхой үр дүнг илтгэж байна.

Мөн Бүгд Найрамдах Турк Улсын Истанбул хотын Таксимийн төв талбай орчим цэнгээний газарт хэсэг бүлэг Монгол эмэгтэйчүүд биеэ үнэлж байгаа нь тэнд хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгдэх эрсдэлийг нэмэгдүүлж байгаа талаар Эрүүгийн цагдаагийн албаны мэдээлэлд дурдагджээ (ЭЦА, 2025).

2025 онд цагдаагийн байгууллагаас Гадаад харилцааны яамны Консулын газар, Тайландын Хаант Улс, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Элчин сайдын яамтай хамтран Камбожийн Хаант Улсаас энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болсон Монгол Улсын 5 иргэнийг эх оронд нь аюулгүй буцаан авчирсан байна.

Биеэ үнэлэгч эмэгтэйчүүд нь энэхүү гэмт хэргийн хохирогч болох хамгийн эрсдэл өндөр бүлэгт тооцогдсоор байгаа бөгөөд хил залгаа болон хүн ам ихээр суурьшсан хотуудад анх удаа биеэ үнэлэх ажил хийхээр ирсэн Монгол охид, эмэгтэйчүүдийг өөрсдийн эрхшээлдээ оруулах зорилгоор гадаад паспортыг нь хураан авч зорчих эрхийг нь хязгаарлан хилээр буцаан гаргахгүй, визний хугацааг санаатайгаар хэтрүүлэн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болгож буй тохиолдлууд нийтлэг байна. Мөн гэмт этгээдүүд хохирогчдыг өөрсдийг нь Монгол Улсаас өөр бусад охидыг элсүүлж авчруулах шаардлага тавьж гэмт этгээд болгож байгаа нь гэмт этгээдүүд

баригдахгүй байх, Эрүүгийн хариуцлагаас мултрах гол арга нь болж байгааг онцлох нь зүйтэй.

Мөн хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд бэлгийн цөөнх буюу ЛГБТ хүмүүсийн асуудал харьцангуй бага анхаарал татдаг байна. Цагдаагийн ерөнхий газарт хүн худалдаалах гэмт хэргийн ЛГБТ хохирогч бүртгэгдээгүй боловч салбарын мэргэжилтнүүдийн хэлэлцүүлэгт (Азийн сан, 2022) тэмдэглэгдсэнээр, уг бүлгийн хүмүүс хөдөлмөрийн болон бэлгийн мөлжлөгт өртөх өндөр эрсдэлтэй гэж үзэж байна.

2.Гадаад улсаас Монгол Улсын чиглэлд.

Дараагийн нэг чухал анхаарах чиглэл нь гадаад улсын иргэдийг Монгол Улсад хөдөлмөрийн болон бэлгийн мөлжлөгт өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх асуудал юм. Одоогийн байдлаар Монгол Улсад гадаадын иргэдийн хөдөлмөрийн болон бэлгийн мөлжлөгтэй холбоотой шүүхээр шийдвэрлэгдсэн тохиолдол бүртгэгдээгүй байна. Гэсэн хэдий ч олон судалгааны тайланд дурдсанаар, гадаадын иргэд Монгол Улсад ажиллах явцдаа хөдөлмөрийн мөлжлөгт өртөх эрсдэл харьцангуй өндөр байгааг тэмдэглэжээ.

Тодруулбал, Монгол Улсад ажиллаж байгаа гадаадын иргэдийг авчирч ажиллуулж буй зарим ажил олгогчид санаатайгаар цалин хөлсийг нь хугацаанд нь олгохгүй байх, эсвэл бусад байдлаар хөдөлмөрийн нөхцөлийг зөрчих байдлыг гаргадаг бөгөөд үүний улмаас тухайн иргэн хууль ёсны оршин суух эрхээ алдсан мэт нөхцөл үүсэж, Гадаадын иргэн, харьяатын асуудал хариуцсан төрийн байгууллагад хандах, улмаар албадан гаргуулах эрсдэлд ордог. Иймхүү гадаадын иргэд хөдөлмөрийн хөлсөө бүрэн авааагүй, хууль ёсны эрхээ хамгаалж чадаагүйгээс хөдөлмөр мөлжлөгт өртөх боломжтой байна.

Мөн хөдөлмөр мөлжлөгийн эрсдэл зарим салбарт харьцангуй өндөр байгааг судалгаагаар нотолжээ. Тухайлбал, Монгол Улсад гэрээгээр ажиллаж буй гадаад иргэд барилга, үйлдвэрлэл, газар тариалан, ой мод, загас, ан агнуур, бөөний болон жижиглэнгийн худалдаа, автомашины засвар, уул уурхай зэрэг салбарт хөдөлмөрлөж байх үед илүү өндөр эрсдэлд өртөх тохиолдол гардаг байна (Төрийн департамент, 2021).

Тухайлбал, 2020 оны 9 дүгээр сард Монгол Улсад хөдөлмөр эрхэлж байсан Мьянмар улсын гурван иргэн хөдөлмөрийн мөлжлөгт өртсөн гэж үзэн хуулийн байгууллагад хандсан тохиолдол бүртгэгдсэн байна. Тэднийг хамгаалах, шаардлагатай тусламж үзүүлэх үйл ажиллагааг олон улсын болон орон нутгийн байгууллагууд, тухайлбал ОУШХБ болон ХТЭТ төрийн бус байгууллагууд хамтран зохион байгуулсан бөгөөд энэ нь гадаадын иргэдийн хөдөлмөрийн эрхийг хамгаалах, урьдчилан сэргийлэх механизмын нэг жишээ болсон юм. Гэвч тэдгээр иргэдийг холбогдох байгууллагуудаар дамжуулан нутаг буцааж, хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.

Энэ чиглэлээр урьд гүйцэтгэсэн судалгаанд гадаадын иргэн ажиллуулах ажлын байрны төлбөр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдан нэмэгдэж буй, мөн аж ахуй нэгжийн санхүүгийн хүндрэлээс шалтгаалаад хөдөлмөрийн визээр бус, бизнес болон жуулчлалын визээр буюу өөр ангиллын визээр гадаадын иргэд хил нэвтэрч орж ирэх болсон нь гадаад иргэдийн эмзэг байдлыг далимдуулах, хохироох, мөлжих эрсдэлийг нэмэгдүүлэхэд нөлөө үзүүлж байна.



Зураг 4. Монгол Улсад оршин суугаа гадаадын иргэд, хөдөлмөр эрхлэх визтэй иргэдийн ажиллаж буй салбар

Эх сурвалж: ГИХГ 2024 оны мэдээлэл

Гадаадын иргэн харьяатын газар (ГИХГ)-ын 2024 оны IV улирлын мэдээллээр Монгол Улсад нийт 123 орны 16,111 иргэн долоон төрлийн визний ангиллаар түр болон байнгын зөвшөөрөлтэйгөөр оршин сууж байна. Тэдгээрийн 34% (n=6,239) нь хөдөлмөр эрхлэгч ангиллаар оршин сууж байгаагийн бараг хоёр хүн тутмын нэг нь уул уурхай, олборлолт болон барилгын салбарт ажиллаж байна (**Error! Reference source not found.**). Хөдөлмөр эрхэлж буй гадаадын иргэдийг улс орноор нь ангилбал, БНХАУ, ОХУ, Вьетнам, БНСУ, Энэтхэг болон Австралийн иргэд зонхилон ажиллаж байна. Газарзүйн байрлалаар авч үзвэл, тэдний ихэнх нь Улаанбаатар хот болон Дорнод, Өмнөговь, Дорноговь аймгуудад төвлөрөн хөдөлмөр эрхэлж байгаа нь ажиглагддаг.

№	Улс	Хөдөлмөр эрхэлж буй гадаад иргэдийн тоо	%	Хөдөлмөр эрхэлж буй нийтлэг ажлын байр
1	БНХАУ	3531	62.8	Барилга, зам гүүр
2	ОХУ	272	4.8	Сургууль, цэцэрлэг зэрэг боловсролын салбарт
3	Вьетнам	234	4.1	Авто засвар
4	БНСУ	220	3.9	Зоогийн газар, гоо сайхан, үйлчилгээний салбарт
5	Австрали	134	2.3	Уул уурхай, хүнд үйлдвэр
6	АНУ	111	1.9	Уул уурхай, хүнд үйлдвэр
7	Филиппин	105	1.8	Хүүхэд асрагч, гэрийн үйлчлэгч
8	Өмнөд Африк	103	1.8	Спорт
9	Англи	62	1.1	Боловсрол
10	Канад	57	1.0	Уул уурхай, хүнд үйлдвэр
11	Япон	47	0.8	Массажист, гэрийн үйлчлэгч
12	Казахстан	36	0.6	Массажист, гэрийн үйлчлэгч
13	Бусад	705	12	Массажист, гэрийн үйлчлэгч

Хүснэгт 4. Хөдөлмөр эрхэлж буй гадаад иргэд, улс орноор, нийтлэг ажлын байраар

Эх сурвалж: Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаад иргэдийн мэдээлэл, 1212.mn

Мөн гэмт этгээдүүд албадан хөдөлмөр эрхлэлт болон бэлгийн мөлжлөгийн хохирогч болсон гадаад иргэдийг Монгол Улсаар дамжуулан ОХУ, БНХАУ зэрэг улс руу худалдаалдаг байж болзошгүй мэдээллүүд бүртгэгдсэн байна (Department, 2021).


Гадаадын улсын иргэд Монгол Улсад хөдөлмөрийн болон бэлгийн мөлжлөгт өртөж болзошгүй тохиолдлууд бүртгэгдэж байгаа хэдий ч, тэдний эрх ашгийг хамгаалах, шаардлагатай тусламж үзүүлэх, хууль ёсны эрхийг хангах боломжийг бүрэн хангах хууль эрхзүйн орчин тодорхой бус хэвээр байна. Үүний улмаас гадаад иргэдийг хохироох, хөдөлмөрийн мөлжлөгийн эрсдэлд оруулах тохиолдлуудад бүрэн хяналт тавих боломж хязгаарлагддаг.

Иймд цаашид Гадаадын иргэн, харьяатын газар болон хөдөлмөрийн хяналт шалгалтын асуудал хариуцсан төрийн байгууллагууд гадаадын иргэдийг хөдөлмөрийн болон бусад төрлийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, тэдний эрх ашиг, аюулгүй байдлыг хуулийн хүрээнд хамгаалах чиглэлд системтэй, үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Монгол Улсын дотоод нөхцөл байдал.

Монгол Улсад Хүн худалдаалах гэмт хэрэг нь ар гэрийн хараа хяналт сул насанд хүрээгүй охид, эмэгтэйчүүдийг эмзэг мэдээллээр эрхшээлдээ оруулан зорчих эрхийг нь хязгаарлан гудамж талбайд буюу “Хөдөө аж ахуйн яам”-ны автобусны буудал”, “Саппоро худалдааны төв”, “Улаанбаатар зочид буудал”-ын урд зэрэг цэгүүдэд зогсоож үйлчлүүлэгч олзлон үйлдэгддэг байсан бол сүүлийн үед сэжигтэй этгээдүүд цахим орчныг ашиглан садар самууныг сурталчлах, хуурамч фейсбүүкийн хаалттай группүүдийг олноор нээж иргэдээс урьдчилгаа мөнгө авч садар самуун агууламжтай (порно) бичлэг хийж зарах, бүртгэлгүй дугаараар зар байрлуулан бусдын биеийг үнэлүүлэх зэрэг арга, хэлбэрээр үйлдэгдэн, хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэг нь зохион байгуулалттай хэлбэрт шилжиж, гэмт хэргийн гаралт, насанд хүрээгүй хохирогчдын тоо жил бүр өсөн нэмэгдэж байна.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.1 дүгээр зүйл “Хүн худалдаалах”, 12.3 дугаар зүйл “Бэлгийн мөлжлөг”, 12.6 дугаар зүйл “Биеэ үнэлэхийг зохион байгуулах” гэмт хэрэг нь (Фейсбүүк, телеграм, вайбер, вичат, MY.mn сайт...болон бусад зарын сайтууд)-д, (high-class) фейсбүүк, инстаграм, тик ток нийгмийн цахим сүлжээнд олны танил (10.000-30.000 мянган дагагчтай) биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийг зохион байгуулдаг “Мадам”, “Агент” этгээдүүд нь урлаг соёл, бизнесийн нөлөө бүхий хүмүүст, мөн гадаад улсын БНХАУ, ОХУ, БНСУ, Япон Улсын иргэдэд зуучилж дундаас нь өндөр ашиг олдог нөхцөл байдал сүүлийн 5 жилийн тоон үзүүлэлтээр тогтоогдож байна.



Зураг 5. Хүн худалдаалах гэмт хэргийн сүүлийн 5 жилийн дотоод нөхцөл байдал

Монгол Улсад хөдөлмөрийн болон бэлгийн мөлжлөгт өртсөн ихэнх тохиолдлууд Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна. Тодруулбал, 2019-2021 оны хооронд бүртгэгдсэн 65 хэрэгт 131 хохирогч тогтоогдсоноос 66%[1] нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна (IRIM, Монгол Улс дахь хүний наймааны шалтгаан, нөхцөл, хүний наймаанд өртөмтгий болон тэсвэртэй байдлын суурь судалгааны тайлан, 2022). Бусад дүүргүүдтэй харьцуулахад Сонгинохайрхан болон Баянзүрх дүүрэгт энэ төрлийн гэмт хэрэг илүү их бүртгэгдсэн нь онцлогтой.

Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн хэрэг үйлдэгдсэн газруудын 57.1% нь Саппоро төвийн орчимд төвлөрсөн бол, Баянзүрх дүүрэгт гарсан хэрэгт холбогдох үйлдлүүдийн дийлэнх буюу 30.8% нь Хүнс, хөдөө аж ахуйн яамны ойролцоох автобусны буудлын орчимд үйлдэгдсэн байна. Эдгээр статистик нь Улаанбаатар хотын тодорхой бүсүүдэд хөдөлмөрийн болон бэлгийн мөлжлөгийн эрсдэл өндөр байгааг харуулж байна.

Хүйсийн тэгш эрх төв (ХТЭТ) ТББ-аас 2022 онд хийсэн судалгааны үр дүнгээр (ТББ, 2022) хуулийн байгууллагад хандаж тусламж авсан 20 хохирогчийн кейс өмнөх статистиктай ижил хандлагыг харуулж байна. Судалгаагаар дотооддоо хохирогч болсон 12 эмэгтэй бүгд Улаанбаатар хотод худалдаалагдсан бөгөөд тэдгээр нь нэг дүүргээс нөгөө дүүрэгт зуучлагчийн хамт хөдөлж үйлчилгээ үзүүлэх, эсвэл нэг байршилд баригдан бэлгийн мөлжлөгт өртсөн тохиолдлуудыг бүртгэжээ.

Энэ төрлийн гэмт хэргийн гаралт Улаанбаатар хотод өндөр байгааг хоёр шалтгаанаар тайлбарлаж болно. Нэгд, хот болон суурин газрын нийгэм, эдийн засгийн хөгжил, хөдөлмөр эрхлэлт, санхүүгийн боломжууд хотод илүү төвлөрсөнтэй холбоотой. Хоёрт, уг төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцооны чадавх, хяналт Улаанбаатар хотод төвлөрсөн нь хохирогчид илүү их бүртгэгдэх, мэдээлэгдэх нөхцөлийг бүрдүүлж байна.

Хэргийн илрүүлэлт, илэрсэн хэргийн давтамжийг харгалзан үзвэл, орон нутгуудаас хилийн ойролцоох аймаг, аймагт, 38 нь хилийн чанадад бүртгэгдсэн байна.

[1] 2019-2021 оны хооронд ЦЕГ-т бүртгэгдсэн 131 хохирогчийн 66% (n=87) нь Улаанбаатар хотод, 6 хэрэг Өмнөговь

сумдууд дараагийн эрсдэлтэй бүсэд тооцогдож байна. Тухайлбал, Монгол Улсын өмнөд хэсэгт өрнөж буй уул уурхайн салбарын хөгжлийн нөлөөгөөр дотоодын болон олон улсын хөдөлгөөн эрчимжиж, БНХАУ-Монголын хилийн ойролцоо хөдөлмөрийн болон бэлгийн мөлжлөгийн эрсдэл нэмэгдэж байна.

Тодруулбал, Өмнөговь аймагт нүүрс тээвэрлэж буй ачааны машины жолооч нарын паспортыг ажил олгогчид нь тээврийн хэрэгслийн барьцаа болгон хураан авч байгаа нь хөдөлмөрийн мөлжлөгт өртөх эрсдэлийг нэмэгдүүлж буй нэг хүчин зүйл болж байна. Ийм нөхцөл нь эрх, эрх чөлөө нь хязгаарлагдсан, хамгаалалтгүй гадаадын иргэдийг өндөр эрсдэлд оруулж байгааг харуулж байна.


Хүн худалдаалах гэмт хэргийн эрсдэлийг тодорхойлох судалгаанд нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүдийг харгалзан үзсэн бөгөөд тэдгээрийн нийлмэл нөлөөллийг тооцоолсноор аймаг, орон нутгийн эрсдэлийн түвшинг үнэлэхийг зорив. Үр дүнд нь хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгдэх өндөр магадлалтай бүс нутгийг тодорхойлохдоо гурваас дээш сөрөг нийгэм, эдийн засгийн үзүүлэлт давхцаж буй аймаг, сумдыг “эрсдэл өндөр бүс” хэмээн ангилсан.

Эдгээр сөрөг хүчин зүйлсэд дараах үзүүлэлтүүд хамаарна. Үүнд:

- Ядуурлын түвшин өндөр, амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой өрхийн эзлэх хувь их байх;
- Гэр бүлийн хүчирхийллийн гаралт өндөр байх;
- Нийт гэмт хэргийн гаралт өндөр байх;
- Дотоод шилжилт хөдөлгөөн эрчимтэй явагдаж байх;
- Хөдөлмөр эрхлэлт доогуур түвшинд байх.
- Ерөнхий боловсролын сургалтын чанар, үр дүн, хяналт хангалтгүй бага байх зэрэг үзүүлэлтүүдийг багтаана.

Эдгээр хүчин зүйлс нь нийгмийн эмзэг байдлыг нэмэгдүүлж, хүний эрх, эрх чөлөөнд халдах нөхцөлийг бүрдүүлэн хүн худалдаалах гэмт хэргийн суурь шалтгаан, өдөөгч орчны нэгэн үзүүлэлт болж байна.

Эдгээр макро түвшний хүчин зүйлсээс гэр бүлийн хүчирхийлэл нь ихэнх Монгол хохирогчдыг хөдөлмөр эрхлэлтийн аюултай сонголт хийхэд хүргэж, энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болгоход хүргэж, гэмт этгээдүүдийн гарт ороход нь нөлөөлж байгааг ижил төстэй олон судалгааны үр дүн нотлон харуулж байна (Төрийн департамент, Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай тайлан , 2021).



Зураг 1. ХХГХ үйлдэгдэх эрсдэл бүхий байршлууд, эмзэг хүчин зүйлээр

Эрсдэлт хүчин зүйлсийн давхардлыг авч үзвэл Монгол Улсын хэмжээнд Улаанбаатар хотын араас БНХАУ-тай хил залгаа Өмнөговь, Дорноговь аймгууд хамгийн эрсдэл өндөр орон нутагт тооцогдож байна.

Эрх бүхий байгууллагын мэдээлснээр, дотоодод гэмт бүлэглэлийнхэн цахим орчныг ашиглан санхүүгийн тусламж, зээл олгохтой холбоотой зар байршуулж охид, эмэгтэйчүүдийг хуурч татан оролцуулдаг байна. Улмаар тэднийг дарамтлах, айлган сүрдүүлэх зэрэг аргаар хяналтдаа авч, хувийн мэдээлэл болон дүрс бичлэгийг нь ашиглан заналхийлэх замаар эрх чөлөөг нь хязгаарлан орон сууц, нийтийн байр зэрэг газарт тусгаарлаж, бэлгийн мөлжлөгт өртүүлэх гэмт хэрэг үйлдэгдэж байгаа талаар Цагдаагийн байгууллага мэдээлжээ. Түүнчлэн ЛГБТ хүмүүсийн хөдөлмөр эрхлэх боломж хязгаарлагдмал байдлаас нийгмийн зүгээс гадуурхах явдал өндөр байдаг нь мөн улмаар эдгээр бүлгийн иргэдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор хохироох эрсдэлийг бий болгож байна (ЭЦА, Эрүүгийн цагдаагийн албаны мэдээлэл, 2025).

Иргэдийн цахим хэрэглээ жилээс жилд нэмэгдэж үүнийг даган цахим орчинд үйлдэгдэх гэмт хэргийн гаралт, хохирлын хэмжээ ихсэж, олон нийтэд ноцтой хор уршиг учруулсаар байна.

Манай улсын цахим худалдааны суваг, тэдгээрийн төрлүүдийг авч үзвэл, 43 хувь нь фейсбүүк, 35 хувь нь цахим хуудас буюу Amazon, Taobao, Alibaba, eBay, Aliexpress, Tmall, 6 хувь нь инстаграм, үлдсэн 16 хувь нь аль аль хэлбэрийг хослуулан ашиглаж байна.

Монгол улсад интернэт хэрэглэгч: 2020 онд 307.166 байсан бол 2021 онд 379.727 буюу 19.1 хувиар, 2022 онд 436.447 буюу 12.9 хувиар, 2023 онд 498.889 буюу 12.5 хувиар тус тус өссөн. 2024 онд 439.963 буюу 11.8 хувиар буурсан хэдий ч 2025 онд 464.960 буюу 5.3 хувиар өсөх төлөвтэй байна.

Гар утас хэрэглэгч: 2020 онд 4.363.919 байсан бол 2021 онд 4.687.304 буюу 6 хувиар, 2022 онд 4.835.520 буюу 3 хувиар, 2023 онд 4.841.935 болж 0.1 хувиар, 2024 онд 5.194.742 болж 6.7 хувиар тус тус өссөн бол 2025 онд 5.392.964 болж 3.6 хувиар өсөх төлөвтэй байна.

Сүүлийн жилүүдэд нийгмийн цахим сүлжээний хэрэглээ эрчимтэй өсөхийн хэрээр зохион байгуулалттай бэлгийн мөлжлөг цахим орчинд дамжин далд хэлбэрээр үйлдэгдэх хандлага нэмэгдэж байна. Тухайлбал, Facebook зэрэг платформ дээр тусгай зориулалтын групп, хуудас олон тоогоор үүсч, биеэ үнэлэлт зохион байгуулахад ашиглагдах болсон нь гэмт этгээдүүдэд хохирогчдыг илүү хялбар аргаар олж тодорхой хэмжээгээр удирдах боломжийг бүрдүүлж байна.

Эдгээр хуудас, группт байршуулсан заруудыг ашиглан “санхүүгийн дэмжлэг авна” гэх мэт шалтгаанаар мэдээллээ оруулсан охид, эмэгтэйчүүдийг гэмт бүлэглэлүүд янз бүрийн нэр болон шалтаг ашиглан уулзалтад дуудан эрхшээлдээ оруулдаг байна. Дараа нь хувийн мэдээлэл, бусдад түгээх боломжтой контент ашиглан дарамт үзүүлэх замаар тэдний эрх чөлөө, сонголтыг хязгаарлаж, шахалт үзүүлэх техникүүдийг хэрэглэдэг. Энэ мэт ажиллагаагаар тэднийг өөрийн хяналтад байлгаж, гуравдагч этгээдэд албадан үйлчилгээ үзүүлэхэд ашиглах нь бүртгэгдсэн.

Үүнтэй зэрэгцэн зарим тохиолдолд гэмт этгээдүүд хохирогчийн хувийн эд зүйлсийг хууль бусаар авах, нэр хүндэд халдах, хувийн мэдээлэл болон дүрс бичлэгийг ашиглан дарамт шахалт үзүүлэх зэрэг үйлдлээр заналхийлж байдгийг эрх бүхий байгууллагууд анзааруулж байна. Ийм нөхцөл байдал нь хохирогчдыг цахим орчинд үйлдэгддэг бэлгийн мөлжлөгийн илүү эмзэг, хамгаалалтгүй байдалд оруулдаг гэж үзэж болно.

Дүгнэлт

Монгол Улсад цахим орчныг ашиглаж үйлдэгдэж буй хүн худалдаалах гэмт хэргийн цар хүрээ, хэлбэр, бүтэц, орон зайн шинж чанар сүүлийн жилүүдэд эрс өөрчлөгдөж, улам бүр зохион байгуулалттай, олон улсын шинжтэй болж байна. Судалгааны үр дүнгээр цахим хэрэгсэл, нийгмийн сүлжээний

платформууд нь хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгдэх шинэ орон зай болон хувирч, хохирогчийг элсүүлэх, айлган сүрдүүлэх, дарамтлах, мөн гэмт үйлдлийг нуун дарагдуулах үндсэн хэрэгсэл болж байгааг тогтоов.

1. Техник, технологийн хөгжил нь хүн худалдаалах гэмт хэргийн динамикт гол нөлөө үзүүлж байна. Цахим шилжилт, интернет хэрэглээний өсөлт нь гэмт этгээдүүдэд хохирогчийг цахим хэлбэрээр элсүүлэх, хуурч мэхлэх, дарамтлах зэрэг үйлдлийг хялбарчилсан бөгөөд энэ нь энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, нотлох ажиллагаанд хүндрэл, бэрхшээлийг учруулж байна.

2. Сүүлийн 10 жилийн статистик мэдээний дүнгээр Монгол Улсад хүн худалдаалах болон түүнтэй төстэй гэмт хэрэг 1000 гаруй бүртгэгдсэн нь уг гэмт хэрэг тогтвортой өсөх хандлагатайг илтгэж байна. Түүнчлэн хохирогчдын дийлэнх нь эмэгтэй, өсвөр насны, нийгмийн эмзэг бүлгийн төлөөлөл байгаа нь нийгэм-эдийн засгийн хүчин зүйлсийн нөлөөллийг тодорхой харуулж байна.

3. Гадаад чиглэлийн урсгал давамгайлж байгаа боловч дотоодын цахим хэрэгсэл, мэдээлэл, харилцаа холбооны технологи ашиглан үйлдэж буй гэмт хэргийн гаралт нэмэгдэж байна. Монгол Улсын иргэдийг гадаад орнуудад бэлгийн болон хөдөлмөрийн мөлжлөгийн зорилгоор худалдаалах тохиолдол ихэвчлэн Зүүн болон Зүүн өмнөд Азийн орнуудад бүртгэгдэж байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд цахим залилан, албадан хөдөлмөр, бэлгийн мөлжлөгийн хосолсон хэлбэр ажиглагдаж байна.

4. Дотоод орчны түвшинд цахим орчныг ашигласан гэмт хэрэг, тухайлбал, цахим хуудас, хаалттай бүлгүүд, зарын сайт, нийгмийн сүлжээг ашиглан биеийг үнэлүүлэх, садар самууныг сурталчлах, айлган сүрдүүлж дарамтлах хэлбэр зонхилж байна. Энэ нь хот суурин газрын дүүргүүд, ялангуяа Улаанбаатар хотын Сонгинохайрхан, Баянзүрх дүүрэгт өндөр төвлөрөлтэй байна.

5. Хүн худалдаалах гэмт хэргийн эрсдэлийг нэмэгдүүлэгч макро хүчин зүйлс (ядуурал, ажилгүйдэл, гэр бүлийн хүчирхийлэл, шилжилт хөдөлгөөн, боловсролын түвшин, хөдөлмөрийн зах зээлийн сул дорой байдал) нь орон нутаг бүрт харилцан адилгүй нөлөө үзүүлж байна. Судалгаагаар гурваас дээш сөрөг үзүүлэлт давхцаж буй аймгуудыг “эрсдэл өндөр бүс” гэж тодорхойлсон бөгөөд Улаанбаатар, Өмнөговь, Дорноговь зэрэг бүсүүд хамгийн эрсдэлтэйд тооцогджээ.

6. Мөрдөн шалгах болон хохирогч хамгаалах тогтолцооны чадавх сул байна. Цахим мөрдөн шалгах арга зүй, нотлох баримт цуглуулах чадамж, төрийн болон төрийн бус байгууллагууд, цаашлаад олон улсын хамтын ажиллагааны уялдаа сул байгаа нь гэмт хэрэгтэй тэмцэх үр нөлөөг бууруулж байна.

7. Цахим технологийг зөв, ёс зүйтэй, нэгдсэн бодлоготой ашиглавал гэмт хэргийн илрүүлэлт, хохирогчийг хамгаалах, урьдчилан сэргийлэх ажлын шинэ боломжуудыг нээж өгч байна.

Санал

1. Мөрдөн шалгах байгууллагын техникийн болон хүний нөөцийн чадавхыг сайжруулах. Цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах, өгөгдлийн шинжилгээ, блокчэйн мөрдөлт, дижитал нотолгоо цуглуулах арга зүйг эзэмшүүлэх сургалт, хөтөлбөрийг тогтмолжуулах нь зүйтэй.

2. Нийгмийн эмзэг бүлэг, өсвөр үе, залуусын цахим боловсролыг нэмэгдүүлэх. Хүн худалдаалах гэмт хэргийн цахим эрсдэлийг танин мэдүүлэх, мэдээлэл хамгааллын ур чадварыг нэмэгдүүлэх, сургууль, их дээд сургуулийн хөтөлбөрт кибер аюулгүй байдлын суурь мэдлэгийг тусгах.

3. Хүн худалдаалах гэмт хэргийн эрсдэлийн үнэлгээг тогтмолжуулах. Аймаг, нийслэлийн түвшинд ядуурал, гэр бүлийн хүчирхийлэл, шилжилт хөдөлгөөн, боловсролын түвшний индексүүдийг нэгтгэсэн “эрсдэлийн газрын зураг”-ийг жил бүр шинэчилж, урьдчилан сэргийлэх бодлогод тусгах.

4. Гадаад иргэдийн хөдөлмөрийн нөхцөл, зуучлалын хяналтыг сайжруулах. Хөдөлмөрийн виз, гэрээний хэрэгжилт,

зуучлалын байгууллагын хариуцлагын тогтолцоог чангатгах замаар хөдөлмөрийн мөлжлөгийн эрсдэлийг бууруулах.

5. Иргэний нийгмийн оролцоо, хохирогч хамгааллын тогтолцоог өргөжүүлэх. Төрийн бус байгууллагуудыг чадавхжуулах, хохирогчийн сэтгэлзүйн болон хууль зүйн туслалцааны хүртээмжийг сайжруулах, мэдээллийн сүлжээг нэгтгэх.

6. Олон улсын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх. Хөрш болон бүс нутгийн орнуудтай цахим орчны гэмт хэрэгтэй тэмцэх мэдээлэл солилцоо, хамтарсан мөрдөн шалгах ажиллагаа, хохирогч хамгааллын хэлэлцээрийг шинэчлэх, хамтарсан платформ бий болгох.

7. Технологийн боломжийг гэмт хэрэгтэй тэмцэхэд ашиглах. Мөрдөн шалгах байгууллагын цахим өгөгдлийн дүн шинжилгээний системийг хөгжүүлэх, хиймэл оюун, машин сургалт ашиглан цахим орчны гэмт хэрэг илрүүлэх автоматжуулсан шийдэл боловсруулах.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт

1.Department, U. (2021). *Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай тайлан* . АНУ: U.S Department.

2.IRIM. (2021). *Монгол Улс дахь хүний наймааны шалтгаан, нөхцөл, хүний наймаанд өртөмтгий болон тэсвэртэй байдлын суурь судалгаа.* Улаанбаатар: IRIM .

3.IRIM. (2022). *Монгол Улс дахь хүний наймааны шалтгаан, нөхцөл, хүний наймаанд өртөмтгий болон тэсвэртэй байдлын суурь судалгааны тайлан.* Улаанбаатар: IRIM.

4.IRIM. (2022). *Монгол Улс дахь хүний наймааны шалтгаан, нөхцөл, хүний наймаанд өртөмтгий болон тэсвэртэй байдлын суурь судалгааны тайлан.* Улаанбаатар: IRIM.

5.IRIM. (2022). *Монгол Улс дахь хүний наймааны шалтгаан, нөхцөл, хүний наймаанд өртөмтгий болон тэсвэртэй байдлын суурь судалгааны тайлан.* Улаанбаатар: IRIM.

6.Азийн сан, A. f. (2022). *ХХГХ-ийн чиг хандлага, түүнтэй тэмцэхэд тулгарч буй асуудал судалгаа.* Улаанбаатар: Азийн сан.

7.Департамент, А.-ы. Т. (2021). *Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай тайлан.* Улаанбаатар: АНУ-ын Төрийн департамент.

8.ТББ, Х. (2022). *Хүн худалдаалах түүнтэй төстэй хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд хийх дүн шинжилгээ судалгааны тайлан.* Улаанбаатар: ХТЭТ ТББ.

9.Төрийн департамент, А.-ы. (2021). *Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай тайлан.* АНУ: Төрийн департамент, АНУ-ын.

10. Төрийн департамент, А.-ы. (2021). *Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай тайлан* . АНУ: Төрийн департамент, АНУ-ын .

11. ЦЕГ. (2025). *Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албаны тоо мэдээ.* Улаанбаатар: ЦЕГ.

12. ЭСЯам, А.-ы. (2022). *Хүн худалдаалах асуудлын төлөв байдлын тухай тайлан.* Улаанбаатар: АНУ-ын ЭСЯам.

13. ЭЦА. (2025). *Эрүүгийн цагдаагийн албаны Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн Хүн худалдаалахтай тэмцэх тасгийн мэдээлэл.* Улаанбаатар: ЭЦА.

14. ЭЦА. (2025). *Эрүүгийн цагдаагийн албаны мэдээлэл.* Улаанбаатар: ЭЦА.

УЛСЫН ОНЦ ЧУХАЛ ОБЪЕКТЫГ ХАМГААЛЖ ИРСЭН ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ, УЛСЫН ОНЦ ЧУХАЛ ОБЪЕКТЫН НЭРШЛИЙН ТУХАЙ

THE HISTORICAL TRADITION OF GUARDING STATE STRATEGIC FACILITIES

Т.Хүрэлбаатар
Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Гэмт явдал, цагдаа, дотоодын цэрэг судлалын төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан-багш, бригадын генерал
T.Khurelbaatar
Senior researcher of institute of Ceiminology and Police Studies, United Research Institute, University of the Internal Affairs, Mongolia, brigader general
Э.Хандармаа
Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Гэмт явдал, цагдаа, дотоодын цэрэг судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан-багш, цагдаагийн дэслэгч
Khandarmaa Erdenebayar
Researcher-teacher of Criminology, Police and Internal Troops Studies Center, Police lieutenant

*хариуцлагатай зохиогч: khandaa0321@gmail.com

Хураангуй: Улс орны тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн, улсын хилийн халдашгүй дархан байдалд ямар нэгэн халдлага, түрэмгийлэл бий болох, терроризм гарах орчин нөхцөл бүрдэхээс урьдчилан сэргийлэх талаар Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд байнга анхаарч ажиллаж байна.

Дэлхийн улс орны цэрэг, улс төр, нийгэм эдийн засгийн байдал улам бүр даяаршин үйлдвэр, техник технологийн өндөр хөгжил дэвшилд хүрч байгаа өнөө үед өөрийн эх орны тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдалд шинэ агуулга, өвөрмөц байдлаар хандах зайлшгүй шаардлага тавигдах болсон бөгөөд

Дотоодын цэргийн байгууллага нь Төр засаг, яам, командлалаас даалгасан үүргүүдийг түүхэн хөгжлийнхөө он жилүүдэд “Онц чухал объект”-д хамаарах ямар ямар объектуудыг хамгаалж ирсэн түүхэн уламжлал нь Цэрэг, армийг цомхотгох ажлын хүрээнд Дотоод явдлын яамны сайдын 1953 оны 6 дугаар сарын 19-ны өдрийн тушаалаар “Тусгай хороо”-г “Тусгай батальон”, “Хуяглан хамгаалах хороо-“г, “Харуул хамгаалалтын тусгай хороо” болгон тус тус өөрчлөн зохион байгуулж дотоодын цэргийн хамгаалалтад байгаа объектуудыг “Улсын онц чухал объектууд”, “Гарнизоны объектууд”, ”Гарнизоны хуяглан хамгаалах объектууд”-гэж ангилж, зөвхөн улсын онц чухал объектуудын хамгаалалтыг тусгай батальонд хариуцуулж байжээ. Улсын онц чухал объект гэсэн нэр томьёо хэдий үеэс эхэлж хэрэглэгдэн алба ажиллагаанд нэрлэгдэн хэрэглэгдэж ирснийг судлан үзлээ.

Abstract: Organizations with special mandates to ensure the national security of Mongolia are constantly working to prevent any threats, aggression, or terrorism that may endanger the country’s independence, territorial integrity, and the inviolability of national borders.

In today’s world, where global military, political, social, and economic conditions are becoming increasingly interconnected and where industrial and technological advancements are rapidly progressing, it has become imperative to approach the protection of one’s nation's independence and territorial integrity with new perspectives and specific characteristics.

The Internal Troops organization has historically been tasked by the government, ministries, and command structures to safeguard various “critically important objects.” As part of the downsizing of the military and armed forces, by Order No. A/63 of the Minister of Internal Affairs dated June 19, 1953, the “Special Detachment” was reorganized into the “Special Battalion,” and the “Armored Protection Detachment” and “Special Guard Detachment” were restructured. Under this reorganization, the facilities under the protection of the internal troops

This article is published under the Creative Commons BY-NC-SA License by 4.0, ©2025 University of Internal Affairs, Mongolia

were classified as “Nationally Critical Facilities,” “Garrison Facilities,” and “Armored Garrison Facilities.” The Special Battalion was assigned the responsibility of guarding only the nationally critical facilities.

We have studied when exactly the term “nationally critical facility” was first introduced and began to be used officially in operations.

Түлхүүр үгс: Улсын онц чухал объект, Дотоодын цэрэг, түүхэн уламжлал, хамгаалалт

Keywords: State Critical Infrastructure, Internal Troops, Historical Tradition, Security

Нэг: Төр засгийн удирдагчдыг Дотоодын цэрэг хамгаалсан нь:

Монгол Улсын Дотоодын цэргийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дүгээр зүйлд “Үндэсний аюулгүй байдлыг хуулиар хүлээсэн үүргийн хүрээнд хангах Төрийн цэргийн байгууллагыг Дотоодын цэргийн байгууллага гэнэ” гэж хуульчлан заажээ. Дотоодын цэргийн байгууллага нь анх байгуулагдсан цаг үеэсээ эхлэн Улс орны чухал үүрэг бүхий албан газрууд, шорон гянданг цагдан манах, хоригдол, ялтанг хуяглан хүргэж хамгаалах алслагдсан хошуу нутгуудад нууц бичиг баримтыг хүргэх, дотоодод гарсан бослого хөдөлгөөнийг дарахад бие даан болон дотоодыг хамгаалах газрын алба хаагчидтай хамтран ажиллах зэрэг үүргийг голчлон гүйцэтгэж байсан байна.

МАХН-ын Төв хорооны нарийн бичгийн дарга нарын 1932 оны 6 дугаар сарын 16 хурлаас МАХН-ын Төв хороо, МХЗЭ-ийн Төв хороо, Засгийн газрыг Дотоодын цэргийн хамгаалалтад шилжүүлсэн.

Дотоод Явдлын Яамны сайдын 1941 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 750 дугаар тушаалаар Маршал Х.Чойбалсангийн Их тэнгэр дэх өвлийн байрыг хамгаалах шинэ үүргийг Дотоодын цэрэгт хүлээлгэжээ.

Дотоод явдлын яамны сайдын 1946 оны 9 дүгээр сарын 24-ний өдрийн 526 тоот тушаалаар (Хүрэлбаатар, 2022, хууд. 179) Ерөнхий сайд, Улсын Бага Хурлын Төлөөлөгчдийн дарга, Монгол Ардын Хувьсгалт Намын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга нарын ажлын байр /Засгийн газрын ордон/, гэр орон, Баянгол дахь зуслан зэрэг объектууд, Монгол Ардын Хувьсгалт Намын Төв Хороо, Улс Төрийн Товчооны 1954 оны 51/306 дугаар тогтоол, Дотоод явдлын яамны сайдын 1954 оны 913 тоот тушаалаар (Хүрэлбаатар, 2022, хууд. 152) Х.Чойбалсангийн бунхан, Ерөнхий сайдын өвөл, зуны өргөө, Их тэнгэрийн аман дахь зочдын байр, Бага тэнгэрийн аман дахь хүнсний лаборатори, Цэргийн ба Нийгмийг аюулаас хамгаалах хэрэг эрхлэх яамны сайдын 1957 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 711 тоот тушаалаар (Хүрэлбаатар, 2022, хууд. 260) Төрийн ёслол, хүндэтгэлийн үүрэг (энэ үүргийг 1959 оны 7 дугаар сар хүртэл гүйцэтгэсэн) 1962 онд Их тэнгэрийн аман дахь Монгол Ардын Хувьсгалт Намын Төв Хороо, Засгийн газрын 50-ын 3 дугаар зочдын байрны хамгаалалтыг Дотоодын цэргийн хамгаалалтад шилжүүлж, мөн манай оронд айлчлан ирж байгаа гадаадын төр, засгийн тэргүүн, дээд хэмжээний хүндэт зочид, төлөөлөгчдийн байрлаж байгаа байр, хөлөглөж яваа онгоц, галт тэрэг, автомашиныг нь хамгаалах үүргийг давхар даалгасан байна.

Тус алба 1932-1996 оны хооронд МАХН-ын Төв хороо, Засгийн газрын ордон, Төр засгийн тэргүүн нарын өргөөг хамгаалж байгаад, Монгол Улсын Их Хурлаар “Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль” батлагдан, хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан, уг үүргийг Төрийн тусгай хамгаалалтын газарт шилжүүлжээ. Тэгэхээр Дотоодын цэргийн алба нь монгол төрийн тусгай хамгаалалтын нэн хариуцлагатай зарим чиг үүргийг 64 жилийн хугацаанд хэрэгжүүлэн ажиллаж ирсэн түүхтэй ажээ.

Хоёр: Улсын үйлдвэр, албан газрыг дотоодын цэрэг хамгаалсан нь:

Монгол Улсын Үндсэн хууль 1960 онд шинэчлэн батлагдав. Үндсэн хуулийн хэрэгжилтийг хангахын хүрээнд манай орны хөгжил, цэцэглэлтэд үнэтэй хувь

нэмэр оруулах, эдийн засгийн онцгой ач холбогдол бүхий уул уурхай, цахилгаан станц, үйлдвэр, завод олноор байгуулагдаж эхлэв.

Шинээр байгуулагдсан үйлдвэр, завод, албан газруудыг Дотоодын цэргийн хамгаалалтад шилжүүлэх тухай төр засгийн шийдвэр гарч, улс орны хөгжил цэцэглэлт, бүтээн байгуулалтад дотоодын цэргийн гүйцэтгэх үүрэг өсөн нэмэгдсэн байна. Үүнтэй уялдуулан Нийгмийг аюулаас хамгаалах яамны сайдын 1961 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 403 тоот тушаалаар (Хүрэлбаатар, 2022, хууд. 291) Нэгдүгээр цахилгаан станц, Сайд нарын зөвлөлийн 1974 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 147 дугаар тогтоолыг үндэслэн, Нийгмийг Аюулаас Хамгаалах Яамны сайдын мөн оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 469 тоот тушаалаар (Хүрэлбаатар, 2022, хууд. 221) Сэлэнгэ аймгийн Бугант дахь (албан баримт бичигт Толгойт гэж нэрлэдэг) алтны үйлдвэр, Сайд нарын зөвлөлийн 1978 оны 439 дүгээр тогтоолоор (Хүрэлбаатар, 2022, хууд. 341) Дархан хотын болон 3 дугаар цахилгаан станц, Дорнод аймгийн Чойбалсан хотын цахилгаан станц, Сайд нарын зөвлөлийн 1978 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн 223 дугаар тогтоолыг (Хүрэлбаатар, 2022, хууд. 340) үндэслэн Нийгмийг Аюулаас Хамгаалах Яамны сайдын мөн оны 8 дугаар сарын 19-ний өдрийн 569 тоот тушаалаар (Хүрэлбаатар, 2022, хууд. 358) Эрдэнэт Уулын Баяжуулах Үйлдвэр, Сайд нарын зөвлөлийн 1983 оны 35 дугаар тогтоолын (Хүрэлбаатар, 2022, хууд. 362) дагуу 4 дүгээр цахилгаан станцын хамгаалалтыг хүлээн авч, хариуцан гүйцэтгэсэн байна.

Манай оронд цагаан морин жилд буюу 1990 онд өрнөсөн ардчилсан хувьсгалын үр дүнгээр төр засгийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт орж, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1990 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 192 дугаар тогтоолоор (Хүрэлбаатар, 2022, хууд. 366) “БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх Улсын цагдан сэргийлэх ерөнхий газар”-ыг байгуулахад түүний бүтцэд Дотоодын цэрэг шилжиж урьдын адил улсын онц чухал объект болох “Их тэнгэр дэх цогцолбор” төр засгийн тэргүүдийн орон байр, дулааны цахилгаан станцууд, гяндан, онцгой, чанга дэглэмтэй хорих ангиуд, Урьдчилан цагдан хорих төв зэрэг объектуудын хамгаалалтыг хугацаат цэргийн албан хаагчдын хүчээр гүйцэтгэж байлаа.

Улсын Их хурлаар 1992 онд шинэ Үндсэн хууль батлагдсан бөгөөд Үндсэн хуулийг хэрэгжүүлэх эрх зүйн шинэчлэлийн ажлын хүрээнд 1995 онд Дотоодын цэргийн тухай хууль батлагдаж, түүхэнд анх удаа дотоодын цэргийн үйл ажиллагааны зарчим, гүйцэтгэх чиг үүрэг, алба хаагчийн эрх зүйн үндэс хуульчлан баталгаажжээ. Уг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5 дахь хэсэгт “Улсын Их Хурлаар 2017 онд шинэчлэн батлсан Дотоодын цэргийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т Дотоодын цэргийн хамгаалалтад байх улсын онц чухал объектын жагсаалт”-ыг Засгийн газар батална гэж тус тус заажээ. Хуулийн эдгээр заалтуудыг хэрэгжүүлэх зорилгоор дотоодын цэргийн хамгаалалтад байх Улсын онц чухал объектуудын жагсаалтыг Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 135 дугаар тогтоол, 2017 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн 281 дүгээр тогтоолоор батлуулан мөрдөж байна.

Засгийн газрын тогтоолд заасны дагуу Монголын Үндэсний Радио Телевизийн хэрэг эрхлэх газар, эфирийн студи, Монцамэ агентлаг, Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Чойбалсан, Ховд, Даланзадгад хотын төвлөрсөн усан сан, өргөх байгууламж, Ховд, Говь-Алтай аймаг дахь усан цахилгаан станц, Баян-Өлгий аймаг дахь Цагаан нуурын чөлөөт бүс, Эрдэнэт уулын баяжуулах үйлдвэр, Стандарт хэмжилзүйн Үндэсний төв, Цагийн эталон, Изотоп төв, Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн төв лаборатори, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн лаборатори, Биокомбинат, Зооноз төв, Өмнөговь аймгийн Цагаан хад суурьшлын бүс, Улаанбаатар хотын II, III, IY дүгээр дулааны цахилгаан станцууд зэрэг улс орны нийгэм, эдийн засгийн нэн чухал ач

холбогдол бүхий объектуудыг хамгаалж, үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудтай нягт харилцан ажиллагаатайгаар хамтран ажиллаж байна. Энд нэг тодруулга хийхэд, Улаанбаатар хотын цэвэр усны хангамжийн объектыг 1959-1993 он хүртэл цагдаагийн байгууллага хамгаалж байгаад, 1993 оны 7 дугаар сараас дотоодын цэргийн хамгаалалтад шилжүүлсэн.

Гурав: Хорих байгууллагыг дотоодын цэрэг хамгаалсан нь:

Дотоодын Цэрэг байгуулагдсан цагаасаа эхлэн хэрэгтэн, ялтанг харгалзах, шорон, гянданг хамгаалах үүрэг гүйцэтгэж ирсэн бөгөөд, 1950-иад оны эхэн үе хүртэл гол төлөв Дотоод явдлын яамны хорих байр, төв хорихыг хамгаалж байжээ. Харин энэ цаг үеэс ялимгүй өмнөх үе болох 1947-1953 онд Төв хорих, Цагаан хуаран, Амгалан, Хужир булан, Налайх, Мах комбинат, Зүүнхараагийн зэрэг хорих лагериудын 50 гаруй объектыг өдөр бүр 148 постоор хамгаалж байсныг дурдах нь зүйтэй.


Гэвч Хүн хүч хүрэлцэхгүй байсан тул 1949 онд Хүүхдийн колони, Салын рам, Үдлэг, Баянгол, Ерөө зэрэг 9 салбарыг, 1950 онд Рашаант, Цагаан-Эрэг, Зүүн хараагийн салбаруудыг тус тус татан буулгажээ.

1960-аад оны дунд үеэс манай Төр засгаас хууль ёсыг улам чангатгах, нийгэмд харш үйлдэл, үзэгдэл бүрийг илрүүлэн, хуулийн хариуцлага хүлээлгэж, хэрэгтэн этгээдийг хөдөлмөрөөр засан хүмүүжүүлэх, ажлын үр нөлөөг дээшлүүлэх бодлого шийдвэр гаргасантай уялдуулан, гяндан, онцгой, чанга дэглэмтэй хорих лагериудыг Дотоодын цэргээр хамгаалуулахаар шийдвэрлэж байсан түүхтэй.

Монгол ардын хувьсгалт намын Төв Хорооны Улс төрийн товчооны 1966 оны 341 дүгээр тогтоолоор (Хүрэлбаатар, 2022, хууд. 305) урьдчилан хорих төв буюу төв шорон, Нийгмийг Аюулаас Хамгаалах Яамны сайдын 1967 оны 12 дугаар 17-ны өдрийн тушаалаар (Хүрэлбаатар, 2022, хууд. 325) Хар айраг дахь хорих анги, Авдрант дахь хорих анги, мөн сайдын 1979 оны 07 дугаар сарын (Хүрэлбаатар, Монгол улсын Дотоодын цэргийн түүх, 2022, хууд. 35) 10-ны өдрийн 515 тоот тушаалаар (Хүрэлбаатар, 2022, хууд. 342) Баянзүрх дэх хорих анги, Сайд нарын зөвлөлийн 1982 оны 87 дугаар тогтоолоор (Хүрэлбаатар, 2022, хууд. 349) Зүүнхараа дахь хорих анги, Сайд нарын зөвлөлийн 1984 оны 51 дүгээр тогтоолын (Хүрэлбаатар, 2022, хууд. 352) дагуу Нийгмийг Аюулаас Хамгаалах Яамны сайдын мөн оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 407 тоот тушаалаар Дүүрэн дэх хорих анги, Сайд нарын зөвлөлийн 1985 оны 301 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж, Нийгмийг Аюулаас Хамгаалах Яамны сайдын 1986 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн А/5 тоот тушаалаар Баганаар дахь, Дарьт дахь гяндан, онцгой болон чанга дэглэмтэй хорих ангиудын гадуур харуул, хамгаалалтыг хариуцан гүйцэтгэж байв.

Монгол Улсын Засгийн Газрын 2002 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 155 дугаар тогтоолын дагуу дотоодын цэргийн хамгаалалтад байсан гяндан, онцгой, чанга дэглэмтэй хорих ангиудын гадуур харуул, хамгаалалтыг ШШГЕГ-т шилжүүлэн өгсөн юм.

Тэгэхээр Дотоодын цэргийн байгууллага нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай нягт хамтран ажиллаж гяндан, онцгой, чанга дэглэмтэй хорих ангиудын гадуур харуул, хамгаалалтыг хариуцан гүйцэтгэж, хорих ангиудад тогтоосон дэглэм, журмыг сахиулах амаргүй үүргийг хагас зуун (55 жил) жилийн хугацаанд гүйцэтгэж байжээ.



Хүснэгт 1. Дотоодын цэргийн байгууллагын хамгаалж байсан Улсын онц чухал объект

Дөрөв. Улсын онц чухал объектын нэршил уламжлал

4.1. Дотоодын цэргийн байгууллагын алба-ажиллагаанд улсын онц чухал объект гэсэн нэр томьёог хэдэн оноос эхлэн хэрэглэж эхэлснийг судлан үзэхэд:

А. 1932 оноос эхлэн 1960-аад он хүртэл Улсын онц чухал объект болох дараах объектуудыг "Тусгай объект" хэмээн нэрлэж байсан. Үүнд:

- МАХН-ын Төв хороо, Засгийн газрын ордон;
- Маршал Х.Чойбалсангийн Их тэнгэр дэх өвлийн өргөө;
- Монгол Улсын Ерөнхий сайд, Улсын Бага Хурлын Төлөөлөгчдийн дарга, Монгол Ардын Хувьсгалт Намын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга нарын орон байр, Баянгол дахь зуслангийн байр;
- БНМАУ-ын Улс төр, эдийн засаг, цэрэг стратеги, маш нууц баримт бичиг төвлөрсөн байгууллага, тэсэрч дэлбэрэх зүйл агуулсан газар; (Хүрэлбаатар, 2022, хууд. 182)
- Төв хорих, Цагаан хуаран, Амгалан, Хужир булан, Налайх, Мах комбинат, Зүүнхараа дахь хорих анги, Хүүхдийн колони.

Б. 1961-1962 он хүртэл "Тусгай объект" гэсэн нэр томьёог "Улсын онцгой объект" гэж нэрлэж байсан байна.

Энэ талаар НАХЯ-ны ажлын тухай авч хэлэлцээд гаргасан МАХН-ын Төв хорооны Улс Төрийн товчооны 1961 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 04 дүгээр тогтоолд "Тусгай объект" гэсэн нэр томьёог "Улсын онцгой объект" гэж нэрлэжээ. Улсын онцгой объектод дараах объектууд хамаарч байсан байна. Үүнд:

- Тусгай объектууд;
- Их тэнгэрийн аман дахь Монгол Ардын Хувьсгалт Намын Төв Хороо, Засгийн газрын 50-ын 3 дугаар зочид байр;
- Манай оронд Төр, засгийн айлчлал хийж байгаа гадаад орны төр засгийн тэргүүн, өндөр дээд хэмжээний хүндэт зочид, төлөөлөгчдийн байрлаж байгаа байр, хөлөглөж яваа онгоц, галт тэрэг, автомашин;
- Улаанбаатар хотын Нэгдүгээр цахилгаан станц зэрэг хамаарна.

В. БНМАУ-ын НАХЯ-ны дүрмийг МАХН-ын Төв хороо, Сайд нарын Зөвлөлийн 1962 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 16/550 дугаар тогтоолоор баталжээ. Энэхүү дүрэмд "Улсын онцгой объект" гэсэн нэр томьёог "Улсын чухал объект" гэж өөрчлөн заасан бөгөөд, эдгээрт дараах объектууд хамаарч байжээ. Үүнд:

- Улсын онцгой объектууд;
- Сэлэнгэ аймгийн Бугант дахь (албан баримт бичигт Толгойт гэж нэрлэг) алтны үйлдвэр;
- Хар айраг дахь хорих анги зэрэг хамаарна.

Г. НАХЯ-ны дүрэмд заасан "Улсын чухал объект" гэсэн нэр томьёог НАХЯ-ны орлогч сайд, хилийн ба дотоодын цэргийн хэрэг эрхлэх газрын даргын 1970 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 10 дугаар тушаалаар (Хүрэлбаатар, 2022, хууд. 319) мөн оны 5 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулсан Онц хилчин харуулчийн зөвлөгөөний уриалгад "Улсын чухал объект" нэр томьёог "Улсын онц чухал объект" гэж өөрчлөн нэрлэсэн. Мөн НАХЯ-

ны коллегийн хурлаар улсын чухал объектын хамгаалалтыг сайжруулах тухай авч хэлэлцээд, баталсан 1972 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 7/26 дугаар бүхий удирдамжид Улсын онц чухал объектыг дараах гурван зэрэгт хуваасан байна. Үүнд:

1 дүгээр зэрэгт: Улс төр, эдийн засгийн ач холбогдлоороо дайсны анхаарлыг онцгой татах, ямар нэгэн ноцтой учрал, зөрчил гарснаар улс нийгмийн амьдрал, эдийн засагт ноцтой хохирол учруулж болох үйлдвэр, байгууллагууд А объект буюу улсын онц чухал объект;

2 дугаар зэрэгт: Эдийн засаг, улс төрийн ач холбогдлоороо дайсны анхаарлыг онцгой татахаргүй үйлдвэр байгууллагууд Б объект буюу улсын чухал объект;

3 дугаар зэрэгт: Орон нутгийн чанартай жижиг салбар, байгууллагууд В объект гэж ангилсан.


1980-аад оны эхэн хүртэл эдийн засгийн аюулгүй байдлыг хангах ажлыг улсын онц чухал объект, улсын чухал объектыг хамгаалах гэдгээр ойлгож байсан боловч, холбогдох эрх бүхий байгууллагаас гаргасан тогтоол, тушаал, дүрэм, заавар зэрэгт дараах байдлаар заасан байна. Үүнд:

1. НАХЯ-ны сайдын 1982 оны 4 дүгээр сарын 02-ны өдрийн 261 дүгээр тушаалд “Нам, улсын чухал объект” (Хүрэлбаатар, Монгол улсын Дотоодын цэргийн түүх, 2022, хууд. 307) гэж нэрлэсэн;

2. Сайд нарын зөвлөлийн “Жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит тусгай хорооны талаар авч хэрэгжүүлэх тухай” 1983 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 76 дугаар тогтоолд “Улсын чухал объект” (Хүрэлбаатар, Монгол улсын Дотоодын цэргийн түүх, 2022, хууд. 327) гэж тэмдэглэсэн;

3. Засгийн газрын 1992 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 82 дугаар тогтоолд “Цагдаа, дотоодын цэргийн хамгаалалтад байх объектууд” гэж тус тус нэрлэн заажээ.

Б. “Улсын онц чухал объект”-ыг нэрлэж байсан он цагуудыг түүхийн эх сурвалж, баримт бичгүүдээс судлан үзэхэд, 1922-1930-аад онд тусгайлан нэрлэгдэж байгаагүй бөгөөд, Дотоодыг хамгаалах газар, гянданг хамгаалах гэж хамгаалж байгаа байгууллагын нэрээр нь нэрлэж, 1932-1960-аад оны эхэн хүртэл “Тусгай объект”, 1960-1970-аад оны эхэн үе хүртэл “Улсын онцгой объект”, “Улсын чухал объект”, 1970-1990 он хүртэл “Нам, улсын онц чухал объект”, “Улсын чухал объект”, “Улсын онц чухал объект”, 1990 оноос өнөөг хүртэл “Улсын онц чухал объект” гэж тус тус нэрлэж байна.



Хүснэгт 2. Улсын онц чухал объектын түүхэн хөгжлийн явцад нэрлэж байсан нэршлүүд

В. “Улсын онц чухал объект” гэх нэршлийг заавар, дүрэм, хуульд баталгаажуулсан байдлыг судлан үзэхэд, НАХЯ-ны сайдын 1979 оны 01 дүгээр тушаалаар батлагдсан Улсыг аюулаас хамгаалах газрын зааварт “БНМАУ-ын улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан, цэрэг стратеги, социалист байгуулалтын

зориулалтын болон хүн амын амьжиргааны чухал ач холбогдлоороо дайсны анхаарлыг татах, хорлон сүйтгэх ажиллагаа явагдаж болзошгүй объект, газар, Зэвсэгт хүчний анги, салбар, маш нууц-онц чухал, маш нууц, нууц, баримт бичиг төвлөрсөн байгууллагуудыг "Улсын чухал объект" гэж анх удаа тодорхойлсон бол УИХ-аар 1993 онд хэлэлцэн баталсан Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 49 дүгээр зүйлд "Дотоодын цэргийн хамгаалалтад байх Улсын онц чухал объектын жагсаалтыг Засгийн газар батална" (Цагдаагийн байгууллагын тухай хууль, 1993), 1995 онд хэлэлцэн баталсан Дотоодын цэргийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5 дахь хэсэгт "Дотоодын цэргийн хамгаалалтад байх Улсын онц чухал объектын жагсаалтыг Засгийн газар батална" (Монгол Улсын Дотоодын цэргийн тухай хууль, 1995) гэж хуульчлан, Засгийн газрын 2003 оны 35 дугаар тогтоолоор батлагдсан Дотоодын цэргийн алба ажиллагааны дүрмийн 52 дугаар зүйлд "Монгол Улсын Засгийн газраас Дотоодын цэргийн хамгаалалтад байхаар тогтоосон улс орны нийгэм, эдийн засгийн онцгой ач холбогдол бүхий үйлдвэр, албан газар, байгууллага, барилга байгууламжийг Улсын онц чухал объект гэнэ" (Хүрэлбаатар, Монгол улсын Дотоодын цэргийн алба ажиллагааны дүрэм, 2003) гэж томьёолсон бол УИХ-аас 2017 оны 2 дугаар сарын 9-ний өдөр баталсан Дотоодын цэргийн тухай хуулийн 4.1.3-т "Монгол Улсын Засгийн газраас тогтоосон онцгой ач холбогдол бүхий байгууллага, үйлдвэр, барилга байгууламжийг Улсын онц чухал объект гэнэ" (Монгол улсын Дотоодын цэргийн тухай хууль, 2017) гэж өөрчлөн, найруулжээ.

Монгол Улсын хуулиудад:

• УИХ-аар 2017 онд шинэчлэн баталсан Дотоодын цэргийн тухай хуулийн 5.1.4 дэх хэсэгт "Дотоодын цэргийн хамгаалалтад байх Улсын онц чухал объектын жагсаалтыг Засгийн газар батална" (Монгол улсын Дотоодын цэргийн тухай хууль, 2017) Цагдаагийн албаны тухай хуулийн 12.2 дугаар зүйлд "Цагдаагийн байгууллагын хамгаалалтад авах Онц чухал объектын жагсаалтыг Засгийн газар батална" (Цагдаагийн албаны тухай хууль, 2017).

Г. Улсын онц чухал объект"-ын хамгаалалт гэсэн нэр тодорхойлолтыг дүрэм, хуульд баталгаажуулсан байдлыг судлан үзэхэд, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 35 дугаар тогтоолоор батлагдсан Дотоодын цэргийн алба ажиллагааны дүрмийн 53 дугаар зүйлд "Улсын онц чухал объектын хэвийн ажиллагааг хангах, объектыг халдлагаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хамгаалж байгаа объектод нэвтрэх /орох, гарах/ хүн тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх, хамгаалалтын бүсэд тогтоосон дэглэм журмыг сахиулах зорилгоор хамгаалалтын хүч хэрэгслүүдийг ашиглан хамгаалж байгаа объектын захиргаатай хамтран зохион байгуулж байгаа цэргийн ажиллагааг Улсын онц чухал объектын хамгаалалт гэнэ" гэж, Дотоодын цэргийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4-т "Улсын онц чухал объектыг хэвийн ажиллагааг хангах, халдлагаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хамгаалж байгаа объектод нэвтрэх хүн, эд зүйл, тээврийн хэрэгслийг шалгах, хамгаалалтын бүсэд тогтоосон дэглэм журмыг зохицуулах цогц үйл ажиллагааг "Улсын онц чухал объектын хамгаалалт гэнэ" гэж тус тус тайлбарласан ажээ.

Цагдаа, дотоодын цэргийн хамгаалалтад байх "Улсын онц чухал объект"-ын жагсаалтыг батлах тухай Засгийн газрын 2004 оны 135 дугаар тогтоолд анх удаа "Улсын онц чухал объект" гэж нэрлэсэн. Засгийн газрын 2017 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн 281 дүгээр тогтоолоор Дотоодын цэргийн хамгаалалтад байх Улсын онц чухал объектыг батлан мөрдөж байна. Гэвч Төрийн тусгай хамгаалалтын газрын хамгаалалтад байх объектуудыг "Улсын онц чухал объект" гэж тусгайлан зааж нэрлээгүй байгаа нь анхаарал татаж байна.

Монгол Улсын хэмжээнд улс орны нийгэм эдийн засаг, улс төрийн өндөр ач холбогдол бүхий объектуудыг Монгол Улсын хууль, Засгийн газрын тогтоолоор Цагдаагийн байгууллага, Дотоодын

цэргийн байгууллага, Төрийн тусгай хамгаалалтын газар хариуцан хамгаалж ажуулгүй байдлын ханган ажиллаж байна.

Монгол Улсын Төрийн тусгай хамгаалалтын хуульд заасны дагуу Төрийн тусгай хамгаалалтад байх объектыг Засгийн газрын 2012 оны 09 дүгээр сарын 29-ны өдрийн 65 дугаар тогтоолоор тогтоосон. Үүнд:

- Засгийн газрын байрууд, яамдууд
- Үндсэн хуулийн цэцийн байр
- Архивын ерөнхий газар
- Авлигатай тэмцэх газар гэх мэт төрийн онцгой ач холбогдол бүхий объектыг хамгаалалтад авахаар тусгасан байна.

Цагдаа, дотоодын цэргийн хамгаалалтад байх "Улсын онц чухал объект" гэж нэрлэсэн боловч, төрийн тусгай хамгаалалтад байх объектыг "Улсын онц чухал объект" гэж нэрлээгүй байгаагаас үзэхэд, дараах зүйлүүдийг тодруулан авч үзэх шаардлага урган гарч байна. Үүнд:

1. Улсын онц чухал объектод ямар зэрэглэлийн объектууд хамаарах, Улсын чухал объектод ямар зэрэглэлийн объект хамаарахыг тусгайлан судлан үзэх;

2. Төрийн тусгай хамгаалалтын газрын хамгаалалтын газрын хамгаалалтад байгаа объектууд "Улсын онц чухал объект"-д хамаарах эсэхийг тодотгох;

Дүгнэлт

Дотоодын цэрэг нь цаг хугацаандаа Дотоодын цэргийн байгууллага нь Монгол улсын түүхэн цаг хугацаандаа гүйцэтгэж ирсэн үүрэг, онцлог, хамгаалалтад байсан хамгаалалтын чиг үүрэг нь объектын хамгаалалтуудыг оновчтой , уян хатан тасралтгүй зохион байгуулж ирсэн уламжлалтай.

Манай улсын цэрэг-улс төрийн гадаад орчин эмзэг, тогтворгүй, хөрш орнууд төрийнхөө бодлогоор батлан хамгаалах чадавхаа бэхжүүлэхэд ихээхэн ач холбогдол өгч, шаардлагатай тохиолдолд хилийн чанадад өөрийн эрх ашгийг цэргийн хүчээр хамгаална гэдгээ ажуулгүй байдлын бодлогын баримт бичгүүддээ тусгаж, улмаар хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээнүүд авч байна.

Дэлхийн дулаарал, цаг уурын өөрчлөлт, уул уурхай, ашигт малтмалын хууль бус олборлолт, орчны бохирдолтын уршгаар экологи, эдийн засгийн тэнцвэрт байдал алдагдаж хүн амьтны гоц халдварт өвчин, хүн амын ядуурал, интернэт орчны зохисгүй хэрэглээнээс үүдэлтэй цахим гэмт хэрэг, халдлага нэмэгдэж байгаа өнөө цаг үед Цагдаа, дотоодын цэрэг, Төрийн тусгай хамгаалалтын газрын хамгаалалтад байгаа объектуудыг судлан үзэж зэрэглэлийг шинэчлэн тогтоох шаардлагатай байна гэж үзэж байна.

Санал

Улс орны амин чухал хэрэгцээний объектууд, хүн амын амьжиргааны чухал хангамжийн объектуудын харуул, хамгаалалтын байдлыг эрх бүхий мэргэжлийн байгууллагуудаас санаачлан, холбогдох байгууллагуудын төлөөллийг оролцуулан, судлан үзэж

1. Улсын онц чухал объектуудын ангиллыг шинэчлэн тогтоох (аль объект нь онц чухал объект, аль объект нь чухал объект болох, зайлшгүй хамгаалалтад байх объект боловч хамгаалалтад байгаа объект байна)

2. Улсын онц чухал объектын талаар Төрөөс баримтлах бодлогын *баримт бичиг"*-ийг боловсруулж Төр засгийн түвшинд батлуулан мөрдүүлэх.

Ашигласан материал

Монгол улсын Дотоодын цэргийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл №22. 4 дүгээр зүйл (Улсын Их Хурал 1995).

Монгол улсын Дотоодын цэргийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл №12. 4 дүгээр зүйлийн 4.1.3 (Улсын Их Хурал 2017).

Монгол улсын Дотоодын цэргийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл №12. 5 дугаар зүйлийн 5.1.4 (Улсын Их Хурал 2017).

Хүрэлбаатар, Т. (2003). *Монгол улсын Дотоодын цэргийн алба ажиллагааны дүрэм.* Цагдаагийн ерөнхий газрын хэвлэх хэсэг.

Хүрэлбаатар, Т. (2022). *Монгол Улсын Дотоодын цэргийн түүх.* Мөнхийн үсэг.

Хүрэлбаатар, Т. (2022). *Монгол улсын Дотоодын цэргийн түүхэнд холбогдох баримт бичиг.* Мөнхийг үсэг.
Цагдаагийн албаны тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл №21. 12 дугаар зүйл 12.2 (Улсын Их Хурал 2017).
Цагдаагийн байгууллагын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл №4. 49 дүгээр зүйл (Улсын Их Хурал 1993).

БҮС НУТАГ ТҮҮНИЙ ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ОПЕРАТИВЫН БАЙГУУЛАМЖ

Н.Наранжамц
Удирдлагын академийн хилийн албаны удирдлага-стратегийн тэнхимийн ахлах багш, доктор, профессор (Ph.D), хурандаа
Naranjamts N.
Senior Lecturer, Doctor, Professor (Ph.D.), Colonel, Department of Management and Strategy of the Border Service of the Academy of Management
Г.Содбаяр
Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн суралцагч, хошууч
Sodbayar G.
Student, Master's student, Major of the Management Academy of the University of Internal Affairs
Ц.Баяндалай
Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн суралцагч, хошууч
Bayandalai Ts.
Student, Master's student, Major of the Management Academy of the University of Internal Affairs

*Хариуцлагатай зохиогч: Sodoo8088@gmail.com

Хураангуй: Бүс нутаг түүний хилийн аюулгүй байдал нь дэлхий дахинд бүс нутаг, улсын хил гэдэг ойлголтыг тусгаар тогтнолын баталгаа, газар нутгийн хаяа хязгаарыг тодорхойлогч гэж үздэг бол, бүс нутагт гарах өөрчлөлт, хилийн аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйл, хилийн аюулгүй байдлыг хангах, улсын хилийг хамгаалах, хил хамгаалалтын оперативын байгууламжийг нэмэгдүүлэх, зэрэг асуудлуудын талаарх судалгааны үр дүнг танилцуулахыг зорилоо.

Abstract: The region and its border security. While the concept of regional and national borders is considered a guarantee of independence and a determinant of territorial boundaries around the world, the aim is to present the results of research on changes in the region, factors affecting border security, ensuring border security, protecting the state border, and increasing operational facilities for border protection.

Түлхүүр үгс: Бүс нутаг, хилийн аюулгүй байдал, оператив, байгууламж, тусгаар тогтнол, улсын хил.

Keywords: Region, border security, operational, facilities, independence, state border.

Удиртгал

Хил хязгаарын тухай ойлголт нь хүн төхөлхтөн үүссэн цагаас бий болсон гэж үздэг бөгөөд энэ нь хүй нэгдлийн үеэс өнөөг хүртэлх хугацааг хамарч байгаа бөгөөд эртний хүн сүрэг нь идэх хоол хүнс, амьтан ургамлыг эрж хайх, олж эзэмших явцдаа байгалийн хил хязгаар хэмээх ойлголтыг бий болгож, өөр бусад хүн сүргээс олж эзэмшсэн хоол хүнс, байгалийн бүтээгдэхүүнээ хамгаалж ирсэн байна. Хүн төрөлхтөний хөжлийн явцад амьдрах орчин, нөхцөл өөрчлөгдөж, хүн сүргээс ухамсарт хүн бий болж, тэдний хэрэгцээ шаардлага өсөн нэмэгдэхтэй уялдан хэлбэр хэмжээ, их багын тухай ойлголт бий болж, энэхүү ойлголтыг хэмжих хэмжүүрийн нэгжийн хязгаар буюу “Хил” хэмээх ухагдахуун бий болсон гэж судлаачид үздэг байна. Өөрөөр хэлбэл “Хил гэдэг нь аливаа юмс зүйлийн хэлбэр хэмжээг тодорхойлогч ухагдахуун” юм (Наранжамц. Н, 2017).

Үндсэн хэсэг;

Монгол Улсын нутаг дэвсгэрийн зах хязгаарыг газрын гадаргуу, усны мандал дээр хил залгаа улсын нутаг дэвсгэрийн хязгаараас зааглаж Монгол Улсын олон улсын гэрээгээр тодорхойлж, тогтоосон шугамыг Монгол Улсын хил (цаашид “улсын хил” гэх) гэнэ. Уг шугамаас эгц дээш агаарын, мөн шугамаас эгц доош газрын хэвлийн хил байна (УИХ, 2017).

This article is published under the Creative Commons
BY-NC-SA License by 4.0, ©2025 University of Internal Affairs, Mongolia

Үүнээс үзвэл хил нь хязгаарлагч, хязгаарын тухай ойлголт болох бөгөөд энэхүү ойлголтыг улс үндэстнүүд газар нутгийн хязгаарыг тодорхойлж буй утгаар нь өргөн хэрэглэж заншсан байна.

Тусгаар улсыг тодорхойлогч хэд хэдэн хүчин зүйлс байдаг байна. Үүнд:

-Өөрийн гэсэн газар нутагтай, хүн амтай, хил соёлтой тусгаар тогтнолоо дэлхий нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээнд тунхаглан зарласан байх явдал юм.

Тусгаар тогтносон тусгаар улсыг тодорхойлогч чухал хүчин зүйлүүдийн нэг болох газар нутаг нь тодорхойлон тогтоогдож тэмдэглэгдсэн хил хязгаартай байх бөгөөд газар нутгийн үндсэн баталгаа нь өөрийн гэсэн улсын хилтэй, энэхүү хил хязгаараа зэргэлдээ улс орнуудаараа хүлээн зөвшөөрүүлж, гэрээ хэлэлцээрээр баталгаажуулан, хууль тогтоомжоор зохицуулсан байх явдлаар хангагдана.

Дэлхий дахинд улсын хил гэдэг ойлголтыг тусгаар нутгийн хаяа хязгаарыг тодорхойлогч гэж үзэн “Улсын хил” гэсэн нийтээр хүлээн зөвшөөрсөн ухагдахуун бий болгон хэрэглэж нэгэнт заншсан болно.

Улсын хилийг:

-Газрын хил;

-Усан хил;

-Агаарын хил;

-газрын хэвлийн хил гэж ангилан авч үздэг бөгөөд даяаршлын өнөөгийн үед улсын хилийн талаарх ойлголт улам бүр өргөсч:

-Нийтлэг хил хязгаар;

-Ашиг сонирхлын хил хязгаар;

-Газар нутгаас ангид хил хязгаар хэмээх шинэ ойлголтууд нэгэнт бий болоод байна (Наранжамц.Н, 2017).

Түүнчлэн улс гүрнүүдийн оршин байгаа газар нутаг нь:

Тусгаар тогтнолын баталгаа эсвэл тусгаар тогтнохын үндэс болдог;

Мөнхөд оршин байх, эзэмшсэн байх нь улс бүрийн язгуур ашиг сонирхол нь болдог;

Хүн амын амьдран байх үндэс, баялгийн эх сурвалж болдог төлийгүй үйлдвэрлэл, үйлчилгээ, хууль ёс сахих эх талбар, өөрийнхөө доорх баялаг нууцлагаараа бусдын ашиг сонирхлыг татаж байдаг юутай ч зүйрлэшгүй үнэт баялаг юм. Дэлхийн улс гүрнүүд аюулгүй байдлаа хангах үндэсний бодлого стратегиа бий болгох, хөгжүүлэх, хэрэгжүүлэхэд ихээхэн анхаарч, ихэнхдээ дэлхий дахин, бүс нутгийн аюулгүй байдлыг чухалчлан үзэж байна (Наранжамц.Н, 2017).

Цэргийн эрдэмтэд, онолчид ертөнцийн орон зайг геостратегийн орон зайгаар нь дараах бүсүүдэд хуваан авч үзэж байна. Үүнд:

-Тивийн бүс;

-Эх газрын бүс;

-Далайн бүс;

-Стратегийн орон зайн бүс;

Сансарын стратегийн бүс гэх мэт. Эдгээрээс стратегийн бүсийг тив дэлхийн газар нутгийн хэсэг эсвэл тухайн газар нутгийг бүхэлд нь ойролцоо байх эдийн засгийн бүс, агаарын орон зайг хамтатган авч үзэж аливаа улсын цэрэг эдийн засгийн болзошгүй аюулаас хамгаалах орчин гэж тодорхойлсон байна. Жишээ нь: ОХУ, Европын болон Евроазийн газар нутаг, Европын улсууд болон: Азербайжан, Армени, Гүрж, Кипр, Ливан, Сири болон Турк тэдгээрт хамаарах Атлант, Каспин тэнгисийн бүс нутгийн болон агаарын орон зайг оруулан дээрх чиглэл дэх гадаад тэнгисийн хилийг хүртэлх орон зайг багтаасан хуурай газар, тэнгис, далайн уудмыг өөрийн улсын Европ дахь стратегийн бүс гэж авч үздэг байна (Наранжамц.Н, 2012, 2024).

Монгол Улсын хилийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.2-д Хилийн аюулгүй байдал гэж улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах, гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсан байхыг хэлнэ (УИХ, 2017).

Монгол Улсын хувьд бүс, бүс нутаг, стратегийн болон оперативын орон зайгаа тодорхойлох зайлшгүй шаардлагатай бөгөөд өнөөдрийн байдлаар төв болон дундад, зүүн хойд, зүүн өмнөд Ази, Европын Орос дахь газар нутаг, Казакстан, Хятадын газар нутаг бүхэлдээ, Энэтхэгийн болон Номхон далай, Солонгосын хойгийг багтаасан орон зайг өөрийн улсын аюулгүй

байдлын бүс, бүс нутаг гэж авч үзэж болох юм (Наранжамц.Н, 2012, 2024).

Өнөөдөр дэлхийн газар нутаг үндсэндээ их гүрнүүдийн хяналтад хуваагдаж, тухайн улсын аюулгүй байдалд нөлөөлөх аливаа сөрөг хүчин зүйлийг даван туулах, арилгахад чиглэсэн цэрэг-улс төр, худалдаа эдийн засаг болон бусад бодлого, үйл ажиллагааг бүс нутгийн хэмжээнд авч хэрэгжүүлж байгаа нь нэгэнт тодорхой билээ. Уламжлалт их гүрнүүд болон хүн ам, газар нутаг, хөгжлөөрөө тэргүүлэгч улсууд дэлхий дахинд өөр өөрийн бодлого (улс төр, эдийн засаг, хууль, худалдаа, далай тэнгисийн баялаг, ашигт малтмал, газрын тосны нөөц гэх мэт хөгжилд түлхэц өгөхүйц эх сурвалжуудыг эзэмших, ашиглах, хяналтадаа байлгах)-ыг тодорхойлон өрсөлдөж байгаа нь нууц биш бөгөөд энэхүү сөргөлдөөн тэмцлийн явцад тухайн бүс нутагт оршиж байгаа бага, дунд буурай улс орнуудын язгуур эрх ашиг, аюулгүй байдал хөндөгдөж буй улс орнууд оршин байх, аюулгүй байдлаа хангахад онцгой анхаарах боллоо. Өөрөөр хэлбэл тухайн улсын аюулгүй байдал нь бүс нутгийн аюулгүй байдал болон дэлхий дахин бүс нутгийн глобал хямрал (дэлхийн дулаарал, эдийн засгийн хямрал, байгаль-экологи, нөөцийн хомсдол гэм мэт)-аас шууд ба шууд бус хамааралтай болох нь нэгэнт тодорхой болж байна. Монгол улс хэдийгээр далайд гарцгүй, эх газрын улс боловч дэлхий дахин болон бүс нутагт нөлөө бүхий хүчирхэг их гүрнүүдтэй хил залган оршдог, аюулгүй байдал нь дээр дурдсан улсуудаас шууд хамааралтай төдийгүй бүс нутагт дээрх улсуудын нөлөөгөөр тогтвортой байх, тогтворгүй байх нь шууд шалтгаалах эмзэг орчинд оршин тогтнож байна (Наранжамц.Н, 2024).

Дэлхий дахинд цэрэг улс төрийн нөхцөл байдал төдийлөн таатай бус, бүс нутаг, улс хоорондын зөрчил тэмцэл үргэлжлэн, зарим тохиолдолд бүхэл бүтэн тив, улсыг хамарсан (хувсгал) тэмцэл гарч, дээрх бүс нутаг, улс оронд тогтворгүй байдлыг бий болгож, улмаар дэлхий дахины цэрэг, улс төр, нийгэм эдийн засагт нөлөөлөхүйцээр даамжрах хандлага бий болж байна.

Бүс нутгийн аюулгүй байдлын орчинд таагүй өөрчлөлт гарах, эдийн засаг, хүмүүнлэгийн хямрал нүүрлэх, улмаар хөрш орнуудын дотоод улс төрийн байдал хурцдах, үндэсний эв нэгдэл, нэгдмэл байдалд нь заналхийлэх хүчин зүйлс их биш ч, үгүйсгэж боломжгүй байна. Үйл явцын ийм таагүй өрнөлийн үед зэвсэгт бүлэглэлүүд салан тусгаарлагчид, олон улсын терорристууд, үндэстэн дамнасан гэмт хэргийн бүлэглэлүүдийн зохион байгуулалттай үйл ажиллагаа идэвхижиж болзошгүй.

Нөгөө талаар монгол улсын хилийн халдашгүй дархан байдлыг үгүйсгэж, улсын хил зөрчин гэмт хэрэг үйлдэгч, хил орчмын нутаг дэвсгэрт амьдрагч иргэдийн амь нас, аюулгүй байдалд заналхийлдэг, улсын хилээр хориглосон бараа материал, зэвсэг, галт хэрэгсэл хил нэвтрүүлдэг, зохион байгуулалттайгаар ноос ноолуур, ангийн үс, эд эрхтэн, археологийн олдвор, үнэт металл, ховор эдлэлийг хууль бусаар хил нэвтрүүлэн худалдсан гэх мэт уламжлалт зөрчлүүд, сүүлийн үед хүн худалдаалах, хар тамхи, мансууруулах бодис хил давуулах гэмт хэрэг илэрхий даамжрах хандлагатай болж, бүс нутагт энэ төрлийн гэмт хэрэг идэвхжиж, манай улс дээрх гэмт хэргийн сүлжээнд бүртгэгдэж, үндэстэн дамнасан гэмт хэргийн бүлэглэлээс манай улсын иргэдийг болон хилийн хяналт шалгалтын сайнгүй нөхцөл байдлыг гэмт үйлдэлдээ ашиглах боллоо. Түүнчлэн улсынхаа хилийг эцэслэн тодорхойлж, тогтоогоогүйн улмаас хилийн асуудлаарх маргаан нь даамжран бүс нутгийн зарим улсуудын хооронд улс төр, дипломатын аргаар зохицуулахад хүндрэлтэй нөхцөл байдлууд бий болоход хүргэж байна. Бүс нутагт салан тусгаарлах үзэл, ажиллагаа идэвхжиж, үргэлжилсээр байгаа нь томоохон улсуудын улс төр, цэрэг, эдийн засгийн хүчийг туйлдуулах, залхаахад хүргэж, улмаар салан тусгаарлагчидтай хүчний тэмцэл явуулахад хүргэж байгаа нь дүрвэгсэд, нууцаар хил нэвтрэгсдийн тоог өсгөхөд хүргэж болзошгүй болно. Бүс нутаг дахь таагүй

нөхцөл байдал нь тухайн бүс нутаг дахь улс орнуудын аюулгүй байдал, түүний дотор улсын хил, хилийн орон зайд улс үндэстний аюулгүй байдалд нөлөөлөх тодорхой сөрөг хүчин зүйлүүдийг (нөхцлийг) бий болгодог байна. Дэлхийн улсуудын авч үзэж байгаагаар дурьдсан нөхцөл баидлууд нь тухайн улсын хилийн аюулгүй байдалд нөлөөлөх, зайлшгүй анхаарвал зохих дараах сөрөг хүчин зүйлүүдийг бий болгодог гэж үздэг байна (Наранжамц.Н, 2017). Үүнд:

-Хөрш улсуудын тусгай албадын явуулж буй тагнуул-сөрөг ажиллагаа;

-Тухайн улсыг өөрийн геополитикийн ашиг сонирхлын хүрээнээс гаргах зорилгоор бусад бүлэг улсуудын зүгээс тодорхой бүс нутагт өөрсдийн нөлөөллийг нэмэгдүүлэх хүчин чармайлт тавьж буй байдал болон найрсаг дотно харилцагч улсуудтай явуулах хамтын ажиллагаанд сөргөөр нөлөөлөх оролдлого;

-Хил залгаа улсуудын үндсэрхэг үзэлтэй байгууллагуудын зүгээс өөрийн төр засгаас тухайн улсад алдагдсан гэх газар нутгаа эргүүлэн авах гэх мэт элдэв шаардлага үйл ажиллагаа;

-Хилийн шугамын явалт өөрчлөгдсөнөөс үүдэлтэй нутаг дэвсгэрийн харъяаллын талаарх санал зөрөлдөөн;

-Хил орчмын нутаг дэвсгэр дэх нийгэм, улс төр, эдийн засгийн нөхцөл байдлын хүндрэл;

-Олон улсын гэмт хэргийн бүлэглэлүүд хууль бусаар дүрвэгсдийг тухайн оронд оруулах, гуравдагч улсад гаргах болон түүхий эд, үнэт зүйлс, материалын нөөц, зэвсэг галт хэрэгсэл, хар тамхи, мансууруулах бодисыг хууль бусаар хил нэвтрүүлэх оролдлого;

-Хил залгаа улстай хилийн шугам тодорхой тогтоогдоогүй байдал, цэрэг улс төрийн цагийн байдлын хурцдал, хил орчим дахь хууль бус бүлэглэлийн үйл ажиллагаа, улс орны дотоод зөрчлийг зохицуулах үйл явцын хүндрэлтэй холбоотойгоор хилийн зарим хэсгийн цагийн байдлын тогтворгүйжилт;

-Хил хамгаалах байгууллага, хилчдийн эсрэг тухайлбал, улсын хилийн шалган нэвтрүүлэх боомт газруудад гэмт этгээд, алан хядагчдын зүгээс явуулж буй хууль бус үйл ажиллагаа;

Мэдээллийн сөргөлдөөний идэвхжил, улс үндэстэн дамнасан гэмт хэргийн бүлэглэлүүд төр засгийн эрх мэдлийг бууруулах, хил орчмын оршин суугч, цэргийн алба хаагчид, тэдний гэр бүлийн эсрэг хууль бус үйлдэл хийхэд турхирах, заналхийлэх замаар сэтгэл зүй, мэдээллийн арга хэмжээнүүдийг зохион байгуулж явуулах зэрэг болно.

Орчин үед дэлхийн улсуудын олон улсын тавцан дээрх байр суурь нь юуны түрүүнд байгалийн баялаг, технологи, мэдээллийн нөөц, тэдгээрийг борлуулах зах зээлийг эзэмших зорилго бүхий өрсөлдөх чадвараар хэмжигдэж байна.

Улсын хил, хилийн аюулгүй байдалд учруулж болох аюул заналыг бүхэлд нь:

-Улс төрийн, эдийн засгийн, нийгмийн, цэргийн, хүн амын, байгаль экологийн аюулгүй байдалтай шууд холбоотой гэж үздэг тул улсын хил, хилийн орон зайд улсын хил хамгаалалтын найдвартай тогтолцоо бий болгохыг шаардаж байдаг.

Улсын хилийг хамгаалах, хилийн аюулгүй байдлыг хангах дээрх хэрэгцээ шаардлага, бүс нутгийн нөхцөл байдал, Монгол Улсын дотоод улс төр, хилийн цагийн байдлаас үндэслэн хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцоог шинээр бий болгох, хилийн аюулгүй байдлын албаны үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар ажиллах шаардлага тавигдаж байна. Эдгээр үндэслэл, хэрэгцээ шаардлагыг тайлбарлах нь илүүц тул бүс нутгийн аюулгүй байдал, хилийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг шинэ шатанд гаргах, хилийн аюулгүй байдлын ажилтнуудыг сургах, бэлтгэх, техник технологийг сайжруулах, бэлэн байдал, ажиллагааны далайцыг эрчимжүүлэх гэх мэт олон талт арга хэмжээг цогцоор нь авч хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна (Дашдаваа.Д, Ганболд.Ц, Муратхан.А, 2021, 2024).

Оперативын байгууламжийн тухай ойлголт

Улсын хил хамгаалалтын оперативын байгууламжийг: Монгол Улсын хилийн тухай хуульд Улсын хил

хамгаалалт нь “Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах, Монгол Улсын хилийн хууль тогтоомж, хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээг хэрэгжүүлэх, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох зорилгоор улсын хилийн зурвас, боомт, бүс, хил орчмын нутаг дэвсгэрт улсын хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах, зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх, цэргийн, инженер-техникийн, мэдээлэл технологийн, тагнуулын, хилийн төлөөлөгчийн арга хэмжээг хослуулан явуулж байгаа үйл ажиллагааг хэлнэ (хууль, 2017) гэж хуульчилсан. Дээрх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд олон хүчин зүйлүүд нөлөөлөх боловч энэхүү судалгааны ажилд хил хамгаалалтын байгууламжийг чухалчлан судласан билээ.

Монгол Улсын хилийн тухай хуулийн 3 дугаар зүйл 3.1.9-д “Улсын хил хамгаалалтын зориулалттай инженер, техникийн байгууламж” гэж хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, улсын хил хамгаалалтад дэмжлэг үзүүлэх зориулалт бүхий саад, мөр хянах зурвас, зам, гүүр, хянах цамхаг, холбоо, дохиолол хяналтын техник хэрэгсэл, замын хаалт болон бусад байгууламжийг хэлнэ (хууль, хилийн тухай хууль, 2017).

Манай Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хил хамгаалалтын дүрэмд хилийн отрядын хил хамгаалалтын байгууламж нь хүч хэрэгсэл, хил хамгаалалтын зааг, хилийн инженерийн байгууламж, дохиолол-хяналтын хэрэгслээс бүрдэнэ гэж тусгасан байна.

А.Хүч хэрэгсэл

-Бие бүрэлдэхүүн;

-Инженер, дохиолол-хяналтын хэрэгсэл;

-Мэдээлэл технологийн хэрэгсэл;

-Техник хэрэгсэл;

-Албаны амьтад;

-Хил хамгаалалтад туслах хүчин зэрэг хүч хэрэгслийг ашиглана гэж тусгасан.

Монгол Улсын хилийн тухай хуульд “Улсын хил хамгаалах байгууллага” гэж Монгол Улсын хэмжээнд улсын хил хамгаалалтыг зохион байгуулах, удирдах үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага, түүний харьяа хилийн цэргийн анги, салбарыг; (хууль, хилийн тухай хууль, 2017) “Хилчин” гэж хилийн цэрэгт алба хааж байгаа цэргийн жинхэнэ алба хаагчийг; (хууль, хилийн тухай хууль, 2017) гэж тодорхойлсон байдаг. Тэгвэл улсын хил хамгаалалтыг газар орон дээр зохион байгуулах үүрэг хүлээдэг хилийн заставууд нь бүсийн онцлог, цагийн байдлаас шалтгаалан тэдний өдөр тутмын хийгдэж буй ажил, гүйцэтгэх үүрэг албаны ачаалал харилцан адилгүй байна.

Монгол Улсын хилийн тухай хуулийн 3 дугаар зүйл 3.1.9-д “Улсын хил хамгаалалтын зориулалттай инженер, техникийн байгууламж” гэж хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, улсын хил хамгаалалтад дэмжлэг үзүүлэх зориулалт бүхий саад, мөр хянах зурвас, зам, гүүр, хянах цамхаг, холбоо, дохиолол хяналтын техник хэрэгсэл, замын хаалт болон бусад байгууламжийг хэлнэ.

Б.Хилийн инженерийн байгууламж

Хил хамгаалалтын инженерийн байгууламжуудын түүхийг судлах явцад эхлээд хашаа, хана, хэрэм босгох зэргээр ордныхоо, хотынхоо, цаашдаа улсынхаа хилийг хамгаалж ирсэн нь тодорхой байдаг. Өөрөөр хэлбэл, хилийн хамгаалалт эхлээд эзэн хаанаа, дараа нь ордноо, тэгээд хотоо эцэст нь хилийнхээ заагийг хамгаалах хэлбэрээр хөгжиж иржээ.

Улсын хилээ төхөөрөмжилж, хаалт саад хана хэрэм босгох арга 1200-аад оны эхээр Оросод анх нэвтэрч зуунаас зуунд боловсронгуй болсоор улсын хилийн инженер техникийн хангалт болон төлөвшиж, хилийг инженер техникийн хэрэгслээр хамгаалах аргыг нөхцөлдүүлжээ. Одоо ч ач холбогдлоо алдаагүйгээр барахгүй ач холбогдол нь улам бүр өссөөр байна. Дэлхийн улс бүхэн тэр дундаа Монгол Улс хилийн шугамын дагуу техникийн төхөөрөмжлөлт хийхийг чухалд үздэг. Энэ дотроос инженерийн төхөөрөмжлөлт нь онцгой байр эзэлдэг. Улсын хилийн дагуу инженерийн

төхөөрөмж хийснээр улсын хил энд байна гэдгийг бүх нийтээр мэдэх, нөгөө талаар улсын хилийг дур мэдэн өөрчлөх, зөрчихгүй байх үүднээс хилийн шугамын дагуу инженерийн байгууламж, саад, хаалт барьж байгуулдаг. Энэ нь улсын хил манах үр ашгийг дээшлүүлэхэд чиглэгдсэн олон төрлийн арга хэмжээний цогц юм. Инженерийн байгууламжид хилийн тэмдэг, багана, хилийн дагуух мөр хяналтын зурвас, төрөл бүрийн саадууд, хяналтын байрууд, зам, харгуй, нисэх онгоц, нисдэг тэрэгний хөөрөх, буух талбай, усан хилийн хөнгөн хөлөг онгоцны зогсоол, худаг ус, хилийн манааны дулаацах байр, машин техник, радиолокацийн станцийн далдлагдсан байрууд зэрэг ордог. Хэрэв инженер-техникийн хангалт байхгүй бол улсын хил зөрчигчид задгайрч тэднийг барьж саатуулалгүй алдах аюултай. Тухайлбал улсын хилээр хууль бусаар нэвтэрсэн этгээдийг нутгийн гүнд хэдэн зуун километрийн зайнд алдах эсвэл дотоодоос гарах зорилготой этгээдийг саатуулж чадалгүй гадагш алдах болно.

Тиймээс улсын хил хамгаалалтад инженерийн байгууламж ашиглахгүйгээр манах, хамгаалах боломжгүй бөгөөд хөрш болон бусад хөгжингүй орнууд цэрэг армийнхаа зэвсэглэл, техник-технологийг шинэчлэх, ашиглах боломжоо улам бүр нэмэгдүүлсээр байгаа билээ.

Инженерийн алба гэдэг нь ихэнх орнуудын зэвсэгт хүчинд байдаг, байлдааны ажиллагааг инженерийн талаар хангах, цэрэг /хүч/-ийг инженерийн хувьд бэлтгэх, тэдэнд инженерийн зэвсэглэлийн хэрэгслийн хангалт хийх, тэдгээрийн зөв ашиглалт, засвар үйлчилгээг хариуцан хангах үүрэг гүйцэтгэдэг тусгай алба юм. (газар, 2003)

Инженерийн байгууламж нь байлдаан /операци/-ы бүх төрлүүдэд газар орныг инженерийн хувьд төхөөрөмжлөх явцад байгуулагдана. Цэргийн бэхлэлт, цэргийн зам, гүүр, аэродром, хуурамч объектуудын макетууд багтана. Төмөр бетонон, мод шороон, хуягласан байж болно. Тэднийг ихэвчлэн задалж угсардаг бүтэцтэй хийцүүд ашиглан байгуулдаг.

1970-аад оны сүүлээс Монгол Улсын төр засгаас улсын хилийн хамгаалалтыг боловсронгуй болгох талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд, манай улсын өмнөд хилийн ихэнх отряд инженерийн талаар төхөөрөмжлөгдөж, ЗХУ-ын буцалтгүй тусламжаар шинэ, шинэ техник хэрэгслүүд хил хамгаалалтад нэвтэрсэн нь, манай хилчдийг Зөвлөлтийн хил хамгаалалтын туршлагаас суралцан, эдгээр техник хэрэгслүүдийг яаж ашиглаж, ямар аргаар хилээ хамгаалж байгаатай танилцаж, тэднээс суралцах боломжийг бүрдүүлсэн байна.

Монгол Улсын хилийн хамгаалалтад:

-Мөр хянах зурвас

-Хориглон хамгаалалтын төхөөрөмж

-Хянах төхөөрөмж

-Инженерийн тэсэрдэггүй саад

-Хилийн зам, гүүр зэрэг инженерийн төхөөрөмжүүд

-Дохиолох хэрэгсэл

-Радиотехникээр илрүүлэх хэрэгсэл

-Техникээр хянах хэрэгсэл

-Гэрлийн техник хэрэгсэл

-Хилийн шалгалтын техник хэрэгсэл

-Өнгөлөн далдлах хэрэгсэл зэрэг хил хамгаалалтын техник хэрэгслүүд нэвтэрснийг илүү боловсронгуй болж, нягтрал, давтамжийг нь нэмэгдсэнээр улсын хил дээр гарах зөрчлийг өдөр, шөнө харгалзахгүй шуурхай илрүүлэн саатуулах боломж нэмэгдэнэ гэж тооцоолж байна.

Өнөөгийн байдлаар Монгол Улсын хилийн 26.2 хувийг хамарсан 2169.5 км урт өргөст торон хашаат ашиглаж байгаагийн дотор 49.2 хувь нь өмнөд хил дээр, 16.3 хувь нь умард чиглэлд байна. Өөрөөр хэлбэл улсын хилийн ихэнх хэсэгт ямар нэг инженерийн саад баригдаагүй гэсэн үг. Мөн хилийн дагуу өнгөрсөн хугацаанд 3526.6 км мөр шалгах зурвас ашиглаж байсан бол өнөөгийн байдлаар 1370.6 км буюу Монгол Улсын хилийн 16.6 хувийг хамардаг болж буурчээ. Улсын хилийн дагуу 73.0 хувьд нь мөр шалгах ийм зурвас татагдаагүй, одоогийн байгаар нь борнойдох зэргээр байнгын ашиглалтад байлгаж чадахгүй байна.

Одоо улсын хил дээр 377 хянах байр байгаа ба нэг хянах байрт дунджаар 21.8 км хэсэг оногдож байгаа юм.

Хил хамгаалах байгууллага дахин байгуулагдсан үе болох 1967 оноос эхлэн хилийн заставын барилга байгууламжийн тоо 150, хөрөнгө оруулалтын хэмжээ 93, техникийн тоо 36 дахин нэмэгдсэн байна. Өмнөд хилийн дагуух заставт дунджаар 1-2 төмөр хянах цамхаг, 3400 км мөр хянах зурвас, 2200 км гаруй өргөс утсан хашаа, 36 км цахилгаан дохиоллын систем, 224 ширхэг кристалл багаж, прожекторын станц-34, радиолокацийн станц-17, заставын тулгуурт байр-75, отрядын хориглолтын район-10, хилийн районд нийт замын сүлжээний урт 4932 км хүрч нийт уртаараа 581 км гүүрийг барьж байгуулан хил хамгаалалтын эрх ашигт нийцүүлэн ашиглаж байна (Д.Нямдорж, 2010) гэж доктор Д.Нямдорж өөрийнхөө судалгааны ажилд дурдсан байдаг.

Харамсалтай нь дээрх байгууламжуудаас өнөөдрийн байдлаар цөөн тооны хянах цамхаг, хэдхэн км мөр хянах зурвас, өргөст утсан хашаа үлдсэнийг эс тооцвол бараг байхгүй гэж хэлж болохоор байна.

д/д	Байгууламжийн нэр	Монгол-Хятадын хилд	Монгол-Оросын хилд	Үүнээс ашиглагдаж байгаа	Ашиглалтын хувь
1	Өргөст утсан хашаа	2318,6	578,2	2169,5	93,7
2	Мөр хянах зурвас	3379	147,6	1370,6	40,5
3	Хянах манаань байр	216	161	377	100,0
4	Хянах цамхаг	65	50	83	72,5
5	Дохиоллын систем	12	-	-	-
6	Модон болон төмөр бетон гүүр	15	23	36	94,7
7	Агаарын баганат шугам	2184,5	507,5	2692	100,0
8	Холбооны кабель шугам	140,863	18,88	160,7	99,0

Хүснэгт 1.Хил хамгаалах байгууллагад ашиглаж байгаа инженерийн байгууламж

Эх сурвалж: Судлаач нэгтгэв

Техникийн харуул, техникээр хил хамгаалахтай холбоотой бүх төхөөрөмжүүд, тийм төрлийн техник хэрэгслүүд, хилийн отрядуудад байсан инженерийн мэргэжлийн офицерууд, тусгай салаа, тухайн ангийн орон тооны бүтцээс үндсэндээ хасагдаж одоо хилийн отрядуудад энэ албыг мэргэжлийн бус офицерууд ёс төдий хавсран гүйцэтгэх болжээ.

Хилийн отрядуудад 2011 онд зэвсэг, техникийн албаны офицерууд (инженерийн албыг хавсран гүйцэтгэж байгаа)-ын дунд явуулсан судалгаанд нийт 27 офицер оролцсоноос мэргэжлийн чиглэлийн нэг ч хүнгүй, 2-3 жил ажиллаж байгаа хүн 15 хувь, бусад нь бүгд 1-2 жил ажиллаж байгаа гэсэн судалгааны дүгнэлт байдагаас инженерийн албаны ажил үүргийг талаар ямар ч мэдлэг, ойлголтгүй байгаа нь харагдаж байна.

В.Дохиолол-хяналтын хэрэгсэл

Монгол Улсын хилийн тухай хуульд “Улсын хил хамгаалалтын зориулалттай инженер, техникийн байгууламж” гэж хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, улсын хил хамгаалалтад дэмжлэг үзүүлэх зориулалт бүхий саад, мөр хянах зурвас, зам, гүүр, хянах цамхаг, холбоо, дохиолол хяналтын техник хэрэгсэл, замын хаалт болон бусад байгууламж”-ийг хэлнэ гэж заасан байдаг.

Түүний нэг төрөл болох дохиолол хяналтын техник хэрэгслийн авч үзье.

Хяналтын техник хэрэгсэл, дохиоллын зориулалттай илрүүлэлтийн техник хэрэгслүүдээс мэдээлэл хүлээн авах, бүртгэх, цуглуулах нэгтгэн боловсруулж дүгнэлт хийх, хүлээн авч байгаа мэдээллийг операторт харуулах болон тухайн төхөөрөмж (дүрсийн камер, гэрэлтүүлгийн хэрэгсэл)-ийг алсаас удирдах, тэдгээрийн ажиллагааны хэвийн байдлыг хангах үүрэг бүхий нэгдмэл төхөөрөмжийг хэлнэ.

Хилийн отряд нь агаарын довтолгооноос хамгаалах цэргийн

салбаруудтай харилцан ажиллагаатай байж, өөрийн хариуцсан хэсэгт отряд, застав, харуул, манаанд хүч хэрэгсэл болон хяналт, дохиоллын техник хэрэгслийг ашиглан агаар, газар, усны мандалд тасралтгүй хяналт зохиодог.

Хяналт нь хил хамгаалалтын болон цэргийн тагнуулын үндсэн аргуудын нэг мөн бөгөөд хилийн шугам, хил залгаа улсын нутаг дэвсгэр, өөрийн нутаг, агаарын орон зайд тасралтгүй ажиглалт зохиох замаар хилийн болон хил орчмын дэглэм зөрчихөөр бэлтгэж байгаа шинж тэмдгүүдийг илрүүлэх зорилгоор явагдана.

Манай улс, хил залгаа улсын хил орчмын нутаг дахь ажил, үйлдвэрлэл, хилийн ойролцоох хот, суурин, бусад анхаарал татаж буй объект, хил давсан зам, инженерийн төхөөрөмж, хяналт, дохиоллын байгууламжаар бүрэн халхлагдаагүй болон хяналтад өртдөггүй газруудад зөрчил гарч болзошгүй хэсэг, хариуцсан хэсгийн уулзварууд, гамшиг, аюулт үзэгдэл гарч байсан болон гарч болзошгүй газар, агаарын орон зай, хилийн гол, нуурын мандал дээр хөдөлгөөн үйлдэж байгаа бүх төрлийн нисэх, хөвөх хэрэгсэлд цэргийн хяналтыг зохион байгуулж, хамгаалалтын нягтралыг нэмэгдүүлэх ба хариуцсан хэсгийн газар орныг нарийн судлаж хянах байр, хяналтын техник хэрэгслүүдийн байрлалыг зөв сонгох, дохиоллын техник хэрэгслийг зөв байршуулах, хяналт явуулах аргад бие бүрэлдэхүүнийг сургаж дадлагажуулах, хяналтын техник, дохиоллын хэрэгслийг чадварлаг ашиглах, өнгөлөн далдлалтын арга хэмжээг хатуу сахих, анхаарал татсан болон шинэ обьектуудад хяналт тавих арга хэмжээг цогцоор авснаар хил хамгаалалтын үр дүн тодорхойлогдоно.

Г.Сэтгэл ханамжийн судалгааны талаар

Хил хамгаалах байгууллагын алба хаагчдаас хил хамгаалалтад ашиглаж буй орчин үеийн техник технологи, цахим хөгжүүлэлтийн талаарх сэтгэл ханамж, цаашид технологийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох зорилгоор хаалттай 12, нээлттэй 2 нийт 14 асуумж бүхий судалгааг анкетын аргаар авч, SPSS-21 судалгааны программаар тоон мэдээллийг боловсруулсан.


Судалгаанд баруун бүсийн 5, зүүн бүсийн 6, өмнөд бүсийн 6, хойд бүсийн 6, төвийн бүсийн 9 нийт 32 ангийн офицер 1395, ахлагч 1703, төрийн үйлчилгээний ажилтан 663, нийт **3761** алба хаагч хамрагдсан. Үүнд 63-80 насны 3, 42-62 насны 579, 29-41 насны 2135, 18-28 насны 1044 алба хаагч байгаагаас 62.5 хувь нь эрэгтэй, 37.4 хувь нь эмэгтэй алба хаагч байна.

Насны үечлэл		Офицер	Ахлагч	ТҮА	Эрэгтэй	Эмэгтэй	Хувь
Нийт	64-81	1		2	3		0.7%
	43-63	194	146	239	300	282	15.3%
	30-42	898	959	278	1352	903	56.7%
	18-29	302	598	144	697	354	**27.7%**

Хүснэгт 2, Судалгаанд хамрагдсан бүрэлдэхүүний насны үечлэл

Эх сурвалж: Судлаач нэгтгэв

Судалгаанд хамрагдсан бүрэлдэхүүний насны үечлэлийн байдлыг судалж үзэхэд 56.7 хувь нь 30-42 насны буюу Y үеийнхэн, 27.7 хувь нь 18-29 насны буюу Z үеийнхэн байгаа бол 15.3 хувь нь 43-63 насны буюу X үеийнхэн байна. Үүнээс харахад одоогийн байдлаар нийт ажиллагсдын талаас илүү хувийг 30-42 насны буюу Y үеийнхэн эзэлж байгаа боловч 18-29 насны буюу Z үеийнхэн 27.7 хувийг эзэлж байгаа нь хэдхэн жилийн дараа зонхилох хувийг бүрдүүлэх нь тодорхой юм. Тиймээс технологд суурилсан онцлог бүхий Z үеийн алба хаагчдаар хил хамгаалалтыг зохион байгуулахад орчин үеийн техник, технологийг албанд өргөнөөр ашигласанаар үзүүлэх үр дүн нь илүү байх юм.



Хүснэгт 3, Судалгаанд хамрагдсан бүрэлдэхүүний Хил хамгаалах байгууллагад ажилласан байдал:

Эх сурвалж: Судлаач нэгтгэв

Судалгаанд хамрагдсан бүрэлдэхүүний 974 хүн буюу 25.8 хувь нь1 жил хүртэл, 1422 хүн буюу 37.8 хувь нь 2-10 жил, 1176 хүн буюу 31.2 хувь нь 11-20 жил, 189 хүн буюу 5 хувь нь 21-ээс дээш жил ажилласан байна.

Дүгнэлт, санал

Хүн төрөлхтөн урьд хожид байгаагүй хувьсамтгай, тодорхойгүй, төвөгтэй, эргэлзээтэй орчинд амьдарч байна. Хиймэл оюун ухаан, техник техниологийн шинэчлэлт, мэдээлэлд тулгуурласан дэвшлүүд нь урьд өмнө байгаагүй боломж бас шинэ эрсдэлийг бий болгож байна. Өөрчлөлтийн хурдац эрс эрчимжиж, байгаа энэ үед улс орон, хувь хүмүүст илүү холыг урьдчилан хардаг, шинэ нөхцөл байдалд хурдтай дасан зохицож, холбогдох шийдвэрүүдийг хурдан шуурхай гаргах чадвартай байхыг шаардах болсон.

Дэлхийн улс оронуудын геополитикийн өрсөлдөөн эрчимжиж, олон туйлт дэлхийн дэг журамд шилжих явцад, олон улсын цэрэг-стратегийн хурцадмал байдал үүсэж болох нөхцөлүүд нэмэгдсээр байна.

Аюулгүй байдлын гадаад орчны нөхцөл байдал болон цэрэг-стратеги, байлдааны ажиллагааны шинж чанарт орж буй өөрчлөлтүүд нь шинэ сорилтыг бий болгож, аюулгүй байдал, батлан хамгаалах асуудал, хилийн аюулгүй байдалыг хангах талаар шинэ нөхцөл үүсэж байна.

Орчин үеийн цэргийн ирээдүйн чиг хандлага нь хөнөөх чадвар өндөр, олон төрлийн тулалдааны талбарт үүрэг гүйцэтгэх чадвартай дрон, хиймэл оюун ухаан, мэдээллийн технологид суурилсан зэвсэглэл, техник, агаарын болон алсын тусгалтай зэвсэглэлийг хөгжүүлэх, цэргийн зэвсэглэлд нэвтрүүлэхийг ихэд анхаарах болоод байгаа энэ үед бид цэрэг-стратегийн орчинд болж байгаа хувьсгал, өөрчлөлт, ирээдүйн хандлагыг сайн мэдэрч, хилийн аюулгүй байдлыг хангахад хил хамгаалалтын оперативын байгууламжаа олон улсын зэвсэгт хүчний мэргэжлийн армийн жишгээр хөгжүүлэх нь нэн чухал асуудал болоод байна.

Тиймээс бид бүс нутгийн хил хамгаалалтын оперативын байгууламжаа нэмэгдүүлэхдээ хилийн инженерийн байгууламж, дохиолол хяналтын хэрэгслээ хөгжүүлэх, хил хамгаалалтад орчин үеийн техник технологийг ашиглах замаар хүний орон зайг багасгаж, техникийн дэвшлийг ашиглахыг чухалчлах шаардлагатай юм.

Чичиргээ мэдрэгч бүхий шилэн кабелийн дохиоллын системийг “Тагнуулын Ерөнхий Газар”-аас мэргэжлийн баг томилон шалгуулж цаашид үндэсний компаниудтай хамтран

хөгжүүлэлт хийж Улсын Хил хамгаалалт, онцгой объектын хамгаалалтад нэвтрүүлэх.

Эх сурвалжийн жагсаалт

Дашдаваа.Д, Ганболд.Ц, Муратхан.А. (2021, 2024). *Хилийн аюулгүй байдал.* Улаанбаатар: Мөнхийн үсэг.

н.наранжамц. (2024). *бүс нутгийн хил хамгаалалт.* Улаанбаатар: улаанбаатар принт.

Наранжамц. Н. (2017). Бүс нутаг ба хилийн аюулгүй байдал. *Хил шинжлэл*, 35.

Наранжамц.Н. (2012, 2024). *Бүс нутаг-Хил хамгаалалтын үзэл баримтлал.* Улаанбаатар хот: Мөнхийн үсэг.

Наранжамц.Н. (2012, 2024). *Бүс нутаг-Хил хамгаалалтын үзэл баримтлал.* Улаанбаатар: Мөнхийн үсэг.

Наранжамц.Н. (2017). Монголын хил судлалын академи. *Бүс нутаг ба хилийн аюулгүй байдал*, 38.

Наранжамц.Н. (2017). хил шинжлэл. *бүс нутаг ба хилийн аюлгүй байдал*, 36.

Наранжамц.Н. (2017). хил шинжлэл. *бүс натаг ба хилийн аюулгүй байдал*, 36.

Наранжамц.Н. (2024). *бүс нутаг-Хил хамгаалалтын үзэл баримтлал.* Улаанбаатар: Мөнхийн үсэг.

УИХ. (2017). Монгол Улсын хилийн тухай хууль. *төрийн мэдээлэл*, 1.

УИХ. (2017). Монгол Улсын Хилийн тухай хууль. *Төрийн мэдээлэл эмхэтгэл*, 1.

ХИЛИЙН БООМТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭДИЙН ЗАСАГ ДАХЬ НӨЛӨӨЛЛИЙН СУДАЛГАА

STUDY OF THE ECONOMIC IMPACT OF BORDER PORT ACTIVITIES

Г.Галбадрах
Дотоод хэргийн их сургуулийн Хилийн албаны сургуулийн захирал, докторант
Galbadrakh.G
Ph.D candidate, Director at the School of Border Service, University of Internal Affairs, Mongolia

*Хариуцлагатай зохиогч: Емайл хаяг: galbadrakh.gan@uia.gov.mn

Хураангуй: Монгол Улсын Хил хамгаалах байгууллага хилийн аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүргээ хил залгаа улсуудтай харилцан итгэлцэл, хамтын ажиллагаанд тулгуурласан энхийг сахих, энх тайванч байдлаар зэрэгцэн орших зарчмыг хүндэтгэн хэрэгжүүлэх чиглэлийг «Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого»-оор тодорхойлсон бөгөөд үйл ажиллагаандаа олон улсын хэмжээнд тавигдаж буй бүхий л шаардлагыг хангах хэрэгцээг бий болгож байна.

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогод Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэхээр тусгасан. Шинэ сэргэлтийн бодлогын онцлог нь бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцоог багасгаж, төр болон хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлж, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн санаачилга, ур чадвар, туршлагыг Монгол Улсын хөгжлийн цөм хэмээн үзэж буй явдал юм. Шинэ сэргэлтийн бодлогын 6 хүчин зүйлийн нэг болох Боомтын сэргэлтийн бодлогын үндсэн зорилго нь боомтоор дамжин хийгдэх худалдааг дэмжих, хөнгөвчлөх, бизнес эрхэлж буй иргэд, аж ахуйн нэгжүүдийн ашиг орлогыг нэмэгдүүлэхэд чиглэж байгаа. Мөн олон улсын худалдааны нэвтрүүлэлт, түгээлт, тээвэр зохицуулалт, логистикын талаарх дотоодын дүрэм журам, стандартыг зохицуулах шаардлага урган гарч байна.

Энэхүү ажлаар хилийн боомтоор нэвтэрсэн тээврийн хэрэгслийн тоо, гадаад худалдааны орлого, экспорт, импортын бүтээгдэхүүний хэмжээг сүүлийн 10 жилийн статистик мэдээлэлд үндэслэн хамаарлыг тогтоох корреляц, регрессийн шинжилгээ хийж, хилийн боомтоор нэвтрэх тээврийн хэрэгслийн тоог нэмэгдүүлэхэд эдийн засгийн өсөлтөд эерэгээр нөлөөлж болохыг тодорхойлов.

Abstract: This paper the Mongolian Border Guard has defined the direction of implementing its special function of ensuring border security by respecting the principles of peacekeeping and peaceful coexistence based on mutual trust and cooperation with neighboring countries in the “Policy of the Mongolian State on Borders”, and it creates the need to meet all international requirements in its activities.

In this work, correlation and regression analysis were conducted to determine the relationship between the number of vehicles entering the border crossing, foreign trade income, and the volume of exports and imports based on statistical data from the last 10 years, and it was studied that increasing the number of vehicles entering the border crossing positively affects economic growth.

Түлхүүр үг: Хил судлалын онол, арга зүй, хилийн боомтын үйл ажиллагаа, эдийн засаг, дотоодын нийт бүтээгдэхүүн, экспорт, импорт

Key words: Border studies theory and methodology, border operations, economics, gross domestic product, exports, imports

This article is published under the Creative Commons
BY-NC-SA License by 4.0, ©2025 University of Internal Affairs, Mongolia

Удиртгал

Хилийн боомтын үйл ажиллагааны онолын үндэслэл

Хилийн боомт (Х.Асхар, 2020) гэдгийг Монгол Улсын хилийн шугамын дагуух хил орчмын нутаг дэвсгэрт, зам харилцаанд тулгуурлан байрлаж, тусгайлан тоноглож, төхөөрөмжилсөн газар, хуулиар олгогдсон эрх бүхийн байгууллагууд улсын хил нэвтрэх, зорчигч, тээврийн хэрэгсэл, ачаа бараанд хяналт шалгалт хийх зорилготой газар гэж тодорхойлдог байна.

Хилийн боомтын үйл ажиллагаа, шалган нэвтрүүлэх албаны онол, арга зүй нь хил судлалын ерөнхий онолоос гадна төрийн хилийн бодлогын онол, гаалийн онол, хилийн хяналт шалгалтын онол, хил хамгаалах урлагийн онол, хилийн стратеги, оперативын онол, хилийн цэргийн тактикийн онол зэрэг хэсгийн онолууд (тусгай онолууд)-аас бүрддэг.

Хил судлалын шинжлэх ухаан нь өргөн хүрээтэй мэдлэгийн салбар бөгөөд орчин цагийн шинжлэх ухааны судалгааны түгээмэл аргуудыг ашигладаг. Тухайлбал, цэргийн шинжлэх ухаан, нийгмийн шинжлэх ухаан, техникийн шинжлэх ухаан, байгалийн шинжлэх ухааны хүрээнд боловсруулагдсан аргуудыг ашигладаг бөгөөд эдгээр нь арга зүйн (методика) болон арга судлалын (методология) үндсийг нь бүрдүүлж байна. Өнөөдөр синергетикийн болон системийн онолуудыг дангаар болон хамтатган хэрэглэж байна. Эдгээр аргаас синергетик арга нь хилийн орчны судалгаанд бүрэн тохирно гэж үздэг (Ц.Ганболд, 2022).

Хил судлал нь цэрэг, техникийн ухаан, эдийн засаг, улс төр судлал, эрх зүй зэрэг шинжлэх ухааны мэдлэгийн уулзвар дээр оршиж, цогц, нэгдмэл чанарыг илэрхийлж байдаг. Үүнээс үзвэл улсын хил хамгаалалтын онол нь хил судлалын ухааны гол цөмийг бүрдүүлж байна гэж үзэх үндэслэлтэй ба хил судлалын шинжлэх ухаан олон шинжлэх ухааны цогц байдгийн мөн чанар нь тэдгээр шинжлэх ухааныг улсын хил, түүний хамгаалалт гэсэн нэг цэг дээр төвлөрүүлж тэдний уялдаа холбоог хангаж байдагт оршино (Ц.Ганболд, 2022) гэж үзжээ.

Монгол Улсын хилийн урт 8252.6 км бөгөөд үүнээс ОХУ-тай 3543 км, БНХАУ-тай 4709.658 км урт хилээр хиллэдэг (Монгол Улсын хил, 2019).

Монгол Улсад нийт 39 боомт байдгаас (Ц.Ганболд, 2022) Монгол Улс, БНХАУ-тай олон улсын зорчигч, ачаа тээврийн харилцааны зориулалттай байнгын ажиллагаатай Булган, Замын-Үүд төмөр зам, авто зам, Бичигт, Сүмбэр, хоёр талын зориулалттай байнгын ажиллагаатай Шивээхүрэн, Гашуунсухайт, түр буюу улирлын ажиллагаатай Даян, Байтаг, Бургастай, Ханги, Баянхошуу, Хавирга зэрэг 17 боомт үйл ажиллагаагаа явуулж байна. Монгол Оросын хилийн 16 боомтоос олон улсын зорчигч, тээврийн харилцааны Сүхбаатар-Наушки, Цагааннуур-Ташанта, Алтанбулаг-Хиагт, Эрээнцав-Соловьевск (авто замын), Боршоо-Хандгайт, хоёр талын зорчигч, ачаа тээврийн харилцааны Эрээнцав-Соловьевск (төмөр замын), Ханх-Монд, Ульхан-Дээд Ульхан, Арцсуурь-Цагаан толгой, Тэс-Шарсуурь гэсэн 10 боомт байнгын үйл ажиллагаа явуулж байна. бусад 19 боомт нь Монголын эсвэл Оросын талын хилийн боомтын дэд бүтэц хөгжөөгүй, хилийн хяналт шалгалтын байгууллагын албан хаагчид ажиллах, амьдрах нөхцөл бүрдээгүйн улмаас ажиллахгүй байна.

Монгол Улсын хилээр нэвтэрсэн зорчигч, тээврийн хэрэгслийн тоог Үндэсний статистикийн хорооноос сүүлийн 10 жилийн байдлаар гаргасан судалгаанаас үзэхэд 2024 онд Монгол Улсын хилийн боомтуудаар нийт 7179.2 (давхардсан тоогоор) мянган зорчигч нэвтэрснийг өмнөх онуудтай харьцуулахад, 2019 оноос 17.8 хувиар, 2020 оноос 5.3 дахин, 2021 оноос 11.1 дахин, 2022 оноос 3.6 дахин, 2023 оноос 34.6 хувиар тус тус өсжээ. 2020-2021 онд дэлхий дахинд КОВИД-19 цар тахал дэгдсэнтэй холбоотойгоор Монгол Улсын хилээр нэвтэрсэн зорчигчдын тоо огцом буурсан боловч 2022 оны 2 дугаар сараас эхлэн хилийн боомтуудыг үе шаттайгаар нээж эхэлснээр зорчигчдын тоо аажмаар нэмэгдэж эхэлжээ. Мөн манай улсын хилээр 2024 онд давхардсан тоогоор 4 030.5 мянган тээврийн хэрэгсэл нэвтрүүлсэн нь 2015 онтой харьцуулахад 2.2 дахин, 2019 оноос 49.6

хувиар, 2023 оноос 35.2 хувиар өссөн байна. /Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо/

Хөрш орнуудын хилээр нэвтэрсэн зорчигч, тээврийн хэрэгслийн статистик мэдээнээс үзэхэд 2024 онд ОХУ-ын авто замын болон төмөр замын боомтоор эхний 10 сард ОХУ-Хятад, Монголын хилийн боомтуудаар 482,000 тээврийн хэрэгсэл нэвтэрсэн нь өмнөх оны мөн үеэс 54.3%-иар ихэссэн. Төмөр замын боомтоор нэвтэрсэн экспортын ачаа тээвэрлэлт өмнөх оны мөн үеэс ойролцоогоор 20-22% өсөлттэй байжээ.

БНХАУ-ын авто замын боомтуудаар 2024 онд нийт 1.77 сая тээврийн хэрэгсэл нэвтэрсэн бөгөөд энэ нь өмнөх онтой харьцуулахад 48.8% өссөн байна. Хилээр нэвтэрсэн нийт зорчигчдын тоо 610 саяд хүрсэн нь 2023 онтой харьцуулахад 43.9%-иар өссөн үзүүлэлт юм.

Хилийн боомтын үйл ажиллагаа нь Монгол Улсын эдийн засгийн хөгжилтэй салшгүй холбоотой. Үүнийг дараах үр дүнгээр харуулья.

Материал, арга зүй

1.Корреляцийн шинжилгээний үр дүн

Үзүүлэлт	Нийт хил нэвтэрсэн тээврийн хэрэгсэл	Гадаад худалдааны нийт эргэлт, сая ам $	Нийт төвлөрүүлсэн импорт, экспортын татвар, сая. төг	ДНБ, тэрбум төг
Нийт хил нэвтэрсэн тээврийн хэрэгсэл	1			
Гадаад худалдааны нийт эргэлт, сая ам $	0.661874568	1		
Нийт төвлөрүүлсэн импорт, экспортын татвар, сая. төг	0.663040674	0.996412781	1	
ДНБ, тэрбум төг	0.671915447	0.991208195	0.99120214	1

Эх сурвалж: Судлаачийн боловсруулалт

Хилээр нэвтэрсэн тээврийн хэрэгслийн тоо гадаад худалдааны нийт эргэлт, нийт төвлөрүүлсэн экспорт, импортын татварын орлого ба ДНБ-ний өсөлтөд нөлөөлж буй нөлөөллийг хамаарлын шинжилгээгээр тодорхойлоход коэффициент 0.66-0.67 буюу хүчтэй бөгөөд эерэг хамааралтай байна. Эндээс гадаад худалдааны нийт эргэлт, нийт төсөвт төвлөрүүлсэн гадаад худалдааны татварын орлого нь дотоодын нийт бүтээгдэхүүнийг бүрдүүлдэг тул цаашид дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтөд хилийн боомтын нэвтрүүлэлтийн хурд хэрхэн нэмэгдүүлэхийг регрессийн шинжилгээгээр тодорхойлъё.

Судалгаанд 2015-2024 онд Замын-Үүд хилийн боомтоор нэвтэрсэн тээврийн хэрэгслийн мэдээллийг гаалийн цахим үйлчилгээний системээс, Монгол Улсын эдийн засгийн 2015-2024 оны үзүүлэлтүүдийг Үндэсний статистикийн хорооны албан ёсны хуудаснаас авсан. Судалгаанд статистик боловсруулалтын Data analyses программыг ашиглав.

Шинжилгээ ба үр дүн

Хилийн боомтын нэвтрүүлэх чадвар, үйлчилгээний чанар нэмэгдсэнээр гадаад худалдаа тэлж улмаар Монгол Улсын эдийн засгийн өсөлтөд нөлөөлдөг. Монгол Улсын экспортын голлох бүтээгдэхүүн нь уул уурхайн бүтээгдэхүүн бөгөөд БНХАУ дангаар худалдан авч байна. Энэ нь нэг талаас нэг улсаас хараат байдлын аюулыг бий болгож байна. Хилийн боомтын нэвтрүүлэлт Монгол Улсын эдийн засагт гадаад худалдааны тэнцэл ашигтай байх, төсвийн татварын орлого бүрдүүлэлт болон эдийн засгийн өсөлтөд эерэгээр нөлөөлдөг болохыг дараах шинжилгээгээр тодорхойлъё.

2.Регрессийн шинжилгээний үр дүн

Regression Statistics	
Multiple R	0.6719
R Square	0.4514
Adjusted R Square	0.3829
Standard Error	15257.8
Observations	10

ANOVA

	df	*SS*	*MS*	*F*	*Significance F*
Regression	1	1532868516	1.53	6.584445	0.033333
Residual	8	1862411943	2.33		
Total	9	3395280459			

	Coefficients	*Standard Error*	*t Stat*	*P-value*	*Lower 95%*	*Upper 95%*	*Lower 95.0%*	*Upper 95.0%*
Intercept	-1158.6	17892	-0.06476	0.9499	-42417.7	40100.39	-42417	40100.39
X Variable	0.0353	0.0137	2.566	0.033	0.00357	0.0670	0.0035	0.067035

Эх сурвалж: Судлаачийн боловсруулалт

Улсын хилээр нэвтэрсэн тээврийн хэрэгслийн тоо(х) ДНБ-ний өсөлт(у)-ийн нөлөөллийн регрессийн шинжилгээний үр дүнд детерминацийн коэффициент 0.45 буюу ДНБ-ний өсөлтөд хилээр нэвтэрсэн тээврийн хэрэгслийн тоо 45 хувиар нөлөөлөх хүчин зүйл бөгөөд ДНБ-ний бусад бүрэлдэхүүн аж ахуйн нэгж, өрх гэр, төрийн хэрэглээний нөлөөлөл нь 55 хувь байна. Хамаарлын коэффициент итгэлтэй гарсан ба нөлөөлөл нь 0.0353 буюу тээврийн хэрэгслийн нэвтрэлт тутамд ДНБ 3.53 сая төгрөгөөр нэмэгдэх зүй тогтолтой байна. Иймд хилийн боомтын дэд бүтэц, хяналт шалгалтын үйл ажиллагаанд ашиглах тоног төхөөрөмжийн хүчин чадал, хүний нөөц, алба хаагчдын чадавхийг нэмэгдүүлж чадвал ДНБ-ний өсөлтийг шууд нэмэгдүүлэх хүчин зүйл болох нь энэхүү судалгааны үр дүн харуулж байна.

Дэлхий дахинд болж буй хүн амын өсөлт, зорчигчдын урьд өмнө байгаагүй чиг хандлага, шилжилт хөдөлгөөний жигд бус хэв маяг, геополитик болон гео-эдийн засгийн нарийн төвөгтэй байдал, терроризмын аюул занал нэмэгдэж байгаа нь хилийн хяналт шалгалт, зорчигчдын аюулгүй байдал нь байнга тулгамдсан асуудлын нэг болгосон байна. "Smart-Ухаалаг" хилийн хяналтын системийг технологийн тусламжтайгаар боловсронгуй байдлаар хэрэгжүүлэх нь улсын хилээр нэвтрүүлэх зорчигч, тээврийн хэрэгсэл, ачаа бараа бүтээгдэхүүнийг улсын хилээр аюулгүй, илүү хялбар нэвтрүүлэх орчныг бий болгох түлхүүр гэж үздэг.

Харин ирээдүйд яах бол, ямар өөрчлөлт, шинэчлэлт хүлээж байна? гэх асуултад хариулт өгөхийг оролдлоо. Мэдээллийн техник, технологийн эрин зуунд нэлээдгүй зүйлд өөрчлөгдөн буйг харж, мэдэрч байна.

Өндөр технологийн одоогийн болон шинээр гарч ирж буй чиг хандлага

Хилийн аюулгүй байдал нь үндэсний аюулгүй байдлын салшгүй хэсэг бөгөөд дэлхийн улс орнуудын амин чухал асуудал юм.

Хилийн аюулгүй байдалд:

-терроризм,

-хууль бус цагаачлал,

-хар тамхи, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус наймаа зэрэг асуудал нь өөрөө сорилтуудыг бий болгож, энэ чиглэлээр тэдгээрийг илрүүлэх олон

төрлийн технологиудыг бий болгосон. Энэ нь хил зөрчигчдийг хууль бусаар нэвтрүүлэх, хилийн боомтоор аюултай эд зүйлсийг хууль бусаар нэвтрүүлэх явдлыг бууруулж байна.

Гэвч хүний нүүр царай таних биометрийн дэвшилтэт программ хангамжийг ашиглах явдал улам бүр нэмэгдэх энэ цаг мөчид хүний эрхтэй холбоотой асуудлаар шүүмжлэлд өртөх сөрөг үр дагавартайг анхаарах ёстой.

Эдгээр өндөр технологид суурилсан улсын хил хамгаалалтын системүүд аюулгүй байдлын хяналтын хурд, хамрах хүрээг сайжруулах амлалтаа биелүүлэхийн тулд засгийн газрын зардлын албаны хүмүүс болон бусад бодлого боловсруулагчид анхааралтай ажиглах болно.

Хилийн аюулгүй байдлыг хангахад технологи хэрхэн нөлөөлөх вэ?

Хилийн хяналт шалгалтын үйл ажиллагаанд техник технологийн хэрэглээ нэмэгдэж байгаа энэ үед Хил хамгаалах байгууллагын алба хаагчид орчин үеийн дүрслэл, таних төхөөрөмжийг ашиглах ёстой болсон. Тэд мөн харилцан уялдаатай мэдрэгчид суурилсан технологиос илрүүлэх өгөгдөл мэдээлэл дээр ажиллах, түүнийг ашиглах ур чадвартай байх шаардлага үүсэж байна.

Мөн түүнчлэн харилцан ажиллагаатай байгууллагуудтай хамтран мэдээлэл солилцож, үйл ажиллагаагаа тодорхой болгох, болзошгүй хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гарсан хилийн зөрчлийг шийдвэрлэх, олон нийтэд ухуулан таниулах зэрэг үр дүнтэй харилцан ажиллах шаардлагатай байна. Технологийг дагаад нэгдсэн нэг систем платформ дээр мэдээллээ солилцох шаардлага үүсэж байна.

Хилийн боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, дэвшилтэт техник технологи, хиймэл оюун ухааныг ашиглах, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх олон улсын чиг хандлага

Дэвшилтэт техник технологийг нэвтрүүлснээр хилийн хяналт шалгалтын үйл ажиллагаанд шинээр нэмэгдэх ур чадваруудын асуудлыг улам боловсронгуй болгож байна. Жишээлбэл, Сүүлийн үеийн агаарын замын хилийн боомтуудад мэдрэгч системд тулгуурласан тоног төхөөрөмжийг суурилуулж, тоноглох болсон. Эдгээр нь хиймэл оюун ухааны технологийг ашиглаж хоорондоо нэг систем болон холбогдох бөгөөд хүний царай таних технологиор тоноглогдсон камеруудаас цуглуулсан мэдээлэл нь тэсрэх бөмбөг хууль бусаар хил давуулсан этгээд байж болзошгүй мэдээлэлтэй холбогдож өгдөг. Энэ холбоо нь хяналт шалгалтын олон цэгүүдэд хөндлөнгөөс хяналт тавих, оролцоог бий болгох боломжийг олгож, агаарын хөлөгт суухаас өмнө ойрхон байгаа хилийн боомтын аюулгүй байдлыг хангуулах ажилтнуудад түүний байршлыг мэдэгдэх боломжтой.

Хилийн боомтод хилийн хяналт шалгалт, аюулгүй байдлыг хангуулахад хиймэл оюун ухааны технологийг дараах байдлаар ашиглахаар байна. Үүнд:

-зорчигчийн сэтгэл хөдлөлийг илрүүлэх

-магадлалыг тооцох аргачлал зэрэг алгоритм багтаж байна.

Хилийн боомтод ашиглаж буй дэвшилтэд техник технологийг дөрвөн төрөлд ангилан авч үзэж байна.

-Хаалт, хашаа, дохиолол, хяналтын техник технологи;

-Хууль бус, хориглосон болон хязгаарласан ачаа, бараг илрүүлэх техник технологи;

-Алслагдсан бүсийн хилийн боомтод ажиллах хилийн хяналт шалгалтыг хянах орон зайн хяналтын технологи;

-Биометрийн таних технологи зэрэг болно.

Хаалт, хашаа, дохиолол, хяналтын техник технологи:

Давуу тал: Хилийн боомтод хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулах, боомтын аюулгүй байдлыг хангахад

Сул талууд: нураах, амархан эвдрэх, барилга, засвар үйлчилгээний зам, хил зөрчигчид хаалт, хашааг давах зэргээр дамжин хил давж болно.

Ачаа бараанд үзлэг шалгалт хийх /сканнерууд X-Rey/

Ихэнх хууль бусаар нэвтрүүлж буй мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисыг хилийн боомтоор нэвтрүүлж, гол төлөв хууль ёсоор нэвтрүүлж буй бараа бүтээгдэхүүнтэй холих, тээврийн хэрэгсэлд нуух зэрэг арга залийг хэрэглэж байна.

Хилийн боомтод хууль бус, хориглосон болон хязгаарласан ачаа, бараг тээврийн хэрэгсэл, чингэлэг, илгээмжээс ялгаруулж буй агаарын даралт, хийн өөрчлөлт зэрэг шинж тэмдгүүдэд тулгуурлан мэдрэгчтэй техник хэрэгслийг ашиглан илрүүлж байна.

Ингэснээр хамгийн сүүлийн үеийн рентген болон гамма сканнер нь хууль бус бараг илрүүлэхэд маш үр дүнтэй байгааг онцолж байна. Харин эдгээр сканнерууд нь үнэтэй байх учир тэдгээрийг үр дүнтэй ашиглахын тулд хилийн хяналтын байгууллагуудын алба хаагчдад маш өргөн хүрээний сургалт явуулах шаардлага үүсдэг байна. Энэхүү тоног төхөөрөмж нь өөрөө овор ихтэй тул гарц бүрт суурилуулснаар тээврийн хэрэгслийн эгнээний тоог хоёр дахин бууруулж болно.

Алслагдсан бүсийн хилийн боомтод ажиллах хилийн хяналт шалгалтыг хянах орон зайн хяналтын технологи

Алслагдсан бүс нутгуудад байрлалтай хилийн боомтоор хил нэвтрэх зорчигч, тээврийн хэрэгсэлд хяналт шалгалт хийх, үйл ажиллагаанд хяналт тавихын тулд олон төрлийн програм хангамжийг нэгтгэсэн цахим хяналтын технологийг ашиглах явдал юм.

Сүүлийн жилүүдэд нисгэгчгүй нисэх хэрэгсэл /төхөөрөмж/, нисэх онгоцуудыг хилийн хэсэгт илүү их ашиглах болсон байна. Эдгээр техник хэрэгслүүдийн тусламжтайгаар харьцангуй бага зардлаар их хэсгийг хурдан бөгөөд үр ашигтайгаар хянах боломжтой. Харин хязгаарлагдмал тэжээлийн ашиглалт, үүнийг дагасан ашиглалтын хугацаа зэргээс хамааraад түүний сул талууд гарч байна.

Биометрийн таних технологи

Сүүлийн үеийн технологийн дэвшлийн үр дүнд улсын хилээр нэвтэрч буй сэжигтэй зорчигч /хил зөрчигч/-ийг танихын тулд түүний физик шинж чанарыг ашиглан хяналт шалгалтыг явуулах олон төрлийн биометрийн таних технологууд бий болсон. Иймэ технологид суулгагдсан RFID чип дээр биометрийн өгөгдөл агуулсан цахим паспортууд орно. Мөн түүнчлэн хиймэл оюун ухаанд суурилсан хүний нүүр, царай таних программыг ашиглан хуруугүй хээ уншигч, нүдний солонгон бүрхэвч зэрэг дахин давтагдашгүй шинж байдлыг шалгах камер ашигладаг. Энэхүү технологи нь найдвартай, нарийвчлалтай, шуурхай байдлыг хангах үүднээс шалгагч, улсын байцаагч нартай шууд харьцдаггүйгээрээ давуу талтай.

Харин биометрийн өгөгдэхүүн мэдээллийн нууцлал, мэдээллийн аюулгүй байдалд эрсдэлтэй гэж үздэг. Хилийн боомтод ажиллаж буй хилийн хяналтын байгууллагуудын ажилтнууд тэдгээрийг үр дүнтэй ашиглахын тулд мөн адил өргөн хүрээний сургалтыг явуулахыг шаарддаг бөгөөд хүний эрхийг хөндсөн зарим асуудал гарах өндөр эрсдэлтэй. Энэ нь ялангуяа өнгөт арьстай хүмүүсд илүү ихээр өртөх магадлал өндөр байдаг.

Аюулгүй байдлын технологийн шинэчлэл

Хилийн аюулгүй байдлыг хангахад "ухаалаг" эсвэл "виртуал" зэрэг технологийн дэвшил рүү шилжсэн.

Нүүр царай таних системийг хурдацтай хөгжүүлэх

Хилийн боомтод хамгийн амжилттай нэвтрүүлэх технологийг тодорхойлоход хэцүү ч дэлхийн улс орнууд хүний нүүр царай таних технологийн хэрэглээг эрчимтэй өргөжүүлж байгааг судалгааны байгууллагууд болон олон улсын шинжээчид үзэж байна.

Дэвшилтэт техник технологийн ирээдүй

Өнөөдөр янз бүрийн технологийн стартапууд болон засгийн газрын агентлагууд хиймэл оюун ухаанаар ажилладаг нисгэгчгүй нисэх хэрэгсэл /дрон/-үүдийг бүтээж байгаа бөгөөд энэ нь хүний оролцоог багасган хиймэл оюун ухаанд суурилсан технологийг илүү нэвтрүүлэхийг эрмэлзэж байна. Тухайлбал, Европын холбооноос санхүүжүүлдэг AirSens төсөл нь сүлжээнд холбогдсон

нисгэгчгүй агаарын тээврийн хэрэгслийн тагнуулын болон өгөгдөл боловсруулах алгоритмуудыг боловсруулсан. Улсын хилийг хамгаалах болон бусад хууль сахиулах байгууллагууд тэднийг урьдчилан тогтоосон хилийн бүсэд байрлуулж, хүний оролцоогүйгээр газар дээрх хүмүүсийг сканнердаж, хянах боломжтой.

Төсөөлөл ямар байх вэ?

2060 онд хил хязгаар нь маш хүчирхэг мэдрэгч бүхий олон мянган жижиг бие даасан дронуудын чимээгүй эргэлддэг давхарга болно гэж төсөөлж болно. Нүүр царай таних чадварыг хиймэл оюун ухаан, том өгөгдлийн шинжилгээтэй хослуулсан мэдээллийн технологи илүү нэвтэрнэ гэж үзэж байна.

Дүгнэлт

Хилийн боомтын үйл ажиллагааг эрчимжүүлэх нь Монгол Улсын эдийн засагт эерэгээр нөлөөлдөг болохыг корреляц, регрессийн шинжилгээгээр баталсан.

Монгол Улсын Засгийн Газраас “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд авч хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээний дагуу “Боомтын сэргэлт”-ийн бодлогыг уялдуулж, тогтмол ажиллагаатай хилийн боомтын тоог нэмэгдүүлэх, ачаа, тээвэр, зорчигчийн нэвтрүүлэх орц, гарцыг нэмэгдүүлэх олон ажил хийгдэж байна. Энэ нь Монгол Улсын эдийн засгийн өсөлтөд эерэгээр нөлөөлөх боловч, зарим эрсдлийг тооцох шаардлагатай. Үүнд:

1.Байнгын ажиллагаатай хилийн боомтыг нэмэгдүүлснээр ачаа, тээврийн эргэлт нэмэгдэх боловч, хүний нөөцийн хомсдол үүсэх магадлалтай;

2.Хилийн боомтын үйл ажиллагааг олон улсын стандартад нийцүүлэн төхөөрөмжлөхөд улсын төсвөөс их хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай;

3.Хилийн боомт дахь хилийн хяналт шалгалтын чадамж сулрах эрсдэлтэй байна.

Дээрх эрсдлийг тооцож, хилийн боомтын үйл ажиллагааг сайжруулснаар Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогод чиглэгдсэн хөтөлбөр, арга хэмжээ үр дүнтэй хэрэгжих боломжтой гэж дүгнэлээ.

Мөн түүнчлэн илтгэлийн төгсгөлд олон улсын чиг хандлага, техник технологийн дэвшлийн талаар судлан оруулж, Монгол Улсын хилийн боомтуудад цаг тухайд нь нэвтрүүлж байх шаардлага байгааг харуулахыг зорисон болно.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт

Abbass, I. M. (2016). MANAGEMENT SKILLS – TOOLS FOR LEADERSHIP IMPERATIVES IN DEMOCRACY. *European Scientific Journal* , July edition vol. 8, No.16.

Aithal, P. S. (2019). A MODERN LEADERSHIP THEORY BASED ON ATTITUDE-BEHAVIOUR (AB) FRAMEWORK. *Research in Higher Education, Learning and Administration*, 62-65.

bayas, T. (2021). Satisfaction ... *Inter Jor mjzvbskduc*, 359-342.

Bennis, W. G. (2008,2021). Leadership is the capacity to translate vision into reality. *Journal of Property Management*, vol. 73, no. 5,.

Cotter-Lockard, D. (2009). *Edgar Schein’s Organizational Culture and Leadership, as seen through the lens of.* ResearchGate.

Dalakoura, A. (2010). *Differentiating leader and leadership development : A collective framework for leadership development.* . Journal of Management Development.

Donate, M. G. (2011). Organizational factors to support knowledge management and innovation. . *Journal of Knowledge Management* , 15(6): 890–914.

McFarllane. (2008). Effectively managing the 21st century knowledge worker. *Journal of Knowledge Management Practice*, 9(1):3-7.

Millar, C. (2016). Knowledge intensive organisations: on the frontiers of knowledge management. . *Journal of Knowledge Management*, 20(5): 845–857.

Nataša Ritonija, N. L. (2016). PROFESSIONAL SKILLS IN MANAGEMENT AND LEADERSHIP, ENTREPRENEURSHIP AND

COMMUNICATION-THE E-PROFMAN PROJECT. *ReasearchGate*, 1-5.

Seidle, B. F. (2016). *Do leadership training and development make a difference in the public sector? .* Public administration review.

Монгол Улсын хил. (2019). *Монгол Улсын хил*. Retrieved from Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Хил хамгаалах ерөнхий газар: https://bpo.gov.mn/content/54

Х.Асхар. (2020). Хилийн боомтын үйл ажиллагааг боловсронгуй болгох арга зам. In Х.Асхар, *Хилийн боомтын өнөөгийн байдал* (p. 4). Улаанбаатар.

Ц.Ганболд, Д. (2022). *Хил судлал.* Мөнхий үсэг ХХК.

ХИЛИЙН БООМТОД ОНЦГОЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ ҮҮССЭН ҮЕИЙН ХАРИЛЦАН АЖИЛЛАГАА

COOPERATION DURING EMERGENCIES AT BORDER CROSSING POINTS

Д.Ариунболд
Удирдлагын академийн суралцагч, хошууч
Ariunbold D.
Student of the Leadership Academy, Major

*хариуцлагатай зохиогч: bbold6796@gmail.com

Хураангуй: Хилийн боомт нь улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа бүтээгдэхүүний урсгалыг зохицуулах үндсэн үүрэгтэй бөгөөд үндэсний аюулгүй байдлыг хангах стратегийн чухал цэг юм. Гэвч дэлхий дахинд геополитикийн нөхцөл байдал өөрчлөгдөж, хил дамнасан гэмт хэрэг, хууль бус наймаа, халдварт өвчин зэрэг аюул нэмэгдэхийн хэрээр хилийн боомтын аюулгүй байдалд сөрөг нөлөөлөх хүчин зүйлс улам бүр олон төрлөөр илэрч байна. Судалгаанд хилийн боомтод онцгой нөхцөл байдал үүсэхэд нөлөөлөх гадаад болон дотоод хүчин зүйлсийг шинжилж, төрийн байгууллагуудын харилцан ажиллагаа, хуулийн зохицуулалтын ач холбогдлыг тодорхойлсон болно. Үр дүнд нь хилийн боомтын аюулгүй байдлыг хангахын тулд эрх зүйн уялдаа холбоог сайжруулах, байгууллагуудын харилцан ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай болох нь харагдаж байна.

Abstract: The border checkpoint plays a strategic role in ensuring national security by regulating the movement of passengers, vehicles, and goods across the state border. In recent years, the changing geopolitical environment, the rise of transnational crime, illegal trade, and the spread of infectious diseases have increasingly posed multifaceted threats to border security. This study analyzes the internal and external factors influencing the emergence of emergency situations at border checkpoints and examines the significance of inter-agency cooperation and legal coordination in addressing these challenges. The research findings reveal that ensuring the safety and stability of border checkpoints requires strengthening the legal framework, improving inter-organizational coordination, and enhancing institutional capacity for effective risk prevention and crisis management..

Түлхүүр үгс: Хилийн боомт, боомт аюулгүй байдал, онцгой нөхцөл байдал, харилцан ажиллагаа

Keywords: Border checkpoint, border security, state of emergency, tradition, Inter-agency cooperation.

Удиртгал

Монгол Улсын хил бол тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын баталгаа бөгөөд хилийн боомт нь улсын эдийн засаг, аюулгүй байдал, гадаад харилцаанд чухал үүрэг гүйцэтгэдэг. Хилийн боомт нь аливаа улсын гадаад ертөнцтэй материаллаг байдлаар харилцах үндсэн хэрэгсэл болохын хувьд улс төр, нийгэм, эдийн засаг, худалдаа, соёл, иргэд хоорондын харилцаанаас гадна аюулгүй байдлын асуудал гагцхүү хилийн боомт, түүний дэд бүтцээр дамжин явагддаг.

Хилийн боомтод явагддаг үйл ажиллагаа нь олон улсын худалдаа, аялал жуулчлал, тээвэр логистикийн урсгалыг хянах төдийгүй улс орны аюулгүй байдлыг хангах анхны шугам юм.

Гэвч хилийн орон зайн нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, хөрш орнуудын бодлогын нөлөө, хууль бус үйлдэл, байгалийн болон хүндрэлтэй нөхцөл байдал зэрэг хүчин зүйлс нь боомтын хэвийн ажиллагаанд сөргөөр нөлөөлөх эрсдэлийг үүсгэдэг. Иймээс хилийн боомтод онцгой нөхцөл байдал үүсэхэд нөлөөлж буй дотоод, гадаад хүчин зүйлсийг судлах нь хил хамгаалалтын бодлого, төрийн байгууллагуудын хамтын

This article is published under the Creative Commons BY-NC-SA License by 4.0, ©2025 University of Internal Affairs, Mongolia

ажиллагаа, аюулгүй байдлын удирдлагын үр нөлөөг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Энэхүү өгүүллэгийн зорилго нь Монгол Улсын хилийн боомтын аюулгүй байдал, боомтод онцгой нөхцөл байдал үүсэхэд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлон, тэдгээрийн шинж чанарыг ангилж, төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын уялдаа холбоо, мэдээлэл солилцооны үүргийг тодорхойлон үнэлэлт, дүгнэлт өгөхөд оршино.

Үндсэн хэсэг

Хилийн боомт нь улс орны аюулгүй байдал, эдийн засаг, олон улсын харилцааны чухал төв цэгүүдийн нэг бөгөөд өдөр тутам олон мянган зорчигч, ачаа тээврийн урсгалыг зохицуулж байдаг. Гэвч тодорхой нөхцөл байдлуудаас шалтгаалан боомтын үйл ажиллагаанд саад учрах, бүрэн зогсох эрсдэлтэй байдаг. Үүнд байгалийн гамшиг, цар тахал, хүн, тээврийн хэрэгсэл барьцаалах, террорист халдлага, хууль бус үйл ажиллагааны эрсдэл зэрэг олон хүчин зүйл нөлөөлж болно.

Аливаа объект руу хүмүүс нэвтрэх, тээврийн хэрэгсэл, ачаа бараа оруулан гаргах үед тэдгээрт хяналт тавих, шалгах зориулалттай, тодорхой эрх бүхий субъектүүдээс бүрдсэн, тусгай тоног төхөөрөмжтэй, хамгаалалттай газрыг шалган нэвтрүүлэх цэг, байр гэдэг түгээмэл ойлголт нийт иргэд, дэлхий даяар байдгийг бид мэдэх билээ. Харин объект гэдэг нь байгууллага, яам тамгын газраас авхуулаад үйлдвэр, тусгай газар, цэргийн анги, салбар, цаашлаад улс орны нутаг дэвсгэр бүхэлдээ багтаж байдаг зүй тогтолтой. Тиймээс эдгээр объект руу нэвтрэхдээ заавал зориулалтын газар буюу шалган нэвтрүүлэх цэг, байраар нэвтэрдэг, үүний тулд зөвшөөрөгдсөн баримт бичиг, үнэмлэх биеийн байцаалт хэрэгтэй байдаг аж. (Х.Асхар, 2024)

Манай улсын өнөөгийн мөрдөж буй эрх зүйн баримт бичгүүдэд хилийн боомтыг дараах байдлаар томьёолсон байна: Үүнд:

- Улсын хилээр нэвтрэх зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа болон мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд хилийн хяналтын байгууллага хяналт шалгалт хийх зориулалтаар тусгайлан тогтоож, төхөөрөмжилсөн газар; (М.Ганболд, 2010)
- Хилийн тухай хуулийн 3.1.12 дугаар зүйлд хилийн боомтыг тодорхойлсон; (Хилийн тухай хууль, 2016)
- “Хилийн боомт” болон “Боомт” нь адил утгатай байх бөгөөд Монгол, Хятадын хилийн 2 талд орших иргэд, тээврийн хэрэгсэл, бараа эд юмст хяналт шалгалт хийж бүртгэн хилээр нэвтрүүлэх зориулалтаар тусгайлан тогтоосон газрыг хэлнэ” (Монгол Хятадын хилийн боомт тэдгээрийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, 2004)

Дээрх тодорхойлолтуудад дүгнэлт хийхэд: Хилийн боомт гэдэг нь улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгсэл, ачаа бараг тусгайлан төхөөрөмжилсөн газраар шалгах үйл ажиллагааг явуулдаг газар гэж тодорхойлж байна.

Хүн төрөлхтөн хөгжихийн хэрээр хувь хүн, нийгэм, иргэншлийн аюулгүй байдлын асуудал улам хурцдаж, ялангуяа Дэлхийн I дайны дараахан гарсан улс төр, нийгмийн их хувьсал өөрчлөлтийн улмаас энэ асуудал дэлхий нийтийн анхаарлын төвд орж эхэлсэн. XX зууны сүүл үеэс аюулгүй байдлын асуудал зөвхөн улс орнуудын төдийгүй дэлхий нийтийн хэмжээнд хамаарах болсон. Аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа нь учирч болзошгүй аюул, заналыг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, няцаах, устгах зэрэг цогц арга хэмжээнд тулгуурладаг бөгөөд энэ нь хувь хүн, нийгэм, улс орон, олон улсын хамтын нийгэмлэгийн хамтын хүчин чармайлтад үндэслэдэг. Иймээс аюулгүй байдлыг судлах нь шинжлэх ухааны олон салбарыг хамарсан, өвөрмөц судлагдахуун бүхий шинжлэх ухааны чиглэл юм.

Аюулгүй байдал гэдэг нь олон салбарт хэрэглэгддэг нийтлэг ойлголт бөгөөд хүрээг нь өргөнөөр хамардаг. В. Далийн тайлбар тольд энэ ойлголтыг “Аюулгүй байдал нь бүрэн бүтэн, найдвартай итгэлтэй байхыг илэрхийлнэ” гэж тодорхойлсон бол, Я. Цэвэлийн тайлбар тольд “Айдас, болгоомжлол

шаардлагагүй, аюулгүй нөхцөл” гэж тайлбарлажээ.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдал гэж (цаашид үндэсний аюулгүй байдал гэх) улс орныхоо үндэсний язгуур ашиг сонирхлыг хангахуйц гадаад, дотоодын тогтвортой, баталгаатай орчныг бүрдүүлсэн төлөв хэмээн тодорхойлдог. Харин үндэсний язгуур ашиг сонирхолд Монгол Улсын тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдал, монголын ард түмний оршин тогтнол ба соёл иргэншил, үндэсний эв нэгдэл, хүний эрх, эрх чөлөөний баталгаат байдал, эдийн засгийн тогтвортой хөгжил, экологийн тэнцвэрт орчин зэрэг ордог гэж Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд тусгасан байдаг. (Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, 2010)

Үүнтэй нийцүүлэн “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д “Монгол Улсын үндэсний аюулгүй байдал гэдэг нь үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах таатай гадаад, дотоод орчин бүрдсэн байхыг хэлнэ” гэж тодорхойлсон байна. (Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, 2010)

Хилийн аюулгүй байдал нь улсын хил, хязгаарын хүрээнд төр, нийгэм, иргэдийн эрх ашиг бүрэн хамгаалагдсан байдлыг илтгэнэ. Энэ нь нутаг дэвсгэрийн халдашгүй дархан байдлыг хадгалах, төрийн тусгаар тогтнолыг хамгаалах, хуулийн этгээд болон иргэдийн улсын хил, хил орчмын дэглэм, хилийн боомтод мөрдөх журмыг чанд сахих, төрийн байгууллагууд болон хилийн аюулгүй байдлыг хангах хүчний чадавхыг бэхжүүлэх, олон улсын эрх зүйн хэм хэмжээг хэрэгжүүлэх замаар хангагддаг.

Хилийн аюулгүй байдлын салшгүй хэсэг болох хилийн боомтын аюулгүй байдал нь тухайн боомтоор улсын хил нэвтэрч буй зорчигч, тээврийн хэрэгсэл, хилийн хяналтын байгууллагын албан хаагч, мөн боомтод үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан, албан хаагчид гэмт халдлагад өртөхгүй байх нөхцөл бүрдсэн байдлыг илэрхийлдэг.

Хилийн боомтын аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа нь хилийн хяналтын байгууллагуудын хяналт шалгалтын хэвийн ажиллагааг хангах, дэг журам сахиулах, хууль бус үйлдэл, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, онцгой нөхцөл байдал үүсэхэд хэрэгжүүлэх цогц арга хэмжээг багтаадаг гэж Хилийн тухай хуульд заасан байна. (Хилийн тухай хууль, 2016)

Ийнхүү хууль тогтоомжид зааснаар хилийн болон боомтын аюулгүй байдал нь хоорондоо нягт уялдаатай бөгөөд нэг нь нөгөөгийнхөө баталгаа болдог. Харин боомтод зорчигч болон хилийн хяналтын байгууллагын албан хаагчдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд заналхийлэл учирч, боомтын хэвийн үйл ажиллагаа доголдох үед боомтын аюулгүй байдал алдагдаж, онцгой нөхцөл байдал үүсэх үндсэн шалтгаан болдог.

Онцгой нөхцөл байдлын тухай ойлголт: Аюулгүй байдлын ухаан нь хүн төрөлхтөн, нийгмийн тогтолцоо, төр улс болон байгаль дэлхий зэрэг оршихуйг бүрдүүлэгч үндсэн элементүүдийн аюулгүй байдлыг хамгаалж, тэдгээрийн тогтвортой, зохистой хөгжлийг дэмжихэд чиглэсэн онол, арга зүйн цогц мэдлэгийн салбар юм. Тэр дундаа онцгой нөхцөл байдал үүсэх эрсдэл, аюул, заналын шинж чанар нь цаг үеийн өөрчлөлт, даяаршлын нөлөөн дор байнга хувьсаж байдаг тул аюулгүй байдал судлал нь эдгээр нөхцөлд урьдчилан сэргийлэх, нөлөөллийг бууруулах, хор уршгийг арилгах арга зүйг судалдаг бие даасан шинжлэх ухааны чиглэл болон төлөвшжээ. Онцгой нөхцөл байдал нь улс орны дотоод, гадаад орчин, нийгэм-эдийн засаг, улс төрийн бодлого, хүрээлэн буй орчны аюулгүй байдал зэрэг олон хүчин зүйлтэй уялдан илэрдэг учраас аюулгүй байдлын судалгааны объект эдгээр бүх хүрээг хамарсан цогц ойлголт гэж үзэх хандлага түгээмэл байна.

Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагууд “онцгой нөхцөл байдал” гэсэн ойлголтыг өөрсдийн хууль тогтоомжийн хүрээнд өөр өөр ухагдахуунаар хэрэглэж байна.

Онц байдал зарлахын өмнөх шатны нөхцөл байдлын үед тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын харилцан

ажиллагаанд хэрэглэгддэг нэр томьёог авч үзвэл, эрх зүйн зохицуулалтын хүрээнд эдгээр байгууллагууд өөр өөр ойлголтоор хэрэглэж байна. Тухайлбал, Хил хамгаалах, Цагдаагийн болон Зэвсэгт хүчний байгууллагууд “онцгой нөхцөл байдал” гэсэн нэр томьёог хэрэглэдэг бол, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага “хямралт байдал”, Онцгой байдлын байгууллага “гамшиг” гэсэн нэр томьёог тус тус хэрэглэн хууль, эрх зүйн зохицуулалтад тусгасан байдаг.

“Онцгой байдал” гэдэг нь гамшгаас урьдчилан сэргийлэх болон түүнийг арилгах, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад төрийн төв байгууллага, холбогдох агентлаг, аж ахуйн нэгж, албан тушаалтнуудын хамтын ажиллагааг уялдуулж зохицуулах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх зэрэг тусгай ажиллагаа явагдаж буй нөхцөл байдлыг илэрхийлдэг. (В.Жавхланцогт, Ж.Өвгөнбүргэд, 2017)

Харин “онцгой нөхцөл байдал” гэдэг нь тодорхой газар нутагт осол, байгалийн аюулт үзэгдэл, бусад гамшгийн улмаас хүний амь нас хохирох, эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзэх, эдийн засагт их хэмжээний хохирол учрах, хүн амын хэвийн амьдралын нөхцөл алдагдах зэрэг нөхцөл үүссэн байдлыг хэлдэг гэж тодорхойлсон байдаг. (М.Ганболд, 2010)

Хилийн боомтын онцгой нөхцөл байдал гэж хилийн боомтод хилийн хяналтын байгууллагуудын алба хаагчид, зорчигч, тээврийн хэрэгсэлд, гамшиг, аюулт үзэгдэл тохиолдох, халдварт өвчин тархах, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал бий болох, зорчигч, тээврийн хэрэгслийг барьцаалах, террорист халдлага үйлдэх нөхцөл байдал бий болж боомтын хэвийн үйл ажиллагаа алдагдахыг хэлнэ гэж судлаачийн хувьд тодорхойлж байна.

Монгол Улс хилийн болон иргэдийн харилцан зорчих нөхцөлийн талаар байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээр болон хилийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд, хилийн хяналтын байгууллагууд өөрсдийн хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, боомт дахь дэг журмыг сахиулах, албан хаагчид болон зорчигчдын аюулгүй байдлыг хангах, мөн боомтод гарч болзошгүй хууль бус үйлдэл, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох үүрэгтэй.

Түүнчлэн, хилийн боомтод онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд “тусгай дэглэм” тогтоон, шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх асуудлыг Хил хамгаалах байгууллага хариуцан зохицуулдаг. Харин хилийн боомтын аюулгүй байдлыг хангах бодит үйл ажиллагааг хилийн отряд (анги)-ийн штаб хэрэгжүүлж, Хилийн цэргийн штаб мэргэжлийн удирдлага, чиглэлээр хангадаг.

Хилийн боомтод онцгой нөхцөл байдал үүсэхэд нөлөөлөх хүчин зүйлс:

Хилийн боомтын онцгой нөхцөл байдал нь улсын хилээр нэвтрэх үйл ажиллагааны хэвийн горим алдагдаж, аюул, занал, зөрчил, хямралт нөхцөл байдал үүсэхийг илтгэдэг бөгөөд энэ нь олон талт хүчин зүйлсийн нөлөөгөөр бий болдог цогц үзэгдэл юм. Ийм нөхцөл байдлын үүсэл, үр дагавар нь дотоод, гадаад орчны шинж чанар, нийгэм-эдийн засгийн нөхцөл, хууль эрх зүйн зохицуулалт болон хүний хүчин зүйлтэй шууд уялдаатай байдаг.

Нэгдүгээрт: Гадаад орчны хүчин зүйл нь хөрш улс орнуудын улс төр, нийгмийн тогтворгүй байдал, бүс нутгийн зөрчил, зэвсэгт мөргөлдөөн, терроризм, хил дамнасан гэмт хэрэг, хууль бус худалдаа, хүн, зэвсэг, мансууруулах бодисын хууль бус хөдөлгөөн зэрэг олон улсын шинжтэй заналуудаар илэрдэг. Эдгээр нь хилийн боомтын үйл ажиллагаанд саад учруулж, онцгой нөхцөл байдал үүсэх шууд шалтгаан болдог.

Хоёрдугаарт: Дотоод улс төр, нийгмийн хүчин зүйл нь төрийн институцийн тогтвортой байдал, хууль сахиулах байгууллагуудын уялдаа холбоо, нийгмийн бухимдал, эдийн засгийн хямрал, авлига, сахилгын зөрчил зэрэгтэй холбоотой байдаг. Эдгээр хүчин зүйл нь онцгой нөхцөлд хариу арга хэмжээ авах чадварыг сулруулж, эрсдэлийг нэмэгдүүлдэг.

Гуравдугаарт: Байгалийн болон хүрээлэн буй орчны хүчин зүйл нь газар

хөдлөлт, үер, цасан шуурга, хэт халалт, цар тахал зэрэг гамшгийн шинжтэй үзэгдлүүд юм. Иймээс нөхцөл байдал нь боомтын дэд бүтцийн ажиллагааг доголдуулж, хүн, тээврийн урсгалыг хязгаарлах, аюулгүй байдлын тусгай дэглэм тогтоох нөхцөл бүрдүүлдэг.

Дөрөвдүгээрт:Хууль эрх зүйн болон зохион байгуулалтын арга хэмжээ нь хилийн боомтын аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагуудын хоорондын эрх зүйн зохицуулалт, уялдаа холбоо, хамтын ажиллагааны түвшнээс хамаарна. Хэрэв эрх зүйн орчин тодорхой бус, давхардал, хийдэлтэй байвал онцгой нөхцөлд хариу арга хэмжээ авах үр дүн буурдаг.

Тавдугаарт: Хүний хүчин зүйл нь боомтод ажиллаж буй албан хаагчдын мэргэжлийн ур чадвар, ёс зүй, хариуцлага, сэтгэлзүйн бэлтгэлжилт болон зорчигчдын хууль сахих соёл, зан төлөвтэй холбоотой. Хүний хүчин зүйл нь онцгой нөхцөл байдлын илрэл, өрнөл, хариу арга хэмжээний чанарт шууд нөлөөлдөг.

Ингэснээр, хилийн боомтод онцгой нөхцөл байдал үүсэхэд нөлөөлөх хүчин зүйлс нь дан ганц аюулгүй байдлын асуудал биш, харин гаднын занал, дотоод зохион байгуулалтын алдаа, байгалийн хүчин зүйл, хүний болон эрх зүйн орчны уялдаа холбоо бүхий цогц шинжтэй үзэгдэл юм. Иймээс эдгээр хүчин зүйлсийг урьдчилан тодорхойлж, эрсдэлийн үнэлгээ хийх, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах нь боомтын аюулгүй байдлыг хангах үндэс суурь болдог.

Хилийн боомтод онцгой нөхцөл байдал үүссэн үеийн харилцан ажиллагааны өнөөгийн байдал:

Монгол Улсын аюулгүй байдлыг хангах тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын харилцан, хамтын ажиллагааны уламжлал нь Монгол Улсад 1933 онд “Хязгаарын цэрэг” байгуулагдсанаар эхэлсэн бөгөөд энэ үеэс хойш тухайн цагийн Монгол Ардын цэргийн нэгтгэл, Нийгмийг аюулаас хамгаалах яамны харьяа байгууллагууд болон орон нутгийн захиргааны байгууллагуудтай нягт уялдаатай ажиллаж ирсэн урт хугацааны туршлагатай. Энэ хамтын ажиллагаа нь хил хамгаалалтын тасралтгүй үйл ажиллагааг хангах, хил орчимд тохиолдох гамшиг, аюулт үзэгдэлд шуурхай арга хэмжээ авах, хилийн зөрчил, будилаан үүсэхээс урьдчилан сэргийлэх, бие бүрэлдэхүүний аюулгүй байдлыг хангахад чиглэгдэж ирсэн билээ.

Монгол Улс хилийн болон иргэдийн харилцан зорчих нөхцөлийн талаар байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээр болон Засгийн газрын шийдвэрийн дагуу агаарын 6, төмөр замын 6, авто замын 27, нийт 39 боомтоор зорчигч, тээврийн хэрэгсэл, ачаа бараа хилээр нэвтрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулан хэрэгжүүлж байна.

Одоогоор Монгол Улсын 7 аймгийн нутаг дэвсгэрт БНХАУ-тай, 8 аймгийн нутаг дэвсгэрт ОХУ-тай хиллэдэг боомтууд байрлаж, эдгээр боомтууд нь гадаад худалдаа, зорчигч тээврийн урсгалын үндсэн гарц болж байна. Хилийн боомтод ажиллаж буй хилийн хяналтын эрх бүхий байгууллагууд нь холбогдох хууль, эрх зүйн баримт бичгийн дагуу хяналт шалгалт, зохион байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлдэг.

Монгол Улсын төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагууд нь Засгийн газрын баталсан холбогдох төлөвлөгөөнүүдийг үндэслэн харилцан ажиллагаагаа зохион байгуулдаг. Тухайлбал, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 375 дугаар тогтоолоор батлагдсан “Онцгой нөхцөл үүссэн үед байгууллагуудын хамтын ажиллагааг зохицуулах ерөнхий төлөвлөгөө”, мөн 2023 оны 136 дугаар тогтоолоор батлагдсан “Нийтийн эмх замбараагүй байдлын улмаас онц байдал тогтоосон үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө”-ийг удирдлага болгон ажилладаг.

Хил хамгаалах байгууллага нь дээрх төлөвлөгөөний дагуу төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудтай “Хилийн зурвас, боомтод онцгой нөхцөл бий болсон үеийн харилцан ажиллагааг зохицуулах чиглэлийн төлөвлөгөө” болон холбогдох бусад хууль, журмын дагуу

харилцан ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна.

Хилийн боомтын аюулгүй байдлыг хангах, боомтод онцгой нөхцөл байдал үүссэн үед төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудтай харилцан ажиллагааг зохион байгуулахад авч хэрэгжүүлэх арга хэмжээ нь байдлаар тусгасан байна. Үүнд:

-Зэвсэгт Хүчин: Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, бүрэн бүтэн байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал болон улсын хилийн халдашгүй дархан байдлыг хамгаалах, иргэний аюулгүй байдлыг хангахад оршино. (Батлан хамгаалах тухай хууль, 2016)

Мөн Зэвсэгт хүчний тухай хуульд зааснаар улсын хил хамгаалах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг хүлээнэ. (Зэвсэгт хүчний тухай хууль, 2016)

ХХЕГ-ын даргын 2007 оны тушаалаар батлагдсан Хилийн цэргийн штабуудын албаны зааварт Хил хамгаалах байгууллага нь улсын хилийн хамгаалалтыг хүч нэмэгдүүлэх, хилийн операц (эрэл) явуулах, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал бий болох, зэвсэггүй бөөн иргэд улсын хил зөрчих, зорчигч, тээврийн хэрэгслийг барьцаалах, террорист халдлага, өдөөн хатгалга түрэмгийлэл үйлдэх нөхцөл байдал бий болсон үед дэмжлэг үзүүлэх зорилгоор хил орчимд байрлаж байгаа зэвсэгт хүчний ерөнхий зориулалтын нэгтгэл, ангиудын штабуудтай харилцан ажиллагааг зохион байгуулна. Энэ үед харилцан ажиллагаатай нэгтгэл, ангиудын удирдлагын байр байгаа газар, холбоо зохион байгуулах журам, холбоо, шифр, кодлох хэрэгсэл бүхий шуурхай бүлэг эсвэл төлөөлөгчдийг солилцох журам зэргийг тохиролцон хамтран ажиллана гэж тодорхойлсон байдаг.

-Тагнуулын байгууллага: Хилийн боомтод гарах магадлалтай хууль бус үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, илрүүлэн таслан зогсоох, мөн онцгой нөхцөл байдал үүссэн үед гүйцэтгэх ажиллагааг тагнуулын хүч хэрэгслүүдтэй хамтран зохицуулж хамгаалах журамд нийцүүлэн хэрэгжүүх:

Хилийн бүс, зурваст дайсны тагнуулын байгууллага, тэдгээрийн сүлжээ, бусад дайсагнасан этгээдүүдийг илрүүлж үйл ажиллагааг нь таслан зогсоох журам;

Улсын хил болон хил орчмын бүсэд улсын аюулгүй байдлын эрх ашгийг хамгаалахын тулд харилцан мэдээлэл солилцох, түүний үндсэн дээр шаардлагатай арга хэмжээ авах зэргийг харилцан тохирно.

-Цагдаагийн байгууллага, Дотоодын цэргийн штаб: Цагдаагийн ерөнхий газар, Хилийн цэргийг удирдах газрын дарга нарын 1998 оны 26/114 дүгээр хамтарсан тушаалаар баталсан "Цагдаагийн болон Хил хамгаалах байгууллагын хамтран ажиллах журам", ХЗДХ-ийн сайд, Санхүү, эдийн засгийн сайд, Тагнуулын ерөнхий газрын дарга нарын 2000 оны 149/114/343 дугаар хамтарсан тушаалаар баталсан "Хилийн боомтын асуудлаар харилцан ажиллах журам"-д тодорхой тусгасан.

Харилцан ажиллах төлөвлөгөөний дагуу улсын хилийн бүс, зурваст байрлах Цагдаагийн байгууллага, Дотоодын цэргийн анги, салбарууд боомт болон хилийн дэглэм, журмыг сахиулах үйл ажиллагаанд оролцохдоо гүйцэтгэх үүрэг, бүрэлдэхүүн, байрлал, ажиллах журмыг тодорхойлж, уулзах район, хүрэлцэн ирэх цаг, харилцан ажиллах дохио болон ар тал, техникийн хангалтын арга хэмжээг тохиролцоно.

Мөн Цагдаагийн байгууллага, Дотоодын цэргийн анги салбарууудтай хамтран ажиллах хилийн анги, салбарууд дараах зарчмуудыг баримтална:

Хилийн тодорхой хэсэгт хилийн операц, эрэл, хээрийн сургууль, зэвсэгт өдөөн хатгалга, зэвсэггүй олон хүний нэвтрэлтийг саатуулах зэрэг ажиллагаа явуулах үед иргэд болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах, зохицуулах журам;

Улсын хил хамгаалалт болон хил орчмын нутаг дэвсгэрт хэв журам сахиулах үүднээс мэдээлэл, мэдээ солилцох ажиллагаа;

Хил орчмын бүсэд онцгой нөхцөл байдал үүссэн үед хэрэгжүүлэх журам;

Улсын хилийг хүчээр хамгаалж буй үед хамтран ажиллах журам, хамтарсан эргүүл, харуул, манааны үүргийг хэрэгжүүлэх журам;

Цагдаагийн байгууллагаас хилээр нэвтрүүлэхийг хориглосон этгээдийг саатуулах зэрэг үйл ажиллагааг харилцан тохиролцон, хамтран хэрэгжүүлнэ. (А.Энхтөр, 2022)

Онцгой байдлын байгууллага: Улсын хил, хил орчмын бүсэд байгалийн гамшиг эсвэл онцгой нөхцөл үүссэн тохиолдолд хамтран ажиллах журам, үүрэгт ажлаа хэрэгжүүлдэг. Мөн хил орчмын бүсэд гамшгийн улмаас учирч болзошгүй хор хохирлыг арилгах, сэргээн босгох арга хэмжээнд оролцож, болзошгүй аюулын талаарх мэдээллийг харилцан солилцон хамтран ажилладаг.

Гаалийн байгууллага: Улсын хил, боомтоор хууль бус ачаа бараа нэвтрүүлэхийг таслан зогсоох, хилийн боомтод онцгой нөхцөл үүссэн үед харилцан зохицон ажиллах, хил дээр дэг журмыг сахиулах, тогтоох зэрэг үүргийг гүйцэтгэнэ. Мөн зорчигч, тээврийн хэрэгсэл, ачаа барааг шалгах, нарийвчилсан хяналт хийх, хорио цээрт хамрагдсан халдварт өвчин, эрүүл мэндэд аюултай барааг хилээр нэвтрүүлэхээс хамгаалах арга хэмжээг хамтран хэрэгжүүлдэг. Улсын хил дээр халдварт өвчний тохиолдолд хорио цээр тогтоох үеийн ажиллагаа, журмыг харилцан тохиролцон хэрэгжүүлнэ.

-Гадаадын иргэн харьяатын байгууллага: Хил хамгаалах байгууллага болон Гадаадын иргэн харьяатын байгууллага нь ХХЕГ, ГИХГ дарга нарын 2011.05.05-ны өдрийн 03/А/157 дугаартай “Мэдээлэл солилцох ажлыг сайжруулах тухай” 04/А/158 дугаартай “Хамтран ажиллах тухай” хамтарсан тушаалын дагуу харилцан ажиллах, мэдээлэл солилцох, холбогдох хууль, журмын дагуу хамтран ажилладаг.

Хөрш орнууд болон гуравдагч орны талаас хууль бус цагаач, дүрвэгсэд, нэрвэгдэгсдийн хөдөлгөөнийг хянах, саатуулах, таслан зогсоох хамтарсан арга хэмжээг хэрэгжүүлэх;

Улсын хил дээр гадаадын иргэд болон харьяат цагаачдад тавих хяналт, тэдний талаарх мэдээллийг харилцан солилцох журам, мөн уг журмыг хэрэгжүүлэх арга замыг зохицуулах;

Улсын хилээр хууль бусаар нэвтэрсэн гадаадын иргэдийг захиргааны журмаар албадан гаргахтай холбоотой асуудлыг хамтран шийдвэрлэх, хэрэгжүүлэх журам тогтоож ажиллана. Мөн хилийн боомтод онцгой нөхцөл байдал үүссэн үед болон бусад үед харилцан ажиллах журмын мөрдөн ажилладаг.

Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын харилцан ажиллагаа дээрх эрх зүйн зохицуулалтын хүрээнд хэвийн явагдаж байгаа ч бодит байдал дээр дараах **асуудлууд тулгамдаж байна**: Үүнд:

-Хилийн боомтын үйл ажиллагаанд төрөөс баримталж буй бодлого, зохицуулалтын хүрээнд нэгдсэн удирдлага, уялдаа холбоо, хамтын ажиллагаа хангалтгүй байгаа нь салбар хоорондын зохион байгуулалт, дэд бүтцийн хөгжил, тоног төхөөрөмжийн хангалтад сөргөөр нөлөөлж байна. Үүний үр дүнд хилийн хяналт, шалгалтын байгууллагуудын ажиллах нөхцөл бүрэн хангагдаагүй, албан хаагчдын нийгэм, эдийн засгийн баталгаа дутмаг байгаагаас ажлын үр дүн, гүйцэтгэл буурч байна.

-Байгууллагуудын харилцан ажиллагаа бодит түвшинд сул. Хилийн хяналтын байгууллагууд нь “Монгол Улсын аюулгүй байдлыг хангах” нийтлэг зорилготой хэдий ч, бодит хэрэгжилтийн түвшинд байгууллагуудын хоорондын уялдаа холбоо, харилцан хамтын ажиллагаа сул, нэгдсэн зохион байгуулалт, шинжлэх ухааны үндэслэлтэй хандлага дутмаг байна.

-Өнөөгийн нөхцөлд хилийн боомтод ажилладаг төрийн байгууллагууд нь бие даасан босоо удирдлагын тогтолцоотой, нэгдмэл бодлого, удирдлагагүй, эрх зүйн орчны тодорхойгүй байдал давамгайлж байна. Энэ нь байгууллагуудын хамтын ажиллагааг хүндрүүлж, онцгой нөхцөл байдал үүсэх үед нэгдсэн удирдлага, уялдаа

холбоотой хариу арга хэмжээ авах боломжийг хязгаарлаж байна.

-Хилийн боомтуудад онцгой нөхцөл байдал үүссэн үеийн харилцан ажиллах төлөвлөгөөнүүд байдаг ч боомт бүрийн онцлогт тохирсон сургалт, дадлага хангалтгүй, зарим боомтод шаардлагатай техник, холбоо, хамгаалалтын хэрэгсэл дутагдалтай байна.

-Хилийн боомт, тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын мэдээллийн систем уялдаа муутай, аюул илрүүлэх эрт сэрэмжлүүлгийн механизм бүрэн ажиллагаанд орж чадаагүй байгаа зэрэг дутагдлууд байгаа нь практик дээр харагдаж байна.

Хилийн боомтын аюулгүй байдлыг хангахад төрийн байгууллагуудын **харилцан ажиллагааг сайжруулснаар доорх үр дүнд хүрнэ** гэж үзэж байна.

Төрийн байгууллагуудын удирдлага, зохицуулалтын тогтолцоог бэхжүүлэх нь чухал бөгөөд үүнд хилийн боомтын цогц бодлого боловсруулах, байгууллагуудын чиг үүрэг, хариуцлагыг тодорхойлох, хяналт шалгалтын үйл ажиллагааг стандартчилах. Энэ арга замыг хэрэгжүүлснээр боомтын дэд бүтэц, тоног төхөөрөмж, хилийн хяналт шалгалтын үйл ажиллагааны уялдаа сайжирч, албан хаагчдын мэргэжлийн нөхцөл, аюулгүй байдал баталгаатай болно.

Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын харилцан ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай. Үүнд байгууллагуудын хооронд мэдээлэл солилцох, харилцан дэмжлэг үзүүлэх, онцгой нөхцөл байдалд шуурхай арга хэмжээ авах журам, сургалт, дадлага хэрэгжүүлэх зэрэг арга хэмжээг системтэйгээр зохион байгуулах шаардлагатай. Ийм арга хэмжээний үр дүнд хилийн боомтод онцгой нөхцөл үүссэн үед байгууллагууд нэгдсэн удирдлага, зөв зохицуулалт дор үйл ажиллагаагаа явуулж, эрсдэлийг бууруулах чадвартай болно.

Эрх зүйн орчныг боловсронгуй болгох нь чухал бөгөөд хилийн боомтод онцгой нөхцөл үүссэн үед төрийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог хуулиар тодорхой болгох шаардлагатай. Энэ нь эрх бүхий байгууллагуудын хоорондын харилцан ажиллагааг хууль ёсны хүрээнд зохицуулж, зохион байгуулалтын хяналт, үр нөлөөг нэмэгдүүлнэ.

Эдгээр арга хэмжээг хэрэгжүүлснээр Монгол Улсын хилийн боомтын аюулгүй байдал, хэвийн үйл ажиллагаа, зорчигч, тээврийн хэрэгсэл, ачаа бараа аюулгүй нэвтрүүлэх чадвар нэмэгдэж, онцгой нөхцөлд шуурхай, зохион байгуулалттай арга хэмжээ авч, үндэсний аюулгүй байдлыг тогтвортой хангах боломж бүрдэнэ.

Дүгнэлт

Монгол Улсын хил бол тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын баталгаа бөгөөд хилийн боомт нь улсын эдийн засаг, олон улсын харилцаа, иргэдийн амьдралд шууд нөлөөлөх стратегийн ач холбогдолтой цэг юм. Онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд боомтын аюулгүй байдал алдагдах нь улсын аюулгүй байдал, зорчигчдын болон албан хаагчдын амь нас, эд хөрөнгөд эрсдэл учруулдаг тул хилийн боомтын хамгаалалт нь оновчтой зохион байгуулалт, нэгдсэн удирдлага, харилцан ажиллагаанд суурилсан байх шаардлагатай. Судалгааны явцад онцгой нөхцөл байдал үүсэх хүчин зүйлс нь дотоод, гадаад, байгалийн болон хүний хүчин зүйлсээс бүрдэж, бие биетэйгээ уялдан эрсдэлийг тодорхойлдог болох нь тогтоогдсон бөгөөд өнөөгийн байдлаар төрийн байгууллагуудын харилцан ажиллагаа тасралтгүй явагдаж ирсэн уламжлалтай боловч удирдлага, сургалт, техник хэрэгслийн хангалт, мэдээллийн системийн нэгдсэн зохицуулалт сул байгаа нь онцгой нөхцөлд шуурхай хариу арга хэмжээ авахад хүндрэл учруулдаг гэж үзэж байна.

Санал

Хилийн боомтын аюулгүй байдлыг бэхжүүлэх, боомтод онцгой нөхцөл үүсэх эрсдэлийг бууруулахад авч хэрэгжүүлбэл үр дүнд хүрнэ гэж үзэж байна:

-Хилийн боомтын үйл ажиллагаанд төрийн байгууллагуудын үүрэг, хариуцлагыг тодорхойлж, удирдлага, хяналтын тогтолцоог стандартчилах.

-Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын хооронд мэдээлэл солилцох, дэмжлэг үзүүлэх, онцгой нөхцөлд шуурхай арга хэмжээ авах сургалт, дадлагыг тогтмол зохион байгуулах.

-Боомтын хамгаалалтын тоног төхөөрөмж, холбоо, хамгаалалтын хэрэгслийг шинэчилж, мэдээлэл, дүн шинжилгээний нэгдсэн системийг бүрдүүлэх.

-Хилийн боомтод онцгой нөхцөл үүссэн үед төрийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог хуульчилж, зохицуулалтын нэгдсэн орчныг бүрдүүлэх.

-Хилийн боомтод нөлөөлж болох хүчин зүйлсийг тогтмол үнэлж, эрсдэлийг бууруулах стратеги боловсруулж хэрэгжүүлэх.

Эдгээр арга хэмжээг хэрэгжүүлснээр Монгол Улсын хилийн боомтын аюулгүй байдал баталгаажих, зорчигч, тээврийн хэрэгсэл, ачаа барааг аюулгүй нэвтрүүлэх чадвар нэмэгдэж, онцгой нөхцөлд нэгдсэн удирдлага, зохион байгуулалт дор шуурхай арга хэмжээ авч, үндэсний аюулгүй байдлыг тогтвортой хангах боломж бүрдэнэ гэж үзэж байна.

Ашигласан материалын жагсаалт

А.Энхтөр. (2022). *Монгол Улсын хилийн цэргийн байгуулалтын онол, практикийн асуудал.*

Батлан хамгаалах тухай хууль. (2016). *Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем*. Retrieved from Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: https://legalinfo.mn/mn/detail?lawId=12122

В.Жавхланцогт, Ж.Өвгөнбүргэд. (2017). *Хилийн албанд ашиглагдах зарим нэр томьёоны тайлбар толь.*

Зэвсэгт хүчний тухай хууль. (2016). *Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем*. Retrieved from Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: https://legalinfo.mn/mn/detail?lawId=12123

М.Ганболд. (2010). *Хилийн нэр томьёоны тайлбар толь.*

Монгол Хятадын хилийн боомт тэдгээрийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, Б.-ы. З. (2004). *Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем*. Retrieved from Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: https://legalinfo.mn/mn/detail/372

Үндэсний аюулгүй байдлын тухай хууль. (2010). *Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем*. Retrieved from Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: https://legalinfo.mn/mn/detail?lawId=18

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. (2010). *Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем*. Retrieved from Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: https://legalinfo.mn/mn/detail/6163

Х.Асхар. (2024). *Хилийн боомтын үйл ажиллагааны онол, практикийн асуудал.*

Хилийн тухай хууль. (2016). *Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем*. Retrieved from Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: https://legalinfo.mn/mn/detail/12418

ЦЭРГИЙН ӨНГӨЛӨН ДАЛДЛАЛТЫН ХУВЦАСНЫ ТҮҮХ, ЗОРИУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА

HISTORY, PURPOSE, AND DEVELOPMENTAL TRENDS OF MILITARY COLORED CAMOUFLAGE

Э.Гүнчинлхам
Дотоод хэргийн их сургуулийн Хилийн аюулгүй байдал судлалын төвийн докторант, ахмад
Enkhtuya G.
Doctoral student at the Center for Border Security Studies, Captain

*хариуцлагатай зохиогч: gvnchinlham@gmail.com

Хураангуй:Өнгөлөн далдлалтын хувцас (camouflage uniform) нь зэвсэгт хүчний байлдааны ажиллагаанд цэргийн алба хаагчдын илрэх магадлалыг бууруулах, орчиндоо зохицох чадварыг нэмэгдүүлэх стратегийн ач холбогдолтой. Өнгөлөн далдлалт нь зөвхөн хувцасны загвар төдийгүй материал, өнгөний палитр, орчны геометр хэлбэртэй зохицох зарчим, технологийн дэвшил зэрэг олон хүчин зүйлийн нөлөөлд хөгжиж ирсэн түүхэн уламжлалтай. Энэ өгүүллийн зорилго нь өнгөлөн далдлалтын хувцасны түүх, хөгжлийн үе шат, технологийн шинэчлэл, орчин үеийн хандлагын тарлаар өгүүлэхэд оршино.

Abstract: Camouflage uniforms are strategically important in the combat operations of the armed forces to reduce the likelihood of detection and increase the ability of military personnel to adapt to their environment. Camouflage has a historical tradition that has developed under the influence of many factors, including not only the design of the clothing, but also the materials, color palette, the principle of adapting to the geometric shape of the environment, and technological advances. The purpose of this article is to describe the history of camouflage clothing, its stages of development, technological innovations, and modern approaches.

Түлхүүр үгс: Өнгөлөн далдлалт, өнгөлөн далдлалтын хувцас, хэвлэмэл өнгөлөн далдлалтын төрөл, өнгөлөн далдлалтын хувцасны үүсэл, хөгжил, түүхэн уламжлал

Keywords: Camouflage, camouflage clothing, types of camouflage prints, origin, development, and historical tradition of camouflage clothing

Удиртгал

Цэргийн болон тактикийн хэрэгслийн тухай ярихад өнгөлөн далдлалтын сэдэв гарч ирдэг. Тактикийн өнгөлөн далдлалт нь цэргийн анги, нэгтгэл, салбаруудад хэрэгжүүлэх бөгөөд тусгай объект, тэдгээрийн байрлалыг нуухын зэрэгцээ байлдааны ажиллагаанд бэлтгэж байгаа бэлтгэлийг нууцлах зорилгоор хэрэгжүүлдэг (Хадхүү, 2014).

Монгол Улс нь өргөн уудам газар нутаг, хил хязгаартай, цөөн хүн амтай, улсын хил нь байгаль, цаг уур, физик газар зүйн хувьд харилцан адилгүй байдаг нь өнгөлөн далдлалт, нууц далдуур ажиллагаанд анхаарал тавьж ажиллахыг шаардах болов.

"Хилийн манаа бүхнийг харах ёстой, харин хилийн манааг хэн ч харах ёсгүй" гэсэн зарчим нь өнгөлөн далдлалтад тавигдаж буй үндсэн

This article is published under the Creative Commons BY-NC-SA License by 4.0, ©2025 University of Internal Affairs, Mongolia

зарчмуудын нэг юм.

Иймд Монгол Улсын хилийн дагуу гарч буй хилийн зөрчилтэй тэмцэх арга замыг улам сайжруулахад одоогийн өнгөлөн далдлалтын хувцасны дижитал өнгийг улам төгөлдөржүүлэх шаардлагатай болж байгаа нь судалгааны үндэс болж байна.

Үндсэн хэсэг

1. Цэргийн өнгөлөн далдлалтын шинжлэх ухааны түүх

Цэргийн агуу хууран өнгөлөн далдлалтын тухай түүхэн баримтуудын нэг бол Легион юм.


Тройны морины маягийн хууралт нь эртний Хятадын цэргийн стратегич Сун Цзугийн "Дайны урлаг" номд дурдсан ойлголт юм.

Эзэн Чингис хааны үед дайн байлдааны үед өнгөлөн далдлалтын талаар арга хэмжээг өргөнөөр хил хамгаалалтдаа ашигладаг байсан байжээ. Үүнд:

“Харгана зорчил”, “нохойн хэрэл", "чонын алхаа" буюу хилийн манаа, харуулын үйл ажиллагааг өнгөлөн далдалж хууран мэхлэхтэй хослон хэрэглэх арга билэг.

"Алиганчлах" буюу тагнан мэдэх арга ухаан Энэ нь “өөрийгөө бусдад бүү илчил, бусдын бодлого үйлдлийг бүгдийг мэд" гэдэг зарчим байжээ.

"Цоргих” арга. Улсын хил зөрчсөн дайсан этгээд түүнчлэн жирийн гэмгүй иргэдийг халхавч болгон дайсан өдөөн хатгах үед үйл ажиллагааг зохион байгуулагч, удирдагч, гол дайсагнасан хүчийг юуны урьд олж илрүүлэн саатуулах, устгах



аргыг энд ашиглаж байв. Түүнчлэн тагнуул, туршуулыг дайсны бүлэг, хэсгийн дотор нь оруулж дотоодоос нь задлах, аюултай этгээдийг барих, устгах, аюулгүй болгоход энэ арга ашиглагддаг байжээ (Арвай, 2015).

2. Өнгөлөн далдлалтын үзэл санаанаы үүсэл

Байгалийн амьтдын өнгөлөн далдлалтыг ажигласан олон жишээ цэргийн тактикт шууд нөлөөлсөн байдаг. XIX зууны төгсгөлд биологичид амьтдын өнгө, хэлбэрийн өөрчлөлтөөр орчиндоо уусан нуугдах аргачлалыг тайлбарлаж эхэлсэн нь дараагийн цэргийн хувцасны загварын онолын үндэс болжээ (Behrens, 2019). Амьтдын өнгөлөн далдлалтыг судалсан “комуфилаж” (Wikipedia, 1918) үзэл баримтлал нь цэргийн шинжлэх ухаанд нэвтрэх нөхцөлийг бүрдүүлсэн.

3. XX зууны эхэн үеийн хөгжлийн шат

3.1 Дайны талбарт өнгө өөрчлөгдөх шаардлага

Өнгөлөн далдлалтын хувцас нь байгууллагын өнгө, сүр хүчийг илэрхийлэх уламжлалт дүрэмт хувцаснаас эрс ялгаатай, тактикийн шаардлагаас үүдэн бий болсон.

Английн армийн “khaki” өнгө нь 1857 оны Энэтхэгийн бослогын үеэс хэрэглэгдэж, улмаар Өрнөдийн армийн жишиг болсон (Sumner, 2012).

Оросын армийн ногоон өнгөлөн далдлалтын хувцас нь XIX зууны сүүлчээр нэвтэрсэн нь ойт орчинд харагдах байдлыг бууруулсан анхны системтэй оролдлогын нэг байв.

3.2 Дэлхийн I дайн

Дэлхийн I дайнд байлдааны байрлал, артиллерийн цохилтоос нуугдах шаардлага нэмэгдсэнээр өнгөлөн далдлалтыг тусгай анги, мэргэжилтнүүд боловсруулж эхлэв.

Франц улс 1915 онд анхны албан ёсны "camouflage" нэгж байгуулсан.

Энэ үед уран бүтээлчид, зураачид оролцож, геометр хэлбэр ашигласан анхны хээнүүд бий болсон.

4. Дэлхийн II дайн дахь шинэ үе

Дэлхийн II дайн өнгөлөн далдлалтын технологийг үсрэнгүй хөгжүүлсэн үе байв. Герман, Зөвлөлт, АНУ зэрэг орнууд орчны онцлогт тохирсон олон төрлийн хээ боловсруулсан.

Германы Waffen-SS-ийн "Platanenmuster", "Erbsenmuster" хээ нь олон улирлын тохируулгатай, олон давхар өнгөний давталт бүхий анхны нарийн алгоритмт хээ байсан (Churchill, 2017).

АНУ-ын “frog skin” хээ Номхон далайн орчинд хэрэглэгдсэн.

Зөвлөлтийн "Amoeba" хээ нь мэргэн буучдад зориулсан хавтгай том толботой загвар байв.

Энэ үеэс эхлэн өнгөлөн далдлалтын үндсэн зарчим орчны гэрэлтэлт өнгөний хэмжээ геометрийн задралын судалгаанд суурилж, тактик, стратегийн салшгүй хэсэг болсон.

5. Хүйтэн дайны үе ба дижитал хээний эхлэл

Хүйтэн дайны үед ЗХУ, АНУ, НАТО-ын орнууд олон янзын биомимик загвар (ой, цөл, цаст, хотын орчин) боловсруулсан. Үүнээс Дижитал (pixelated пикселжүүлсэн) хээ гарч иржээ.

2000-аад оны эхээр Канадын CADPAT, АНУ-ын MARPAT загварууд нь пиксел хэлбэрийн "Дижитал" хээ хэрэглэсэн нь илрэх магадлалыг улам бууруулсан (Gawne, 2020).

Дижитал хээ нь: Орчны гэрэл сарнилт, зайны гүн мэдрэмж, хүний нүдний оптикийн алдаа дээр тулгуурлан жижиг дөрвөлжин пиксел ашигладаг.

Дайны дараагаар тагнуулын шинэ хэрэгслүүд бий болох болсноор өнгөлөн далдлалтын үүрэг, ач холбогдол улам бүр нэмэгдэх болсон. НАТО-гийн армиудын цэргийн удирдлагын албаны баримт бичгүүдэд тэмдэглэхдээ: "Өнгөлөн далдлалтын арга хэмжээ нь тасралтгүй, үнэмшилтэй байх ёстой" гэж тэмдэглэгдэж байжээ (Алтангэрэл, 2018).

6. “Dazzle” (Гялбаа) ба “Camouflage” (Өнгөлөн далдлалт) хосолсон үзэл баримтлал

Анхны онолын хоёр үндсэн чиглэл:

6.1 Dazzle camouflage - (анхны оптик хуурмаг байдал өөрөөр бол гялалзсан өнгөлөн далдлалт) нь дайсны зай, чиглэлийг буруу ойлгуулах, объектын бодит хөдөлгөөнийг төөрөгдүүлэх зорилго бүхий геометрийн том хээг ашиглан юмны гадаргууг өнгөлөн хучих, өнгөц үзэгдэх зүйлээр хууран далдлах гэсэн үг.

6.2 Natural camouflage - (байгалийн өнгөлөн далдлалт) нь амьтдын биологийн хээ, өнгийг дуурайсан системтэй өнгөлөн далдлалт.

Цэргийн хувцасны хээ нь эдгээр хоёр чиглэлийн онолын уулзварт бий болсон.

7. Орчин үеийн хөгжлийн чиг хандлага

Өнөөдөр өнгөлөн далдлалтын хувцасны судалгаа дараах чиглэлд хөгжиж байна:

7.1 Олон спектрийн өнгөлөн далдлалт

Дулааны (IR), хэт ягаан (UV), радарын долгионд илрэх байдлыг бууруулах материал.

Нано бүрхүүл, олон давхар бүтцийн тусгай даавуу.

7.2 Адаптив буюу өөрөө өнгө сольдог систем

Алагдахгүйн зориулалттай электрон-материал ашигласан “e-camouflage”.

Хамелеон зарчмаар ажилладаг ухаалаг гадаргуун материал.

7.3 Байгаль орчны нарийвчилсан GIS + AI загварчлал

Өндөр нарийвчлалтай хиймэл дагуулын зураг, газрын байр зүйн өгөгдөл, AI ашиглан тухайн орны биологид (амьд байгалийн тухай судалдаг байгалийн шинжлэлийн шинжлэх ухааны нэг бөгөөд судлагдахуун нь амьд биес_ тэдгээрийн гадаад орчинтой харилцах харилцаа юм) (Википедиа, 2024) тохирох өнгөлөн далдлалтын стандарт санал болгодог системүүд хөгжиж байна.

Өнгөлөн далдлах хээг уралдаг 10 гаруй гэр бүл байдаг.

Энэ нь хэтийн төлөв, мөн бүс нутгийн асуудал болдог юм (Williams, 2015). Ялангуяа өнөө үед олон тооны дизайнерууд бидний ярьж байгаа хээг олон зуун жилийн тэртээгээс бүтээж байсан бөгөөд бидний ихэнх нь үүнийг сонсоогүй байх. UF PRO дээр өнгөлөн далдлах хээнүүдийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл тавигдсан байдаг.

Бруштрок



Өнгөлөн далдлалтын өвөг дээдсийн нэг. Анх Их Британид ашиглагдаж байсан энэ нь 1950, 1960-аад онд Бельги, Франц зэрэг бусад орнуудад (гүрвэлийн хээ) энэ хээг өөрсдийн хувилбараар хийхэд хурдан нөлөөлсөн.

Пакистан, Зимбабве зэрэг орнуудад (Родезияас өвлөн авсан) одоо ч ашигласаар байгааг харж болно.

Шоколадны чипс



Албан ёсоор "Зургаан өнгийн цөл" гэж нэрлэгддэг энэ нь АНУ-ын Персийн булангийн нэгдүгээр дайны улмаас өргөн тархсан бөгөөд "Гурван өнгийн цөл"-ийн нарийн хувилбартай адил юм.

Dpm



Британийн "Эвдрэлтэй хээтэй материал". M81 Woodland-тай адил энэ нь янз бүрийн хуулбар болон өнгөний схемд хамгийн их ашиглагддаг өнгөлөн далдлах хээнүүдийн нэг болжээ.

Дижитал хээ




Дижитал гэдэг нь заавал пикселжүүлсэн өнгөлөн далдлалт биш. Үнэндээ дижитал хээ гэдэг нь компьютер болон алгоритм дээр суурилсан хээ юм.

Канад улс 1990-ээд оны сүүлээр пикселжүүлсэн дүрэмт хувцас гаргаж эхлэхээс өмнө пикселжүүлсэн хээ байсан.

АНУ-ын Зэвсэгт хүчний яам энэ жишээг дагаж, 2001 онд MARPAT-ийг үүсгэсэн. CADPAT эсвэл MARPAT-ийг дижитал хэлбэрээр зохион бүтээж болох ч Vegetato, Multicam гэх мэтийг дижитал хэлбэрээр зохион бүтээж болно.

Нугас анчин



Дэлхийн 2-р дайны үеийн Америкийн M1942 толбон өнгөлөн далдлалтаас гаралтай. Номхон далай дахь дайнд голчлон ашиглагддаг бөгөөд түүний үр удам Азиас гадна Латин болон Өмнөд Америкт байдаг. Австралийн DPCU-г мөн "хамаатан" гэж үздэг.

Flecktarn



Бундесвер Труппенверсух 76-ийн үр дүн нь зөвхөн Германы худалдааны тэмдэг төдийгүй Бельги,

Хятад, Дани, Польш улсад хэд хэдэн ижил төстэй загвар гаргахад хүргэсэн.

Leaf

1948 онд АНУ-ын Армийн Инженерийн Судалгаа, Хөгжлийн Лаборатори нь ERDL загварыг бүтээсэн бөгөөд энэ нь зөвхөн Вьетнамын дайнтай адилтгагдаад зогсохгүй бусад хэд хэдэн загварт нөлөөлсөн.

60 хувиар томруулсан хувилбар нь M81 Woodland болсон.

Таавар



Эдгээр нь нэлээд өвөрмөц, 20-р зуунд Бельги, мөн Филиппин, Югославт гарч эхэлсэн.

Бороо



“Бороо” гэсэн загварын элемент нь анх Дэлхийн 2-р дайны Германы хээ угалзанд өвсийг дуурайлган дүрсэлсэн байдаг.

Варшавын гэрээний орнууд босоо шугамыг нэг өнгийн дээр ашигласан нь харааны чимээ үүсгэж, шөнийн харааны төхөөрөмжүүдийн эсрэг маш үр дүнтэй байв.

Салгагч



Сплиттертарн хээ нь Дэлхийн 2-р дайнтай нягт холбоотой өргөн хэрэглэгдэж байна.

Швейцарь улс 1955 он хүртэл ашиглаж байсан ч Германы Бундесвер болон Бундесгренцшутцын анхны өнгөлөн далдлалт байсан. Болгарт хэд хэдэн хувилбар байдаг бөгөөд Шведийн M90 нь өнөөгийн хамгийн орчин үеийн хувилбар юм.

Tigerstripe



Brushstroke-ийн "үеэл" болох энэ цэцэг нь Францын гүрвэлийн загвараас санаа авсан. Хурдан хугацаанд өөрийн гэсэн онцлогтой болсон.

Үндэсний ба иргэний боловсруулсан хэв загваруудын тухай

2000-аад оны эхээр өнгөлөн далдлалтын хөгжлийн шинэ үе шат эхэлсэн бөгөөд энэ нь зөвхөн пикселжүүлсэн загвар төдийгүй өнгөлөн далдлалтын аргын хувьд ч мөн адил байв.

Монгол Улсын хилээр сүүлийн таван жилд гадаадаас хил зөрчигчдийг 100 хувь илрүүлсний 80 гаруй хувийг хилчид илрүүлсэн нь хил хамгаалах өнгөлөн далдлалтын тактик зөв



байсныг нотолсон (Баатарцогт, 2008).

АНУ-ын Армийн Натик Лабораториуд Crye Precision (CP)-тэй хамтран өөр өөр орчин, ургамлын бүсэд тохиромжтой бүх нийтийн загварыг боловсруулсан (Wikipedia, 1918).

Энэхүү хамтын ажиллагааны үр дүн нь "Scorpion" загвар гэж нэрлэгддэг загвар байв. 2004 онд АНУ-ын Армийн дүрэмт хувцасны туршилтууд өөр загварыг бий болгосон: Universal Camouflage Pattern (UCP) нэртэй пикселжүүлсэн MARPAT загварын дахин будсан хувилбар.

Crye Precision нь Scorpion-ийг цаашид хөгжүүлэхээр шийдэж, Multicam нэртэйгээр худалдаанд гаргахаар шийджээ.

Анх "airsoft camo" гэж шоолуулдаг байсан. АНУ-ын армийн цэргүүд Multicam-ийг Афганистанд тулалдаж байх үед нь хурдан үнэлж сурсан бөгөөд UCP загвар нь маш муу

ажилласан тул бүр аюултай гэж тооцогддог байв.

Энэхүү санал хүсэлтийн үр дүнд АНУ-ын арми өнгөлөн далдлах



сайжруулалтын хүчин чармайлт (CIE)-г эхлүүлсэн бөгөөд үүний үр дүнд эхний үе шатанд Multicam-ийг зөвхөн Афганистаны кампанит ажилд зориулж ашигласан.

CIE-ийн сүүлийн үе шат бүх зүйлийг өөрчилсөн. Энэ нь хуурах, шилжилтийн болон ой мод/ширэнгэн ойн орчимд зориулагдсан шинэ өнгөлөн далдлалтын гэр бүлийн тендерийг нээсэн.

Туршилтад зориулж даавуу нийлүүлэх, Crye Precision, ADS/Hyperstealth, Brookwood болон Kryptek.дөрвөн компанийг сонгосон:

Scorpion W2 төрсөн.

Үүний үр дүнд АНУ-ын арми анхны Scorpion загвар руугаа буцаж, Crye-ийн өмнө нь хийж байсан зүйлийг хийсэн: хууль эрх зүйн үр дагавраас урьдчилан сэргийлэхийн тулд үүнийг хангалттай өөрчилсөн.

Монгол Улсын хилээр сүүлийн таван жилд гадаадаас хил зөрчигчдийг 100 хувь илрүүлсний 80 гаруй хувийг хилчид илрүүлсэн нь хил хамгаалах өнгөлөн далдлалтын тактик зөв байсныг нотолсон (Баатарцогт, 2008).

Улсын хил хамгаалалтад үүрэг гүйцэтгэж буй хилчид нь өөрийн үйл хөдлөл, ажиллагааг сайтар өнгөлөн далдалж чадахын зэрэгцээ илчлэгдэх шинж тэмдгээр нь дайсагнагч этгээдүүдийн хил зөрчиж болзошгүй үйл ажиллагааг тодорхойлж чаддаг байх нь чухал байдаг (Дашдэлэг, 2008).

Ялангуяа Дорнод, Замын-Үүд, Увс гэх мэт ХЗГБЧ-дэд өнгөлөн далдлалтын зарчим, шаардлага хэрэгжихгүй, энэ төрлийн хангалтад ач холбогдол өгөх асуудал туйлын хангалтгүй байгаагаас хил зөрчигчид зохион байгуулалттайгаар хууль бус гэмт үйлдлээ үргэлжлүүлсээр байгааг таслан зогсоох цаг нэгэнт болсон гэдгийг уг чиглэлүүдийн отрядын дарга, штабууд анхааралдаа авах нь зүйтэй байна (Наранжамц, 2008).

Хэдийгээр өөр өөр арга барилтай шинэ өнгөлөн далдлах загварууд зах зээлд гарч байгаа ч Multicam болон түүний уламжлалуудын бодит ноёрхол тасраагүй байна (Wikipedia, Multicam., 2025).

Олон камерын өнгөний схем болон ерөнхий мэдрэмж нь НАТО-гийн хүчний дунд шинэ стандарт болсон. Оросын тусгай хүчний нийгэмлэг хүртэл энэ хэв маягийг хүлээн авч байна.

Ирээдүйд өөр өөр технологид суурилсан сорилтууд тулгарч байна.

Газрын радар (нь идэвхтэй төрлийн мэдрэгчүүдийн нэг бөгөөд хиймэл дагуулын замналын дагуу гадаргын байр зүйн төвшнийг хэмжихийн тулд радарын завсрын чадамжийг ашигладаг. Тэд маш богино цахилгаан соронзон дохиог хүлээн авах болон дамжуулах үеийн хугацааны зөрүү дээр тулгуурлан хиймэл дагуулын далайн төвшнөөс дээш өндөртэй харьцуулах замаар хуурай газрын эсвэл цас, мөсөн гадаргуугийн тухай мэдээллийг нарийн хэмжиж гаргадаг) (Хүрэлтулга, 2009) болон хэт улаан туяа зэрэг хэт спектрийн технологи нь орчин үеийн армиудыг өнгөлөн далдлах талаар дахин бодоход хүргэж байна. Урт хугацаанд ухаалаг материалыг үйлдвэрлэхэд хялбар болж,

өргөн хүрээнд ашиглах боломжтой болно. Жишээлбэл: Гай Крамер (хамтын ажиллагааны төхөөрөмжөөр байгалийн өнгийг харьцуулж гаргах төхөөрөмж) эцэст нь объектуудын эргэн тойронд гэрлийг нугалахад янз бүрийн хэлбэртэй линзний давхаргыг ашигладаг Quantum Stealth технологийн талаар дэлгэн үзүүлэв.

Энэ нь голчлон дэд бүтэц болон том объектуудыг нуухад чиглэгддэг боловч бусад эрдэмтэд оптик, цахилгаан болон соронзон шинж чанарыг ашиглан өнгийг нь өөрчлөхийн зэрэгцээ хэт спектрийн төхөөрөмжүүдээс зайлсхийх боломжтой ухаалаг даавуун дээр ажиллаж байна.

Дүгнэлт

Өнгөлөн далдлалтын хувцасны хөгжил нь байгаль, шинжлэх ухаан, технологийн нэгдэлд тулгуурласан цогц үйл явц бөгөөд цэргийн алба хаагчдын аюулгүй байдал, тактикийн давуу талыг хангах стратегийн элемент болж хөгжсөөр байна. Анхдагч өнгөний шийдлээс эхэлж, роботжуулалт, AI, олон спектрийн технологитой хосолсон өнөөгийн хөгжлийн түвшинд хүрсэн нь ирээдүйд өнгөлөн далдлалт улам ухаалаг, динамик хэлбэрт шилжих боломжтойг харуулж байна.

Өнгөлөн далдлалт нь дэлхийн 2 дугаар дайны үед хамгийн их хөгжсөн ба улс орнуудын цэргийн жанжин штабууд, дээд удирдлагын түвшинд авч үзээд зогсохгүй, тактикийн өнгөлөн далдлалт бүх шатанд байх ёстой хангалтын арга хэмжээний нэг болсон түүхтэй байна.

Өнгөлөн далдлалтын өнгө нь эсрэг талаа төөрөгдөлд оруулж, цэргийн байрлал, хүч хэрэгсэл, цэргийн төрөл бүрийн объектууд, тэдгээрийн байрлал, ажиллагааны байдал, цэргийн удирдлагын төлөвлөгөөг халхавчлахад чиглэгдсэн иж бүрэн арга хэмжээнээс бүрдэж байдаг.

Хил хамгаалалтын өнгөлөн далдлалт гэдэг нь: Хил хамгаалах байгууллага, түүний харьяа анги, салбар, бие бүрэлдэхүүний хил хамгаалалтын талаар тавигдсан үүргийг хэрэгжүүлэх, цагийн байдлын өөрчлөлтийн үед ажиллах үед хил зөрчигч, зөрчихөөр бэлтгэж байгаа этгээдийг төөрөгдүүлэх, албаны бэлэн байдал, удирдлагын бодлого, шийдвэр, хүч хэрэгсэл, объект, тэдгээрийн байршлыг нууцалж буй цогц арга хэмжээг хэлнэ.

Улсын хил хамгаалалтын өнгөлөн далдлалтын үндсэн зорилго нь улсын хил хамгаалж буй жинхэнэ бодит үйл ажиллагаа, объектуудыг нууцалж, хуурамч, ажиллагаа, объектуудыг жинхэнэ мэтээр хил зөрчигчдөд мэдэгдүүлэн төөрөгдүүлж, санаачилгыг гартаа авах явдал юм. Ингэснээр улсын хил хамгаалалтын чанар, үр ашиг дээшилж, хилийн манаа, харуул заставаас хил зөрчигчийг илрүүлэн саатуулах боломж нэмэгдэнэ.

Хил хамгаалалтын өнгөлөн далдлалтыг хилийн бүх төрлийн манаа, харуул, застав, салбар, ангиуд өдөр тутмын алба үйл ажиллагааныхаа явцад байнга тасралтгүй хийж байх үүрэгтэй.

Заставын дарга нар нь хуурамч хянах байруудаа байнгын ажиллагаатай мэт байлгах, ажиллагаагаа нууц далдуур явуулах, санаатай төөрөгдүүлсэн ажиллагааг үе үе зорилго, чиглэлтэй хийж байх, хилийн манааны хөдөлгөөний замнал байрлалуудыг өөрчлөх, бүх төрлийн манаагаар өнгөлөн далдлалтын сахилга батыг хатуу сахиулах нь заставын хариуцсан хэсгийн хил хамгаалалтыг найдвартай зохион байгуулах, өнгөлөн далдлалтыг идэвх санаачилгатай явуулах үндэс нь болно.

Өнгөлөн далдлалтын зарим хэв маяг нь тодорхой дайны улмаас

бэлгэдэл болж, бидний соёлын ой санамжид гүн гүнзгий шингэсэн байдаг. Өнгөлөн далдлалтын шинэ хөгжил нь ихэвчлэн дайн байлдааны мөн чанар болон технологийн хувьсан өөрчлөгдөж буй үр дүнтэй уялдаатай юм.

Гипер спектрийн (хүний нүдэнд үзэгдэх цахилгаан соронзон спектрийн хэсэг юм) төхөөрөмжүүдийн одоогийн хөгжил нь үүнийг гэрчилж байна.

Технологийн уламжлалт өнгөлөн далдлах хувцсыг харах чадвар улам бүр нэмэгдэж байгаа тул өнгөлөн далдлах загвар нь хурдацтай хөгжиж байгаа тул хамгийн сүүлийн үеийн дэвшилтэд түлхэц өгөх нь маш чухал юм.

Орчин үеийн тулааны талбарт технологи улам бүр дэвшилттэй болж байгаа тул хуучны гилли костюм загвар (байгаль орчинтойгоо уялдаж, маш сайн далдлах) хэрэглэгдэх явдал нь улам багасаж байна.

Санал

Дээрх дүгнэлтүүдэд үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна.

1. Хилийн зөрчил гарч болзошгүй хилийн застав, харуулын хариуцсан хэсэгт

ил болон хуурамч, нууц манаанаы байр обьектыг тухайн байгаль физик, газар зүйн нутгийн онцлогт тохирсон өнгийг гаргаж цаг үеэ олон өнгөлөн далдлалтыг хийж хил хамгаалалтын албаны үйл ажиллагааг нууцлах.

2. Улсын хил хамгаалалтын үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангаж

явуулахын тулд өнгөлөн далдлалтын хувцасыг газар оронд, улиралын цаг уурын онцлогт тохирсон загвар, дэвшилтэд технологитой болгохыг шаардагдаж байна.

3. Заставын дарга нарнаас авсан судалгаанаас үзэхэд застав харуулд өнгөлөн

далдлалтын хувцас хүрэлцээгүй байдаг тул хилийн манаанаы өнгөлөн далдлалтын хувцас хэрэглэлийн хангалт сайжруулах.

Ашигласан материал

1. Behrens, R. R. (2019). *Camouflage and art: Design, deception, and the military.* . University of Iowa Press.
2. Churchill, N. (2017). *The camouflage uniforms of the German SS: 1938–1945.* Schiffer Publishing.
3. Gawne, J. (2020). *U.S. camouflage: 1940–2010.* Osprey Publishing.
4. Sumner, I. (2012). *British colours and standards 1747–1881.* Osprey Publishing.
5. Wikipedia, T. F. (1918). Dazzle camouflage. https://en.wikipedia.org/wiki/Dazzle_camouflage-ээс Гаргасан
6. Wikipedia, T. F. (2025 оны 12 07). Multicam.
7. Williams, J. (2015). *Military camouflage: A century of concealment.* Oxford University Press.
8. Алтангэрэл, А. (2018). *Хилийн заставын хариуцсан хэсэгт өнгөлөн далдлалтын арга хэмжээг сайжруулах нь. Судалгааны тайлан.* Улаанбаатар.
9. Арвай, Ш. (2015). *Монгол Улсын хилийн талаар баримтлах бодлого, стратегийн онцлог.* Улаанбаатар.
10. Википедиа, Ч. н. (2024 оны 09 16). Байгаль.
11. Наранжамц, Н. (2008). *Хилийн операци.* Улаанбаатар.
12. Хадхүү, Ё. (2014). *Өнгөлөн далдлалтын гарын авлага.* Улаанбаатар.

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА

CURRENT SITUATION AND DEVELOPMENT TRENDS IN HUMAN RESOURCES OF COURT DECISIONS AGENCY

П.Баярбаатар
Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Ял эдлүүлэх эрх зүйн тэнхимийн ахлах багш, доктор (Ph.D), дэд хурандаа
P.Bayarbaatar
Ph.D, Lieutenant colonel, Senior Lecturer at the Department of Law in Sentencing of Court decision execution school, University of Internal Affairs
Б.Уянга
ДХИС-ийн ШШГАС-ийн Ял эдлүүлэх эрх зүйн тэнхимийн багш, дэслэгч
B. Uyanga
Lecturer in Department of Penal Law of the School of Court decision of UIA, leuitenant

*хариуцлагатай зохиогч: *Bayarbaatar405@gmail.com

Хураангуй: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын соёл, үнэт зүйлийг хүний нөөцийн асуудалтай холбон үзэж алба хаагчийн эрүүл мэнд буюу ажил мэргэжлээс шалтгаалах өвчлөл, сэтгэл зүйн байдал буюу ажлаас халшрах хам шинжийг судлан хүний нөөцийн менежментэд анхаарах асуудлыг судалгаанд үндэслэн дүгнэлт, санал дэвшүүллээ.

Abstract: This article aims to provide recommendations and present the findings of research on the culture and values of court decision agencies, with a focus on human resource issues, including officer health or work-related illnesses, psychological conditions, and burnout syndrome.

Түлхүүр үг: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, алба хаагч, ажлаас халшрах хам шинж, хүний нөөцийн менежмент, мэргэжлээс шалтгаалах өвчлөл,

Keywords: Court decision agency, officer, burnout syndrome, human resource management, work-related illness.

Удиртгал

Орчин цагийн “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага үүсэж хөгжөөд 100 гаран жилийн буурал түүх”,-ийг ардаа үдэж хөгжлийн шинэ үүдийг үе үеийн чадварлаг алба хаагчдаараа дамжуулан нээсээр ирсэн билээ. “Ардын намын төв хороо, Ардын Засгийн газраас аливаа гэмт хэрэг үйлдэж ял шийтгэгдсэн хүмүүсийг засан хүмүүжүүлэх талаар хуучны харгис ёс журмыг халж, 1921 оны 07 дугаар сарын эцсээр комендантын яамнаас Гүрсэдийг томилон, хуучин нийслэл хүрээн дэх эзэрхэг феодалын засаг захиргааны гянданг шалган үзэж Ардын Засгийн газраас хүлээн авах ажлыг даалган гүйцэтгэж байжээ. Энэ үед Гүрсэд нь Монголын автономитын үеийн анхны хууль цаазын мэргэжилтэн байсан гэж хэлж болно.

Үүний дараагаар буюу олноо өргөгдсөн XI дүгээр он, европын тооллоор 1921 оны 08 дугаар сарын 03-ны өдөр Дотоод яам, олон яамны сайд, Засгийн газрын зөвлөх, эрхэлсэн түшмэл нарын 09 дүгээр хуралдаанаар тус байгууллагатай холбоотой “Гяндан хороо”-г цагдан сэргийлэх хороонд хамааруулахгүй болгох, Гяндан хороог захирах ба гяндангийн ерөнхий хоёр даргыг туслах түшмэлийн зэргээр явуулах болсны зэрэгцээ 16 хуягтай байхаар шийдвэрийг гаргаж байжээ” (Очгэрэл, Дамдинцэрэн, & Галбадрах, 2021, хууд. 174)

Тэртээ 1921 онд зөвхөн хорих ял эдлүүлэх ажиллагааг гүйцэтгэх чиг үүрэгтэй байсан тус байгууллага өнөөдөр эрүү, иргэн, захиргааны шүүхээс гаргасан бүхий л төрлийн шийдвэрийг гүйцэтгэдэг Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн

This article is published under the Creative Commons
BY-NC-SA License by 4.0, ©2025 University of Internal Affairs, Mongolia

яамны харьяа Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болон өргөжин хууль дээдлэх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, хүний эрх, эрх чөлөөг зөвхөн хуульд зааснаар хязгаарлах явцад энэрэнгүй, шуурхай байх зарчмыг баримтлан нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцсэн үйл ажиллагаагаа алба хаагч буюу хүний нөөцөөрөө дамжуулан явуулж байна.

Энэхүү хүндхэн бөгөөд хариуцлагатай үүргийг гүйцэтгэж буй байгууллагынхаа хүний нөөцийн хөгжилд бид илтгэлээр дамжуулан өчүүхэн боловч хувь нэмэр оруулахыг хүслээ.

Хүний нөөц бол бусад нөөцтэй харьцуулахад "хамгийн шавхагдашгүй, арвин баялаг мөн бөгөөд хүнийг зөв удирдаж, чиглүүлж чадвал тэд үр ашигтай хөдөлмөрлөж, хөгжихийн хэрээр сэтгэж шинийг эрэлхийлэх, бүтээлч сэтгэлгээтэй болж төлөвшдөг. Аливаа байгууллагын өрсөлдөх гол үзүүлэлтийн нэг нь хөдөлмөрийн бүтээмж бөгөөд түүнийг дээшлүүлэх үндсэн хүчин зүйл нь сэтгэл зүйн бэлтгэлтэй, өндөр мэдлэгтэй, ур чадвартай хүний нөөц гэж үздэг. Өөрөөр хэлбэл, хүний нөөцийн менежментийн үндсэн зорилгыг чадварлаг, мэргэшсэн алба хаагчдыг татах, тэрхүү ажилтныг тогтвортой ажиллуулах, идэвхжүүлэх явдал юм" (Цэцэгмаа, 2014, хууд. 31) гэж тодорхойлсон байдаг.

Нийгэм-сэтгэл зүйн талаас нь үзвэл алба хаагчийн бүтээлч уур амьсгал бий болгоход "удирдах ажилтны оролцоо, нийгэм ба ёс суртахууны урамшуулал, соёлын ба оюун санааны хэрэгцээг хангах, хамт олны эерэг уур амьсгалыг бүрдүүлэх, алба хаагчийн санаачилга ба хариуцлагын хөгжил, сэтгэл зүйн шийтгэл ба урамшуулал" (Цэцэгмаа, 2014, хууд. 22) зэргийг ашигладаг байна. Энэ нь ердөө алба хаагчийг тогтвортой ажиллуулах, идэвхжүүлэхэд чиглэгддэг. Нөгөөтээгүүр алба хаагч бүрийн хувийн чадварыг дээд зэргээр ашиглахад оршдог ба "хувийн чадвар гэдэгт:

- мэргэжлийн мэдлэг, чадвар, туршлага;
- боловсролын буюу танин мэдэх чадвар;
- бие, сэтгэл зүйн буюу ажиллах чадвар;
- бүтээлч буюу бүтээл бий болгох чадвар;
- харилцааны буюу хамтран ажиллах харилцан нөлөөлөх чадвар;
- ёс зүйн чадвар буюу үнэт зүйл, мотивац зэрэг багтдаг.


Алба хаагч бүрийн хөгжлийн шалгуур нь биеийн болон оюуны хүчний хөдөлмөрийн явц дахь тухайн хүний бүтээлч чадварын өгөөж" (Цэндсүрэн & Батхүрэл, 2013, хууд. 341) гэж үздэг. Иймээс байгууллагын хүний нөөцийн чадвар нь алба хаагч бүрийн хувийн чадвар болон тавигдсан зорилгын дагуу ашиглаж буй үр дүнгээр тодорхойлогддог.

Үндсэн хэсэг

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаа сайжирснаар нийгэмд шударга ёс тогтон, хүний эрх, эрх чөлөө хангагдаж, улмаар иргэний ардчилсан нийгэм бүрэлдэн тогтоход чиглэгдсэн эерэг үзүүлэлт өсөн нэмэгдэж, ард түмний сайн сайхан амьдралын чанар дээшлэх зүй тогтолтой. Тус байгууллагын үйл ажиллагаанд хариуцлагын тогтолцоог өндөрсгөн, алба хаагчдын мэргэжлийн ур чадвар, ёс зүйг дээшлүүлэх, мерит зарчмыг баримталж, албан тушаал дэвших нээлттэй, ил тод тогтолцоог хэвшүүлэх гарцыг бид хайх хэрэгтэй байна

"Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хөгжлийн үндсэн тулгуур болох хүний нөөцийг "хандлага - ёс зүй – мэдлэг – чадвар - туршлага"-д суурилсан тогтолцоонд шилжүүлэхэд чиглэгдсэн "Хүний нөөцийн бодлогын баримт бичиг" стандарт" бий болгох зайлшгүй шаардлага урган гарч иржээ. Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуульд зааснаар бүтээгдэхүүний үзүүлэлт, шаардлагын хэм хэмжээг зохих журмын дагуу зөвшилцөн боловсруулж, эрх бүхий байгууллагаас баталсан норматив-техникийн баримт бичгийг хэлнэ гэж тодорхойлсон байдаг.

Практикт хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст ажиллаж буй алба хаагчдын томилгоо, шилжих, дэвших нь асуудалтай, алба хаагчдын сахилга, хариуцлага ёс зүй муу, тогтвортой ажиллах хүчний хомсдол бий болж байна гэх мэтчилэн шүүмжлэл гарах болсон хүний нөөцийн эрх зүйн хэм хэмжээний актыг шинэчлэх, хүний нөөцийн оновчтой тогтолцоо төгөлдөршөөгүйтэй холбоотой гэж үзсэн.



Зураг 1. ШШГБ-ын хүний нөөцийн үйл ажиллагааг зохицуулж буй эрх зүйн хэм хэмжээний актад өгсөн үнэлгээ:

Судалгаанд 1600 гаран алба хаагч оролцсоны 51.6 хувь нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн журмыг шинэчлэх шаардлагатай гэж үзсэн бол 24.8 хувь нь сайн боловсруулагдсан боловч хэрэгжүүлэхэд асуудал байна, 23.3 хувь нь ямар нэгэн асуудал байхгүй учир хэвээр үлдээх талаар илэрхийлсэн.

Нэг. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын соёл, үнэт зүйл:

"Байгууллага нь үйл ажиллагаандаа зайлшгүй шаардлагатай материал, түүхий эд, мөнгө санхүү, мэдээлэл технологи болон хүний нөөцийг заавал ашигладаг. Байгууллагын амжилтад нөлөөлдөг олон хүчин зүйл бий үүний дотроос хүний нөөц" (Цэндсүрэн & Батхүрэл, 2013) гэдгийг дээр дурдсан билээ. Тэгвэл түүнтэй холбоотой бий болж тогтсон байгууллагын соёл нь голлох үүргийг гүйцэтгэдэг гэж үздэг.

Байгууллагын соёл гэдэг нь тухайн байгууллагын алба хаагчийн нийтлэг үнэт зүйлс болон туршлагын нэгдэл гэж ойлгож болно. Байгууллагын соёл нь үр дүнтэй харилцаа холбооны системийг бий болгоход чиглэгдсэн үндсэн үүргийг гүйцэтгэхээс гадна байгууллагын амжилтыг зөвхөн алба хаагчийн мэдлэг, инженерчлэл, технологийн салбарт гаргасан нээлт биш, харин тухайн байгууллагад тогтсон ёс суртахууны зарчим, нийтлэг соёл, оюун санааны ертөнцөөр тодорхойлдог байна.

Энэхүү нэр томьёо нь харьцангуй сүүлд гарч ирсэн бөгөөд байгууллагын соёлыг бүх ажилтны хуваалцсан нийтлэг үзэл бодол, үнэт зүйлсийн систем гэж ойлгож болно. Нөгөөтээгүүр алба хаагчдын дунд баталсан буюу зөвшөөрсөн нийтлэг үнэт зүйлс, дүрэм журам, зан үйлийн тогтолцоо гэж үзэж болдог байна.

Байгууллагын соёл нь ихэвчлэн "удирдлагын манлайллын хүсэл сонирхол, алба хаагчийн хандлага, өмнөх туршлагаас үүдэлтэй харилцан үйлчлэлийн үр дүнгээр илэрдэг. Учир нь нэг талаас байгууллагын соёл нь зорилго давамгайлсан санаа, үнэт зүйлс, нэр хүндтэй удирдагчид хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, стандарт, дүрмүүдэд нөлөөлдөг бол нөгөө талаас байгууллагын үнэт зүйлсийн тогтолцоог бүрдүүлэх төдийгүй гол үзэл баримтлал нь

алба хаагчийн орчин" (Үүрийнтуяа, 2020, хууд. 7) гэдгийг анхаарах хэрэгтэй болдог.

Байгууллагын соёлын гол шинж чанарт эрхэм зорилго, зорилго, үнэ цэнэ, үүрэг, хэрэгцээ зэргийг оруулдаг. Эдгээр бүх зүйл нь хүний орчинд бий болж, хэрэгждэг төдийгүй байгууллагын зохион байгуулалт нь соёлыг бүрдүүлдэг. Байгууллагын тогтвортой байдал нь нийгэмд батлагдсан хэм хэмжээ, дүрмийн уламжлалтай холбоотой. Гэхдээ зохион байгуулалтын соёл бий болсон үед энэ нь уламжлалын шинж чанарыг олж авдаг бөгөөд тухайн байгууллагад ажиллаж байгаа хэдэн үед ч тогтвортой хадгалагддаг. Өөрөөр хэлбэл төрийн албаны залгамж халааг ч бас харуулж байдаг.

"Байгууллагын доторх хамгийн бүрэн төгс зохион байгуулалтын соёл нь дараах чиг үүргээр тодорхойлогддог байна. Үүнд:

а) аюулгүй байдлын - байгууллагын үнэт зүйлс, хэм хэмжээ, дүрмийн тогтолцоо нь гадаад орчноос хүсээгүй, сөрөг хандлагыг нэвтрүүлэхэд хамгаалалт болдог төдийгүй удирдлага солигдсон ч үнэт зүйлс, дархлаа байсаар байхыг хэлдэг.

б) нэгтгэх – алба хаагч бүр өөрсдийгөө байгууллагын нэг хэсэг гэж мэдрэх, үүрэг, хариуцлагаа тодорхойлох боломжийг олгодог.

в) зохицуулалтын чиг үүрэг - алба хаагчийн зан байдлыг төлөвшүүлж, хянадаг. Норм, стандарт, дүрэм, түүний дотор бичигдээгүй дүрмийн тусламжтайгаар алба хаагчийн зан төлөвийг тодорхойлдог.

г) орлуулах - байгууллагын хүчтэй соёл нь зарим нэгэн албан ёсны механизм, харилцаа холбоог албан бус механизмаар солих боломжийг олгодог бөгөөд ингэснээр менежментийн зардлыг хэмнэх боломжийг олгодог.

д) дасан зохицох - шинээр томилогдсон алба хаагчийг нэгж, тасаг, газар хэлтэс, байгууллага нийгмийн болон үйл ажиллагааны тогтолцоонд нийцүүлэх боломжийг олгодог.

е) боловсрол, хөгжлийн чиг үүрэг - байгууллагын соёлын өндөр түвшин нь боловсролд эергээр нөлөөлж, байгууллагын боловсролын түвшнийг дээшлүүлж сурах хөгжих эрмэлзэлтэй алба хаагчийг нэмэгдүүлэх, улмаар хүний капитал, нийгмийн тогтвортой байдлын тогтолцоог сайжруулж өгдөг байна.

Дээрх нөхцөл байдлаас үүдэн байгууллага түүхэн хөгжлийн явцад үнэт зүйл, үзэл баримтлал, уур амьсгал, зан үйлийн тогтсон хэв маяг бий болдог байна. Аливаа байгууллага үнэт зүйлээ тодорхойлохдоо дараах үзэл баримтлалыг тусгасан байвал зохино" (Armstrong & Handbook , 2023) гэж судлаачид үздэг. Үүнд:

- тэгш байдал: ялгаварлалгүй хандлагад дасан зохицсоноор алба хаагч шударга ба үнэн, зөв байдаг гэсэн ойлголт бөгөөд удирдлага шударга бус шийдвэр гаргахаас хамгаалах, үүрэг гүйцэтгэлтийн хувьд эрх тэгш боломжийг хангах, цалин хөлсний ялгаваргүй систем үйлчлэх зэргийг багтааж ойлгодог;

- хүндэтгэл эсхүл анхаарал халамж: алба хаагчийн ирээдүй, аюулгүй байдал эсвэл өөрийн хүндэтгэлийг хөндсөн шийдвэр гаргах үедээ хувь хүний байдал, нөхцөлийг хангаж үздэг;

- зохион байгуулалттай сурч, хөгжих боломж: шаардагдаж буй дэмжлэг, үйл ажиллагааг хангах замаар бүх ажилтныг сурч, хөгжих боломжоор хангана гэдэгт итгэх итгэл;

- хүмүүст тулгуурласан гүйцэтгэл: гүйцэтгэлийн соёлыг хөгжүүлэх, тасралтгүй сайжруулалтад хүргэхэд ач холбогдолтой бөгөөд хоёр талын хүлээлтийг тодорхойлох, тохиролцох замаар удирдлагад хэрэгтэй ажилтны ажлыг гүйцэтгэлийн талаар шударга эргэх холбоог хангахад чиглэгддэг;

- ажиллах нөхцөл: аль болох амьдралд нийцсэн тав тухтай ажлын орчныг бүрдүүлэх, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахад чиглэгддэг.

Иймхүү дээр дурдсан үнэт зүйлс нь байгууллагын бодлогод тусгагддаг боловч зарим байгууллагын хувьд үйл


ажиллагааны чиглэлдээ тулгуурлан өргөжүүлэх, эсвэл хүний нөөцийн ямар асуудлыг тэргүүн зэрэгт тавьж байгаагаас хамааран өөр өөр байдлаар тодорхойлж болдог байна.

Байгууллага	Үнэт зүйл
Цагдаагийн ерөнхий газар	“Эх орон, ард иргэддээ өргөсөн тангараг” (ЦЕГ, 2025)
Дотоод хэргийн их сургууль	“Дуурьсах суу алдар, хандах нэгэн зүг, итгэх эрхэм чанар, сахих журамт ёс”
Татварын ерөнхий газар	“Шударга байдал: Нэг нөхцөл байдалд байгаа хүн бүртэй адилхан харьцах Хариуцлага: Байгууллага, ажилтнуудын бүтээмж, авхаалж самбааг нэмэгдүүлэх Зөв хандлага: Сайн дурын шаардлагыг дээд зэргээр нэмэгдүүлэх Мэргэжлийн ур чадвар: Ажилтны ур чадвар, эзэмшил, сэтгэл ханамжийн өндөр түвшинд хүрэх Бие даасан байдал: Ямар ч нөхцөлд маш сайн үйлчилгээ үзүүлэх,зөв зүйлийг хийх Шинэ санаачилга: Ажлаа илүү сайн хийх шинэ арга замыг тасралтгүй эрэлхийлж хэрэгжүүлэх Хамтын ажиллагаа: Үр дүнд хүрэхийн тулд харилцан итгэлцэл, хүндэтгэлтэйгээр бие биетэйгээ хамтран ажиллах” (ТЕГ, 2025)
Нийгмийн даатгалын ерөнхий газар	“Нийгмийн даатгалын байгууллагын бэлгэдэл **ШҮХЭР** бөгөөд энэхүү үгийг бүтээгч үсэг бүхэнд ажилтан бидний ирээдүйн зорилго чиглэл, эрхэмлэх үнэ цэнийг тодорхойлсон. **Ш- шилдэг мэргэшсэн** **Ү–** үнэнч, ёс зүйтэй **Х**-хамтын ажиллагаа, түншлэлийг дэмжигч **Э**-эелдэг, тусч **Р**-эрч хүчтэй, бүтээлч санаачилгатай” (НДЕГ, 2025)
Төрийн албаны зөвлөл	• “Тэгш байдал, шударга ёсны зарчим • Ажлын болон түншлэлийн сайн харилцаа итгэл, хүндэтгэл • Хэрэглэгчдэд чиглэсэн үйлчилгээ • Нээлттэй, ил тод байх зарчим • Удирдлагын манлайлал • Мэргэшсэн, тогтвортой төрийн алба, мэдлэг чадвартай төрийн албан хаагч • Шинийг санаачлан, үргэлж сайжруулан, шинийг туршин нэвтрүүлж байх, • Төсвийн байгууллагын хөгжил, түүний үйл ажиллагааны үр ашиг, үр нөлөө, хөгжил, дэвшил” (МУТАЗ, 2025)

Хүснэгт 1. Төрийн зарим байгууллагаас үнэт зүйлээ тодорхойлсон байдал

Дээрх байгууллагуудын үнэт зүйлсээ тодорхойлсон байдлаас харахад нэг талаас хүний нөөц, нөгөө талаас хуулиар хүлээсэн чиг үүргээ үнэт зүйл гэж тодорхойлсон байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 1600 гаран алба хаагчдаас 2023 онд байгууллагын үнэт зүйлийн талаарх ойлголтын талаарх судалгаа авахад судалгаанд оролцогчдын 59.8 хувь нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад үнэт зүйл байдаг эсэхийг мэдэхгүй, 4.4 хувь нь үнэт зүйл байхгүй, 35.7 хувь нь байгууллага үнэт зүйлээ тодорхойлоогүй гэсэн хариу өгсөн байна.



Зураг 2. Байгууллагын үнэт зүйлийн талаар ойлголтыг боловсролын байдалтай харьцуулсан үзүүлэлт:

Түүнчлэн судалгаанд оролцогчдын 45.6 хувь нь байгууллагын үйл ажиллагаанд чиглэсэн буюу шүүхийн шийдвэрийг бүрэн биелүүлж буй үйл ажиллагаа, 24.1 хувь нь байгууллагын өндөр мэдлэг, ур чадвар, зөв хандлагатай алба хаагч нь өөрөө шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үнэт зүйл, 16.2 хувь нь байгууллагын үйлчилгээ үзүүлсэн хүнд чиглэсэн буюу гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдийг нийгэмшүүлж байгаа нь, 20.1 хувь нь байгууллагын үйлчилгээний үр дүн буюу хүний эрх, эрх чөлөөг хангаж зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээж буй нь үнэт зүйл гэж хариулсан байна.

Хоёр. Алба хаагчдын эрүүл мэнд:

Хүн хөдөлмөрлөх явцад тухайн хөдөлмөрийн нөхцөл, ажлын байрны сөрөг хүчин зүйлсээс шалтгаалан бие махбодод өөрчлөлт үзүүлж буй өвчнийг ажил мэргэжлээс шалтгаалах өвчин гэдэг. Алба хаагч ажлын байранд тогтоосон дүрэм журам, хөдөлмөр хамгаалал сахиагүйгээс тодорхой хугацааны турш, сөрөг нөлөөнд орж эмгэг байдал буюу өвчинд өртөхөд хүргэдэг. Энэхүү “ажил мэргэжлээс шалтгаалах өвчлөлд хөдөлмөрийн явц, ажлын байрны орчин болон дараах хүчин зүйлс шууд нөлөөлдөг. Үүнд:


1. Химийн хүчин зүйлс буюу ажлын байранд хэрэглэгддэг бүх хортой бодис тэдгээрийн нэгдэл хамаардаг. Тухайлбал, хэвлэх төхөөрөмжийн хор, агааржуулагч шингэн, бензин, тос тосол, албан өрөөний тоос зэрэг зүйлсийг ойлгоно.

2. Физикийн хүчин зүйлс буюу халуун, хүйтэн температур, дуу чимээ, доргион, хэт ягаан туяа, лазерын туяа гэх мэт зүйл нөлөөлдөг.

3. Биологийн хүчин зүйлс буюу бактери, вирус, мөөгөнцөр, шимэгч зэрэг ажлын байран дахь биологийн аюултай хүчин зүйлс хамаардаг байна. Тухайлбал, эмч, сувилагч, лабораторийн ажилтан нь өвчтэй хоригдлын цус, шээс зэрэгт шинжилгээ хийх явцад биологийн аюултай хүчин зүйлсэд өртөх эрсдэлтэй байдаг.


4. Эргономикийн хүчин зүйлс нь аливаа алба хаагчийн бие махбод, сэтгэл зүйн чадавхаас хэтэрсэн ачаалалтай ажил, тохиромжгүй загвар, жин, хэмжээтэй багаж хэрэгсэл зэрэг нь яс, булчин, холбогч эдийн гэмтэл төдийгүй осолд өртөх эрсдэлийг бий болгож байдаг.

5. Сэтгэл зүйн хүчин зүйлсэд ихэвчлэн оюуны хөдөлмөр эрхлэгч буюу их хэмжээний мэдээллийг хүлээн авах, боловсруулах, буцааж мэдээллийг дамжуулах, шийдвэр гаргах ажлыг хийдэг хүнд тохиолддог” (ГБХНХЯ, 2012) байна. Тухайлбал, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн хувьд хоригдол, хоригдогчтой холбоотой гэмт хэрэг, хувийн байдалд авир араншин зэрэг мэдээлэлд дүн шинжилгээ хийх, орголт гэмт хэрэг, ноцтой зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, нийгэмшүүлэх зэрэг ажлыг хийдэг онцлогтой учир сэтгэл зүйн хүчин зүйлсийн нөлөөнд өртөх магадлалтай юм.




Зураг 3. ШШГБ-д ажилласан үеэс хойш мэргэжлээс шалтгаалах өвчлөлд өртсөн судалгаа

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ажилласнаас хойш мэргэжлээс шалтгаалах өвчлөлд өртсөн эсэх асуултад судалгааны түүврийн 59.7 хувь буюу нь өвчлөлд өртөөгүй гэж хариулсан бол 40.3 хувь нь өвчлөлд өртсөн гэсэн үр дүн үзүүлсэн байна.



Зураг 4. Архаг суурь өвчин эмнэлгийн байгууллагаар оношлогдоод хэдэн жил болсон талаарх асуулга:

Судалгааны түүврийн 52.8 хувь 1-5 жил, 7.2 хувь нь 6-10 жил, 1.4 хувь нь 11-15 жил, 0.7 хувь нь 16 жилээс дээш жил болж байгаа гэх хариултыг өгсөн байна.



Зураг 5. Алба хаагчид зонхилон тохиолдож буй өвчлөл:

Асуулгын үр дүнгээс харахад 44.8 хувь нь зүрх судасны өвчлөл, 40.7 хувь нь хоол боловсруулах замын өвчлөл дийлэнхийг эзэлж байна. Тэгвэл зүрх судасны өвчний эрсдэлт хүчин зүйлийг өөрчлөх боломжтой, өөрчлөх боломжгүй гэсэн хоёр бүлэгт хуваадаг байна.


Мэдрэлийн гаралтай өвчлөл 27.2 хувь, бөөр шээс ялгаруулах замын өвчлөл 26.8 хувь, нүд чих хамар хоолойн өвчлөл 24 хувь, үе мөчний өвчлөл 23.1 хувь нь алба хаагчдад өвчилсөн гэж хариулсан байна.

Дээрх өвчлөл ямар хугацаанд сэдэрдэг талаар тодруулахад 145 буюу 9 хувь нь жилд 3-аас дээш удаа, 485 буюу 30.2 хувь нь жилд 1-2 удаа, 296 буюу 18.4 хувь нь 2 жилд 1 удаа, 114 буюу 7.1 хувь нь сүүлийн 3 жилд архаг суурь өвчин сэдрээгүй гэж хариулсан байна.

Харин 836 буюу 52 хувь нь архаг суурь өвчинтэй болсон нь миний ажил үүрэгтэй шууд холбоотой гэж үзсэн бол 399 буюу 24.8 хувь нь холбоогүй гэж хариулсан байна.

Гурав. Алба хаагчдын сэтгэл зүйн байдал:

Ажлын сэтгэл ханамжид нөлөөлдөг чухал хүчин зүйл бол ажлаас халшрах хам шинж юм. Мөн энэ шинжийг тухайн хүний эрхэлж буй ажилтай холбоотой илрэх бие махбодын болон сэтгэл зүй сульдах, ядрах, цуцалтын түвшнээр тодорхойлогдож хөдөлмөрийн бүтээмж буурах буюу алдах үйл явц гэдэг. Алба хаагч ажлаас халшрах хам шинжийн түвшин нэмэгдэхийн хэрээр байгууллага, хамт олон үйлчлүүлэг болон харилцагч нарт үзүүлэх сөрөг нөлөөлөл нэмэгдэх ба тэр дундаа ажлын сэтгэл ханамж буурч хөдөлмөр эрхлэх хүсэлгүй болдог байх магадлалтай юм.



Зураг 6. Алба хаагчдын ажлаас халшрах хам шинжийн ерөнхий индекс

Судалгаанд хамрагдсан 1604 алба хаагчдын 31 буюу 1,9 хувьд нь ажлаас халшрах хам шинж маш доогуур, 194 буюу 12 хувь доогуур буюу бараг илрээгүй сайн үзүүлэлттэй гарсан бол 86.1 хувь буюу 1379 алба хаагчид ажлаас халшрах хам шинж дундаас дээш түвшинд илэрсэн дүн гарсан.

“Ажлаас халшрах хам шинжийн түвшин нэмэгдэхэд ажилтан ажиллах эрч хүчгүй болох, хүмүүстэй харьцах явцад зөрчилдөх нь ихсэх, амьдралын утга учир, үнэт чанарын талаарх мэдрэмж сулрах, өөртөө итгэх итгэл алдрах, бусад хүмүүсийн санаа бодол, мэдрэмжид хайхрамжгүй хандах буюу хүнлэг чанар буурах, бусадтай харилцаанд орох, сэтгэл хуваалцлаас төвөгшөөж зожигрох зэрэг шинж тэмдгүүдээр хам шинж илэрч байдаг байна.

Тэгвэл ажлаас халшрах хам шинж нь алба хаагчдад ядрах, нойргүйдэх, аливаа зүйлийг эергээр хүлээн авахаа болих, хүмүүст шүүмжлэлтэй, хүнлэг бусаар хандах, өөрийн үүргийг гүйцэтгэх хүсэлгүй болох, ажилдаа хойрго хандах, урт завсарлаг авах, хоцрох, эсвэл ажлаасаа эрт

гарах хувийн хэрэгцээндээ төвлөрөөд амьдралын зорилгоо алдах, атаархалд автах, сэтгэл гутрал, депресс өртөх, хардамтгай болох, эргэн тойронтойгоо зөрчилдөх, үйл ажиллагааны үр өгөөж буурах, даалгаврыг зөвхөн зааврын дагуу гүйцэтгэх, никотин, кофе, согтууруулах ундаанаас хамааралтай болох донтох магадлал өндөр болдог" (Баярбаатар, 2021, хууд. 42) гэж үздэг. Согтууруулах ундаа, никотин, кофе зэргээс хамааралтай болох эмгэг гэдэг нь дээрх зүйлийг хэтрүүлэн хэрэглэснээс үүдэлтэй нийгэм, сэтгэц болон бие махбод физиологийн дасан зохицох байдалд эмгэг хямрал үүсгэгч хэлбэрээр явагддаг.



Зураг 7. Ажлаас халшрах хам шинжийн бүрэлдэхүүн хэсгийн үзүүлэлт

Судалгаанд хамрагдсан алба хаагчийн ажлаас халшрах хам шинжийг бүрдүүлдэг шинжийн нэг болох сэтгэл зүйн тамирдал 452 буюу 28.1 хувь нь өндөр түвшинд, 1025 буюу 63.9 хувь нь дунд түвшинд, 127 буюу 7.9 хувь доогуур гарсан бөгөөд алба хаагчдын 92 хувь нь сэтгэл зүйн тамирдал гэсэн үр дүн үзүүлсэн байна. Энэ нь мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой үүсэж байгаа сэтгэл хөдлөлийн дарамттай байдал, биеийн болон сэтгэлийн энергийн бууралтыг харуулсан байдаг. Сэтгэл зүйн тамирдлыг сэтгэл зүйн тэнхээ алдрах эмгэг шинж гэх ойлголтоор тайлбарлаж болно. Сэтгэл зүйн тамирдал нийгмийн ажилтан, харуул хамгаалалтын албан тушаалд ажиллаж буй алба хаагч хамгийн их буюу 80 хувьд нь өндөр үзүүлэлттэй илэрсэн байна.

Харин харилцаа холбооны хөндийрөлд 302 буюу 18.8 хувь нь өндөр, 892 буюу 55.6 хувь нь дунд түвшинд илэрсэн бөгөөд алба хаагчдын 74.4 хувь нь хүмүүстэй харилцаа, холбоо тогтоохоос зайлсхийх, эсвэл цөөрүүлэх, харилцаа үүссэн нөхцөлд уцаарлах, бухимдах, зөрчилдөх, хамт олондоо эргэлзэх, сөргөөр хандах зэрэг хандлагатай үр дүн үзүүлсэн байна.

Алба хаагчдын 11.7 хувь буюу 188 нь ажлын амжилтын бууралт өндөр, 35.7 хувь буюу 573 нь ажлын амжилтын бууралт дундаж түвшинд, 52.5 хувь буюу 843 алба хаагч ажилдаа амжилт гаргах эрмэлзэлтэй илэрсэн. Судалгааны үр дүнгээс харахад нийт алба хаагчийн 47.5 хувь нь ажилдаа ямар ч амжилт гаргах гэсэн тэмүүлэлгүй буюу хөдөлмөрлөх явцад өөртөө итгэх итгэл, өөдрөг үзэл, үүсэж байгаа асуудлыг шийдвэрлэх чадвар доогуур буюу уналттай байна.

Ажлаас халшрах хам шинж илэрч байгаа алба хаагчдын хариултаас харахад 51.6 хувь нь буюу 817 алба хаагч заримдаа болон ихэвчлэн хамтран ажиллаж байгаа алба хаагчид уур бухимдал төрүүлж, тайван тэнцвэртэй байдлыг алдагдуулж байдаг гэсэн хариулт өгсөн бол, 49.3 хувь нь буюу 789 алба хаагч нь байгууллагынхаа ажилтнуудтай албан ёсны харилцааны хэм хэмжээ баримталж, аль болохоор цөөн харилцахыг эрмэлздэг гэж хариулсан байна. Харин алба хаагчдын 57 хувь буюу 910 алба хаагч би өөрийн нөхцөл боломжийн хил хязгаараас давсан ачаалалтай ажиллаж байгаа талаар мэдрэмж ихэвчлэн болон үргэлж төрдөг гэсэн байна.

Мөн 888 алба хаагч буюу 55 хувь нь бүх зүйлээс холдон хөндийрч, амрахыг хүсэж байна гэсэн мэдрэмжтэй ажиллаж байна гэж хариулсан байна. Дээрх үзүүлэлтээс дүгнэхэд алба хаагчдын дийлэнх буюу 47.5 - 80 хувь нь ажлаас халширсан, хамт олонтойгоо таарамжгүй, хөндий харилцаатай байж болзошгүйг илтгэж байна. Тэгвэл байгууллагын хөдөлгөгч хүч, амин сүнс нь алба хаагчид, хамт олон байдаг ба чухам тэд нэгэн бие бүрэлдэхүүн болж дуу гаргавал дуу нэгтэй, дугтарвал хүч нэгтэй байж бүхий л зүйлсэд манлайлагч байх чадвар дутагдаж буйг харж болохоор байна.

Дүгнэлт

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн эрх зүйн байдал, албан үүргээ гүйцэтгэх явцад мэргэжлээс шалтгаалах өвчлөлд өртөж буй эсэх, ажлаас халшрах хам шинжид судалгаа хийсний дүнд дараах дүгнэлтэд хүрлээ.

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн үйл ажиллагааг төрийн тусгай алба болон байгууллагын онцлогтой уялдуулан менежментийн шинжлэх ухааны үүднээс хөгжүүлэх шаардлага байна. Өөрөөр хэлбэл байгууллагын соёл, үнэт зүйлийг тодорхойлох, хүний нөөцийг томилох, сургах ажиллагааг орчин үеийн шинэ хандлага, үзэл баримтлалд нийцүүлэн явуулах нь цаашдын байгууллагын хөгжилд чухал хувь нэмэр оруулна гэж үзлээ. Тухайлбал, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдаас байгууллагын үнэт зүйлийн талаарх ойлголтын талаарх судалгаа авахад судалгаанд оролцогчдын 59.8 хувь нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад үнэт зүйл байдаг эсэхийг мэдэхгүй, 4.4 хувь нь үнэт зүйл байхгүй, 35.7 хувь нь байгууллага үнэт зүйлээ тодорхойлоогүй гэсэн судалгааны дүнгээс харахад тус байгууллага үнэт зүйл, соёлоо тодорхойлох цаг нэгэнт ирсэн гэж үзэж байна.

2. Судалгаанд оролцсон алба хаагчдын өгсөн үр дүнгээс харахад 509 буюу 44.8 хувь нь зүрх судасны өвчлөл, 462 буюу 40.7 хувь нь хоол боловсруулах замын өвчлөл дийлэнхийг эзэлж байна. Энэ нь ажлын байрны стрессээс болж үүсэх магадлалтай. Иймд байгууллагын зүгээс алба хаагчдыг эрүүл мэндийн шинжилгээ үйлчилгээнд хамруулах, эрүүл мэндийг сахин хамгаалахад чиглэсэн цогц бодлого авч хэрэгжүүлэх шаардлага байна гэж үзлээ.

3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд алба хаагчдын дунд ажлаас халшрах хам шинж их байна. Энэ нь хэт их ачаалалтай, стресстэй байгаагаас шалтгаалж байна.

4. Судалгаанд оролцогчдын хариултад дүн шинжилгээ хийхэд алба хаагчид мэргэжлийн хувьд өсөж хөгжих боломжид сэтгэл хангалуун биш гэж 58.9 хувь, өөрийн авьяас чадвар, ажлын туршлагаа хэрэгжүүлэх боломжид сэтгэл хангалуун биш гэж 51.1 хувь нь хариулсан, түүнчлэн цаашид өөр ажилд шилжих талаар бодож байгаа 1200 алба хаагч буюу 74.7 хувийг эзэлж байгаа нь онцгой анхаарал татаж байна.

Санал

1. Алсын хараа-2050, Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хөгжлийн стратеги төлөвлөгөөнд нийцүүлэн “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын Хүний нөөцийн бодлогын баримт бичиг”-ийг боловсруулах;

2. Анги, байгууллага бүр алба хаагчдын эрүүл мэндийн байдлын судалгааг бий болгон, хувь хүн бүрд тохирсон эрүүл мэндийн үйлчилгээг мэргэжлийн байгууллагын тусламж, дэмжлэгээр явуулдаг тогтолцоонд шилжих;

3. Удирдах ажилтнаас алба хаагчтай харилцах болон хамт олны эерэг уур амьсгалыг бий болгоход чиглэсэн зөв хандлагад тулгуурласан ажил, арга хэмжээг зохион байгуулдаг байх;

4. Алба хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх хүрээнд албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах зэрэг болно.

Ашигласан материалын жагсаалт

Armstrong, M., & Handbook , A. (2023). HRM Practic.9 th ed., 2003 p. 131-132.

Баярбаатар, П. (2021). Хорих байгууллагын алба хаагчийн ажлаас халшрах хам шинжийг ажлын сэтгэл ханамжтай харьцуулсан нь. Улаанбаатар.

ГБХНХЯ. (2012, 11 23). mlsp.gov.mn. Гэр бүл, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам. Retrieved from Гэр бүл, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам.

МУТАЗ. (2025, 5 7). https://www.csc.gov.mn/. Retrieved from https://www.csc.gov.mn/: https://www.csc.gov.mn/

НДЕГ. (2025, 5 7). https://nndg.ndaatgal.mn/about-us/. Retrieved from https://nndg.ndaatgal.mn/about-us/: https://nndg.ndaatgal.mn/about-us/

ТЕГ. (2025, 5 7). ТЕГ. Retrieved from https://www.mta.gov.mn/main/content/: https://www.mta.gov.mn/main/content/62748

Үүрийнтуяа, О. (2020). Байгууллагын соёлыг удирдлагын удирдах маягтай харьцуулсан судалгаа. Улаанбаатар.

ЦЕГ. (2025, 05 07). police. Retrieved from police.gov.mn: https://police.gov.mn/

Цэндсүрэн, Н., & Батхүрэл, Г. (2013). Менежмент. Улаанбаатар.

Цэцэгмаа, Ц. (2014). Хүний нөөцийн менежмент. Улаанбаатар.

ЗУДЫН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРИМ АСУУДАЛ, ШИЙДЭЛ

SOME PROBLEMS AND SOLUTIONS TO RISK MITIGATION OF ZUD

Б.Саранцэцэг
Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн профессор, доктор (Ph.D), дэд профессор, дэд хурандаа
Sarantsetsteg B.
Professor of Academy of Management, Institute of University of Internal Affairs, Ph.D, lieutenant Colonel
Н.Одмаа
Дотоод хэргийн их сургуулийн докторант, ахмад
Odmaa N.
Doctoral student, University of Internal Affairs, senior

*Хариуцлагатай зохиогч: batsukhjavkhlan25@gmail.com

Хураангуй: Цаг агаар, ур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан байгалийн гамшгийн аюулт үзэгдлийн тоо, давтамж, хамрах хүрээ, хохирол нэмэгдэж байгаатай холбогдуулан гамшгийн эрсдэлийг бууруулах, аюул, эмзэг байдал, өртөнги, чадавхыг урьдчилан тооцоолох, цаашид сөрөн тэсвэрлэх чадавхтай нийгмийг бий болгох нь өнөөдөр бидний тулгамдсан асуудлын нэг болоод байгаа билээ.

Монголын Улсын байгалийн аюулт үзэгдлийн нэг бол зуд бөгөөд манай орны хөдөө аж ахуйн болон мал аж ахуйн салбарт үзүүлж байгаа хохирол, хүн амын эрүүл мэнд, ядуурал, ажилгүйдэл зэрэг сөрөг нөлөөлөл ихтэй гамшигт үзэгдэл юм.

Иймд зудын эрдэлийн менежментийн онол, зудын эрсдэлийн үнэлгээн дээр тулгуурлан зудын эрсдэлийг бууруулах арга хэмжээг тодорхойлж, түүнийг оновчтой болгох шийдэл гаргах зорилгоор эрсдэлийг бууруулах арга хэмжээний чиглэл, төлөвлөлтийн талаар загвар боловсруулан нэвтрүүлэх зорилго дэвшүүлэн энэхүү өгүүллийг бичлээ.

Abstract: As the number, frequency, scope, and damage of natural disasters increase due to weather and climate change, one of our pressing issues today is to reduce disaster risk, predict hazards, vulnerabilities, exposures, and capacities, and create a resilient society.

One of the most frequent disasters in Mongolia's history is the plague, and its negative consequences are a global catastrophe that affects every social and economic sector of Mongolia, including population health, migration, urbanization, poverty, and unemployment, and ultimately national security.

Therefore, based on itch management theory and itching risk assessments, I have written this article with the aim of developing a model for risk reduction and planning for risk reduction interventions with the aim of identifying and developing solutions to improve itching.

Түлхүүр үгс: Гамшгийн эрсдэл, зудын эрсдэл, эрсдэлийн менежмент, уур амьсгалын өөрчлөлт.

Keywords: Disaster risk, zud risk, risk management, climate change.

Удиртгал

Монгол Улс НҮБ-аас батлсан “Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд хэрэгжүүлэх Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичиг”, “Тогтвортой хөгжлийн хөтөлбөр-2030”, “Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Парисын хэлэлцээр” зэрэг баримт бичгийн зорилтуудын уялдаа ханган ажиллаж байгаа билээ.

Гамшгийн эрсдэлийг бууруулах дэлхийн үнэлгээний тайланд 2030 он гэхэд дэлхийн дахинаа учирч болзошгүй гамшгийн тохиолдол 40 хувиар нэмэгдэнэ,

This article is published under the Creative Commons BY-NC-SA License by 4.0, ©2025 University of Internal Affairs, Mongolia

үүний дотроос уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшиг, аюулт үзэгдлийн давтамж даруй гурав дахин ихэснэ гэсэн судалгаа гарчээ (Онцгой байдлын ерөнхий газар, 2022).

Гамшгийн эрсдэлийн нөхцөл байдал, гамшиг ослын ямар ч үед байнгын бэлтгэл, бэлэн байдлыг шаардахын зэрэгцээ учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зөв менежмент, зөв төлөвлөлт, зөв тогтолцоо, сайн засаглал, сахилга хариуцлагыг мөн давхар шаардаж сануулсаар байгаа билээ.

Мөн Монгол Улсын эдийн засгийн гол салбар болох хөдөө аж ахуй, ялангуяа мал аж ахуйн салбарт зудын эрсдэл ихээхэн хохирол учруулсаар байгаа нь судалгаанаас харагдаж байна. Цаашид манай орны хувьд зудын эрсдэлийг 2023-2024 2030, 2050 оноор тооцож гаргасан судалгаагаар 2030 оны үед зудын эрсдэл их зэрэглэлд байх газар нутгийн хэмжээ 2023-2024 оны дунджаас 14 4%, нэн их эрсдэлтэй байх нутаг 3 4% нэмэгдэх төлөвтэй үр дүн гарсан байдаг (АДАП төсөл, 2023). Улсын хэмжээнд /2024 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн байдлаар/ зудын улмаас 3,925,734 мянган толгой малын зүй бус хорогдол гарсан. Энэ нь Улсын дундаж оны эхний нийт малын 6.1 орчим хувийг эзэлж байна (УОК, 2024).

Энэ бүгдээс дүгнэн үзээд зудын эрсдэлийн удирдлагын онол, арга зүй, туршлага сургамжийн судалгаан дээр тулгуурлан зудын эрсдэлийг бууруулах арга замыг тодорхойлж, шийдэл гаргахад оршино.

Үндсэн хэсэг

Эрсдэлийн менежментийн олон улсын стандарт (ISO 31000:2020)-д “эрсдэл нь зорилтыг тодорхой бус болгож буй үр нөлөө” гэж тодорхойлсон. Тодорхойгүй байдал нь сөрөг үр дагаварт хүргэж болзошгүй Тодорхой бус байдал гэдэг нь аливаа тохиолдол, түүний үр дагавар болон тохиолдох магадлалын талаарх ойлголт, мэдлэгтэй холбоотой мэдээлэл зарим нэг талаар хангалтгүй байхыг хэлнэ (газар, 2020) гэж тодорхойлсон

Эрсдэл нь аливаа аюулын улмаас хүн ам, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд хохирол учруулж болзошгүй хүчин зүйлийг таамаглан тусгасан ойлголт юм

Магадлал нь гамшгийн аюул тохиолдох магадлал (0 25, 25%) эсвэл давтамжаар (10 жилд 1 удаа), үр дагавар нь учирч болзошгүй хохирлоор хэмжигдэнэ Гамшгаас хамгаалах салбарт эрсдэлийг аюул, өртөх байдал, эмзэг байдал, чадавхын харилцан хамаарлаар тодорхойлно. (Онцгой байдлын ерөнхий газар, 2022)

Эрсдэл нь аюул, өртөх байдал, эмзэг байдалтай шууд, харин чадавхтай урвуу хамааралтай . Аюул, өртөх байдал, эмзэг байдал нэмэгдэхэд эрсдэл нэмэгдэнэ, харин чадавх нэмэгдэхэд эрсдэл буурна.

Орчин үеийн болон ирээдүйн эрсдэлүүд нийгэм эдийн засгийн тогтолцоонууд дахь технологи, санхүү болон улс төрийн хэлхээ холбоо гүнзгийрэхтэй холбоотойгоор улам бүр нарийн төвөгтэй болж тэдгээрийн өмнө байгаагүй шинэ хувилбарууд бий болж байна Үүний нэг хэлбэр нь нийлмэл эрсдэлүүдтэй бид нүүр тулгарах болсон явдал юм Нийлмэл эрсдэлүүд нь:

- ▶ харилцан уялдаатай эрсдэл,
- ▶ хавсарсан эрсдэл,
- ▶ цуварсан эрсдэл байж болно

Жишээлбэл, зуны улиралд гантай, ирэх өвөл нь зудын гамшиг тохиолдвол түүнийг харилцан уялдаатай эрсдэл гэж үзэх юм Монголчуудын аж амьдралд гангаас үүдэлтэй зудын эрсдэл элбэг тохиолддог. Хавсарсан эрсдэлийн хувьд, КОВИД-19 цар тахал дэлгэрч хөл хорио тогтоосон үед гэнэтийн үер тохиолдож, иргэд олон нийтийг нүүлгэн шилжүүлэх байранд шилжүүлэх үед халдварт өвчний дэглэм алдагдаж, тус байранд олон хүн халдвар авч амь насаа алдах тохиолдол байж болно. Цуварсан эрсдэлийн хувьд газар хөдлөлтийн дараа гал түймэр, аюултай бодисын осол тохиолдох магадлалтай (Онцгой байдлын ерөнхий газар, 2022)

Эрсдэлийн менежмент нь эрсдэлийг тодорхойлох, дүн шинжилгээ хийх, үнэлэх, бууруулах, хяналт үнэлгээ хийх чиг үүргийг хэрэгжүүлэх менежментийн бодлого, журам, практик

ажиллагааны системтэй хэрэглээ, харин эрсдэлийн менежментийн үйл явц нь эрсдэлийг тогтоох, илрүүлэх, шинжлэх, үнэлэх, арга хэмжээ авах, хянах, дүн шинжилгээ хийх, нөхцөл байдлыг тодорхойлох, мэдээлэх, зөвлөлдөх үйл ажиллагаанд удирдлагын бодлого, дүрэм, журмыг системтэйгээр хэрэглэх явдал (газар, 2020) болохыг олон улсад дагаж мөрддөг стандартад тодорхойлсон байна. Зураг 1-т эрсдэлийн менежментийн үйл явцын бүдүүвчийг харуулав.

Эрсдэлийн менежментийн үйл явцыг эрсдэлийн менежмент удирдамж стандартыг MNS ISO31000:2020 нэртэйгээр манай улсад хэрэглэж байгаа бөгөөд эрсдэлийг тодорхойлох, шинжлэх, үнэлэх, бууруулах, хянах, шалгах болон хамрах хүрээ, төлөв байдал, шалгуурыг тодорхойлох, зөвлөгөө өгөх, харилцан хамтарч ажиллах үйл ажиллагааг практикт тодорхой бодлого чиглэлтэйгээр дэс дараалалтай хэрэглэх гэж тодорхойлж дараах байдлаар дүрсэлсэн.



Зураг 1. Эрсдэлийн менежментийн үйл явц

Эх сурвалж: (стандарт, 2020)

Эрсдэлийн шинжилгээний үйл явцын үр дүн нь эрсдэл бүрийг ач холбогдлоор нь эрэмбэлэх ба эрсдэлийг бууруулах арга хэмжээг ач холбогдлоор нь жагсааж, зудын эрсдэлийг бууруулах арга хэмжээнд ашиглаж болно.

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 286 дугаар тогтоолын 5 дугаар “Ган, зудын байдалд үнэлгээ хийх журам” хавсралтад “Зуд” гэж өвөл, хаврын улиралд цаг агаар хүндэрснээс мал сүрэг бэлчээр, усаар нэн гачигдан, турж зутран олноор хорогдох нөхцөл бүрдэхийг ойлгоно (систем Э. з., 2015) Зудыг дотор нь цагаан зуд, харын зуд, шуурган зуд, хүйтэн зуд, хавсарсан буюу туурайн зуд гэж ялгасан байдаг (зуд, 2024).

Зудын үзүүлэлтүүд		
Шалгуур үзүүлэлт	**Үзүүлэлтийг хэмжих хугацаа**	**Босго**
Цагаан зуд		
• Цасны нягт	Цастай үед	0.25 г/см3-с их
•10 хоног, сарын дундаж температур олон жилийн дунджаас хүйтэн байх	Цастай үед	- 3 градусаас их
• Цасны дундаж зузаан, олонжилийн дундажаас зузаан	Цастай үед	Өндөр уул, ойт хээрийн бүсэд 25см-ээс их

байх,/эсхүл бэлчээрийн ургамлын малд идэгдэх хэсэг ... см зузаан цасанд бүрэн дарагдсан байх/	Цастай үед	Цастай үед хээрийн бүсэд 22см-ээс их,
	Цастай үед	Говь, цөлийн бүсэд 12 см-ээс их
Цагаанаар зудархуу		
Цасны нягт	Цастай үед	0.20-0.24 г/см3
Цасны дундаж зузаан	Цастай үед	өндөр уул, ойт хээрийн бүсэд 16см-ээс их, Хээрийн бүсэд 11см-ээс их, Говь цөлийн бүсэд 5см-ээс их
Хар зуд		
• Зун нь гантай, гандуу байсан нутагт өвөлцас ороогүй	Өвөл-хавар	
• 10 хоног, сарын дундаж температур олонжилийн дунджаас хүйтэн байх	Өвөл-хавар	-3 градусаас их
Хараар зудархуу		
• Зун нь гантай, гандуу байсан нутагт өвөл цас бага орсон	Өвөл-хавар	
• 10 хоног, сарын дундаж температур олон жилийн дунджаас хүйтэн байх	Өвөл-хавар	-2 градусаас их
Мөсөн буюу төмөр зуд		
• Цаг зуурын дулааралт, хүйтрэлтийн улмаас цасны өнгөн хэсэг буюу гүнд мөсөн бүрхэвч тогтсоноос мал бэлчээрлэх боломжгүй болсон	Цас, мөсөн бүрхэвчтэй үед	
• Эсхүл цасны нягт их болох	Цас, мөсөн бүрхэвчтэй үед	0.35 г/см3-с их
• Зудыг үнэлэх туслах үзүүлэлт бий		

Хүснэгт 1. Зудын үзүүлэлт

Эх сурвалж: (систем Э. з., 2015)

Малчдын ойлголтоор өвөл,-хаврын улиралд мал сүрэг бэлчээр, унд усаар гачигдаж, эцэж туран үй олноороо үхэж хорогдохыг зуд гэж ойлгодог. Зуд бол хур тунадас, бэлчээрийн ачааллаас гадна цасан шуурга, эрс хүйтрэлт зэрэг зүйлээс мөн хамаардаг (З.Батжаргал нар. , 2012).

Зундаа ган болох, бэлчээр хомсдох, ус хүрэлцэхгүй болж, олон мал нэг дор хуралдах, бэлчээр цасанд битүү дарагдах, эсвэл цас хайлмагтан мөсөн өнгөр тогтох эсвэл хүчтэй салхи олон хоног шуурснаад. мал бэлчээрт гарч чадахгүй болох зэрэг учир шалтгаанаас зуд тохиолддог. Зуд хэмээх ойлголт нь мал тэжээлээр хомсдол2. турж хорогдохтой холбоотой бөгөөд дараах төрлүүдэд хуваагдана: цагаан зуд, харын зуд (туурайн зуд), шуурган зуд, төмөр зуд. Зудын аюул нь өвөл, хаврын улирлыг дамжин урт хугацаагаар үргэлжилдэг

Зуд нь өвөл, хаврын улиралд мал сүрэг бэлчээрээр өл залгаж, энергийн алдагдлаа нөхөж чадахгүй эцэж туран үй олноороо үхэж хорогдоход хүрэх байгалийн нөхцөлийг ойлгоно (Нацагдорж.,Л, Дуламсүрэн.,Ж, 2009). "...мал сүрэг бэлчээрт идээшлэн өл залгаж чадахгүй удсанаас тураалд орох, өлбөрч үхэх нөхцөл нь:

Бэлчээрт тэжээлийн нөөц байсаар атал түүнийг мал сүрэг ашиглах боломжгүй болох;

Бэлчээрт тэжээлийн нөөц ерөөсөө байхгүй болох гэсэн хоёр хүчин зүйлтэй холбоотой байж болох юм.

Үүний нэгдэх хүчин зүйл нь:

а. бэлчээр цасанд дарагдах, өөрөөр хэлбэл малчдын нэрлэдэгээр цагаан зуд болох;

б. мал бэлчих боломжгүй цаг агаарын нөхцөл удаан хугацаагаар хадгалагдах. Энэ нь их хүйтэн болох (хүйтэн зуд гэж нэрлэдэг) хүчтэй салхи шуурга олон хоногоор үргэлжлэх (шуурган зуд гэж нэрлэдэг), бэлчээрт мөсөн хальс тогтож юмуу цас нимгэн ч хатуурч мөсжих (төмөр буюу шилэн зуд гэж нэрлэдэг) зэрэг тохиолдол байж болно.

Харин хоёрдах хүчин зүйл нь:

а. Зун ган болсноос бэлчээрийн гарц муу, энэ нь өвөл их цас унасан, унаагүй аль ч тохиолдолд зуд болоход хүргэх ба цас ороогүй бол хар зуд, цас орсон бол цагаан зуд болно.

б. Зун бэлчээр сайн гарсан ч гэсэн усан хангамж хүрэлцээгүйгээс юмуу мал аж ахуйн зохион байгуулалт муугаас болж нэг дор олон мал бөөгнөрч, бэлчээр дэх тэжээлийн нөөцөө эрт барах, үүнийг малчид туурайн зуд хэмээдэг.

Олон улсын байгууллагуудын баримталж буй байр сууринд хийсэн шинжилгээнээс үзэхэд гамшгийн эрсдэлийн менежментийн нэгдсэн үйл ажиллагааны таван стратегийг хэрэгжүүлэх нь зүйтэй юм. Үүнд:

- Олон түвшний болон салбарын харилцан ажиллагаа, зохицуулалтыг хангах замаар гамшгийн эрсдэлийг бууруулах болон хариу арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах;
- Аюулын зураглал болон эмзэг байдлын үнэлгээнд үндэслэсэн бодит үнэн зөв мэдээлэлд тулгуурлан шийдвэр гаргах;
- Байгаа болон бодит үнэн зөв мэдээллийг үр дүнтэй солилцох болон харилцаа, уялдаа холбоог сайн хангах замаар хамтрагч талуудын нэгдсэн ажиллагаа, зохицуулалтыг сайжруулах;
- Бодлого, бүтэц зохион байгуулалт, чадавхыг бий болгох болон нөөц хүч хэрэгслийг зөв зохицтой бүрдүүлэх замаар гамшгийг тэсвэрлэн гарах боломжийг хангах;
- Гамшгийн эрсдэлийн менежментийн үйл ажиллагааг үндэсний түвшнөөс орон нутгийн түвшинд хүртэл хэрэгжүүлэх зэрэг болно.

Зудын эрсдэлийн менежментийн арга зүй нь зудын шалтгааныг тодорхойлох, эрсдэлийн түвшинг үнэлэх, урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, сэргээн босгох гэсэн үндсэн үе шатуудаас бүрдэнэ (Турнер, 2003) гэж үзсэн байна. Үүнд:

Эрсдэлийг тодорхойлох ба үнэлэх.

Зудын эрсдэлийн индекс (Dzud Risk Index, DRI): Зудын магадлалыг тодорхойлох математик загваруудыг ашиглан эрсдэлийг үнэлэх арга (Фернандез-Гименез, 2015)

Газарзүйн мэдээллийн систем (GIS) ашиглан эрсдэлийг зураглах: Энэ арга нь зудын эрсдэлийн бүсүүдийг тодорхойлох, малчдад сэрэмжлүүлэг өгөхөд хэрэглэгддэг (Erdal, 2012)

Мал аж ахуйн өгөгдлийн шинжилгээ: Хур тунадас, цасан бүрхүүлийн зузаан, температурын хэлбэлзэл, мал сүргийн тарга хүч зэрэг үзүүлэлтүүдийг ашиглан зудын магадлалыг үнэлэх.

Урьдчилан сэргийлэх арга хэмжээ.

Эрсдэлийг бууруулах бодлого боловсруулах: Төрийн байгууллагууд зудын эрсдэлийг бууруулах стратеги, бодлого боловсруулах.

Малчдын дасан зохицох чадавхыг нэмэгдүүлэх: Өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх, малын тоо толгойн зохистой харьцааг баримтлах, хөдөлгөөнт бэлчээрийн менежмент зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх .

Мэдээллийн системийг хөгжүүлэх: Цаг уурын урьдчилсан мэдээг сайжруулах, зудын эрсдэлийн талаар малчдад эрт мэдээлэх тогтолцоо бий болгох (Mongolia, 2020).

Хариу арга хэмжээ ба сэргээн босголт

Засгийн газар болон олон улсын байгууллагуудын тусламж: Зудын дараа малчдад өвс, тэжээл, санхүүгийн дэмжлэг үзүүлэх.

Орон нутгийн удирдлага, иргэдийн оролцоо: Зудын үед бие даан амьдрах боломжийг нэмэгдүүлэх сургалт, дадлага хийх (Bank, 2021).

Сэргээн босголт ба урт хугацааны тогтвортой хөгжлийн бодлого.


- Малчдыг төрөлжсөн үйлдвэрлэлд шилжүүлэх, малын эрүүл мэндийг сайжруулах, нийгмийн хамгааллын тогтолцоог бэхжүүлэх.
- Даатгалын бодлогыг нэвтрүүлэх.

Судалгааны арга зүй

Монгол Улсын хэмжээнд ихээхэн хохирол дагуулсан 2000-2002, 2009-2010, 2023-2024 оны зудын үед хийсэн судалгааны ажлаас нийт хорогдлыг он оноор нь гарган харьцуулан судалгаа хийлээ. Үүнд:

№	Малын хорогдлын хувь, оноор	5 хүртэл	5 -10 хувь	10 – 20 хувь	20-оос дээш хувь	Нийт
1	2000-2002	55	99	88	88	330
2	2009-2010	53	49	79	149	330
3	2023-2024	158	68	50	54	330

Хүснэгт 2. Сумдын тоо, малын хорогдлын хувиар, 2000-2002 болон 2009-2010, 2023-2024 оны зуд



Зураг 2. Сумдын тоо, малын хорогдлын хувиар, 2000-2002 болон 2009-2010, 2023-2024 оны зуд

2023-2024 оны зудын мэдээллээс судалгаа хийхэд 21 аймгийн хэмжээнд Монгол Улсын Засгийн газрын 286 дугаар тогтоолд суурилан боловсруулсан аргачлалын дагуу зудын нийгэм, хүн амд учруулах эрсдэлийг салбар дундын оролцоотойгоор үнэлж, аймгуудын дүнгийн дунджаар улсын дүнг тооцож гаргасан. (Онцгой байдлын ерөнхий газар, 2024) 2024 онд нийт 64,238,714 мал өвөлжиж байгаа бөгөөд хорогдсон малын тоо 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн мэдээгээр 2,009,746 буюу **3.1** хувьд хүрсэн бол нийт малчин өрхийн 72462 буюу **37.5 хувь** нь өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрсэн (Онцгой байдлын ерөнхий газар, 2024) байна. Том малын зүй бус хорогдол 2024 оны эхний хагас жилийн байдлаар 8.1 саяд хүрч, өмнөх оноос 4.2 саяар буюу 2.1 дахин нэмэгдэж, нийт малын 12.5 хувьд хүрлээ. 4,957 өрх 70 ба түүнээс дээш хувийн хорогдолтой, 513 өрх 100 хувь малгүй болсон байна. (УОК, 2024)

Хавсралтад байгаа 2024 оны зудын эрсдэлийн үнэлгээний дүн 2024 оны ерөнхий үнэлгээний үр дүнгээс (Онцгой байдлын ерөнхий газар, 2024) / үзэхэд зудын эрсдэлийн үнэлгээний дундаж түвшин 8.04 байгаа нь зудын эрсдэл олон аймагт харьцангуй өндөр байгаа нь тогтоогдсон. Эрсдэл хамгийн өндөр аймгууд Сүхбаатар (12.2), Завхан (10.5), Архангай (10.4), Увс (10.3), Баян-Өлгий (9.9), Дундговь (9.2), Баянхонгор (9.0) аймгууд хамгийн өндөр эрсдэлтэй байна. Эдгээр аймгууд нь **аюулын үнэлгээ, эмзэг байдал өндөр, харин чадавх сул** байна.

Судалгааны үр дүн

Зудын эрсдэлийн үнэлгээг зудын төрөл тус бүр дээр хийх бөгөөд тухайн эрсдэлийн түвшинг тодорхойлогч нөлөөлөх гол хүчин зүйл болох өртөнги, эмзэг байдал, чадавхын үнэлгээг гүйцэтгэх болно. Үнэлгээг гүйцэтгэхдээ тухайн зудын аюул, өртөгдөх салбарын эмзэг байдлыг үнэлэхээс гадна тухайн зудад нэрвэгдэж болзошгүй аймаг, сум, баг, малчин өрхийн чадавхын үнэлгээг нарийвчлан тооцох шаардлага тулгарч байна.

Энэ бүгдээс дүгнэн үзээд зудын эрсдэлийн менежментийг хэрэгжүүлэхдээ хамгийн чухал нь зудын эрсдэлийг

бууруулах арга хэмжээ бөгөөд түүнийг оновчтой, шуурхай хэрэгжүүлэхдээ зудын эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны чиглэлийг тодорхой болгож, хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг байж болох нөхцөлүүдтэй тухайн бодит нөхцөлийг харьцуулан дүн шинжилгээ хийж, 3 үндсэн үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд эрсдэлийг бууруулах нийтлэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр дараах саналыг боловсрууллаа.



Зураг 3. Зудыг эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны чиглэл ба тэдгээрийг хэрэгжүүлэх арга хэмжээнүүд

Эх сурвалж: Судлаачийн боловсруулсан хувилбар

- Санал болгож буй нийтлэг арга хэмжээнүүд нь зудын байж болох тухайн нөхцөлөөс хамаарч эсвэл бэлчээрийн мал маллагаанд шинэ техник технологи нэвтэрснээс нэмэлт арга хэмжээгээр баяжигдаж болно гэж үзлээ.:

- Эрсдэлийг бууруулах арга хэмжээний шийдэл

- Зудын эрсдэлийн менежмент бол нэг удаа авах арга хэмжээгээр хязгаарлагдахгүй бөгөөд аливаа байгалийн эрсдэл, аюулт үзэгдлийн дараагаар мал аж ахуйн салбарын бүтэц, зохион байгуулалтад зайлшгүй хийгдэж буй өөрчлөлт, шинэчлэлд байнга нийцэж байх ёстой үйл явц юм. Тухайн салбарын үйл ажиллагааг илүү дэвшилтэд техник технологиор шинэчилж, түүнд оролцогч талуудыг өөрчлөхөд салбарын хангалт, үйлчилгээний сүлжээ илүү зохион байгуулалттай болсноор байж болох эрсдэл үндсээрээ өөрчлөгдөхөд хүрдэг. Түүнчлэн байж болох эрсдэл нь Засгийн газраас хөдөө аж ахуйн талаар баримталж буй бодлого, үйл ажиллагаа болон зах зээлийн ойрын ирээдүйн хандлагаас хамааралтайгаар өөрчлөгдөж болно.

- Эрсдэлийн давтамж, үр дагавартай холбогдуулан эрсдэлийн менежментийн дараах арга механизмуудыг ашиглаж болох юм. Үүнд:

- Нэгдүгээрт, давтамж нь их боловч учруулж буй үр дагавар нь арай бага байх юм бол эрсдэлийг багасгаж бууруулах нь хамгийн сайн арга хэмжээ байх болно;

- Хоёрдугаарт, эрсдэлийн давтамж нь бага ч гэсэн нэлээд их хэмжээний хохирол үр дагавартай бол эрсдэлийг шилжүүлэх арга хэмжээ байж болох юм;

- Гуравдугаарт, эрсдэлийн давтамж бага байх хэдий ч ноцтой хохирол, сөрөг үр дагавартай (2001, 2010, 2024) бол Засгийн газраас энэхүү сөрөг үр дагаврыг даван туулах арга хэмжээ болон тусламжийн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

- Хэрэв зудын эрсдэл цаашид улам ихсэж үргэлжлэх хандлагатай байх тохиолдолд бэлчээрийн тогтвортой менежмент, мал маллагааг сайжруулж, мал өвөлжилтийн бэлтгэл, бэлэн байдлыг хангах нь зудын эрсдэлийн менежментийн үндсэн арга хэмжээ байх болно. Малын тоо толгойг бэлчээрийн даацад тохируулан хязгаарлаж өвлийн улиралд малыг байнгын тэжээлд оруулж, зудын гамшгийн хор уршгийг арилгах арга хэмжээний зохицуулалтыг сайжруулахдаа эрсдэлийг бууруулах, шилжүүлэх, даван туулах/сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх шаардлагатай юм.

- Зудын эрсдэлийн үнэлгээний үр дүнд үндэслэн зудын эрсдэлийг бууруулах болон зудтай тэмцэх үйл ажиллагааны стратегийг тодорхойлох, зөв шийдвэр гаргах сонголтыг хийхэд гол шийдэл нь оршино.. Гэхдээ зудын эрсдэлийн үнэлгээгээр зудын хүлцэх эсвэл үл хүлцэх эрсдэлийн байдлаас хамаарч зудын эрсдэлийг бууруулах арга хэмжээний стратеги, төлөвлөлтийг тодорхойлох шийдвэр харицан адилгүй байж болно.

- Зудын эрсдэлийг бууруулах болон зудтай тэмцэх стратеги, төлөвлөлтийн санал болгож буй хувилбарыг зурагт харууллаа. Ингэж ажиглалтын хугацаанд зудын тохиолдлын давтамж, хохирлын зэрэг, болзошгүй сөрөг үр дагавар, эрсдэлийн (хүлцэх болон үл хүлцэх) түвшинд үндэслэн зудын эрсдэлийн менежментийн арга механизмуудыг төрөлжүүлснээр хязгаарлагдмал нөөц хүч хэрэгслийг оновчтой төлөвлөж үр ашигтай зарцуулах боломжтой байх болно. Тухайлбал, зудын эрсдэлийн үнэлгээгээр байгаль, цаг-уурын ноцтой аюулт үзэгдэл тохиолдох магадлал, хохирлын зэрэг бага эсвэл дунд хэмжээнд байхад тухайн бэлчээрийн даацад малын тоо толгойг тохируулах, нэмэгдэл олон нөөц өвс, тэжээл бэлтгэх тооцоог оновчтой хийж үргүй зардал гаргахгүй байх ач холбогдолтой юм.

ЗУДЫН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ БОЛОН ЗУДТАЙ ТЭМЦЭХ СТРАТЕГИ, ТӨЛӨВЛӨЛТ

Эрсдэлийг бууруулах арга хэмжээ:	Бэлэн байдлыг хангах, шуурхай удирдлага зохицуулалт:	Санхүүгийн зохицуулалт:
Зудын эрсдэлийн үнэлгээнд үндэслэн эрсдэлийг бууруулах төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх ; Малын тоо толгойг бэлчээрийн даацад тохируулан цөөлөх ; Зун намрын отор нүүдэл хийж малдаа тарга хүч авахуулах; Онд орох малыг даатгалд хамруулах; Байгалийн хадлан нөөцлөх Орон нутагт тэжээлийн жижиг, дунд үйлдвэрийн байгуулах ; Хөдөө аж ахуйн дэд бүтцийг сайжруулах ; Өвөлжөө хаваржааны хашаа хороог дулаалах ; Худаг ус цэгийн тоог нэмэгдүүлэх; Нэмэгдэл тэжээлээс гадна аюулгүйн нөөц тэжээлийг өвөлжөө,хаваржаанд байршуулах; Өвс тэжээлийн тээвэр зохицуулалтыг зохион байгуулах;	• Хүйтний улирлын мэдээ, тухайн жилийн бэлчээрийн ургамалжилт, ургацын мэдээ болон гангийн индексийн мэдээнд үндэслэн зудын урьдчилсан мэдээг орон нутагт хүргүүлэх (8 сарын 20); • Зудад нэрвэгдэж болзошгүй аймаг орон нутаг, малчдад сэрэмжлүүлэх мэдээ, мал өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах анхааруулга санамж хүргүүлэх ((9 сарын 1); • Мал өвөлжилтийн бэлтгэл ажлыг шалгах (10 сарын 15); • Отроор өвөлжих малчид болон малын тоо толгойг тогтоож нүүлгэн шилжүүлэх(11 сарын 15); • Өвөлжилтийн байдалд үнэлгээ хийж зудад нэрвэгдэх аймаг сумдыг бэлэн байдлын дээд зэрэгт шилжүүлж аюулын түвшин зэрэглэл тогтоох (12 сарын 15); • Малчдад тусламж үзүүлэх хэрэгцээний үнэлгээ хийх (12 сарын 15); • Сум, аймгийн нөөцийг малчдын суурьт хүргүүлэх ажлыг зохион байгуулах; • Хүндэрч болзошгүй аймаг, сумдын малыг нэмэлт тэжээлд оруулах (12 сарын 30) ; • Малын хорогдлын болон малчдын амьжиргаа, эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээ, хүнс, түлээ түлшний хангалтын мэдээг авч хариу арга хэмжээг зохион байгуулах (1 сарын 15);	• Онд орох малыг албан, сайн дурын даатгалд хамруулах • Гамшгийн эрсдэлийн сангаас хүндэрсэн аймаг сумдад мөнгө болон мөнгөн бус тусламж өгөх; • Засгийн газрын нөөц хөрөнгөөс хүндэрсэн аймгуудад зудтай тэмцэх арга хэмжээнд зардлыг нөхөн олгох; • Цөөн малтай эмзэг бүлгийн малчдад малын хорогдлын гамшгийн нөхөн төлбөрийг олгох; • Төрийн болон арилжааны банкуудаас эргэн төлөгдөх нөхцлөөр хөнгөлттэй зээл олгох;

Зураг 4. Зудын эрсдэлийг бууруулах болон зудтай тэмцэх стратеги, төлөвлөлт

Эх сурвалж: Судлаачийн боловсруулсан хувилбар

Аль ч тохиолдолд шийдвэр гаргалтын сонголтыг дараах байдлаар гүйцэтгэнэ: -

Шийдвэр гаргалтын нэгдүгээр шат нь зудын эрсдэлээс зайлсхийх боломжтой эсэхэд дүн шинжилгээ хийнэ. Хэрэв зудын эрсдэлээс зайлсхийх боломжтой гэж үзвэл дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

-малын тоо толгойг бэлчээрийн даацад тохируулж бэлчээрийн даацаас хэтэрсэн илүү малыг цөөлөх;

-бэлчээр сайтай эсвэл арай сайн нөхцөлтэй газар нутаг руу отор нүүдэл хийх, том малыг алсын оторт гаргах (бэлчээрийн

талхагдлыг бууруулах үр дагавар бүхий мал дагасан нүүдэл нь одоо ч гэсэн хамгийн оновчтой стратеги хэвээрээ байгаа).

Шийдвэр гаргалтын хоёрдугаар шат нь зудын эрсдэлийг бууруулах боломжтой эсэхэд дүн шинжилгээ хийнэ. Хэрэв зудын эрсдэлийг бууруулах боломжтой гэж үзвэл дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ. Зудын эрсдэл нь зудад нэрвэгдэх өртөнгийн эмзэг байдлыг бууруулахын зэрэгцээ зудтай тэмцэх чадавхыг сайжруулах арга хэмжээ авснаар буурна гэж үзэж дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- малын хашаа хороог дулаалах, өтөг бууц нөөцлөх, худаг, булаг шандыг хамгаалах;
- тэжээлийн нөөцийг нэмэгдүүлэхийн тулд байгалийн хадланг нөөцөлж хурааж авах, орон нутагт тэжээлийн жижиг, дунд үйлдвэрийг байгуулж ажиллуулах;
- бэлчээрийг хуваарьтай ашиглах, өвөлжөө хаваржааны бэлчээрийг нөөцлөх, цасанд дарагдсан бэлчээрийн цасыг арилгаж малд бэлчээрлэх боломж олгох;
- малчдын эрүүл мэнд, төрийн болон мал эмнэлгийн үйлчилгээг тогтмолжуулах;
- тэжээлийг хүндэрсэн баг, суурьт хүргэх тээвэр зохицуулалтыг зохион байгуулах;
- малчдын бүлэг, хоршооны үйл ажиллагааг дэмжиж хамтын хөдөлмөрийн давуу талыг ойлгуулах;
- гамшгийн эрсдэлийг бууруулах түншлэл хамтын ажиллагааны аймаг, сумын зөвлөлгөөнөөр аймаг, сумын хөгжлийн сангаас эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд төсөв хөрөнгө хувиарлаж шийдвэрлэж байх;
- зудаас хамгаалах төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх;
- зудын үед мэдээ, мэдээлэл цуглуулах яаралтай тусламж дэмжлэг үзүүлэх шуурхай бүлгийг томилох;
- зарлан мэдээлэл, сэрэмжлүүлэх мэдээг цаг хугацаанд түргэн шуурхай хүргэх зэрэг болно.

Шийдвэр гаргалтын гуравдугаар шат нь эрсдэлийг шилжүүлэх боломжтой эсэхэд дүн шинжилгээ хийнэ. Хэрэв эрсдэлийг шилжүүлэх боломжтой гэж үзвэл дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ. Үүнд:

малыг индексжүүлсэн болон бусад төрлийн даатгалд хамруулах;

малын эрсдэлийн сан байгуулж малын зүй бус хорогдлыг нөхөн төлбөрөөр зохицуулах;

малаа алдсан малчдыг малжуулах хөтөлбөрт хамруулах зэрэг санхүүгийн арга механизмыг ашиглана.

Шийдвэр гаргалтын дөрөвдүгээр шат нь хатуу ширүүн уур амьсгалд мал сүрэг дасан зохицох боломжтой эсэхэд дүн шинжилгээ хийнэ. Хэрэв дасан зохицох арга хэмжээг хэрэгжүүлэх боломжтой гэж үзвэл дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ. Үүнд:

-малын үүлдэр угсааг чанаржуулах;

-зудад тэсвэртэй сайн чанарын үүлдэр гаргаж авах, төмөр сүргийг бий болгох;

-хангайн хүйтэн сэрүүн болон говь, хээрийн бүсэд малын тэжээлийг ургуулах технолгийг нэвтрүүлэх;

-эрчимжсэн мал аж ахуйг газар тариалан эрхлэхтэй хослуулах;

-малчдад амьдралын өөр эх үүсвэр, орлогыг нэмэгдүүлэх, малын түүхий эд, мах, махан болон сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зах зээлийг нэмэгдүүлэх;

малчдын хотонд хөдөө аж ахуйн түүхий эдийг боловсруулах, орчин үеийн технологийг нэвтрүүлэх арга хэмжээ авах.

Зудын эрсдэлийг бууруулах стратегийг болон түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөлтийг тодорхойлсны дараах асуудал бол зудын аюул нүүрэлсэн үед бэлтгэлтэй байх, тохиолдсон үед бэлэн байх явдал юм.

Иймд зудын эрсдэлийг бууруулах стратегийг болон түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөлтийг “улсын түвшний”, “аймгийн түвшний”, “сум/малчны түвшин” гэж хуваан зураг үзүүлсэн арга хэмжээг зохион байгуулснаар зудын эрсдэлийн менежментийг боловсронгуй болно гэж үзэн дараах загварыг боловсруулан дэвшүүлж, зудын эрсдэлийг бууруулах арга хэмжээний шийдэл болно гэж үзлээ.

Дүгнэлт, санал

Сүүлийн жилүүдэд өсөн нэмэгдэж байгаа зудын эрсдэлийг танин мэдэх, ойлгох, урьдчилан сэргийлэх, учирч

болзошгүй хохирлыг бууруулах арга замыг олж, хохирол багатай даван туулах чадавхаа бэхжүүлэх, эрсдэлийг бууруулах асуудлыг иргэд, олон нийтийн түвшинд төдийгүй, цаашлаад улс орны тогтвортой хөгжил, аюулгүй байдлын түвшинд авч үзэж, зудын эрсдэлийг бууруулах хэрэгцээ, шаардлага тулгарч байна.

Зудын эрсдэлийн менежмент нь удаан хугацаанд үргэлжлэх байгалийн болон нийгэм-эдийн засгийн нийлмэл шинжтэй эрсдэлийг оновчтой даван туулах, урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах зорилготой иж бүрэн арга хэмжээний цогц юм. Зудын аюул нь улирал дамжин үргэлжилдэг динамик үйл явц учраас түүнтэй тэмцэх үйл ажиллагааг урьдчилан сэргийлэх болон хариу арга хэмжээ авах гэсэн хоёр үндсэн бүлэгт хуваан хэрэгжүүлэх шаардлагатай.

Нэгдүгээр бүлэг арга хэмжээ нь зудад бэлтгэлтэй байх, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн бөгөөд мал өвөлжилтийн бэлтгэлийг хангуулах, эрсдэл өндөртэй бүс нутагт урьдчилсан төлөвлөлт хийх, тэжээл, өвсний нөөц бүрдүүлэх, малын тоог зохистой төвшинд байлгах, малчдын хувийн бэлтгэлийг хангах зэрэг нь онцгой ач холбогдолтой.

Хоёрдугаар бүлэг арга хэмжээ нь зудын гамшиг бодитоор нүүрлэсэн үед хэрэгжүүлэх хариу арга хэмжээнүүд юм. Үүнд зудын нөхцөл байдлыг үнэн зөв тодорхойлох, мэдээллийн урсгалыг нэг стандарттай болгох, гамшигт нэрвэгдсэн бүс нутагт тусламж, дэмжлэгийг цаг алдалгүй хүргэх, нөөц бололцоог дайчлах зэрэг багтана.

Эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэхдээ төв, орон нутгийн түвшний уялдаа холбоог сайжруулж, гамшгийн бэлэн байдлын төлөвлөгөөг үе шаттайгаар хэрэгжүүлснээр зудын сөрөг нөлөөллийг хохирол багатай даван туулах боломжтой юм. Мөн малчдын амьжиргаа, эрүүл мэнд, нийгмийн хамгааллыг цогц байдлаар авч үзэх нь зудаас үүдэх нийгмийн эрсдэлийг бууруулахад чухал хувь нэмэр оруулна.

Зудын эрсдэлийн менежментийг сайжруулахдаа зудын эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны чиглэлийг тодорхой болгож, хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг байж болох нөхцөлүүдтэй тухайн бодит нөхцөлийг харьцуулан дүн шинжилгээ хийж, 4 үндсэн үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд эрсдэлийг бууруулах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх зорилгоор саналыг боловсруулсан.

Мөн зудын эрсдэлийн менежментийг сайжруулахдаа эрсдэлийн үнэлгээнд үндэслэн эрсдэлийг бууруулах (урьдчилан сэргийлэх), эрсдэлийг шилжүүлэх (даатгал, хариуцлагын хуваарилалт),даван туулах/сөрөн тэсвэрлэх (тусламж, хариу арга хэмжээ) гэсэн үндсэн гурван чиглэлээр авах арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Зудын эрсдэлийг системтэйгээр үнэлж, хүлцэх болон үл хүлцэх түвшинг ялган тодорхойлж, олон хувилбарт төлөвлөлт боловсруулах нь гамшгийн эрсдэлийн менежментийн чадавхыг нэмэгдүүлэх чухал алхам юм.

Зудын эрсдэлийг бууруулах болон зудтай тэмцэх стратеги, төлөвлөлтийн оновчтой тогтолцоог бүрдүүлэх нь гамшгийн эрсдэлийн менежментийн гол зорилт бөгөөд энэхүү зорилго нь зөвхөн зудын үр дагаврыг хохирол багатай даван туулах бус, урьдчилан сэргийлэх, давтамжтай үүсдэг эрсдэлд дасан зохицох чадварыг дээшлүүлэхэд чиглэгдэнэ.

Иймд зудын эрсдэлийг бууруулах арга хэмжээний талаарх дараах саналыг дэвшүүлж байна:

Зудын эрсдэлийг бууруулах арга хэмжээний стратеги боловсруулан хэрэгжүүлэх,

Зудын эрсдэлийг удирдах, сөрөн тэсвэрлэх чадвахыг нэмэгдүүлэх,

Зудын болзошгүй хохирлыг бууруулахын тулд гамшгийн эрсдэлийг бууруулах улсын болон орон нутгийн төсвийн хэмжээг нэмэгдүүлэх, орон нутгийн хөгжлийн бодлого төлөвлөлттэй уялдуулах,

Гамшгийн эрсдэлийг шилжүүлэх чиглэлээр гамшгийн эрсдэлийн даатгалын хуулийн төсөл боловсруулах, малын индэксжүүлсэн даатгалын цар хүрээг улам тэлэх.

Эх сурвалж

/ЖАЙКА/, Я. О. (2023). *Монгол Улс* . Улаанбаатар: Улаанбаатар.

Bank, A. D. (2021). *Country Partnership Strategy: Mongolia, 2021–2024—Sustaining inclusive growth in a period of uncertainty.* УБ: УБ.

Erdal, G. K. (2012 оны 00 00). "Effects of climate change on agricultural production: A case study of Turkey.". *"Effects of climate change on agricultural production: A case study of Turkey."*, хууд. APSTRACT /Applied Studies in Agribusiness and Commerce/ .

Mongolia, U. (2020). *Assessing the impact of climate change on Mongolia's pastoral communities and livestock farming.* УБ: https://www.mn.undp.org.

АДАП төсөл. (2023). *"Уур амьсгалын эрсдэлийн мэдээллийг ашиглан газар, ус, мал аж ахуйн менежментийг үндэсний болон орон нутгийн түвшинд төлөвлөх заавар, аргачлал, гарын авлага"-ын Эрсдэлийн төлөвлөлтийн багийн тайлан, 2023.* 25: 10.

газар, С. х. (2020 оны 11 17). *https://www.estandard.gov.mn/website/home.aspx ISO 31000:2020, Эрсдэлийн менежментийн стандарт.* https://www.estandard.gov.mn/website/home.aspx : https://www.estandard.gov.mn/website/home.aspx-ээс Гаргасан

З.Батжаргал нар. . (2012). Монголын нүүдлийн мал аж ахуй экосистемийн сүлжээ. З. нар.-Д, *Монголын нүүдлийн мал аж ахуй экосистемийн сүлжээ* (хууд. 479). Улаанбаатар.

зуд. (2024 оны 9 17). *https://mn.wikipedia.org/.* https://mn.wikipedia.org/.-ээс Гаргасан

Нацагдорж.,Л, Дуламсүрэн.,Ж. (2009). Зудын үнэлгээний асуудалд– "Ган зуд" эмхтгэл . Л. Д. Нацагдорж.-Д, *Зудын үнэлгээний асуудалд– "Ган зуд" эмхтгэл* (хуудсд. 90-91). Улаанбаатар.

Онцгой байдлын ерөнхий газар. (2022). "Гамшгийн эрсддэлийн удирдлага" . О. б. газар-Д, *гарын авлага* (хуудсд. 13-14). Улаанбаатар:

Онцгой байдлын ерөнхий газар. (2022). *Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийн хэрэгжилтийн Монгол Улсын дунд хугацааны тайлан, 2022.* 25: 11.

Онцгой байдлын ерөнхий газар. (2024). *Зудын эрсдэлийн ерөнхий үнэлгээ.* Улаанбаатар: Онцгой байдлын ерөнхий газар.

Онцгой байдлын ерөнхий газар. (2024). *"Нэгдсэн шуурхай штабын мэдээ, тайлан".* Улаанбаатар: Онцгой байдлын ерөнхий газар.

систем, Э. з. (2010). Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал". *Төрийн мэдээллийн эмхэтгэл*, 48.

систем, Э. з. (2015 оны 07 07). Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 286 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт "Ган, зудын байдалд үнэлгээ хийх журам". Улаанбаатар, Монгол Улсын Засгийн газар, Монгол.

стандарт, М. У. (2020). *Эрсдэлийн менежмент MNS ISO31000:2020.* Улаанбаатар: Монгол Улсын стандарт хэмжилзүйн газар.

Турнер, Б. Л. (2003). "Тогтвортой байдлын шинжлэх ухаанд эмзэг байдлын шинжилгээний хүрээ.". *"Тогтвортой байдлын шинжлэх ухаанд эмзэг байдлын шинжилгээний хүрээ."*, 8.

УОК. (2024). *"Нэгдсэн шуурхай штабын мэдээ, тайлан".* 09: 03.

Фернандез-Гименез, М. Е. (2015 оны 00 00). "Lessons from the Dzud: Adaptation and Resilience in Mongolian Pastoral Social-Ecological Systems."Зудын сургамж: Монголын нүүдэлчин нийгэм-экологийн тогтолцооны дасан зохицол ба тогтвортой байдал.". *"Lessons from the Dzud: Adaptation and Resilience in Mongolian Pastoral Social-Ecological Systems. 65*, хууд. 50.

Хүнс, х. а.-ы. (2017). *Ган-зудын хосолсон гамшгийн эрсдэлийг эрт мэдээлэх,.* улаанбаатар: Бодлого судлалын төв /www.cpr.mn /.

Ш.Болдбаатар. (2015). *Үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх зудын эрсдэлийг бууруулах арга зам.* Улаанбаатар.

Хавсралт 2024 оны зудын эрсдэлийн үнэлгээний дүн

Д/д	Аймаг	Аюулын үнэлгээ	Эмзэг байдал	Чадавх	Эрсдэлийн түвшин	Эрсдэлийн түвшин өндөр сумд
1.	Архангай	7.6	5.6	4.1	10.4	Батцэнгэл, Жаргалант, Их тамир, Өндөр-Улаан, Өлзийт, Өгийнуур, Тариат, Төвшрүүлэх, Хангай, Хайрхан, Хотонт, Цахир, Цэнхэр, Эрдэнэмандал
2.	Баянхонгор	5.82	7.1	4.6	9	Баянбулаг, Баянлиг, Баян-Өндөр, Баянцагаан, Галуут, Гурванбулаг, Жаргалант, Заг, Өлзийт, Хүрээмарал, Эрдэнэцогт
3.	Баян-Өлгий	7.9	5.25	4.17	9.9	Булган, Алтай, Сагсай, Толбо, Улаанхус, Цэнгэл, Дэлүүн
4.	Булган	5.8	4.6	6.6	4.04	Баяннуур, Дашинчилэн, Могод, Рашаант,
5.	Говь-Алтай	6.1	5.3	4.6	7.01	**Маш их:** Баян-Уул, Дэлгэр, Жаргалан, Тайшир, Цээл, Чандмань, Шарга **Их:** Бусад сумд
6.	Говьсүмбэр	7.2	6.6	5.5	8.6	Сүмбэр, Шивээгөьт, Баянтал
7.	Дархан-Уул	6.18	4.98	4.6	5.2	
8.	Дорнод	5.3	5.2	4.2	6.5	Баянтүмэн, Булган, Гурванзагал, Сэргэлэн, Хөлөнбуйр, Халхгол, Дашбалбар, Цагаан-Овоо, Матад
9.	Дорноговь	10.4	7.4	2.3	7.7	
10.	Дундговь	7.3	6.2	5.7	9.2	**Маш их:** Өлзийт, Эрдэнэдалай **Их:** Адаацаг, Гурвансайхан, Дэрэн, Дэлгэрцогт, Луус, Өндөршил, Сайхан-Овоо, Сайнцагаан, Хулд, Цагаандэлгэр
11.	Завхан	8.3	8	6.3	10.5	Асгат, Баянхайрхан, Баянтэс, Идэр, Их-Уул, Нөмрөг, Отгон, Сонгино, Тосонцэнгэл, Түдэвтэй, Тэс, Тэлмэн, Цагаанхайрхан, Цагаанчулуут, Цэцэн-Уул, Шилүүстэй, Яруу
12.	Орхон	7.8	4	6.5	1.5	
13.	Өвөрхангай	7.5	5.8	4.3	7.0	**Маш их:** Богд, Баруунбаян-Улаан, Зүүнбаян-Улаан **Их:** Баян-Өндөр, Бат-Өлзий, Бүрд, Есөнзүйл, Төгрөг, Хужирт, Хархорин, Өлзийт, Нарийнтээл,
14.	Сүхбаатар	9,4	6.3	4.9	12,2	Нийт сумд
15.	Төв	6.1	6.6	5.2	7.8	**Маш их:** Борнуур, Жаргалант, Лүн, Өндөрширээт, Сэргэлэн, Эрдэнэсант **Их:** Бусад сумд
16.	Сэлэнгэ	4.9	5.3	5.2	5.08	
17.	Увс	6.9	6.9	4.6	10.3	**Маш их:** Баруунтуруун, Давст, Зүүнговь, Зүүнхангай, Малчин, Наранбулаг, , Өндөрхангай, Сагил, Тариалан, Түргэн, Хяргас, Цагаанхайрхан **Их:** Бөхмөрөн, Тэс, Улаангом
18.	Ховд	3.4	5.4	3.4	5.4	Алтай, Булган, Мөст, Үенч
19.	Хөвсгөл	6.62	5	4	8.2	Цэцэрлэг, Ренчинлхүмбэ, Цагаан-Үүр, Шинэ-Идэр, Баянзүрх, Жаргалан, Бүрэнтогтох, Галт, Улаан-Уул, Цагаан-Уул, Цагааннуур
20.	Хэнтий	7	5.84	5.6	7.3	Галшар, Баянмөнх, Дархан
Дундаж:		**6.8**	**5.9**	**4.6**	**8.04**	

ДОРНОД АЙМАГТ 2021-2022 ОНД БҮРТГЭГДСЭН ҮХРИЙН АРЬС ТОВРУУТАХ ӨВЧНИЙГ СУДАЛСАН ДҮН

STUDY RESULTS ON LUMPY SKIN DISEASE IN CATTLE REPORTED IN DORNOD PROVINCE DURING 2021–2022

М.Мөнгөнбаръяа
Дотоод хэргийн их сургуулийн магистрант, хошууч
Mungunbariya M.
MA scholar, major, University of Internal Affairs
Н.Батсайхан
Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургуулийн захирал, доктор (Ph.D), дэд профессор, хурандаа
Col. Batsaikhan N.
Assoc.Prof, Ph.D, Director, Colonel, School of Emergency Management, University of Internal Affairs

*хариуцлагатай зохиогч: batsaikhan.N@uia.gov.mn

Хураангуй: Үхрийн арьс товруутах өвчин нь Capripoxvirus-ын төрөлд хамаарах ДНХ агуулсан вирусээр үүсгэгддэг. Сүүлийн жилүүдэд Зүүн Өмнөд Азийн улс орнуудад эрчимтэй тархаж байна.

Манай улсад 2021 онд Зүүн бүсийн 3 аймагт уг өвчин анх бүртгэгдсэн. 2021-2022 онд нийт 4899 үхэр 6-11 дүгээр сард өвчлөл бүртгэгдсэнээс 3730 (76.1%) үхэр 7-8 дугаар сард өвчилсөн байна. Үхрийн арьс товруутах өвчин (ҮАТӨ)-ний дайралтын түвшин (өрх) дундаж 8.2% байна. Бидний судалгаагаар уг өвчинд гадна худаг, горхи, нуур цөөрмөөс усалдаг мал илүү ихээр өвчилж байгаа нь бусад улсад хийсэн зарим судалгааны дүнтэй адил байна. Газар зүйн байршлаар эрсдэлийг тооцоход Дорнод аймгийн хойд хэсгээр буюу Баяндун, Баян-Уул, Цагаан-Овоо, Сэргэлэн, Гурванзагал сумын нутгаар өндөр эрсдэлтэй байна.

Түүнчлэн уг өвчин нь зун, намрын улиралд ялаа, шумуулын нислэгийн үетэй давхцан дэгдэж байгаа нь халдварын тархалт нисдэг төрлийн шавжаар дамждаг гэсэн таамаглалыг дэвшүүлж, тоон болон чанарын судалгаанд тулгуурлан үр дүнг боловсруулаа.

Abstract: Lumpy Skin Disease (LSD) is caused by a DNA virus belonging to the genus Capripoxvirus. In recent years, the disease has spread rapidly across countries in Southeast Asia.

In 2021, the disease was first reported in three eastern provinces of Mongolia. During the period of 2021–2022, a total of 4,899 cattle were affected between June and November, of which 3,730 cases (76.1%) occurred during July and August. The average household-level attack rate of LSD was 8.2%.

Our study revealed that cattle drinking water from open sources such as wells, streams, ponds, and lakes were more likely to be infected, which is consistent with findings reported in other countries.

Based on the geographical risk assessment, the northern part of Dornod Province—particularly the Bayandun, Bayan-Uul, Tsagaan-Ovoo, Sergelen, and Gurvanzagal soums—was identified as a high-risk area.

Furthermore, the disease coincided with the peak season of fly and mosquito activity during summer and autumn, suggesting that mechanical transmission by biting insects may play a significant role in the spread of the virus. The results were derived from both quantitative and qualitative analyses.

Түлхүүр үг: Үхрийн арьс товруутах, аймгууд, шинж тэмдэг, эрсдэлт хүчин зүйлс
Key words: lumpy skin disease, provinces, symptoms, risk factors

This article is published under the Creative Commons BY-NC-SA License by 4.0, ©2025 University of Internal Affairs, Mongolia

Үндэслэл

Үхрийн арьс товруутах өвчин (ҮАТӨ) нь анх 1929 онд Африк тивийн Замби улсад оношлогдсон бөгөөд өнөөдрийн байдлаар Африк, Европ, Зүүн өмнөд Ази, Дундад Ази, Төв Азийн улс орнуудад эрчимтэй тархаж буй халдварт өвчин юм. Энэхүү өвчин нь Монгол Улстай хил залгаа Оросын Холбооны Улс (ОХУ), Бүгд Найрамдах Хятад Ард Улсад (БНХАУ) сүүлийн жилүүдэд тогтмол бүртгэгдэж байгаа нь манай улсын халдвар авах эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Монгол Улсад ҮАТӨ анх 2021 онд Дорнод аймагт оношлогдсон бөгөөд 2022 онд Булган, Увс аймагт шинээр илэрсэн. Эдгээр аймгууд нь ОХУ-тай хил залгаа бөгөөд халдварын тархалтад хил орчмын нөхцөл байдал, хортон шавьж дамжуулагчдын нөлөө байх боломжтойг үгүйсгэхгүй юм.

Судалгааны явцад Увс аймгийн Давст суманд 2022 онд бүртгэгдсэн тохиолдол нь үхэрт эмнэл зүйн шинж тэмдэг бүдэг илэрсэн бөгөөд тухайн жил бороо хур элбэг ялаа, шумуул зэрэг цус сорогч шавьжийн тоо өмнөх оноос эрс нэмэгдсэн талаар малчид мэдээлжээ. Үүнтэй адил 2021 онд Дорнод аймагт өвчин анх бүртгэгдэх үед мөн бороо хур элбэг байсан нь шавьжийн өсөлт, идэвхжилд эерэгээр нөлөөлсөн байх магадлалтай.

2022 оны халдварын нөхцөл байдлаас харахад Дорнод аймагт өвчний тархалт хамгийн өндөр байсан бол Увс болон Булган аймгуудад гарсан тохиолдлууд харьцангуй цөөн байв. Эдгээр аймагт халдварын анхны тохиолдол илэрмэгц малын шилжилт хөдөлгөөнийг хориглох, өвчилсөн мал сүргийг устгах зэрэг хариу арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлсний үр дүнд тархалтыг хязгаарлаж чадсан.

ҮАТӨ нь одоогоор бүрэн судлагдаагүй өвчний тоонд хамаарах бөгөөд түүний эмнэл зүйн шинж тэмдэг, халдвар дамжих зам, урьдчилан сэргийлэх болон тэмцэх стратеги, арга хэмжээний талаар эрдэмтэн, судлаачдын дунд тодорхой ойлголт хараахан бүрдээгүй байна.

Үхрийн арьс товруутах өвчний гаралт, тархалтын эрсдлийг тооцох зорилгоор тархвар зүйн онцлог, тархалтын түвшин, газарзүйн байршлын ялгаа, эрсдэлт бүс нутгийг тааамаглах, шумуулын тархалтыг тогтоох, өвчний эрсдэлт хүчин зүйлсийг тодорхойлж, урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээг оновчтой төлөвлөх боломжийг бүрдүүлэх зорилгоор энэхүү судалгааг гүйцэтгэлээ.

Арга зүй

Мал эмнэлгийн ерөнхий газрын малын өвчлөлийн мэдээ, орон нутгаас ирүүлсэн тайлан, Мал эмнэлгийн нэгдсэн системд бүртгэгдсэн дархлаажуулалтын үр дүн зэрэг мэдээллийн эх үүсвэрийг цуглуулж, Ms Excel хэрэглээний программ дээр нэгтгэж, дутуу, алдаатай өгөгдлийг цэвэрлэж, дахин нягтлах замаар мэдээллийн санг боловсруулж тархвар зүйн бичиглэл судалгааны аргаар дээрх хэрэглээний программаар график, хүснэгтэн мэдээлэлд хөрвүүлж, дүн шинжилгээ хийв. Мэдээллийн санг ашиглаж ArcGIS программаар газар зүйн зураглал гаргав.

Тархалтыг тооцохдоо дараах томьёогоор тооцсон.

$$Т = \frac{\text{тухайн аймагт ҮАТ өвчний шинж тэмдэг илэрсэн малын тоо}}{\text{Аймгийн нийт мэдрэмтгий малын тоо}}$$

Дайралтын түвшин тооцохдоо дараах томьёогоор тооцсон.

$$ДТ = \frac{\text{Тухайн өрхөд өвчний шинж тэмдэг илэрсэн малын тоо}}{\text{Тухайн өрхийн мэдрэмтгий малын тоо}}$$

Үр дүн

Дорнод аймгийн Чулуунхороот сумын Эрээнцав багт 2021 оны 8 дугаар сарын 21-ний өдөр үхрийн арьс товруутах өвчний анхны тохиолдол илэрч, УМЭАЦТЛ-ийн 8 дугаар сарын 26-ны өдрийн шинжилгээний дүнд үндэслэн Монгол Улсад уг халдвар анх удаа оношлогдсон болохыг тогтоосон.

Нийт 3 аймгийн 21 сумын 889 өрхийн 4,899 толгой үхэр үхрийн арьс товруутах өвчний ил шинж тэмдгээр өвчилсөн. 4,428 толгой үхрийг устгалд хамруулсан.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 302 дугаар тогтоолоор “Монгол Улсын нутаг дэвсгэрт оношлогдсон Мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний олон улсын худалдаанд хориг саад үүсгэдэг гоц халдварт, халдварт өвчин, хүний амь нас хохирох эрсдэл үүсгэдэг зооноз өвчний жагсаалт”-д “үхрийн арьс товруутах өвчин”-ийг оруулсан.

ҮАТӨ-өөр нийт 4899 толгой үхэр өвчилж 471 (9%) толгой үхэр хорогдсон байна. Тархвар зүйн хувьд 6-11 дүгээр сард өвчлөл бүртгэгдсэн нь урин дулаан цагт ялаа, шумуулын нислэгийн үетэй давхцаж байна. (График 1)





График 1: Үхрийн арьс товруутах өвчний тархвар зүйн муруй


Өвчлөл 6 дугаар сард 76 (1.6%), 7 дугаар сард 424 (8.7%), 8 дугаар сард 1,645 (33.6%), 9 дүгээр сард 2,085 (42.6%), 10 дугаар сард 568 (11.6%), 11 дүгээр сард 101 (2.1%) толгой мал өвчилсөн бөгөөд 3730 (76.1%) үхэр 7-8 дугаар сард өвчилсөн байна. (Зураг 1)



Зураг 1: ҮАТӨ бүтгэгдсэн байршил сараар

ҮАТӨ-ний дайралтын түвшинт сумаар харьцуулж үзэхэд гол, мөрөн, нуур ихтэй сумдад илүү өндөр байна. (Зураг 2)

ҮАТӨ-ний дайралтын түвшин (өрх) дундаж 8.2% байна.



Зураг 2: ҮАТӨ-ний Дайралтын түвшин сумаар

Монгол орны халдварт өвчин дамжуулагч шумуулын судалгааны тойм

Халдварт өвчин дамжуулагч шумуулын судлагдсан байдал: 1980 оноос хойш шумуулын экологийн талаар системтэй судалсан судалгаа байхгүй байна. Монгол оронд хийгдсэн судалгаагаар Монгол орны шумуулын талаарх судалгааг Чехийн эрдэмтэн И.Минор, (1976); манай эрдэмтэд Оюунсүрэн, (1968); Д.Галбадрах, (1966) нар 4 төрлийн 22 зүйлийн шумуул тархсан болохыг тогтоосон байна (Галбадрах & Абмэд, 2014).

Хүн, мал эмнэлгийн салбар дундын хамтын Зооноз өвчин судлалын үндэсний төв, Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторитой хамтарсан судалгаагаар Увс, Сэлэнгэ, Дорнод, Ховд, Улаанбаатар зэрэг аймаг нийслэлээс шумуул түүвэрлэн зүйлийн бүрдлийг тодорхойлох, шумуулаар дамжин тархах боломжтой өвчний шинжилгээг хийж гүйцэтгэсэн. Нийт 3613 шумуулд молекул биологийн шинжилгээ хийхэд 11.1%-д вирусийн уургийн ген илэрсэн ба Сэлэнгэ аймгийн Сүхбаатар, Хүдэр, Ерөө, Дорнод аймгийн Халхгол сумдын нутгаас Баруун Нилийн чичрэг өвчний вирусийн уургийн ген, Дорнод аймгийн Халхгол, Матад, Хэрлэн сумдын нутгаас цуглуулсан шумуулд Денге өвчний вирусийн уургийн ген тус тус тодорхойлогдов. Бидний түүвэрлэсэн шумуулын 95.5-ийг Aedes төрлийн шумуул эзэлж, зонхилогч төрлийн үүргийг гүйцэтгэж байна. (Хүснэгт 1)


Шумуулын төрөл	Увс (n=131)	Сэлэнгэ (n=618)	Дорнод (n=1073)	Ховд (n=1640)	Улаанбаатар (n=151)	Нийт (N=3613)
Aedes	101 (77.1%)	487 (78.8%)	951 (88.6%)	1640 (100%)	124 (82.1%)	3451 (95.5%)
Culex	30 (22.9%)	130 (21%)	122 (11.3%)		27 (17.9%)	160 (4.4%)
Anopheles	-	1 (0.1%)	1 (0.1%)			2 (0.05%)

Хүснэгт 1. Шумуулын төрлийг тогтоосон дүн N=3613

Судалгаанд хамрагдсан газар нутагт *Aedes dorsalis*, *Aedes intrudens* зүйлийн шумуул дийлэнх буюу 73.1%-г эзэлж байна. Сэлэнгэ, Дорнод аймгийн нутгаас Хумхаа өвчнийг дамжуулагч *Anopheles maculipennis* зүйлийн шумуулын тархалт тэмдэглэгдэв (Хүснэгт 2).

Шумуулын төрөл зүйл	Увс n=131 (25%)	Сэлэнгэ n=61 (12%)	Дорнод n=122 (23.2%)	Ховд n=160 (30.4%)	Улаанбаатар n=51 (9.7%)	Нийт N=525
Aedes Pullatus	-	-	-	11	20	31 (5.9%)
Aedes intrudens	65	-	46	20	-	131(25%)
Aedes dorsalis	66	28	42	117	-	253(48%)
Culex vagans	-	-	33	12	-	45 (8.6%)
Culex modestus	-	32	-	-	31	63 (12%)
Anopheles maculipennis	-	1	-	-	-	1 (0.9%)
Anopheles spp.	-	-	1	-	-	1 (0.9%)
Нийт	131	61	122	160	51	525

Хүснэгт 2. Шумуулын зүйлийг тогтоосон дүн (n=525)



Зураг 3: Aedes dorsalis (Meigen, 1830)зүйлийн Монгол дах тархалт

Шумуул нь нар үзэхгүй харанхуй газар, бут сөөгт нуугдах бөгөөд зохиомол гэрэлтүүлгээс үргэдэггүй ба хар өнгөнд мэдрэмтгий бөгөөд хооллохдоо эзэн амьтнаа түүний ялгарч байгаа нүүрсхүчлийн хий, хөлсний болон содон үнэрээр олдог.Цус сорж хооллох нь шумуулын амьдралын зайлшгүй хэрэгцээт идэш болно. Эмэгчин шумуул нь цус сорохдоо амны аппаратын хатгагч хэсэг нь хүн ба амьтны биед шигтгэн хооллодог. Эр эм шумуул нь амьдралын явцад нэг л удаа эвцэлддэг. Үүний дараа эм нь цус сорж хооллон өндгөө боловсруулдаг. Зарим эмэгчин шумуул 1 удаа хооллохдоо 2 минутын турш 0,3 мл цус сорж, цус соролтын хэмжээнээс шалтгаалж 120-150 өндөг гаргана. Үдэш шөнийн цагаар өндгөө цэнгэг усны гадаргууд гаргана. Бие гүйцсэн эм шумуул 7-28 өдөр амьдрах чадвартай. Шумуул нь харанхуй бүрийд хазах хүнээ олох ба урд хоёр хөлийн хооронд байрлах маш мэдрэмтгий дулааныг мэдрэгчийн тусламжтайгаар олно. Үүнийхээ тусламжтайгаар халуун цустай биетийг,

мөн хамгийн халуун цус биеийн аль хэсэгт байна гэдгийг олж мэдэж чаддаг байна.

Шумуулын амьдрах орчин, үржлийн гол байршил нь гол, нуур бөгөөд Дорнод аймгийн шумуулын тархалтыг гол, нууранаас 10 км радиусаар тооцож тархалтыг тооцоолов. (Зураг 4)




Зураг 4: Шумуулын тархалтын таамаглал

Үхрийн тоо толгойн өгөгдлийг 20%, ҮАТӨ-ний өвчний өгөгдлийг 20% Дамжуулагчийн тархалтыг 40% авто замын сүлжээг 20% байхаар тооцож эрсдэлтэй бүс нутгийг тодорхойлсон.

Эрсдэлийн зураглал гаргахад шаардлагатай Үхрийн тоо толгойн тархалт, худаг, гол мөрөн уст цэгийн байршил, шүлхий өвчин бүртгэгдсэн байршил, авто замын сүлжээний орон зайн өгөгдлийг тоон өгөгдөлд хөрвүүлж, ҮАТӨ-ны тархалтад

Үхрийн тоо толгойн өгөгдлийг 20%, ҮАТӨ-ний өвчний өгөгдлийг 20% Дамжуулагчийн тархалтыг 40% авто замын сүлжээг 20% байхаар тооцож эрсдэлтэй бүс нутгийг тодорхойлсон. (Зураг 5) Дорнод аймгийн Матад сумын зүүн хэсэг Халхгол сумын баруун хэсгээр ҮАТӨ-ний эрсдэл бага Баяндун, Баян-Уул, Цагаан-Овоо, Сэргэлэн, Гурванзагал сумын нутаг буюу Дорнод аймгийн хойд хэсгээр өндөр эрсдэлтэй байна.



Зураг 5: ҮАТӨ-ний эрсдэлийн зураг

Шүүн хэлэлцэхүй

Бидний судалгаагаар уг өвчинд гадна худаг, горхи, нуур цөөрмөөс усалдаг мал илүү ихээр өвчилж байгаа нь бусад улсад хийсэн зарим судалгааны дүнтэй адил байна.

Бидний судалгааны ажлын үр дүнд Дорнод аймагт уг өвчний халдварлалт өндөр байсан. Дорнод аймагт 2021 онд уг өвчин анх удаа оношлогдож, 8-11 дүгээр сар хүртэл үргэлжлэв. Тухайн үед бид өвчилсөн бүх үхрийг устгасан боловч энэ өвчин 2022 онд Дорнод аймагт дахин сэргэлээ. Үүнээс харахад уг өвчний үүсгэгч хатаад унасан гүвдрүүнд хадгалагдаж хүйтний улиралд малын өтөг бууц зэрэгт удаан хугацааны турш вирусийн идэвхээ хадгалж, урин дулааны улиралд ялаа, шумуулын идэвхжил ихсэх үеэр дахин тархаж байж болзошгүй юм. Учир нь Capripoxvirus нь ДНХ агуулсан вирус тул гадаад орчинд маш тэсвэртэй бөгөөд хатаж унасан арьсны гүвдрүү товруу, малын шивтэр бууц зэрэг нарны тусгал тусахгүй газарт 3-6 сар хүртэл хадгалагдах боломжтой. Өвчлөл 2-45 хувьд хэлбэлзэнэ. Харин хорогдол ихэвчлэн 10 хувиас бага байна.

Дүгнэлт

1. YATӨ-өөр нийт 4899 толгой үхэр өвчилж 471(9%) толгой үхэр хорогдсон байна. YATӨ-ний тохиолдол ялаа, шумуулын нислэгийн үетэй давхцаж байна.

2. Aedes dorsalis, Aedes intrudens зүйлийн шумуул дийлэнх буюу 73.1%-г эзэлж байна.

3. YATӨ-ний дайралтын түвшин (өрх) дундаж 8.2% байна.

4. Дорнод аймгийн Матад сумын зүүн хэсэг Халхгол сумын баруун хэсгээр YATӨ-ний эрсдэл бага Баяндун, Баян-Уул, Цагаан-Овоо, Сэргэлэн, Гурванзагал сумын нутаг буюу Дорнод аймгийн хойд хэсгээр өндөр эрсдэлтэй байна.

Ашигласан материал

• Lumpy skin disease – A field manual for veterinarians, 2017 (En, Ru**, Sq**, Sr**, Tr**)

• Beard, P. M. (2016). Lumpy skin disease: A direct threat to Europe. Veterinary Record, 178(22), 557–558. https://doi.org/10.1136/vr.i2800

• Chihota, C. M., Rennie, L. F., Kitching, R. P., & Mellor, P. S. (2001). Mechanical transmission of lumpy skin disease virus by Aedes. Epidemiology and Infection, 126, 317–321.

• Hamdi, J., Munyanduki, H., Tadlaoui, K. O., Harrak, M. El, & Fihri, O. F. (2021). Capripoxvirus infections in ruminants: A review. Microorganisms, 9(5), 1–16. https://doi.org/10.3390/microorganisms9050902

• Kiplagat, S. K., Kitala, P. M., Onono, J. O., Beard, P. M., & Lyons, N. A. (2020). Risk factors for outbreaks of Lumpy skin disease and the economic impact in cattle farms of Nakuru county, Kenya. Frontiers in Veterinary Science, 7(May). https://doi.org/10.3389/fvets.2020.00259

• Odonchimeg, M., Erdenechimeg, D., Tuvshinbayar, A., Tsogtgerel, M., Bazarragchaa, E., Ulaankhuu, A., Selenge, T., Munkherel, D., Munkhtsetseg, A., Altanchimeg, A., Odbileg, R., Soyolmaa, G., Enkhmandakh, Y., Batmagnai, E., Sugar, S., Kimura, T., Sugimoto, C., Isoda, N., Batsukh, B., & Yoshihiro, S. (2022). Molecular identification and risk factor analysis of the first Lumpy skin disease outbreak in cattle in Mongolia. Journal of Veterinary Medical Science, 1244–1252. https://doi.org/10.1292/jvms.22-0250

• Roche, X., Rozstalnyy, A., TagoPacheco, D., Kamate, A., Pittiglio, C., Alcrudo, D, B., Bisht, K., Karki, S., Kayamori, J., Larfaoui, F., Raizmen, E., VonDobschuetz, S., Dhingra, M, S., & Sumption, K. (2020). Introduction and spread of lumpy skin disease in South, East and Southeast Asia. In Introduction and spread of lumpy skin disease in South, East and Southeast Asia. FAO. https://doi.org/10.4060/cb1892en

• Tuppurainen, E. S. M., Venter, E. H., & Coetzer, J. A. W. (2005). The detection of lumpy skin disease virus in samples of experimentally infected cattle using different diagnostic techniques. Onderstepoort Journal of Veterinary Research, 72(2), 153–164. https://doi.org/10.4102/ojvr.v72i2.213

• Tuppurainen, E. S. M., Venter, E. H., Shisler, J. L., Gari, G., Mekonnen, G. A., Juleff, N., Lyons, N. A., De Clercq, K., Upton, C., Bowden, T. R., Babiuk, S., & Babiuk, L. A. (2017). Review: Capripoxvirus diseases: Current status and opportunities for control. Transboundary and Emerging Diseases, 64(3), 729–745. https://doi.org/10.1111/tbed.12444

• Zan, X., Huang, H., Guo, Y., Di, D., Fu, C., Wang, S., Wu, Y., Wang, J., Wang, Y., Ma, Y., Chai, C., Su, R., Song, Q., & Wang, W. (2022). Molecular characterization of a novel subgenotype of lumpy skin disease virus strain isolated in Inner Mongolia of China. BMC Veterinary Research, 1–9. https://doi.org/10.1186/s12917-022-03383-5

• http://www.who.int/malaria/media/world-malaria-report-2015/en/

• Галбадрах Д., Абмэд., Д. 2014 Монгол орны шумуулын зүйлийн бүрэлдэхүүн эпидемиологийн холбогдол. “Халдварт өвчин судлал” сэтгүүл, УБ., №2, х.46-50

• Цэндсүрэн А., Намхайдорж Б., Чогсомжав Л., Пунцагдулам Ж., Тэгшжаргал Д., Улыкпан К., Мягмарсүрэн Д. 1987. Шавьжийн анги. *БНМАУ-ын амьтны аймаг 1-р боть.* х. 22-24.

• Мягмаржав Б., Даваа Г., 1999. Монгол орны гадаргын ус. Улаанбаатар интерпресс компани. х.350.

• Нямдаваа Д., 2007 Бүтээлийн товчоон, IV боть “Вирүс судлалын шинжилгээний аргууд ” УБ.

ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

ANALYSIS OF THE EARTHQUAKE DISASTER PROTECTION PLAN

Г.Батмөнх
Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн магистрант, дэд хурандаа
Batmunkh.G
Graduate student at the Institute of Management Academy, the University of Internal Affairs, lieutenant colonel

*хариуцлагатай зохиогч: Batmunkh.G@gmail.com

Хураангуй. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний өнөөгийн байдлаар гамшгийн нөхцөл байдал, тэр тусмаа газар хөдлөлтийн гамшгийн үед иргэдийн эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгийг аврах, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах үндэс бол харилцан ажиллагааг зөв оновчтой зохион байгуулснаар хэмжигдэнэ. Ялангуяа гамшгийн хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг явуулах үед бусад хүч хэрэгслийг татан оролцуулах, тэднийг хэн удирдах, хаана байрлуулах, мэдээлэл хэрхэн дамжуулах гэх мэт харилцан ажиллагааны олон асуудлууд үүсэх бөгөөд эдгээрийг зөв оновчтой төлөвлөж харилцан ажиллагааг амжилттай зохион байгуулснаар хүч хэрэгслийг шуурхай хуваарилах, цаг хугацаа хэмнэх, хор уршгийг богино хугацаанд арилгах, хохирол багатайгаар даван туулах ач холбогдолтой билээ.

Энэхүү илтгэлээр гамшгаас хамгаалах төлөвлөгөөний түүхэн хөгжил, эрх зүйн баримт бичиг, гамшгаас хамгаалах үйл ажиллагааны үе шат, гамшгаас хамгаалах төлөвлөгөөний боловсруулалт болон Олон улсын туршлагыг харьцуулан судалж үзэхэд манай улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар, загвар нь хэрэглэхэд хялбар ойлгомжтой байгаа бөгөөд энэхүү төлөвлөгөө нь бүх шатанд цаас төдий хэрэгжилт хангалтгүй гэсэн ойлголт төрж байна. Мөн гамшгийн өмнөх үе шатанд бэлэн байдлыг хангах үйл ажиллагааны хүрээнд бүх шатны гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангиуд бэлэн байдлыг хангах, эрсдэлийг бууруулах арга хэмжээ тусгасан ч санхүүгийн асуудал тулгарч байгаа нь ихээхэн сөргөөр нөлөөлж байна. Иймд Олон улсын туршлага сургамжид үндэслэн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний оролцооны зарчмыг баримтлан гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, эрсдэлийг бууруулах төлөвлөлтийг тухайн орон нутгийн гамшгийн эрсдэлийн үнэлгээнд суурилсан оновчтой боловсруулахад үр дүнтэй төлөвлөгөө болно гэж үзэж байна.

Abstract. The current state of disaster management planning is that the basis for effectively organizing disaster management activities, especially in the event of an earthquake, to save the health, lives, and property of citizens, and to eliminate the consequences of a disaster, is measured by the proper and rational organization of interaction. In particular, when eliminating the consequences of a disaster and carrying out urgent reconstruction operations, many interaction issues arise, such as involving other forces, who will control them, where they will be located, how to transmit information, etc. By properly planning and successfully organizing these interactions, it is important to quickly allocate people, forces, and equipment, save time, eliminate the consequences in a short time, and overcome the damage with minimal damage.

This report compares the historical development of disaster management plans, legal documents, disaster management activity stages, disaster management plan development, and international experience. It is clear that the guidelines and models for developing our country's disaster management plans are easy to use and understand, and that this plan is not only paper-based but also insufficiently implemented at all stages. Also, in the pre-disaster phase, disaster management departments and professional units at all levels have included measures to ensure preparedness and reduce risks, but financial problems are having a significant negative impact. Therefore, based on international experience and lessons learned, it is believed that the disaster

This article is published under the Creative Commons BY-NC-SA License by 4.0, ©2025 University of Internal Affairs, Mongolia

management plan, based on the participatory principle, will be an effective plan for the rational development of disaster prevention, preparedness, and risk reduction planning based on local disaster risk assessment.

Түлхүүр үг. Төлөвлөгөө, байгууллага, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги.
Key words. Plans, organizations, disaster relief services, and professional classes.

Оршил. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны оновчтой, тодорхой бодлогыг боловсруулж, хөгжлийн чиг хандлага, зорилго, зорилтыг зөв тодорхойлох нь нийгэм, эдийн засгийн хөгжлийн янз бүрийн түвшинд, газар хөдлөлтийн гамшгийн ээдрээ төвөгтэй нөхцөлд гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлага, төлөвлөгөөг оновчтой явуулах боломжийг бүрдүүлдэг.

Байгалийн болон хүний үйл ажиллагаатай холбоотой аюулт үзэгдэл, ослын нөхцөл байдал, цаашдын төлөв, шинж чанарын талаар нарийвчлан судлах, гамшгийн эрсдэлийг үнэлэх, үүний үндсэн дээр болзошгүй гамшиг, осолтой тэмцэх чадавхыг дээшлүүлэх, гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлтгэл, бэлэн байдлыг хангах, гамшгаас хамгаалах үйл ажиллагаа, түүний удирдлагыг боловсронгуй болгоход чиглэсэн тодорхой бодлогыг боловсруулах хэрэгтэй.

Манай улсад сүүлийн 10 жилд тохиолдсон гамшгийн статистикаас харахад жилд дунджаар 3200 орчим аюулт үзэгдэл, осол тохиолдож, 180 гаруй хүн амь насаа алдаж, 110 орчим тэрбум төгрөгийн хохирол учирч байна.

Улаанбаатар хотын бүс нутгийн орчимд сүүлийн 10 жилийн хугацаанд магнитуд нь 3.5 болон түүнээс их хүчтэй газар хөдлөлт 13 удаа болсон байна. 2024 онд Улаанбаатар хот орчмын бүс нутагт нийт 447 удаагийн газар хөдлөлтийн чичирхийлэл болсон судалгаа гарсан. Газар хөдлөлтийн давтамж, чичирхийлэлийн тоо жил ирэх тусам нэмэгдэж байгаа нь бэлэн байдлыг хангах, хэрхэн ажиллах төлөвлөгөөг урьдчилан хийх шаардлагатай болж байна.

Зорилго. Сүүлийн жилүүдэд уур амьсгалын өөрчлөлт, хүний буруутай үйл ажиллагааны улмаас томоохон хэмжээний цаг агаар, геологи, биологийн гаралтай аюулт үзэгдэл, ослын төрөл, тоо, давтамж жилээс жилд өсөн нэмэгдэж байгаа өнөө үед гамшигт тэсвэртэй хот суурин, хүрээлэн буй орчныг цогцлоох, гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, сэргээн босгох, хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангах нөхцөл байдал зайлшгүй тулгарч байна. Иймд гамшгаас хамгаалах төлөвлөгөө, Олон улсын туршлага сургамжийг харьцуулан судалж, гамшгаас хамгаалах төлөвлөгөөг сайжруулах арга замыг тодорхойлоход оршино.

Үндсэн хэсэг /арга зүй/. Төлөвлөлт бол өнөөгийн байдлаас хүрэх гэж хүсч буй байдал хоёрыг холбогч гүүр гэж олонх судлаачид үзжээ. Тэгвэл төлөвлөгөө зохиох хариуцлагыг менежерүүд хүлээдэг. Төлөвлөлт бол аливаа байгууллага өмнөө тавьсан зорилгодоо хамгийн хэмнэлттэй ямар арга замаар хүрэх вэ гэдгийг шийдвэрлэх үйл явц юм. Харин төлөвлөгөө нь тэрхүү үйл явцыг удирдан зохион байгуулж буй субъектийн гаргасан шийдвэрүүдийг тусгасан албан ёсны баримт бичиг (Цэдэв П., 2018, хууд. 15) юм.

Мөн үүссэн нөхцөл байдалд үйл ажиллагаагааг оновчтой төлөвлөхийн тулд төлөвлөлтийн үйл явцыг сайтар судалж танин мэдэх нь зүйтэй. Тооцооны үндсэн дээр нөөцөд тулгуурлан, зорилгод уялдуулан гүйцэтгэж байгаа үйл ажиллагааны ерөнхий төлөв планыг төлөвлөлт гэж болно (Цэдэв П., 2018). Төлөвлөлтийн асуудлыг авч үзэхдээ төлөвлөлт, төлөвлөгөө гэсэн үндсэн ойлголтыг ялган ойлгох шаардлагатай. Өөрөөр хэлбэл төлөвлөлт нь цаг хугацаа, тооцоолол, бодомжийн шинж чанартай хүчин зүйл бөгөөд энэхүү бодомжийг зорилгын нэгэн адил бодит биелэгдэхүйц байдлаар тооцоолон цаасан дээр буулгасан бичиг баримтыг төлөвлөгөө гэж нэрлэнэ.

Энэ утгаараа төлөвлөгөө бол биелэгдэхүйц үйл ажиллагааг тусгасан баримт бичиг, байгууллагын үйл ажиллагааны чиглүүлэгч нь юм.

Энэ бүгдээс дүгнэн үзэхэд гамшгаас хамгаалах төлөвлөгөө гэж гамшгаас урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, хүмүүнлэгийн тусламжийг зохион байгуулах үйл ажиллагааг иж бүрнээр хэрэгжүүлэх бэлтгэл арга хэмжээг хэлнэ.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны бодлогыг тодорхойлоход анхаарах нэг гол онцлог бол газар хөдлөлийн гамшиг нь улс орныг төдийгүй бүс нутгийг, тив, дэлхийг хамарч болдгоос гадна гамшгаас хамгаалах үйл ажиллагаа нь улс орны тогтвортой хөгжил, хүн амын аюулгүй байдлыг хангах нэг үндсэн нөхцөл болдог явдал юм.

Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний түүхэн хөгжлийг тоймлон судалж үзэхэд анх Улсын Иргэний Хамгаалалтын газарт иргэний хамгаалалт төлөвлөгөө нэртэйгээр хийгдэж байсан. Улсын иргэний хамгаалалтын Төв Штаб Улсын иргэний хамгаалалтын оперативын болон улсын алба, аймаг, хот, сум, район /одоогийн дүүрэг/, яам, тусгай газар, объектын иргэний хамгаалалтын төлөвлөгөө боловсруулах ажлыг 1976 оны сүүлийн хагасаас эхэлж, дэс дараатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна. Төв штаб эхлээд төлөвлөгөө боловсруулах заавар гаргаж улсын алба, аймаг, хотуудад хүргэсэн ба 1977 оны эхний хагаст дээрх төлөвлөгөөнүүдийг үлгэрчилсэн загвар боловсруулж штабуудад өгснөөр тэд уг төлөвлөгөөг боловсруулахад хялбар дөхөм гарын авлагатай болсон байна. Төв штаб төлөвлөгөө боловсруулах ажлыг аргазүйн болон мэргэжлийн удирдлагаар байнга хангаж, аймаг, хотын иргэний хамгаалалтын штабын дарга нар, улсын албадын мэргэжилтнүүдийн цугларалтаар тодорхой аргачилсан хичээл зааж, семинар хийж, газар дээр нь очиж биечлэн туслалцаа үзүүлж ажилласны үр дүнд 1979 оны эхний хагас гэхэд улсын 14 алба, 18 аймаг, 3 хот, нийслэлийн төвийн 4 дүүрэг, Налайх хот төлөвлөгөөгөө боловсруулан батлуулж мөрджээ. Энэ хугацаанд 301 сум болон 50 гаруй сум эрхтэй хороо, орон нутгийн хотууд үндсэндээ төлөвлөгөөтэй болж, ийнхүү төлөвлөгөө боловсруулах ажлыг 1967 оноос эхэлсэн түүхтэй (Дамдин П, 2017, хууд. 71).

Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг нарийвчлан боловсруулах, 2003 онд Гамшгаас хамгаалах тухай шинээр батлагдсан хуулийн заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Гамшгаас хамгаалах ерөнхий газрын даргын 2004 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 354 дүгээр тушаалаар “Аймаг, нийслэл, сум, дүүргийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний нийтлэг загвар, хэрэглэх зааврыг тус тус баталсан байна. Энэ нь гамшгаас хамгаалах төлөвлөгөөний бүтэц агуулгыг тодорхойлон гаргасан байна.

Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний эрх зүйн зохицуулалтыг судлахад:

Гамшгаас хамгаалах үндэсний чадавхыг бэхжүүлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр “Гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх үндэсний хөтөлбөр (2015-2025)”, “Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр (2015-2025)”, “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги (2015-2030)” зэрэг гамшгаас хамгаалах үйл ажилагааны бодлого стратегийг тодорхойлсон баримт бичгийг батлан хэрэгжүүлж, улс орны аюулгүй байдал, тогтвортой хөгжлийг хангахад хувь нэмрээ оруулж ирсэн нь одоог хүртэл даган мөрдөж байна.

Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх талаар Гамшгаас хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах алба, хуулийн этгээд гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй байна”. Мөн зүйлийн 8.2-т “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө нь гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах,

хойшлуулшгүй сэргээн босгох, хүмүүнлэгийн тусламжийг зохион байгуулах удирдлагын баримт бичиг байна", 8.3-т "Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар, аргачлалыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална (Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, 2017)" гэж тус тус заасан.

Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 120 дугаар тушаалаар "Аймаг, нийслэл, сум, дүүрэг, гамшгаас хамгаалах алба, аж ахуйн нэгж байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар", Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2019 оны А/388 дугаар тушаалаар "Аймаг, нийслэл, сум, дүүргийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах үлгэрчилсэн загвар" тус тус батлагдсан.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа гэж гамшгаас урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэхийг хэлнэ (Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, 2017).

Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд дараахь зарчмыг баримтална. Үүнд:

1. хүмүүнлэг, шуурхай, ил тод, хариуцлагатай байх;
2. мэргэжлийн нэгдмэл удирдлагатай байх;
3. шинжлэх ухаан, дэвшилтэт техник, технологи, инновацид тулгуурласан байх;
4. өмчийн хэлбэрийг үл харгалзах;
5. иргэдийн оролцоонд тулгуурлах.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа нь гамшгийн өмнөх, гамшгийн үе, гамшгийн дараах буюу хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаа гэсэн үе шаттай байна.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны үе шатуудад хэрэгжүүлэх арга хэмжээг Хүснэгт 1-д үзүүллээ.

1. Гамшгийн өмнөх үйл ажиллагаа		
1	Гамшгийн эрсдэлийг үнэлэх	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд нь өмчийн хэлбэрийг үл харгалзан гамшгийн эрсдэлийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ хийнэ.
	Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах алба, хуулийн этгээд гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй байна. Гамшгаас хамгаалах төлөвлөгөө нь гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, хүмүүнлэгийн тусламжийг зохион байгуулах удирдлагын баримт бичиг байна.
	Гамшгийн эрсдэлийг бууруулах	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, байгууллага, хуулийн этгээд дараахь арга хэмжээг авна. Үүнд: -болзошгүй гамшгийн шалтгаан, нөхцөлийг арилгах; -барилга байгууламж, сургууль, цэцэрлэг, эмнэлэг зэрэг улс, орон нутгийн төсөвт байгууллага, үйлдвэр, үйлчилгээний байгууллагын аюулгүй байдлын шаардлага, стандартыг хангах; -гамшгийн эрсдэлийг бууруулах бүтцийн болон бүтцийн бус арга хэмжээг хэрэгжүүлэх; -гамшигтай тэмцэх чадавхыг нэмэгдүүлэх; -хөгжлийн бодлогын төлөвлөлтөд гамшгийн эрсдэлийг тооцох.
	Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах	Гамшгаас хамгаалах бэлэн байдал нь дараах зэрэгтэй байна. Үүнд: 1. Өдөр тутмын бэлэн байдал; (гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах; харилцаа холбоо, зарлан мэдээлэх хэрэгслийн бэлэн байдлыг хангах, тогтоосон дохиогоор ажиллах арга, ажиллагаанд хүн амыг сургаж дадлагажуулах; гамшгаас хамгаалах хүч хэрэгслийн бэлэн байдлыг хангах;

		гамшгаас хамгаалах хүч хэрэгслийн бэлэн байдлыг хангах; гамшгаас хамгаалах судалгаа, шинжилгээний мэдээллийг түгээх; гамшгийн болон орон нутгийн нөөц бүрдүүлэх; гамшгийн үед дайчлан гаргах хүч хэрэгслийн бүртгэл, тооцоог гаргах; салбар дундын төлөвлөгөө, мэдээ, мэдээлэл солилцох, хамтран ажиллах;) 2. Өндөржүүлсэн бэлэн байдал; (гамшгийн зарлан мэдээллийн дохиог хүн амд хүргэх, гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийх, хэрэгжүүлэх; засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг ажлын тусгай горимд шилжүүлэх; гамшгийн зарлан мэдээллийг хүн амд шуурхай, хүртээмжтэй хүргэх; хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоох, хүч хэрэгсэл, гамшгийн болон орон нутгийн нөөцийг дайчлах; гамшгийн нөөцийг улсын хэмжээнд Засгийн газрын шийдвэрээр, орон нутагт тухайн шатны Засаг даргын шийдвэрээр нэмэгдүүлэх; соёл урлаг, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулахыг хязгаарлах, цуцлах, хориглох; харилцаа холбоо, эрчим хүч, хүнс хангамж, шатахуун түгээх газар болон стратегийн зориулалттайгаас бусад худалдаа, үйлдвэрлэл, нийтийн үзвэр, үйлчилгээний газар, боловсролын байгууллагын үйл ажиллагааг бүрэн болон хэсэгчилсэн байдлаар түр зогсоох, хилийн боомтыг түр хаах, эсхүл түүгээр нэвтрэх хөдөлгөөнийг хязгаарлах; голомтын бүсээс хүн, мал, амьтан, эд хөрөнгийг түр нүүлгэн шилжүүлэх, нэрвэгдэгсдэд тусламж үзүүлэх, түр орон байр, хүнс тэжээлээр хангах арга хэмжээг зохион байгуулах; нийгэм-эдийн засгийн аюулгүй, тогтвортой байдал, хүн амын үйлчилгээний хэвийн нөхцөлийг хангахад чухал үүрэг бүхий хуулийн этгээдэд тусгай дэглэм тогтоож мөрдүүлэх; төрийн болон төрийн өмчит байгууллагын үүрэг, зориулалт, хөдөлмөрийн нөхцөл, ажлын цагийн хуваарийг тогтоосон хугацаагаар өөрчлөх; улсын онц чухал, төрийн тусгай хамгаалалтад байгаа болон стратегийн ач холбогдол бүхий объект, байгууллагын хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах шаардлагатай арга хэмжээг авах; стратегийн хүнс, бараа, бүтээгдэхүүний хомсдол, үнийн хөөрөгдөл болон нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох байгууллагад чиглэл болгох, хяналт тавих; олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон нийгмийн сүлжээн дэх гамшгийн тухай илт худал мэдээллийн тархалтыг бууруулах, зогсоох арга хэмжээг тухайн нөхцөлийн хэр хэмжээнд тохируулан тодорхой хүрээ, хугацаатайгаар авч хэрэгжүүлэх; эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх шийдвэр гаргах, хэрэгжилтийг хангуулах; гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдал үүссэн үед улсын хил хамгаалах байгууллага холбогдох байгууллагатай хамтран хилийн боомтод тусгай дэглэм тогтоож, мөрдүүлэх; химийн хорт болон аюултай бодис, ачаа тээвэрлэлтийг хязгаарлах, шаардлагатай тохиолдолд түр хугацаагаар зогсоох; зайлшгүй шаардлагатай тохиолдолд иргэн, байгууллага, хуулийн этгээдээс холбогдох мэдээллийг авах бөгөөд тухайн мэдээллийн нууцлалыг хадгалах, түүнчлэн гамшгаас хамгаалахаас бусад зорилгоор урвуулан ашиглахгүй байх;) 3. Бүх нийтийн бэлэн байдал; (дээрх 1,2 заасан арга хэмжээг бүхэлд нь хэрэгжүүлнэ.)
	Гамшгаас хамгаалах хяналтыг хэрэгжүүлэх	Гамшгаас хамгаалах хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, гамшгийн эрсдэлийн үнэлгээ, гамшгаас хамгаалах төлөвлөгөөний

		хэрэгжилтэд гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч хяналт тавина.
	Гамшгаас хамгаалах сургалт зохион байгуулах	Гамшгаас хамгаалах сургалт нь төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн албан тушаалтан, ажилтан болон иргэнийг сургаж дадлагажуулахад чиглэнэ. Гамшгаас хамгаалах сургалтыг дараахь ангиллаар явуулна. Үүнд: 1.Удирдах албан тушаалтны; 2.Онцгой байдлын байгууллагын; 3.Оюутан, сурагч, сургуульд элсэхийн өмнөх насны хүүхдийн; 4.Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн албан тушаалтан, ажилтны; 5.Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн; 6.Иргэний.
	Гамшгийн мэдээллийн сан бүрдүүлэх	Тохиолдсон гамшиг, аюулт үзэгдэл, ослын дүн мэдээг нэгтгэх, статистикийн мэдээллийг боловсруулах, гамшгаас хамгаалах судалгаа, шинжилгээ хийх, үр дүн, санал, зөвлөмжийг үйл ажиллагаандаа ашиглах, мэдээлэх, нийтийн хүртээл болгох, гамшгийн мэдээллийн санг бүрдүүлэх ажлыг улсын хэмжээнд онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ. Гамшгийн мэдээллийн сан дараахь мэдээллээс бүрдэнэ. Үүнд: 1.Гамшгийн эрсдэлтэй нутаг дэвсгэрийн газар зүйн мэдээлэл; 2.Гамшигт нэрвэгдэж болзошгүй хүн ам, дэд бүтцийн бүртгэл, мэдээлэл; 3.Гамшиг, аюулт үзэгдэл, ослын болон хохирлын дүн мэдээ; 4.Бусад мэдээлэл.
	2. Гамшгийн үеийн үйл ажиллагаа	
2	Гамшгийн харилцаа холбоо, зарлан мэдээллийг зохион байгуулах	Гамшиг болон аюулын дохио, сэрэмжлүүлэг, гамшгийн нөхцөл байдал, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг мэдээлэх зорилгоор зарлан мэдээллийг шуурхай зохион байгуулна. Гамшиг болон аюулын тухай мэдээ, мэдээллийг цуглуулах, холбогдох шийдвэрийг төрийн болон нутгийн захиргааны байгууллагад хүргэх, түүнчлэн улс хооронд харилцан мэдээлэл солилцоход харилцаа холбооны бүх төрлийн сүлжээг ашиглана. Гамшиг болон аюулын дохио, сэрэмжлүүлгийг харилцаа холбоо, хэвлэл мэдээллийн байгууллага өмчийн хэлбэр үл харгалзан шуурхай, үнэ төлбөргүй дамжуулах үүрэгтэй. Голомтын бүсэд үүрэг гүйцэтгэж байгаа шуурхай бүлэгтэй холбоо зохион байгуулах, мэдээлэл солилцох ажиллагааг онцгой байдлын болон төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллага гүйцэтгэнэ.
	Голомтын бүс тогтоох	Аймаг, сум, нийслэл, дүүргийн нутаг дэвсгэр, объектод хор уршгийг арилгах арга хэмжээг шууд удирдан зохион байгуулж байгаа мэргэжлийн байгууллагын удирдлага, эсхүл мэргэжлийн байгууллагын саналыг үндэслэн тухайн шатны Засаг дарга; хэд хэдэн аймгийн нутаг дэвсгэр болон улсын онц чухал обьектод онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар тогтооно. Голомтын бүсэд хэрэгжүүлж байгаа арга хэмжээг тухайн шатны онцгой байдлын байгууллага удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хяналт тавина.
	Эрэн хайх, аврах	Эрэн хайх, аврах ажиллагааг томилгоот шуурхай бүлэг гүйцэтгэнэ. Шуурхай бүлгийн удирдагч онцгой байдлын байгууллагын алба хаагч байх ба эрэн хайх, аврах ажиллагааг удирдан зохион байгуулах үүрэгтэй. Эрэн хайх, аврах ажиллагаанд оролцож байгаа сайн дурын хэсэг, иргэн шуурхай бүлгийн удирдагчийн зааврын дагуу үүрэг гүйцэтгэнэ. Нэрвэгдэгсдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээг эмнэлгийн

		байгууллага өмчийн хэлбэр үл харгалзан шуурхай үзүүлэх үүрэгтэй.
	Хүч хэрэгсэл дайчлан гаргах, нүүлгэн шилжүүлэх	Гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед шаардлагатай тохиолдолд хүч хэрэгслийг дайчлан гаргаж, хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, музейн үзмэр, цуглуулга, түүх, соёлын дурсгалт зүйлийг аюулгүй газарт нүүлгэн шилжүүлнэ. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж нь хүн амыг нүүлгэн шилжүүлэх талбай, байршуулах байр, байгууллага, хуулийн этгээд нь түр цугларах аюулгүйн талбайтай байна.
	Гамшгийн хор уршгийг арилгах	Гамшгийн хор уршгийг арилгах үйл ажиллагааг төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд өөрөө, эсхүл үүссэн нөхцөл байдлыг харгалзан Онцгой байдлын байгууллага мэргэжлийн байгууллагатай хамтран гүйцэтгэнэ.
2. Гамшгийн дараах буюу хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаа		
3	Нийгмийн амьдралыг хэвийн нөхцөлд оруулах;	Нөхөн сэргээх, урт хугацааны болон түр зуурын арга хэмжээ авах, ахуйн үйлчилгээ болон орон сууцаар хангах явдал юм.
	Дэд бүтцийг сэргээн босгох.	Сэргээн босголт нь гамшигт нэрвэгдэгсдийг гамшгийн өмнөх хэвийн нөхцөл оруулах оролдлого юм. Барилга байгууламж, дэд бүтцийг сэргээн босгох урт хугацааны хөгжлийн төлвийг хэлнэ. Хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд дотоодын болон гадаад улсын, эсхүл олон улсын байгууллага, хуулийн этгээд, иргэдийн хүмүүнлэгийн тусламжийг авч болно.

Хүснэгт 1. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны үе шатуудад хэрэгжүүлэх арга хэмжээ

Манай улсын хувьд Гамшгаас хамгаалах тухай хуульд зааснаар улсын хэмжээнд гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөл, аймаг, нийслэл, дүүргийн хэмжээнд орон нутгийн зөвлөл ажиллаж, гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн болон салбар дундын хамтын ажиллагаа, иргэдийн оролцоог хангах, бодлогын зөвлөмж гаргах чиг үүргийг хэрэгжүүлнэ (Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, 2017).

Гэхдээ үндэсний болон орон нутгийн зөвлөл нь дөнгөж шинэ түвшинд ажиллаж байгаа тул олон улсын туршлага сургамжийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байна.

Өнөөдрийн байдлаар хэрэгжүүлэн мөрдлөг болгож байгаа Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах бүтцийг авч үзвэл гамшгаас хамгаалах төлөвлөгөө нь 6 бүлгээс бүрдэнэ (Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, 2013). Үүнд:

- *Нэгдүгээр бүлэг.* Нийтлэг үндэслэл;
- *Хоёрдугаар бүлэг*. Танилцуулга;
- *Гуравдугаар бүлэг.* Гашмгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө;
- *Дөрөвдүгээр бүлэг.* Хариу арга хэмжээний төлөвлөгөө /аюулт үзэгдлийн төрөл бүрээр/;

• Эрэн хайх, хор уршгийг арилгах төлөвлөгөө;

• Гамгшгаас хамгаалах дайчилгаа зохион байгуулах төлөвлөгөө;

• Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө;

Тавдугаар бүлэг. Сэргээн босгох төлөвлөгөө;

Зургадугаар бүлэг. Хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах төлөвлөгөө;

- Хавсралт /захирамжлалын баримт бичгийн төсөл, зарлан мэдээллийн схем, хүч хэрэгслийн тооцоо судалгаа, нөөц, хангамж, байр зүйн болон план зураг гэх мэт/ бүтэцтэй байна.

Нийслэл Улаанбаатар хотын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хавсралт-1-д үзүүллээ.

Олон улсын туршлагад хийсэн судалгаа:

д/д	Гадаад орны нэр	Хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, туршлага
1	ОХУ	ОХУ-ын Ерөнхийлөгчийн эрх бүхий төлөөлөгчидтэй, Засгийн газар болон холбооны гүйцэтгэх байгууллагуудын харилцан ажиллагааг тодорхойлж “ОХУ-ын далай, тэнгис, усан байгууламжид тохиолдсон гамшгийн үед эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулах үеийн улсын албадын харилцан ажиллагааны төлөвлөгөө”-г баталсан байдаг юм. Мөн ОХУ-ын Ерөнхийлөгчийн 2005 онд зарлигаар "ОХУ-д тохиолдсон гамшгийн үед төрийн болон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг зохицуулах харилцан ажиллагаа" гэсэн удирдлагын баримт бичиг гаргасан байна. Энэхүү баримт бичгээр ОХУ-ын Дотоод хэргийн яам, Онцгой байдлын яам, Хууль зүйн яам, бусад холбооны яам болон гүйцэтгэх байгууллагын харилцан ажиллагааны зохицуулалтыг зохион байгуулдаг бөгөөд мөн тухайн үед хэн удирдах, хэн гүйцэтгэх, хэн дэмжлэг үзүүлэх гэх мэт бүх асуудлыг тусгасан байдаг.
2	БНХАУ	Хятад улс нь олон төрлийн байгалийн аюулт үзэгдэлд өртөмтгий бөгөөд үүнд үер, ган, хөрсний гулсалт, шуурга, газар хөдлөлт ордог. Уур амьсгалын дулаарал болон улс орны хурдтай үйлдвэржилт, хотжилтоос шалтгаалан иргэдийн байгалийн аюулт үзэгдэлд өртөх эмзэг байдал нэмэгдсээр байна. Тус улсад жил бүр дунджаар 300 сая хүн гамшигт өртөж, 4 сая хүнийг гамшгийн улмаас нүүлгэн шилжүүлдэг байна. Эдүгээ гамшгийн улмаас учирч буй хохирлын хэмжээ өнгөрсөн 30 жилтэй харьцуулахад 40 хувиар өссөн нь тус улсын тогтвортой хөгжилд ноцтой заналхийлж байгаа юм. Байгалийн гамшгийн аюулыг бууруулах зорилгоор Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний хороог шинээр байгуулан тус хороо нь гамшгийн эрсдэл бууруулах асуудлыг сурталчлах болон хөгжлийн төлөвлөлт ба үйл явцад тусгах арга хэмжээг хэрэгжүүлдэг байна [1] . Дээрх байгууллага нь хамгийн их заналхийлж буй аюулт үзэгдлүүдтэй холбоотой гамшгийн эрсдэлийн тухай мэдээллийг цуглуулж, нэгтгэж, судалж, үнэлэх чиглэлээр хамтын ажиллагааг бэхжүүлж, Иргэний хэрэг, Усны нөөц, Газрын нөөц болон хөдөө аж ахуй хариуцсан яамд, мөн статистик, цаг уур, газар хөдлөлтийн асуудал хариуцсан товчоод гамшигтай холбоотой үндэсний хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, гамшгийн үед хэрэгжүүлэх хамтарсан бэлэн байдлын төлөвлөгөөг боловсруулж, хариу арга хэмжээ зохицуулах механизмыг зохион байгуулдаг байна. Гамшгийн эрсдэлийг бууруулах зорилгоор эрт зарлан мэдээлэл, хариу арга хэмжээ, гамшгийн менежментэд сансрын технологийг ашиглаж, гамшгийн дараах яаралтай тусламж, сэргээн босголтыг шуурхай зохион байгуулах зэрэг олон арга хэмжээг хэрэгжүүлж байна. Мөн гамшигтай хамгийн үр ашигтай аргаар тэмцэхийн тулд ялангуяа хөрш орнуудад адил төрлийн эрсдэл заналхийлж байгаа тохиолдол, эрсдэл бууруулах бүсийн хамтын ажиллагааг чухалчилж байна.

3	Япон улс	Япон улсад гамшгаас хамгаалах үйл ажиллагааг нутгийн өөрөө удирдах байгууллага, нутгийн захиргааны байгууллага хэрэгжүүлдэг бөгөөд тэдний хоорондын харилцан ажиллагааг гамшгаас хамгаалах төлөвлөгөөндөө маш нарийн тусгасан байдаг байна. Энэхүү харилцан ажиллагааны асуудлыг Гамшгаас хамгаалах Үндэсний зөвлөл хариуцан ажилладаг бөгөөд мөн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хариуцан боловсруулах ажлыг зохион байгуулж хэрэгжилтийг хангуулдаг байна. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг нарийн боловсруулж хэрэгжүүлдэг бөгөөд тус улс өөрийн онцлогт тохируулан газар хөдлөлтийн гамшгийн үед ажиллахад төлөвлөгөөг маш нарийн зохион байгуулалттайгаар боловсруулж мөрдүүлдэг байна. Тус улсын Гамшгаас хамгаалах Үндэсний зөвлөл гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулахдаа бүх талын төлөөллийг оролцуулан тэдний гүйцэтгэх үүргийг тодорхойлж түүгээр дамжуулан харилцан ажиллагааг яаж зохион байгуулахыг тодорхойлж өгдөг байна. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний зарчим нь болзошгүй гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед хүний эрх, эрх чөлөөг дээдлэх, аюулгүй байдлыг хангах, урьдчилан төлөвлөгдсөн, шуурхай, уян хатан, тасралтгүй байх, хязгаарлагдмал нөөцийг үр дүнтэй ашиглах “хийж гүйцэтгэх ажил”, “хэрэгжүүлэх арга зам”, “хугацаа”, “хариуцах эзэн /хүн/”, “хамтран хэрэгжүүлэх байгууллага /алба/”, “шаардагдах зардал” гэсэн асуумжид хариулагдахаар, “удирдлага, зохион байгуулалт,” “гамшгаас урьдчилан сэргийлэх”, “аврах”, “хор уршгийг арилгах”, “сэргээн босгох ажиллагаа” гэсэн үе шатаар төлөвлөгдсөн байдаг бөгөөд эдгээр асуудлаас харахад харилцан ажиллагааг давхар тооцон боловсруулдаг байна.

Хүснэгт 2. Олон улсын гамшгаас хамгаалах үйл ажиллагаа, төлөвлөлт

Дээрх олон улсын туршлагыг харьцуулан судлахад Онцгой байдлын байгууллага ба тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага, гамшгаас хамгаалах улсын болон орон нутгийн албад, төв орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудын харилцан ажиллагаа түүнд оролцогчдын түвшин, бүрэлдэхүүний байдлаас хамаарч стратегийн, оперативын, тактикийн гэж хуваан үзэж болж байна.

Менежментийн ухааны үүднээс удирдлага зохион байгуулалтыг дээд, дунд, доод удирдлага нь дээрх харилцан ажиллагааны түвшинтэй уялдаж байна. Иймд хариу арга хэмжээ, харилцан ажиллагааны төлөвлөлтийг боловсруулахад гамшгаас хамгаалах сургалтыг оруулах зайлшгүй шаардлага бий болж байна.

Судалгааны үр дүн. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний өнөөгийн байдалд SWOT шинжилгээ хийж дотоод хүчин зүйл буюу давуу болон сул тал, гадаад хүчин зүйл буюу боломж болон таатай нөхцөл, аюул буюу таагүй нөхцөл байдлыг тодорхойлсон.

Давуу тал:	Сул тал:
Гамшгаас хамгаалах тухай хууль, эрх зүйн зохицуулалт бүрдсэн; Улс, аймаг, нийслэл, дүүргийн түвшинд Онцгой комисс, Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний болон орон нутгийн зөвлөл, Газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөл ажиллах, гамшгаас хамгаалах тогтолцооны бүтэц бүрдсэн;	Төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах, үнэлэх тогтолцоо сул; Гамшгийн эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах төлөвлөлтөд төсөв хязгаарлагдмал тул төлөвлөсөн үйл ажиллагааг бүрэн хэрэгжүүлэхэд хүндрэлтэй; Зарим аймаг, сумдад техник, тоног төхөөрөмж дутагдалтай, хариу арга хэмжээ авах чадамж сул; Олон нийтэд зохион байгуулж байгаа гамшгаас хамгаалах, гамшгийн эрсдэлийн талаарх

Хүний нөөцийн хувьд мэргэшсэн аврагч, гал сөнөөгчид, ажилтан, алба хаагч, сайн дурынхан ажиллаж байна; Гамшгаас хамгаалах чиглэлээр олон нийтийн сургалт, нөлөөллийн аян нэмэгдэж, иргэдийн мэдлэг дээшилж байна; Мэдээлэл технологийн чиглэлээр сэрэмжлүүлгийн ухаалаг шийдлүүдийг нэвтрүүлэхээр туршиж эхэлсэн; Олон улсын хамтын ажиллагаатай байгууллага болох Дэлхийн эрүүл мэдийн байгууллага, Дэлгийн зөн олон улсын байгууллагуудтай хамтран гамшгаас хамгаалах чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байна.	нэгдсэн дадлага сургуулийн хугацаа нь урт, мэргэжлийн боловсон хүчин дутмаг, сургах тогтолцоо сул; Аюулт үзэгдэл, ослын үед байгууллага хоорондын мэдээлэл солилцох, уялдаа холбоо дутмаг, хамтран ажиллах механизм сул; Зарим байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөө хуучирсан, шинэчлэгдээгүй, бодит нөхцөл байдалтай нийцдэггүй.
Боломж:	**Аюул:**
Олон улсын туршлага сургамжид суурилсан төлөвлөлт хийх боломжтой; Гамшгаас хамгаалах төлөвлөлтөд Олон улсын хяналт, үнэлгээний сайн туршлагыг нэвтрүүлэх; Ухаалаг шинэлэг технологи ашиглах энэ нь газарзүйн мэдээллийн систем /GIS/, хиймэл дагуулын зураглал, гар утасны апп, эрт сэрэмжлүүлгийн систем ашиглах боломжтой; Олон нийтэд мэдлэг олгох зорилгоор сургуулийн насны хүүхдүүд, залуучуудыг гамшгаас хамгаалах, гамшгийн эрсдэлийг ойлгох боловсролд хамруулах боломж шаардлагатай байна; Гамшгийн эрсдэлийг бууруулахад хувийн хэвшлийн байгууллагатай түншлэл байгуулан хамтран ажиллаж, хөрөнгө, нөөц, логистикийг нэмэгдүүлэх боломжтой; Олон улсын байгууллагатай хамтын ажиллагаа байгуулан санхүүжилт нэмэгдүүрэх чиглэлээр төсөл, хөтөлбөрийг үргэлжлүүлэн ажиллах боломжтой;	Сүүлийн жилүүдэд газар хөдлөлтийн давтамж нэмэгдэж байгаа нь аюул дагуулж байна; Улаанбаатар хотын төвлөрөл нэмэгдэж байгаа өнөө үед гамшгийн эрсдэл, аюул өндөр байна; Төлөвлөлтгүй барилгажилт нь газар хөдлөлт, үер зэрэг гамшигт өртөмтгий байдлыг нэмэгдүүлэх эрсдэлтэй; Инженерийн дэд бүтэц хуучирсан нь газар хөдлөлтийн гамшгийн үед гэмтэхэд систем бүхэлдээ доголдож, гамшгийн дараах сэргээн босгох ажиллагаа удаашрах аюултай; Гамшгийн үед төрийн байгууллагуудын удирдлага, зохицуулалт давхардал болон зөрчил үүсэх магадлалтай;

Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний өнөөгийн байдалд SWOT шинжилгээнээс үзэхэд гамшгаас хамгаалах тухай хууль, эрх зүйн зохицуулалт бүрдсэн, улс, аймаг, нийслэл, дүүргийн түвшинд Онцгой комисс, Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний болон орон нутгийн зөвлөл, Газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөл ажиллах, гамшгаас хамгаалах тогтолцооны бүтэц бүрдсэн, хүний нөөцийн хувьд мэргэшсэн аврагч, гал сөнөөгчид, ажилтан, алба хаагч, сайн дурынхан ажилладаг, гамшгаас хамгаалах чиглэлээр олон нийтийн сургалт, нөлөөллийн аян нэмэгдэж, иргэдийн мэдлэг, мэдээлэл технологийн чиглэлээр сэрэмжлүүлгийн ухаалаг шийдлүүдийг нэвтрүүлэхээр туршиж эхэлснээс гадна олон улсын хамтын ажиллагаатай байгууллага болох Дэлхийн эрүүл мэдийн байгууллага, Дэлгийн зөн олон улсын байгууллагуудтай хамтран гамшгаас хамгаалах чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлдэг нь давуу талтай байна.

Зарим төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын гамшгийн үеийн харилцан ажиллагааны төлөвлөгөө нь нууцийн зэрэглэлтэй, мэргэжлийн болон мэргэшүүлэх сургуулиуд тогтмол хийгдээгүй, томилогдсон бүлгүүдийн хоорондын хамтын ажиллагаа бүрэлдээгүй, аюулт үзэгдэл, ослын үед байгууллага хоорондын мэдээлэл солилцох, уялдаа

холбоо дутмаг, хамтран ажиллах механизм сул, гамшгийн гүйцэтгэх үүрэг тус бүрээр нарийвчлан тодотгож, сургалт, дадлагыг зохион байгуулж байгаагүй зэрэг сул талтай.

Боломжийг ашиглаж сул талаа арилгах, давуу талаараа аюулаас зайлсхийх, сул тал, аюул заналыг хоёулыг нь бууруулах боломжтой гэж үзэж байна.

Дүгнэлт

Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд хийсэн шинжилгээ сэдвийн хүрээнд төлөвлөлтийн онол арга зүйн асуудал, гамшгаас хамгаалах төлөвлөлтийн тухай ойлголт, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд төлөвлөлтийг хэрхэн хийх, гамшгаас хамгаалах төлөвлөлтийн талаарх зарим улс орны туршлага түүнд үндэслэн өнөөгийн байдалд шинжилгээ хийж, гамшгаас хамгаалах төлөвлөлтийг сайжруулах арга замыг дэвшүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг зайлшгүй судлах шаардлага тулгарч байна.

Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хийх хамгийн оновчтой арга хэлбэр бол бүх түвшинд боловсруулах явдал юм. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний цар хүрээ хүн амын хэрэгцээ болон тухайн гамшгийн эрсдэлээс хамааран олон янз байхын зэрэгцээ эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааны үед үүсэх маш олон төрлийн хэрэгцээг хангахуйцаар хийгдэх шаардлагатай бөгөөд төлөвлөгөөг боловсруулах ажлыг хамтран хэрэгжүүлэх гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн төлөөллийг оролцуулах бөгөөд эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан төлөвлөгөөг боловсруулах нь зүйтэй гэж дүгнэж байна.

Санал

Мөн илтгэлдээ гамшгаас хамгаалах төлөвлөгөөний өнөөгийн байдалд шинжилгээ хийж, судалж үзэхэд дараах саналыг тусгалаа. Үүнд:

- Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээний төлөвлөгөөг Олон улсын туршлага сургамжид тулгуурлан боловсруулж, бүрэн хэрэгжүүлэх;
- Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах зорилт, арга хэмжээ, хэрэгжүүлэх байгууллага, шаардагдах төсөв хөрөнгийн мэдээллийг гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодорхой тусгаж оруулах, хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн асуудлыг цаг бүрд нь шийдвэрлэх;
- Гамшгийн үед хоргодох түр байрнуудын тэсвэржилтийг нэмэгдүүлэн хүчитгэж, гамшгийн үед хэрэглэх шаардлагатай дулаан хувцас, эм, эмнэлгийн хэрэгсэл, материал, хоол хүнсний хангалтыг бэлэн байлгах;
- Иргэдэд гамшгийн болон зарлан мэдээллийн төхөөрөмж, дуут цамхгийн бэлэн байдлыг хангаж, байгууламжийг хүчитгэх, дохио өгөх, зарлан мэдээлэл дамжуулах төхөөрөмжийг нэмж суурилуулах, байнга сайжруулж байх.

Ном зүй

Дамдин П. (2017). *Монгол Улсын Иргэний хамгаалалтын түүхэн замнал.* Улаанбаатар: ОБЕГ.

Цэдэв П. (2018). *Гамшгаас хамгаалах төлөвлөлт.* Улаанбаатар: ДХИС.

Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. (2013 оны 06 11). ОБЕГ-ын даргын 2013 оны 6 дугаар сарын 11 өдрийн А/170 тушаал. *“Аймаг, нийслэл, сум, дүүргийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний загвар”-ыг нэгдүгээр, “Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний загварыг ашиглах заавар”-ыг хоёрдугаар хавсралт*. Улаанбаатар, Улаанбаатар, Монгол: ОБЕГ.

Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. (2017 оны 02 02). Гамшгаас хамгаалах тухай хууль. *Төрийн мэдээлэл*, 07. https://legalinfo.mn/mn

ХАВСРАЛТ-1

УЛААНБААТАР ХОТЫН ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Удирдан зохицуулах байгууллага	Дэмжлэг үзүүлэх байгууллага
Нэг. Удирдлага, зохион байгуулалт				
1.1	Нийслэлд үүссэн газар хөдлөлтийн гамшгийн үед авч хэрэгжүүлэх үйл ажиллагааг шуурхай эхлүүлж, бүх төрлийн холбооны хэрэгслийн тогтворжилтыг шалгаж, нөхцөл байдлыг удирдлагад мэдээлэх	Ц+20 минут	НОБГ, “УБШУЗТ” ОНӨТҮГ	НЦХМТГ
1.2	Гамшгийн цагийн байдал үүссэн нөхцөлд холбооны сувгийн найдвартай ажиллагааг шалгаж, ажиллагаанд оруулж, мэдээ мэдээллийг шуурхай дамжуулах	Ц+30 минут	НОБГ, “УБШУЗТ” ОНӨТҮГ	НЦХМТГ
1.3	Газар хөдлөлтийн гамшгийн үед үүссэн цагийн байдлын талаар нийслэлийн Онцгой комиссоос мэдээлэл хийх	Ц+2 цаг	НЗДТГ-ын ХМОНХХ	НОБГ
1.4	Нийслэлийн нөөц удирдлагын ажлын байрыг гаргаж, шуурхай штабын үйл ажиллагааг тасралтгүй явуулж, удирдлага зохион байгуулалтаар хангах	Ц+3 цаг	НОБГ	НЗДТГ-ын Цэргийн штаб
Хоёр. Хариу арга хэмжээ				
2.1	Газар хөдлөлтийн гамшиг болсон тохиолдолд Онцгой комиссын гишүүд, Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн томилгоот бүрэлдэхүүн, хүч хэрэгсэлтэй зарлан мэдээллийн дохио хүлээхгүйгээр ажлын байрандаа цугларах	Ц+1 цаг 30 минут	Нутгийн захиргааны байгууллагууд	НОБГ
2.2	Нийслэлийн Аврах ангийн бэлтгэл ээлж, Гал түймэр унтраах, аврах 10 дугаар ангийн томилгоот ээлжийн бүрэлдэхүүн Төрийн ордны томилгоот хэсгүүдэд аврах үйл ажиллагаа эхлүүлэх	Ц+1 цаг	НОБГ	ЧДОБХ
2.3	Нийслэлийн Аврах анги, Гал түймэр унтраах, аврах 34 дүгээр ангийн томилгоот ээлжийн бүрэлдэхүүн нийслэлийн Засаг даргын Тамгын газрын байранд аврах үйл ажиллагаа явуулах	Ц+1 цаг	НОБГ	НЗДТГ
2.4	Нийслэлийн хэмжээнд Төрийн 26, хувийн 101 эмнэлгийн барилга байгууламжаас газар хөдлөлтийн гамшигт нураагүй үлдсэн эмнэлгүүдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тасралтгүй үзүүлэх ажлыг зохион байгуулах	Ц+3 цаг	НЭМГ	Дүүргүүдийн ЭМТ
2.5	Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1511 дүгээр захирамжаар томилгоожсон 344 байгууллагын барилга байгууламжаас газар хөдлөлтийн гамшигт нураагүй үлдсэн объектод орон гэргүй болсон иргэдийг байршуулах ажлыг зохион байгуулах	Ц+5 цаг	НХБХГ, ННТГ	НОБГ
2.6	Газар хөдлөлтийн үед гамшгийн голомтуудад хэв журам сахиулах, материал баялгийг хамгаалалтад авах, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах	Ц+2 цаг	НЦУГ	ТЦА-ны ЗЦГ
2.7	Газар хөдлөлтийн улмаас Орон сууцны конторуудын аваарын техникийн бүлгүүд цаашид ашиглагдах боломжтой байруудын	Ц+1 цаг 30 минут	“ОСНААГ” ОНӨААТҮГ	“Дулааны сүлжээ” ТӨХК

	дулааны системүүдийг хөлдөлтөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах			
2.8	Газар хөдлөлтийн улмаас цахилгааны аваарын техникийн бүлгүүд нэн шаардлагатай байгууллага болон 1-р зэргийн хэрэглэгчийг цахилгаанаар хангах ажлыг зохион байгуулах	Ц+3 цаг	“Цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК	“ОСНААГ” ОНӨААТҮГ
2.9	Газар хөдлөлтийн улмаас нийслэлийн усан хангамжийн системд үүссэн хохирлын тооцоо гаргаж, эхний ээлжид хэрэглээний цэвэр усаар шаардлагатай нэгжүүдийг хангах арга хэмжээ авах	Ц+5 цаг	“УБУСУГ” ОНӨААТҮГ	“ОСНААГ” ОНӨААТҮГ
2.10	Газар хөдлөлтийн гамшгийн улмаас цацраг, химийн хорт бодис алдагдсан үед хор уршгийг арилгах арга хэмжээ авах	Ц+2 цаг	НОБГ	НЦУГ
2.11	Нефтийн агуулах, шатахуун түгээх станц, шингэрүүлсэн шатдаг хий аж ахуйн нэгж байгууллагуудын аюулгүй байдлыг хангах, гарсан гал түймрийг шуурхай унтраах	Ц+30 минут	НОБГ	ТЦА-ны ЗЦГ
2.12	Тандалтын бүлгүүдийг гаргаж, гамшгийн голомтын заагийг тодорхойлох	Ц+6 цаг	НОБГ	НЦУГ
2.13	Газар хөдлөлтийн гамшгийн голомтод аврах үйл ажиллагааг явуулах үеийн шаардлагатай хүнд машин механизм, багаж хэрэгслийг дайчлах ажлыг зохион байгуулах	Ц+8 цаг	НЗДТГ, УБЗАА	НОБГ
2.14	Газар хөдлөлтийн үед нэрвэгдэгсдийг түр байрлуулах орон байр, дулаан хувцас, хоол хүнс, цэвэр усаар хангаж, эмнэлгийн тусламж үзүүлэх ажлыг дүүргүүд төлөвлөгөөний дагуу зохион байгуулах	Ц+5 цаг	Дүүргүүдийн ЗДТГ	УБЗАА
2.15	Газар хөдлөлтийн гамшгийн голомт нь их хэмжээний талбайг хамарч, иргэдийг зайлшгүй нүүлгэн шилжүүлэх шаардлага гарсан тохиолдолд 31 байршилд нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах	Ц+10 цаг	НЗДТГ-ын Цэргийн штаб, ТЦА-ны ЗЦГ, ННТГ, НЦУГ	НГЗБА
2.16	Газар хөдлөлтийн улмаас буцалтгүй нэрвэгдэгсдийг таниулах, оршуулах ажлыг онцгой комиссын шийдвэрээр зохион байгуулах	Ц+24 цаг	НЦУГ, НЭМГ	НОБГ

ДААТГАЛЫН ГЭРЭЭНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ

SOME ISSUES OF THE LEGAL REGULATION OF INSURANCE CONTRACTS IN JAPAN

Т.Наранцогт
СЭЗИС-ын Эрх зүйн тэнхимийн ахлах багш, хууль зүйн магистр /LL.M/
Narantsogt T.
Senior Lecturer of the Department of Law, UFE, Master of Laws (LL.M)

*Хариуцлагатай зохиогч: Narantsogt.T@gmail.com

Хураангуй: Даатгалын гэрээний эрх зүйн харилцааны онцлогийг түүний ойлголт, мөн чанар, зохицуулалтын хүрээнд, Тухайлан Япон улсын даатгалын гэрээний эрх зүйн зохицуулалтын онцлог, түүний хэрэгжилт, тулгамдаж буй зарим асуудлыг судлах зорилготой. Даатгалын гэрээ нь эрсдэлийг хуваалцах, санхүүгийн тогтвортой байдлыг хангах үндсэн үүрэгтэй бөгөөд иргэний эрх зүйн зарчмуудтай нягт уялддаг.

Япон улсын Даатгалын тухай хуульд даатгалын гэрээг тодорхойлохдоо харилцан туслах гэрээтэй төстэй байдлаар авч үздэг. Энэ нь даатгуулагч тодорхой хэмжээний хураамж төлөх, даатгагч хохирол учирсан тохиолдолд нөхөн төлбөр олгох үүрэг хүлээдэг зарчмаар зохицуулагддаг. Даатгалын эрх зүйн зохицуулалтад орлого, зарлагын тэнцвэр, эрсдэл-хураамжийн зохистой харьцаа зэрэг санхүүгийн үндсэн зарчмууд чухал байр суурь эзэлдэг.

Уг судалгааны ажил нь Япон улсын даатгалын гэрээний эрх зүйн зохицуулалтыг танин мэдэх замаар Монгол улсын Иргэний хууль дахь даатгалын гэрээг илүү боловсронгуй болох арга замыг эрэлхийлж, даатгалын гэрээний ач холбогдлыг танин мэднэ.

Abstract: This article aims to examine the characteristics of the legal relationship of insurance contracts through their concept, nature, and regulatory framework, with a particular focus on the legal regulation of insurance contracts in Japan, their implementation, and key challenges. Insurance contracts serve the fundamental purpose of risk-sharing and ensuring financial stability, closely aligning with the principles of civil law.

The Japanese Insurance Act defines insurance contracts in a manner similar to mutual aid agreements. Under this framework, the insured pays a certain amount of premium, while the insurer assumes the obligation to provide compensation in case of incurred losses. The legal regulation of insurance emphasizes key financial principles such as the balance between income and expenses and the proper correlation between risk and premium.

This research aims to explore the legal regulation of insurance contracts in Japan and, through this understanding, seek ways to improve the regulation of insurance contracts under the Civil Code of Mongolia. It also aims to highlight the significance of insurance contracts in social and economic contexts.

Түлхүүр үгс: Даатгал, даатгалын гэрээ, эрсдэл, зарчим
Keywords: Insurance, Insurance contract, Risk, Principle

Үндэслэл

Монгол улс даатгалын салбар хөгжлийн эхэн шатандаа явж байна. Олон улсад даатгалд суурилсан банк санхүүгийн салбар бүрэлдсэн бол манай орны хувьд банкны салбарт үндэслэж даатгал хөгжиж байгаа нь эдийн засаг талаас онцлогтой.

Зах зээл өндөр хөгжсөн орнуудад даатгалаар дамжуулан дотоодын нийт бүтээгдэхүүний 8-12 хувийг бүрдүүлдэг (https://www.mongolbank.mn/mn/p/financial-stability, 2023) бол манай улс маш бага хувийг эзэлж байна, мөн банк санхүүгийн салбарын 4 хувийг эзэлж (https://www.frc.mn/#/doc/list & id=781, 2022), уг хувь нэмэгдэх бус багасах хандлагатай байгаа нь Монгол улсад салбарын эрх зүйн зохицуулалт хангалтгүй,

This article is published under the Creative Commons
BY-NC-SA License by 4.0, ©2025 University of Internal Affairs, Mongolia

даатгалын үйлчилгээ үзүүлэгч байгууллагын чадавх сул, даатгалын байгууллагаар үйлчлүүлэх талаар иргэдийн мэдлэг мэдээлэл дутмаг, энэ талаарх соёл, хүн амын сэтгэл зүй бэлэн болоогүй, хандлага төлөвшөөгүй байгаатай холбоотой байна.

Монгол улсад даатгалын гэрээтэй холбоотой маргаан өсөх, гэрээний зохицуулалтаас үүдэлтэй гэрээний талуудын эрх ашиг хөндөгдөх, даатгалын салбар зогсонги байдалд орох, ашиггүй ажиллах, эдийн засагт эзлэх хувь хумигдах, даатгуулагч нөхөн төлбөрөө авч чадахгүй байх, дахин даатгуулах бус эрсдэлийг өөртөө үлдээх, даатгалд итгэх иргэдийн итгэл багасах зэрэг сөрөг хандлага ажиглагдах болов. Мөн даатгалын олон талт үйл ажиллагаа түүний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага хэрэгцээ нэмэгдсээр байна.

Олон улс болон үндэсний хэмжээнд даатгалын гэрээний харилцаанаас үүдэлтэй эрх зүйн маргаан ихсэх хандлагатай. Даатгалын гэрээ нь аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах зорилготой иргэний эрх зүйн чухал гэрээний нэг төрөл юм. Энэ нь даатгагч болон даатгуулагч хоёр талын хооронд байгуулж, тодорхой эрсдэл тохиолдсон үед даатгалын нөхөн төлбөр олгох үүргийг даатгагч хүлээдэг эрх зүйн харилцаа юм. Даатгалын гэрээ нь санхүүгийн аюулгүй байдлыг хангах, эрсдэлийг бууруулах, эдийн засгийн тогтвортой байдлыг дэмжих гол хэрэгсэл болж хөгжиж ирсэн.

Даатгалын гэрээг олон улсын болон үндэсний хууль тогтоомжид тодорхойлон тусгасан байдаг. Жишээлбэл, Япон Улсын Иргэний хууль, Арилжааны хууль зэрэгт даатгалын гэрээний үндсэн зарчим, эрх зүйн үндэслэлийг тодорхойлсон байдаг.

Даатгалын гэрээний эрх зүйн зохицуулалт нь гэрээний чөлөөт байдал, эрсдэлийн хуваарилалт, шударга байдал, итгэлцэл, нөхөн төлбөрийн зарчим зэрэг суурь зарчмуудад үндэслэн хэрэгждэг. Эдгээр зарчмууд нь даатгалын гэрээг найдвартай, үр ашигтай хэрэгжүүлэх үндэс суурийг бүрдүүлдэг бөгөөд даатгуулагч болон даатгагчийн хоорондын эрх, үүргийг тодорхойлж өгдөг байна.

“Даатгал” гэж юу болох талаар нэгдсэн тодорхойлолт байдаггүй (山下・, 2016 , p. 3) бөгөөд онолын хувьд ч гэсэн нэгдсэн ойлголтод хүрээгүй байна (山下, 2016, p. 3). Сүүлийн жилүүдэд даатгал, даатгалын эрх зүйд даатгалын гэрээг бусад даатгалтай төстэй гэрээнээс ялгахын тулд даатгалын бүтэц, даатгалын ач холбогдлын талаар хэлэлцүүлэг өрнөх болсон. Япон улсын Даатгалын тухай хуульд даатгалын тодорхойлолтыг оруулаагүй нь хуулийн эх бичвэрт даатгалын бүх шаардлагыг зохицуулах (тодорхойлох)-д хүндрэлтэй байсанд оршино (萩本編著・, 前掲注 1, 2021, pp. 4-8). Гэхдээ Япон улсын Даатгалын тухай хуулийн (цаашид Даатгалын тухай хууль) 1 дүгээр зүйлд даатгалтай холбоотой гэрээнд холбогдох хууль хэмээн заасан байх тул Даатгалын тухай хуулийн 2.1-д тодорхойлсон даатгалын гэрээ нь Даатгалын тухай хуулийн 1 дүгээр зүйлд заасан даатгалын механизм дээр суурилсан ойлголт гэдгийг дурдах хэрэгтэй (吉澤卓哉牙経, 2010, p. 119). Даатгалын тухай хуулийн 2.1-т заасан даатгалын гэрээг дангаар нь тайлбарлах бус харин Даатгалын тухай хуулийн 1 дүгээр зүйлд заасан “даатгал” гэдгийг харгалзан ойлгох ёстой ойлголт гэж үзэх нь зүйтэй.

Уг судалгааг Шинжлэх ухааны судалгааны нийтлэг болон тусгай аргууд болох эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах, логик, харьцуулсан эрх зүй судлал болон эрх зүйн онол, хэм хэмжээний онол, Эрх зүйн үйлчлэлийн хүрээн дэх судалгааны арга зүйг гол баримтлал болгон судлав. Мөн Монгол болон Япон улсын даатгалын гэрээний эрх зүйн зохицуулалт, түүний үндсэн зарчмуудын талаарх ойлголтыг харьцуулан судалж, үндэсний даатгалын гэрээний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох арга замыг эрэлхийлэв.

Даатгалын гэрээний тухай ойлголт

Хүн төрөлхтний түүхээс үзэхэд эд хөрөнгийн шинжтэй буюу арилжаа худалдаа, ажил хэргийн харилцан

тохиролцоог онцгой анхаарч, өгөх авах эд зүйл, төлөх үнэ хөлс, хийх ажил, үзүүлэх үйлчилгээ, хүлээх хариуцлагын талаар шүүхэд зарга нэхэмжлэл гаргах, гүйцэтгэлийг албадах боломжтой хууль, эрх зүйн эх сурвалж, төрийн бүтцийг бүрдүүлж, мэргэшсэн хуульчдыг бэлтгэж иржээ (С.Нарангэрэл, 2001, хуудсд. 7-8) Ялангуяа амлалт, хэлэлцээ, тохиролцооны тодорхой хэсгийг "хэлцэл", "гэрээ" гэдэг эрх зүйн ойлголтод хамруулж, гэрээний талууд эрх, үүргийн хувьд холбогдох, үүрэг, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх эрх зүйн арга хэлбэр хөгжсөн байна. (Хутыз, 1994, pp. 99-100) Эрх зүйн харилцаанд хамгийн чухал зүйл бол гэрээ (Хутыз, 1994, pp. 99-100) байдаг. Энэ нь хувийн автономи гэгдэх өөрийгөө тодорхойлох зарчмын илрэл юм. (Bydlinski, 2017, p. 547)

Даатгалын гэрээ байгуулахад гэрээний зарчмыг баримтална. (Markus, 2022, хууд. 69) Даатгалын гэрээний эрх зүй тусгайлсан хэм хэмжээ агуулаагүй бол иргэний эрх зүйн зарчим үйлчилнэ. ((Hrsg), 2014, хууд. § 1a Rz 2.) Даатгал нь хохирол бий болоход саад болохгүй харин бий болсон хохирлыг арилгахад чиглэдэг. (Schauer, Das österreichische Versicherungsvertragsrecht, 1995) Даатгалын харилцааг гэрээний эрх зүйн харилцаагаар зохицуулдаг. (хороо, 2014, хууд. 24)

Япон улс болон Монгол улсын даатгалын гэрээний эрх зүйн зохицуулалтын шинжилгээ

Япон улсын Даатгалын тухай хууль дахь "Даатгалын гэрээ" /Даатгалын тухай хуулийн 2.1/-ний тухай ойлголтыг энэ хэсэгт нарийсган судлахын зорилоо. Ингэснээр даатгалын гэрээний ойлголт болон салбарын тусгай зарчмыг гүнзгийрүүлэн танин мэдэх боломж бүрдэнэ.

2008 онд Даатгалын тухай хуульд даатгалын гэрээний зохицуулалтыг нэмсэн байна. Энэ нь Даатгалын тухай хуульд орсон томоохон өөрчлөлтүүдийн нэг юм. (萩本修編著, 保険法立案関係資料（別冊商事法務 321 号）㊦頁（商事法務, , 2008, p. 300) Даатгалын тухай хуулийн төсөл санаачлагч нь "Харилцан туслах гэрээний даатгалын гэрээтэй төстэй агуулгатай гэрээний хувьд тухайн зохицуулалтыг баримтлах" (萩本修編著, 萩本編著・前掲注 1)頁。, 2008, хууд. 300)-ыг зорин тус хуулийн 2.1 дэх хэсгийг зохицуулсан гэж тайлбарладаг. Даатгалын тухай хуулийн тайлбарт ч Даатгалын тухай хуулийн 2.1 дэх хэсэгт зохицуулсан "Даатгалын гэрээ"-ний тодорхойлолт нь даатгалын гэрээтэй төсөөтэй хамтран туслах гэрээнд ч хамаарна хэмээн ойлгох нь зүйтэй (大串淳子 , 2008, 2011, 2013, 2015, pp. 10,13,25,36,408,)

Гэхдээ, Даатгалын тухай хуулийн 2.1 дэх хэсэг нь "ямар нэр томьёо байхаас үл хамааран" тухайн зохицуулалтын агуулгад хамаарах гэрээг "Даатгалын гэрээ" гэж ойлгон Даатгалын тухай хуулийн зохицуулалт хэрэглэгдэнэ. Үүнийг зөвхөн даатгалын гэрээ болон хамтран туслах гэрээгээр хязгаарлахгүй.

Даатгалын тухай хуулийн төслийг санаачлагч нь Даатгалын тухай хууль-ийн 2.1 дэх хэсгийн тайлбарт даатгалын гэрээтэй төстэй харилцан туслах гэрээнд ч үйлчлэхээр тайлбарласан. (有斐閣 , 2009,2010, pp. 28-31,34-35,52-55,136-138)

Япон улсын Даатгалын тухай хууль нь "харилцан туслах гэрээ"-г багтаасан ойлголт ба Даатгалын тухай хууль батлагдсанаар (1) Даатгал гэх ойлголтыг тодорхойлох эсэх, (2) Харилцан туслах гэрээний хувьд Даатгалын тухай хууль үйлчлэх эсэх асуудал хөндөгдсөн. (山下＝米山編, 2022, p. 131)

Хэдийгээр харилцан туслах гэж нэрлэсэн ч энэ нь агуулгын хувьд даатгалтай бараг ялгаагүй байх тохиолдолд хууль, дүрэм журмыг ялгах ёсгүй гэсэн санал гарсаар ирсэн (鴻 常 夫 , 1974,1978,2002, pp. 219-222,266-271). Хуулийн зохицуулалтын агуулгыг тодорхойлоход "харилцан туслах"-ын нэгэндээ туслах мөн чанар болон үндэслэл болсон хуулийн онцлогийг харгалзан үзэх ёстойг онцолсон байх бөгөөд үүнийг тус бүрийн хуулийн зохицуулалтаар авч үзэх нь зүйтэй" (萩本編著・, 前掲注 1, 1996, p. 86) гэж тайлбарласан байдаг.

Даатгалын тухай хууль нь тус хуулийн 2.1 дэх хэсэгт даатгалын гэрээний суурь ойлголтыг, ердийн даатгалын гэрээ (Даатгалын тухай хуулийн 2.6 дахь хэсэг), амьдралын даатгалын гэрээ (Даатгалын тухай хуулийн 2.8 дахь хэсэг), гэмтэл, өвчний даатгал (Даатгалын тухай хуулийн 2.9 дэх заалт)-ыг тус тус тодорхойлсон. Даатгалын эрх зүйн онол нь даатгалын гэрээний тодорхойлолт нь тус зүйлийн 6 дахь хэсгээс хойш даатгалын төрлүүдийг тодорхойлолтыг оруулахын тулд оруулсан зохицуулалт гэж ойлгох нь ойлголтын зөрүү үүсгэхгүй байх үүднээс зохистой гэх тайлбар (山下＝永沢編著, 2013, p. 4) байдаг. Харин Даатгалын тухай хуулийн 2.1 дэх хэсэгт заасан даатгалын гэрээ нь Даатгалын тухай хуулийн суурь ойлголт юм. Тус заалтын ач холбогдлыг тодруулах нь чухал асуудал юм.

Япон улсын хууль тогтоогчид Даатгалын тухай хуулийн 2.1 дэх заалтын дагуу даатгалын гэрээг дараах онцлогтой гэж тайлбарласан (萩本編著, 2016, p. 29). Үүнд:

1) Гэрээний нэршил хамаарахгүй (Даатгалын гэрээ, харилцан туслах гэрээ нь сонгодог жишээ боловч үүнээс өөр нэртэй байсан ч даатгалын гэрээ гэж үзэж болох юм.

2) Талуудын нэг тал нь гэрээнд заасан тодорхой үйл явдал үүссэн нөхцөлд нөхөн төлбөр төлөхөөр тохиролцсон

3) Нөгөө тал нь даатгалын хураамж төлөхөөр тохиролцсон

4) (3)-т дурдсан даатгалын хураамж, харилцан туслах гэрээний хураамжийг (2)-т заасан тодорхой үйл явдал тохиолдох магадлалын дагуу төлөх

Академийн түвшинд Даатгалын гэрээний тухай ойлголтыг Даатгалын тухай хууль батлагдахаас өмнөх нийтлэг ойлголтын дагуу дараах шинжтэй хэсгүүдтэй гэж ойлгож ирсэн. Үүнд:

1) Нэг талын мөнгөн хураамж (даатгалын хураамж)

2) Нөгөө талын гэнэт үүссэн эдийн засгийн хохирлыг нөхөн төлөх (нөхөн төлбөр)

3) (1) болон (2) дахь нөхцөл эсрэг харилцаанд (山下友信, 2005, p. 6) байна

4) Орлого, зарлагын тэнцвэрийн зарчим (Principle of equalization of income and expenditure)

5) Даатгалын эрсдэл хураамжийн тэнцвэрийн зарчим (principle of the balance between performance and counter-performance)

(4) ба (5)-д заасан шинжид тулгуурлан (1) ба (2) дахь шинжийн хооронд харилцан үүрэг үүсгэх бөгөөд эдгээр шинжийг агуулсан байвал академик түвшинд даатгалын гэрээ бүхийг даатгал гэж ойлгож ирсэн.

Даатгалын тухай хууль батлагдахаас өмнө Арилжааны тухай хуульд ердийн даатгалын гэрээ, амьдралын даатгалын гэрээний тодорхойлолтыг заасан боловч даатгалын гэрээний тодорхойлолт байгаагүй юм. Мөн түүнчлэн Даатгалын тухай хуулиас ялгаатай нь даатгалын хураамж, даатгалын нөхөн төлбөрийн хоорондын хамаарлуудыг зохицуулсан заалт байгаагүй. Иймээс даатгалын уламжлалт тогтолцооны тухай хэлэлцүүлэгт үндэслэн даатгалын эрх зүйн онолын хувьд (4) болон (5)-д дурдсан шинжүүдийг даатгалын гэрээний эрх зүйн шинж хэмээн ойлгож болно.

Даатгалын тухай хууль батлагдахаас өмнөх ойлголтын нэгэн адил Даатгалын тухай хууль-ийн 2.1 дэх заалтын дагуу даатгалын гэрээ гэдгийг (4) Орлого, зарлагын тэнцвэрийн зарчим болон (5) Даатгалын эрсдэл хураамжийн тэнцвэрийн зарчимд суурьласан гэж үзэх нь өнөөгийн нийтлэг ойлголт юм (嘉村・, 2010, pp. 9-11).

Япон улсын Даатгалын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн “даатгал” болон 2.1 дэх хэсгийн “даатгалын гэрээ”-ний харилцан хамаарал нь Даатгалын эрх зүйн онолын хувьд Даатгалын тухай хууль-ийн 2.1 дэх заалтын дагуу даатгалын гэрээнд хамаарах боловч Даатгалын тухай хуулийн 1 дүгээр зүйлд заасан “даатгал” биш байх боломжтой юм (後藤・, 2016, pp. 53-54). Дээр дурдсанчлан Даатгалын тухай хууль-ийн 2.1 -т заасан даатгалын гэрээний ач холбогдлыг тодруулахын тулд Даатгалын тухай хуулийн 1 дүгээр зүйлд заасан

“даатгал” хоорондын харилцааг тодорхой болгох шаардлагатай.

Даатгалын шинжлэх ухаан, даатгалын эрх зүйн онолоор даатгалын механизмын хувьд орлого, зарлагын тэнцвэрийн зарчим болон даатгалын эрсдэл хураамжийн тэнцвэрийн зарчим байхыг шаардана гэдэгтэй санал нэгддэг (岡田豊基, 2010,2012, pp. 1-2, 16-17, 25-26, 38-39,). Даатгалын тухай хуулийн 1 дүгээр зүйлд даатгалын үндэс суурь нь орлого, зарлагын тэнцвэрийн зарчим болон даатгалын эрсдэл хураамжийн тэнцвэрийн зарчим гэж үзэж болно (吉澤, 2008,, pp. 27-53).

Даатгалын эрх зүйн онолоор Даатгалын тухай хууль-ийн 2.1 дэх хэсгийн даатгалын гэрээ нь даатгалын механизмтай байх гэсэн “бичигдээгүй урьдчилсан нөхцөл” (山下ほか〔洲崎〕, 2011, p. 3)-тэй гэж тайлбарладаг.

Монгол улсын даатгалын гэрээний эрх зүйн зохицуулалтын онцлогын хувьд Иргэний хуулийн §2.1-д Иргэний хууль тогтоомж нь Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ гэж тодорхойлжээ. Монгол улсад өнөөдрийн байдлаар 931 хууль хүчин төгөлдөр үйлчилж байна. Энэ дотроос даатгалын харилцааг зохицуулсан хууль тодорхой хэмжээг эзэлж байна. Тодруулбал, Даатгалын тухай хууль 2024.04.30 (2004-2017 онд 12 удаа нэмэлт, өөрчлөлт орсон). Даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлд сайн дурын ба албан журмын гэсэн хоёр төрлийн даатгал байхаар заасан. Сайн дурын даатгалын үед гэрээний чөлөөт байдлын зарчим илүү хангагдах бол албан журмын даатгалын нөхцөлийг хуулиар нарийвчлан тогтооно. Даатгалын гэрээ, давхар даатгалын гэрээний суурь зохицуулалт, мөн даатгалын мэргэжлийн оролцогчид буюу даатгалын салбар дахь худалдааны төлөөлөгч, зуучлагч, хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа буюу даатгалын салбар дахь худалдааны төлөөлөл, зуучлалын гэрээний онцлог зохицуулалт тус хуульд тусгагдсан. Даатгалын багц хуулийн хүрээнд Эрүүл мэндийн даатгал, Нийгмийн даатгал, Жолоочийн хариуцлагын даатгал, Малын индексжүүлсэн даатгал, Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгал, Үр тариалангийн даатгал болон даатгалын мэргэжлийн оролцогчдын тухай хуулиуд үйлчилж байна. Хувийн эрх зүйн салбарт хамаарах гэрээ нь Иргэний хуульд үндэслэгдэж зохицуулагдах бөгөөд энэ хэсэгт тэгш эрхийн зарчмын хүрээнд байгуулагдана.

Дүгнэлт, санал

Даатгалын гэрээ нь эрх зүйн харилцаанд чухал үүрэг гүйцэтгэж, хохирлыг арилгах зорилготой бөгөөд иргэний эрх зүйн зарчимд тулгуурлан зохицуулагддаг.

Япон улсын Даатгалын тухай хуулийн 2.1 дэх хэсэг нь даатгалын гэрээг тодорхойлсон бөгөөд энэ нь **харилцан туслах гэрээтэй төстэй агуулгатай гэрээ** ч байж болно.

Даатгалын гэрээний үндсэн шинжүүд нь гэрээний нэршил харгалзахгүй, нэг тал нь нөхөн төлбөр төлөх, нөгөө тал нь хураамж төлөх, хураамжийг эрсдэлийн дагуу төлөх зэргээр тодорхойлогддог.

Хуулийн энэ зохицуулалт нь даатгалын гэрээний агуулгыг нарийвчлан тодорхойлж, **орлого, зарлагын тэнцвэр** болон **даатгалын эрсдэл хураамжийн тэнцвэрийн зарчим**д суурилсан эрх зүйн онолыг ашигладаг байна.

Судалгааны үр дүнд Япон улсын даатгалын гэрээний эрх зүйн орчин нь харьцангуй боловсронгуй, мэргэжлийн эрх зүйгээр зохицуулагддаг бол Монгол улсын хувьд эрх зүйн зохицуулалт илүү ерөнхий сул зохицуулалттай байх тул боловсронгуй болгох шаардлагатай байна. Мөн хоёр улсын тухайд даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах, гэрээний ил тод байдлыг нэмэгдүүлэх шаардлагатай. Энэ нь даатгалын салбарын тогтвортой хөгжлийг дэмжих, гэрээний талуудын эрх, үүргийг илүү тэнцвэртэй болгоход чухал нөлөө үзүүлэх юм.

Даатгалын гэрээний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгохдоо дээрх тэнцвэрийн зарчмуудыг харгалзан үзэх, мөн даатгуулагч ба даатгагчийн эрх,

үүргийн тэнцвэрийг хангах чиглэлд анхаарах шаардлагатай.

Ашигласан материал

С.Нарангэрэл. (2001). *Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо.* Улаанбаатар : Адмон ХХК.

Хутыз, М. (1994). *Римское частное право: Курс лекций. –Былина.*

Bydlinski, P. (2017). *Grundzüge des Privatrechts: für Ausbildung und Praxis10.*

Schauer. (огноо байхгүй). *Versicherungsvertragsrecht.*

Markus, W. (2022). *Versicherungsvertragsrecht.* Österreich.

(Hrsg), F. i. (2014). *VersVG: Versicherungsvertragsgesetz § 1a Rz 2.*

Schauer. (1995). *Das österreichische Versicherungsvertragsrecht.*

хороо, С. з. (2014). *Монгол Улсын арилжааны даатгалын тогтолцоо үүсч хөгжсөн түүхэн замнал.* Улаанбаатар.

萩本編著,(1974) 前掲注 1),

鴻常夫 ,〔初出 1978 (2002）, 保険法の諸問題

大串淳子, (2008, 2011, 2013, 2015). *・解説保険法・現代保険法, ・商取引法.* 〔第 ⚓ 版補訂版〕 .

有斐閣, 村. 敏. (2009,2010). *法解説, 保険法, 一保険の意義と保険契約の類型, 他方との関係新しい保険法の理論と実務 2.*

鴻常夫, 有. 竹. (1974,1978,2002). *保険法の諸問題,手形法・保険法の理論.*

萩本編著・. (1996). *前掲注 1.*

山下＝永沢編著. (2013). *・前掲注.*

萩本編著. (2016). *・前掲注.*

山下友信. (2005). *保険法.*

嘉村・. (2010). *前掲注.*

吉澤卓哉牙経. (2010). *な保険ではない保険法上の犬保険契約玄 について牛保険学雑.*

岡田豊基. (2010,2012). *現代保険法.*

吉澤, 牛. (2008,). *前掲注 保険学のフロンティア*. 義塾大学出版会.

山下ほか〔洲崎〕. (2011). *前掲注 3).*

萩本修編著. (2008). *萩本編著・前掲注 1)頁。.*

萩本編著・. (2021). *前掲注 1.*

後藤・. (2016). *前掲注, 役員解任の訴えの本質.*

山下・. (2016). *前掲注, 基準日後株主による取得価格決定申立.*

山下. (2016). *米山・前掲注.*

萩本修編著. (2008). *保険法立案関係資料（別冊商事法務 321 号）⚓頁（商事法務, .* 萩本 修.

山下＝米山編. (2022). *前掲注 4).*

ИХ, ДЭЭД СУРГУУЛИУДЫН ХУУЛЬ САХИУЛАХ БОЛОВСРОЛ ОЛГОХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР: ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА, ЧИГ ХАНДЛАГА

Б.Энхболд
Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, доктор, дэд профессор
B.Enkhbold
Commissioner, The National Human Rights Commission of Mongolia, Doctor, associate Professor

*хариуцлагатай зохиогч: commissioner6@nhrcm.gov.mn

Хураангуй: Энэхүү судалгаа нь хууль сахиулах боловсрол олгож буй гадаадын зарим орны их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрт дүн шинжилгээ хийж, онцлог, ач холбогдлыг нээн илрүүлэх, Монгол Улсад хэрэгжүүлэх боломжийн талаар дүгнэлт, санал дэвшүүлэхэд чиглэгдсэн бөгөөд энэ хүрээнд 9 улсын 27 их, дээд сургуулийн хөтөлбөрт дүн шинжилгээ хийсэн. Судалгааны үр дүнд үндэслэн хууль сахиулах боловсролыг хөгжүүлэх, мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Гэмт хэрэг судлал”, “Цагдаа судлал”-ын бакалавр, магистр, докторын сургалтын хөтөлбөрийг иргэний их, дээд сургуулиудад хэрэгжүүлэх боломжтой бөгөөд олон талын ач холбогдолтой гэж дүгнээд, тодорхой санал дэвшүүлсэн болно.

Түлхүүр үг: Их дээд сургууль, Хууль сахиулах боловсрол, Гэмт хэрэг судлал, Цагдаа судлал, Сургалтын хөтөлбөр, хууль сахиулагч.

Keywords: University and college, Law Enforcement Education, Criminology, Police studies, Educational Program, Law Enforcement

1. Удиртгал

Хууль сахиулах салбарын үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх, олон нийтийн итгэлийг хүлээж ажиллахад хууль сахиулах боловсролын гүйцэтгэх үүрэг чухал юм. Манай улсад хууль сахиулах боловсролын талаар судалгаа шинжилгээний ажил тасралтгүй хийгдэж, үндэсний болон олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион, хэлэлцүүлэг зохион байгуулж, идэвхтэй оролцож байгаа нь эерэг өөрчлөлтүүдийг бий болгож байна.

Хууль сахиулах боловсролын судлагдсан байдлаас үзэхэд энэ чиглэлийн судалгааны ажил, боловсрол олгох онол, практикийн асуудлыг хөгжүүлэхэд төрийн мэдлийн хууль сахиулах чиглэлийн сургууль, тус салбарын эрдэмтэн, судлаачдын үзэл баримтлал, судалгааны бүтээлүүдэд тулгуурлан хийсэн дүгнэлт санал ихээхэн хувийг эзэлж байна. Харин хууль сахиулах боловсрол олгоход иргэний их дээд сургуулийн гүйцэтгэх үүрэг, хөтөлбөрийн онцлог, төгсөгчдийг хууль сахиулах салбарт бэлтгэх агуулга, мөн чанарын талаар харьцангуй бага судлагдсан нь дүгнэгдэж байна. Иймд хууль сахиулах боловсрол олгоход иргэний их дээд сургууль, эрдэмтэн судлаачдын гүйцэтгэх үүрэг, ач холбогдлын талаар судалгаа шинжилгээний ажлыг эрчимжүүлэх шаардлага тулгарч байгаа юм.

Энэхүү судалгааны ажлын зорилго хууль сахиулах боловсрол олгож буй гадаадын зарим их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрт дүн шинжилгээ хийж, төрийн мэдлийн хууль сахиулах сургуулиудаас ялгагдах онцлог, ач холбогдлыг нээн илрүүлж Монгол Улсад хэрэгжүүлэх боломжийн талаар дүгнэлт хийж, санал дэвшүүлэхэд чиглэгдсэн болно. дэвшүүлсэн зорилгын хүрээнд 1/Хууль сахиулах боловсролын агуулга, тогтолцоо, 2/Хууль сахиулах боловсролын түүхэн хөгжлийн тойм, 3/Монгол Улсад хууль сахиулах боловсрол олгох, хууль сахиулагчийг бэлтгэж буй өнөөгийн байдал, 4/Иргэний их, дээд сургуулийн хөтөлбөрийн онцлог, ач холбогдол, 5/Монгол Улсад иргэний их, дээд сургуулиудад “Гэмт хэрэг судлал”, “Цагдаа судлал” хөтөлбөрийг хэрэгжүүлэх боломж, хэрэгцээ гэсэн асуудлыг судалсан.

Судалгааны ажлын хүрээнд АНУ, БНСУ, ХБНГУ, Их Британи Улс БНФУ, Испани Улс, БНХАУ ОХУ зэрэг 9 улсын 27

This article is published under the Creative Commons BY-NC-SA License by 4.0, ©2025 University of Internal Affairs, Mongolia

их, дээд сургуульд (хавсралт) хэрэгжиж байгаа “Хууль сахиулах”-ын боловсрол олгох хөтөлбөр, эрдэмтэн, судлаачдын 30 гаруй бүтээл, Дотоод хэргийн их сургуулийн цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх болон шинжлэн магадлахуйн хөтөлбөр, холбогдох статистик, баримт материалд харьцуулалт хийх, дүн шинжилгээ хийх аргыг ашиглаж нэгдсэн дүгнэлт, санал гаргасан болно.

Энэ судалгаа нь зөвхөн иргэний их, дээд сургуульд хэрэгжүүлж байгаа хууль сахиулах боловсрол олгох хөтөлбөрийн агуулга, ач холбогдлыг нээн илрүүлэхэд чиглэгдсэн болно.

2. Хууль сахиулах боловсролын агуулга, тогтолцоо

Олон улсын төвшинд хууль сахиулахын боловсрол гэсэн ойлголт түгээмэл хэрэглэдэг бөгөөд англи хэлэнд “The law enforcement education” гэж орчуулагдаж байна. Судалгааны бүтээл, эрдэмтэн судлаачдын дүгнэлт, олон улсын хандлагаас үзэхэд хууль сахиулах боловсролыг өргөн болон явцуу утгаар тодорхойлох хандлага байна (Sapp, 1990). **Өргөн утгаар авч үзвэл**, иргэдэд хууль сахиулах боловсрол олгох, гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах, иргэдийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн шинжлэх ухааны мэдлэг бүтээх, хэрэглээнд нэвтрүүлэх, дадал, чадвар олгох цогц ойлголт. Харин **явцуу утгаар авч үзвэл**, хууль сахиулах салбар тухайлбал, цагдаагийн алба хаагч, мөрдөгч, шинжээч, хорих ял, шүүхийн шийдвэр гүйцэтгэх болон хууль сахиулах бусад салбарын алба хаагчдыг бэлтгэхэд чиглэсэн шинжлэх ухааны мэдлэг олгох, сургах үйл явцыг хэлнэ.

Хууль сахиулах боловсролын агуулга нь практик сургалт, онолын сургалт, тусгай мэдлэгийн сургалтаас бүрддэг бөгөөд эдгээр агуулгыг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн олгох сургалтын хөтөлбөрөөр тухайн боловсролыг олгодог байна (Edwards, 2019). Сургалтын хөтөлбөрт багтсан хичээлийн агуулгыг авч үзвэл, 1/ практик сургалт, 2/ онолын сургалт, 3/ тусгай мэдлэг олгох сургалтаас бүрддэг байна.

Хууль сахиулах боловсрол олгох институт, хөтөлбөрийг авч үзвэл, 1/ Цагдаагийн академи, коллежийн хөтөлбөр, 2/ хууль сахиулах сургуулийн хөтөлбөр, 3) иргэний их, дээд сургуулийн хөтөлбөр, 4) хууль сахиулах сургалтын төв, үргэлжилсэн болон мэргэжлийн сургалтын хөтөлбөрөөс бүрдэж байна (Garner, 1999).

Цагдаагийн академи, коллежийн хөтөлбөрт хууль сахиулагчийг бэлтгэхэд чиглэгдсэн практик болон тусгай мэдлэг олгох сургалт багтдаг бөгөөд ихэвчлэн эрчимжүүлсэн сургалтаар мэргэжлийн диплом, зарим тохиолдолд дээд боловсролын зэрэг олгодог байна. Судалгаанаас үзэхэд дэлхийн ихэнх улсад хууль сахиулагч бэлтгэх чиг үүрэг бүхий академи, коллеж үйл ажиллагаа явуулдаг байна (Carlan, 2009).

Хууль сахиулах сургуулийн хөтөлбөрт дээд боловсролтой хууль сахиулагч бэлтгэхэд чиглэгдсэн төрийн мэдлийн сургалтын институт багтдаг бөгөөд бакалавр, магистр, докторын зэрэг олгох хөтөлбөрийг хэрэгжүүлдэг байна. Тухайлбал, БНСУ-ын Үндэсний цагдаагийн их сургууль, БНФУ-ын Үндэсний цагдаагийн их сургууль гэх мэт.

Иргэний их, дээд сургуулийн хөтөлбөрт хууль сахиулахын боловсрол олгоход чиглэсэн хөтөлбөр хамаардаг бөгөөд харилцан адилгүй нэршилтэй байна. Интернэт орчинд хайлт хийж үзэхэд, “Гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцоо ба аюулгүй байдал”, “Гэмт хэрэг судлал” “Цагдаагийн удирдлага”, “Цагдаа судлал” “Хууль сахиулах удирдлага” гэх мэт 20 гаруй нэршил бүхий хөтөлбөр илэрч байх ба агуулгын хувьд бакалавр, магистр, докторын төвшинд сургалт явуулж байна (Paoline, 2007). Өөрөөр хэлбэл, дэлхийн улс орнуудад хууль сахиулах, цагдаагийн судлалын чиглэлээр боловсрол олгодог 100 гаруй иргэний их дээд сургууль үйл ажиллагаа явуулж, хууль сахиулах боловсролыг өргөн хүрээнд олгож байна. Үүнд, АНУ-ын Мичиганы их сургуулийн “Гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцоо ба хууль сахиулах ажил”, БНСУ-ын Кёнгги Их сургуулийн “Цагдаагийн удирдлага, нийтийн аюулгүй байдал”-ын хөтөлбөр, Их

Британийн Лестерийн их сургуулийн “Цагдаагийн удирдлага, менежмент”-ын хөтөлбөрийг дурдаж болохоор байна. /Цаашид “Гэмт хэрэг судлал”, “Цагдаа судлал”-ын хөтөлбөр гэх/ Хавсралтаас үзнэ үү.

Хууль сахиулах сургалтын төв, үргэлжилсэн болон мэргэжлийн сургалтын хөтөлбөрт хууль сахиулах салбарын офицер, ахлагч суралцдаг бөгөөд дараагийн шатны албан тушаалд шаардлагатай сургалтын багтдаг. Тухайлбал, мөрдөн шалгах арга зүй, удирдлагын манлайлал, шинэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чадвар гэх зэргийг дурдаж болно.

Дээрх агуулгаас үзэхэд хууль сахиулах боловсролыг төрийн мэдлийн хууль сахиулах чиглэлийн тусгай сургуулиуд олгохоос гадна иргэний их, дээд сургуулийн хөтөлбөрөөр олгож, хууль сахиулах салбарын онол, практикийг хөгжүүлэх, хүний нөөцийг бүрдүүлэхэд голлох үүрэг гүйцэтгэдэг байна.

3. Хууль сахиулах боловсролын түүхэн хөгжлийн тойм

Хууль сахиулах боловсролын агуулга нь нийгмийн өөрчлөлт, иргэдийн ухамсар, техник технологийн хөгжил, алба хаагчийн мэргэших шаардлагаас шалтгаалан түүхэн цаг хугацааны явцад хөгжиж ирсэн нь судлаачдын бүтээлээс харагдаж байна (А, 2021). Судалгааны дүгнэлтүүдэд үндэслэн дэлхийн улсуудад хууль сахиулах боловсрол хөгжиж ирсэн түүхэн хөгжлийг дараах үечлэлд хуваан үзэж болохоор байна.

I. Туршлагад суурилсан мэдлэгийн үе (1900 оноос өмнөх үе)

II. Хууль сахиулах боловсрол олгож эхэлсэн үе (1900-1945 он)

III. Хууль сахиулах боловсролыг мэргэжлийн түвшинд хөгжүүлсэн үе (1946-1970 он)

IV. Шаталсан боловсролын тогтолцоо, стандарт тогтоосон үе: (1971-1990 он)

V. Шилжилт, шинэ үеийн хууль сахиулахын боловсрол (1990 хойш)

Хууль сахиулах боловсролын түүхэн хөгжлөөс үзэхэд хууль сахиулах дээд боловсрол олгох сургалтыг 1) Ихэвчлэн иргэний их, дээд сургууль хэрэгжүүлдэг АНУ-ын загвар, 2) Иргэний их, дээд сургууль болон төрийн мэдлийн цэргийн зохион байгуулалт бүхий сургууль хэрэгжүүлдэг холимог хэлбэрийн Европ-Азийн загвар, 3) Төрийн мэдлийн цэргийн зохион байгуулалт бүхий сургууль хэрэгжүүлдэг ОХУ, БНХАУ-ын загвар гэсэн гурван тогтолцоо бүрдсэн бөгөөд загвар бүр өөрийн давуу болон сул талтай байна. Монгол Улсын хувьд хууль сахиулах боловсрол олгох тогтолцооны өнөөгийн байдал нь гурав дахь буюу сүүлийн загвартай илүү төстэй байна.

4. Монгол Улсад хууль сахиулах боловсрол олгох, хууль сахиулагчийг бэлтгэж буй өнөөгийн байдал

Монгол Улсын Дотоод хэргийн их сургуульд хууль зүй, дотоод хэрэг, онцгой байдлын салбарын мэргэжилтнийг бакалаврын түвшинд сургаж бэлтгэхээс гадна, магистр болон докторын зэрэг олгох сургалтыг зохион байгуулж байна. Тус сургууль нь 1934 онд БНМАУ-ын Ардын сайд нарын зөвлөлийн /хуучин нэрээр/ 8 дугаар тогтоолоор “Төв сургууль” нэртэйгээр байгуулагдаж 90 жилийн хугацаанд цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, онцгой байдал, хилийн цэрэг, дотоодын цэрэг болон хуульчдыг бэлтгэж ирсэн Монгол Улсын ууган сургуулийн нэг болох судалгааны бүтээлүүдээс дүгнэгдэж байна.

Дотоод хэргийн их сургуулийн Ахлагчийн сургуульд Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын захиалгаар цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ахлагч бүрэлдэхүүний тодорхой мэргэжлээр 2 сараас нэг жилийн хугацаанд бэлтгэж мэргэжлийн боловсрол олгож байна. Харин Цагдаагийн сургууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургууль, Шинжлэн магадлахуйн институт Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн А/343 дугаар тушаалын хавсралтад зааснаар дараах хөтөлбөрөөр бакалаврын боловсрол олгож байна. Үүнд:

Сургуулийн нэр	Хөтөлбөрийн нэр	Олгох зэрэг	Суралцах хугацаа	Мэргэжил
Цагдаагийн сургууль	- Цагдаа судлал - Мөрдөх алба - Кибер гэмт хэрэг судлал	Бакалавр	4 жил	Аюулгүй байдал хангах үйлчилгээ /Иргэний өмч хөрөнгө хамгаалах/
	- Эдийн засгийн мөрдөгч - Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил - Замын хөдөлгөөний аюулгүй байдал		2 жил	
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургууль	- Шүүхийн шийдвэр гүйцэтгэл - Нийгмийн ажил	Бакалавр	4 жил	
Шинжлэн магадлахуйн институт	- Шинжлэн магадлахуй	Бакалавр	4 жил	

Цагдаа, шүүхийн шийдвэр, шинжлэн магадлахуйн 4 жилийн хөтөлбөрт тусгай шалгуур хангасан 18 насанд хүрсэн, бүрэнд дунд боловсролтой иргэдийг сургаж байгаа бол цагдаагийн сургуулийн 2 жилийн хөтөлбөрт их, дээд сургууль төгссөн иргэдээс сонгон шалгаруулж суралцуулах бөгөөд Аюулгүй байдал хангах үйлчилгээ /Иргэний өмч хөрөнгө хамгаалах/ мэргэжлээр бакалаврын боловсролын зэрэг олгож байна. Мөн “Гэмт явдал судлал”, “Цагдаа судлал”, “Шинжлэн магадлахуй” магистр, докторын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж ахисан түвшний боловсрол олгодог байна. Түүнчлэн Удирдлагын сургуульд “Хууль сахиулах удирдлага”, “Цагдаагийн стратеги-тактик, удирдлага”, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн стратеги-тактик, удирдлага” мэргэжлүүдээр магистр, “Хууль сахиулах удирдлага” чиглэлээр докторын хөтөлбөрийг тус тус хэрэгжүүлж удирдах төвшний хүний нөөцийг бэлтгэж байна.

Дээрх хөтөлбөрүүд нь үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, иргэдийн аюулгүй байдлыг хангах мэргэжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний хөгжлийн суурь ур чадвар, цагдаагийн албаны чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах эрх зүй, эрүүл мэнд, бие бялдар, сэтгэл зүйн болон ёс зүй, харилцааны ур чадварыг онол болон практиктай хослуулан хэрэглэх чадварыг эзэмшдэг бөгөөд аль ч төвшиндөө “Эрх зүйч” мэргэжлийн боловсрол олгодоггүй байна.

Дотоод хэргийн их сургууль нь 3000 сонсогчийн хичээлийн төв байр болон 850 сонсогчийн байр, номын сан, спорт цогцолбор, сургалт-дадлагын төв зэрэг сургалтын орчныг бүрдүүлсэн бөгөөд цаашид “Оюутны хотхон” хэлбэрээр хөгжих нөхцөлийг бүрдүүлжээ.

Холбогдох хөтөлбөр мэргэжлийн чиглэлээр жилд дунжаар Цагдаагийн сургуулийг 300, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийг 60, Шинжлэн магадлахуйн институтийг 10, Ахлагчийн сургуулийг 600 орчим сонсогч төгсдөг бол магистр, докторын сургалтыг 60, нийт 1000 орчим хууль сахиулагч шаталсан боловсролын тогтолцоогоор бэлтгэн гаргадаг бол 90 жилийн хугацаанд Дотоод хэргийн их сургууль 50 гаруй мэргэжлээр 60.000 гаруй мэргэжилтэн бэлтгэсэн (Дотоод хэргийн их сургуулийн төгсөгчдийн мэдээлэл) хууль сахиулах салбарын сургалт, эрдэм шинжилгээний төв болон хөгжжээ. Төгсөгчдийн 98 орчим хувь нь цагдаа, шүүхийн шийдвэр, шүүхийн шинжилгээ зэрэг төрийн тусгай чиг үүргийн байгууллагад ажиллаж байгаа ч хууль сахиулах салбарын хүний нөөцийг бүрдүүлэхэд хүрэлцдэггүй болох нь судалгаанаас дүгнэж байгаа юм.

Иргэний их, дээд сургууль төгсөгчдөөс хууль сахиулах салбарт тухайлбал, цагдаа,

шүүхийн шийдвэр гүйцэтгэх, шүүхийн шинжилгээний байгууллагад сонгон шалгаруулж ажиллуулж ирсэн түүхэн уламжлал нь Монгол Улс дахь эрх зүйн боловсрол олгож эхэлсэн үеэс эхлэлтэй юм. Профессор С.Жанцан 1960 онд МУИС-ийн бүрэлдэхүүнд Хуулийн салбар байгуулагдан ажилласнаар хууль зүйн сургалт судалгааны ажил явуулах, цаашид хууль зүйн шинжлэх ухааны хөгжих оюуны уурхай болсон гэж дүгнэжээ (С.Жанцан, 2005). Энэ үеэс хуулийн салбарт Захиргааны эрх зүйн хүрээнд "Цагдаагийн байгууллагын захиргааны үйл ажиллагаа" (Ж.Долгорсүрэн, 2014), "Эрүүгийн эрх зүй", "Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй", "Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн эрх зүй" хичээлийг тусгай хөтөлбөрөөр зааж байсан бол криминологи хичээлийг хэдий үеэс зааж эхэлсэн талаар баримт байхгүй байна. Монгол Улсад 1974 онд БНМАУ-ын Прокурорын газрын дэргэд Гэмт явдлын шалтгаан нөхцөлийг судлах хүрээлэнг байгуулж, олон арван судалгаа хийж байсны дотор МУИС-ийн хуулийн салбарын эрдэмтэн судлаачид голлох хувийг эзэлж байснаас дүгнэхэд Криминологи хичээл ямар нэгэн төвшинд судлагдаж байсан байх боломжтой юм.

1992 оноос хувийн хэвшлийн их дээд сургууль байгуулахыг Үндсэн хуулиар зөвшөөрсөнтэй холбоотойгоор хууль зүйн их, дээд сургуулиуд байгуулагдаж эрх зүйч мэргэжил олгох сургалтын хөтөлбөрт "Криминологи", "Цагдаагийн эрх зүй", "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх", "Хоригдлыг нийгэмшүүлэх", "Гэмт хэргийн ул мөртэй ажиллах" зэрэг хичээлийг сонгох, эсхүл цөөн цаг цагаар судалж байснаас гадна "Эрүүгийн эрх зүй", "Эрүүгийн процессын эрх зүй" хичээлийг 3 багц цагаар заавал судлахаар тусгаж сургалт явуулдаг байсан нь хууль сахиулах салбарын хүний нөөцийг бүрдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байсан гэж үзэж болох юм.

МУИС болон бусад хувийн хэвшлийн их, дээд сургууль төгсөгчдөөс цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ажиллах сонирхолтой төгсөгчийг сонгон авч хүний нөөц бүрдүүлэх явдал өнөөг хүртэл түгээмэл байсаар байна. Тухайлбал, 2024 оны байдлаар цагдаагийн байгууллагын хүний нөөцийн 31.8 хувийг дотоод хэргийн их сургууль төгсөгчид, 68.2 хувийг иргэний их, дээд сургууль төгссөн хүмүүс бүрдүүлж байгаа бөгөөд үүнээс 48.9 хувь эрх зүйн боловсролтой байна. Харин Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн 20.8 хувийг дотоод хэргийн их сургуулийн төгсөг, 79.2 хувийг бусад их дээд сургуулийн төгсөгч эзэлж байгаа бол үүнээс 20.7 хувь нь эрх зүйч мэргэжилтэй алба хаагч эзэлж байна (Комисс, 2024).

Мөн хууль зүйн их дээд сургуулийн эрх зүйн чиглэлийн магистрын сургалтын хөтөлбөрт хууль сахиулах салбарын алба хаагчид элсэн суралцаж "Криминологи", "Цагдаагийн эрх зүй", "Эрүүгийн эрх зүйн", "Эрүүгийн процессын эрх зүй"-н чиглэлээр магистрын зэрэг хамгаалсан тохиолдол цөөнгүй байна. Тухайлбал, цагдаа судлалын чиглэлээр магистрын зэрэг хамгаалж буй судлаачдыг сургуулиар нь авч үзвэл, 49.1 хувь нь Дотоод хэргийн их сургуульд, 10.3 хувь нь Их засаг их сургууль, 10.3 хувь нь Билиг дээд сургууль, 7,6 хувь нь Монголын үндэсний их сургууль, 6.3 хувь нь МУИС-ийн Хууль Зүйн Сургуульд тус тус хамгаалагдсан байна (Гэмт явдалтай тэмцэх асуудал онол, 2017).

Монгол Улсад хууль сахиулах боловсрол олгоход чиглэсэн эрх зүйч мэргэжлээс ялгаа бүхий "Цагдаа судлал", "Гэмт хэрэг судлал" гэсэн бие даасан сургалтын хөтөлбөр өнөөг хүртэл иргэний их, дээд сургуулиудад нэвтэрч сургалт, эрдэм шинжилгээний эргэлтэд ороогүй, хууль сахиулах боловсролыг эрх зүйн боловсролоос ялган хөгжүүлэх бодлого бүрэлдээгүй, түүнийг агуулга мөн чанарыг үнэлэх, хүлээн зөвшөөрөх хандлага сул байсаар байна.

5. Иргэний их, дээд сургуулийн "Гэмт хэрэг", "Цагдаа судлал" хөтөлбөрийн онцлог, ач холбогдолд хийсэн дүн шинжилгээ

Хууль сахиулах боловсрол олгох чиглэлээр "Гэмт хэрэг судлал", "Цагдаа судлал"-ын хөтөлбөр хэрэгжүүлдэг гадаадын зарим их дээд сургууль (хавсралтаас үзнэ үү) болон

төрийн мэдлийн хууль сахиулах сургуулийн хөтөлбөрийн агуулгад харьцуулан дүн шинжилгээ хийхэд дараах нийтлэг болон ялгаатай тал илэрч байна. Хөтөлбөрийг төрийн болон хувийн хэвшлийн сургуульд хэрэгжүүлж байгаагаас үл хамаарч хууль сахиулах боловсрол олгох, нийтийн хэв журам сахиулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах болон олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай онолын мэдлэг, ур чадвар, ёс зүйн төлөвшил олгоход чиглэгддэг ба иргэдийн итгэлийг хүлээж, эерэг харилцаа тогтоох зорилгод аль аль нь чиглэгддэг байна (Sherman, 1978).

Харин сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх процесст дараах ялгаа байна. Үүнд:

- Хөтөлбөрийн судлах зорилго: Иргэний их, дээд сургуулийн хөтөлбөрийн зорилго нь хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаа, бодлогын дүн шинжилгээ, гэмт хэргийн шалтгаан нөхцөл судлал болон хууль сахиулах байгууллагын захиргаа гэх мэт гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцооны талаар боловсрол олгоход чиглэгддэг. Эдгээр хөтөлбөрөөр төгсөгчдөд олон салбарт хөрвөн ажиллах чадвар олгоход чиглэдэг бөгөөд зөвхөн цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага төдийгүй хуульч, бодлогын судлаач, шинжээч болон хувийн аюулгүй байдлыг хангах албанд ажиллах боломжийг олгодог байна. Харин төрийн мэдлийн цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх сургуулийн хөтөлбөрийн зорилго нь зөвхөн хууль сахиулах салбарт ажиллах практик ур чадвар, бие бялдар, сэтгэл зүйн болон цагдаагийн ажлыг хийхэд шаардагдах тактик, хууль сахиулах процессыг хэрэгжүүлэх тусгай мэдлэг, чадвар бүхий хүний нөөц, офицерыг бэлтгэхэд чиглэгдэж, сургалтын хөтөлбөрийг төрөөс хянаж, зөвшөөрөл олгодог байна.

- Сургалтын агуулга: Иргэний их, дээд сургуулиудын хөтөлбөр нь онолын мэдлэг олгоход чиглэгдсэн гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцооны онол, гэмт хэрэг судлал, социологи, сэтгэл судлал, нийтийн захиргаа, хууль, ёс зүй, олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагаа, цагдаад итгэх олон нийтийн хандлага, цагдаа, хорих байгууллагын харьцуулсан судлал, шинжлэн магадлахуй зэрэг хичээлийг онол, судалгааны арга зүйд тулгуурлан судалдаг бөгөөд шинэ төрлийн гэмт хэрэг, түүний шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх шинэ арга тактикийг нийгмийн үзэгдэлтэй холбон судалдаг байна. Тухайлбал, цахим гэмт хэрэг, форензик ярилцлага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны ёс зүй гэх мэт. Бие бялдрын чадвар олгох, галт зэвсгийн бүтэц, зүй тогтол болон тактикийн хичээлийг хууль сахиулах мэргэжлийн сургуультай харьцуулахад маш бага цагаар заадаг байна. Харин төрийн мэдлийн хууль сахиулах сургуулийн хөтөлбөр нь бие хамгаалах, үйл ажиллагааны тактик, галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх, цэргийн хэргийн мэдлэг олгох, удирдлагын шийдвэрийг гүйцэтгэх чадвар, зохиомол орчинд суурилсан дадлагын сургалт, тухайлбал, хэргийн газрын үзлэг, ул мөр бэхжүүлэх, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, жагсаал цуглаан, замын хөдөлгөөн зохицуулах, сэжигтэн, хохирогчтой ажиллах арга зүй, хууль зүйн мэдлэг, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны дараалал, олон нийттэй харилцах ур чадвар, хариу арга хэмжээний үеийн шийдвэр гаргалт гэсэн сургалт дийлэнх хувийг эзэлдэг байна.

- Хөтөлбөрт суралцах суралцагч, багш: Иргэний их, дээд сургуулийн хөтөлбөрт хууль сахиулах, улс төрч, бодлогын шинжээч болон судлаач, нийгмийн ажлын чиглэлээр ажиллах сонирхолтой иргэн, эсхүл дээд боловсролтой эзэмшсэн хэн ч элсэн суралцах боломжтой байдаг бол төрийн мэдлийн хууль сахиулах сургуульд ирээдүйд хууль сахиулах салбарын ажилтан болоход шаардагдах тусгай шалгууруар сонгогдсон суралцагч (сонсогч) болон карьераа дээшлүүлэх зорилгоор суралцаж байгаа албан тушаалтан суралцдаг онцлогтой. Багшлах бүрэлдэхүүний хувьд иргэний их дээд сургуулиудад “гэмт хэрэг судлал”, “цагдаа судлал”-ын чиглэлийн онолын эрдэмтэн, судлаачид ихэвчлэн багшлах, эрдэм

шинжилгээ судалгааны ажил хийдэг бол хууль сахиулах чиглэлтийн сургуульд практик туршлага бүхий багш, судлаачид ажилладаг байна.

- Сургалт явуулах арга зүй: Иргэний их, дээд сургуулиудад ихэвчлэн лекц, семинар, судалгааны төсөл, бүлгийн хэлэлцүүлэг, бичгийн даалгавар хэлбэртэй байдаг бол практик сургалтыг гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцооны байгууллага болох цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, хорих анги, албадан сургалтын төв, тэдгээрийн үйл ажиллагаатай танилцах, дадлага хийх хэлбэрээр явуулдаг байна. Харин төрийн мэдлийн хууль сахиулах сургуулиуд ихэвчлэн биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэх болон хууль хэрэглээний чадвар олгох сургалтыг бага бүлэг, зохиомол орчин бүрдүүлэх, тохиолдол шинжлэх байдлаар явуулдаг. Онолын мэдлэг олгох сургалтыг сургалтын нийтлэг арга болох лекц, семинар, бие даалт гэх мэт иргэний их, дээд сургуульд ашигладаг нийтлэг аргаар явуулдаг ч харьцангуй бага цагийг зарцуулдаг байна. Суралцах хугацаандаа гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцооны байгууллагуудад дадлага хийж, практик ажилд оролцох, дэмжлэг үзүүлэх байдлаар ур чадвар сэтгэл зүйн бэлтгэлийг эзэмшдэг байна. Сургалтын орчны хувьд цэргийн баазтай төстэй өндөр зохион байгуулалт, дэг журам мөрдөгддөг харуул хамгаалалт бүхий сургалтын орчин бүрдүүлсэн хотхон (кемп)-д зохион байгуулдаг бөгөөд суралцагчид ихэвчлэн байрлаж суралцдаг байна.

- Суралцах хугацаа: Иргэний их, дээд сургуулийн бакалаврын боловсрол олгох хөтөлбөр 2-4 жил, магистр, докторын сургалтын хөтөлбөр 2-3 жилийн хугацаагаар суралцдаг.Түүнчлэн тус хөтөлбөрт өдөр, орой, эчнээ хэлбэрээр суралцах боломжтой бөгөөд цахим сургалтын хэлбэрээр суралцах хувилбарын санал болгодог. Харин төрийн мэдлийн хууль сахиулах сургуулиуд ихэвчлэн сургалтын төвшин, олгох чадвараасаа хамаарч хэдэн сараас 2 жил хүртэл мэргэшүүлэх сургалт, бакалаврын боловсрол олгох сургалт 4 жил, магистр, докторын сургалтын хөтөлбөр 3-5 жилээр суралцах боломжтой. Хөтөлбөрүүд нь ихэвчлэн бүтэн цагаар өдрөөр суралцахыг шаардлага бөгөөд цахим болон сонголттой уян хатан байх боломж хязгаарлагдмал байдаг нь судалгаанаас харагдаж байна.

Хөдөлбөрийн нийтлэг болон ялгаатай байдлаас үзэхэд, иргэний их дээд сургуулиуд оюутнуудыг хууль сахиулах, аюулгүй байдал, судалгааны салбарт бэлтгэж, гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцооны талаар онол, арга зүйн гүнзгий мэдлэг олгоход чиглэдэг бол төрийн мэдлийн хууль сахиулах сургууль, академи нь практик ур чадвар, сахилга бат, хууль сахиулах үйл ажиллагааг алдаагүй хэрэгжүүлэх дадал, чадварт бэлтгэх сургалт явуулдаг онцлогтой болох нь дүгнэгдэж байна.

Харьцуулсан судалгаанаас үзэхэд иргэний их, дээд сургуульд “Гэмт хэрэг судлал”, “Цагдаа судлал”-ын хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь дор дурдсан ач холбогдлыг илэрхийлдэг байна (Sherman L. W., 2019) (Weisburd, 2015) (Lum, 2017). Үүнд:

- Судалгаа, дүн шинжилгээний ажил хөгждөг: Хууль сахиулах салбарын үйл ажиллагаа, цаашид хэрэгжүүлбэл зохих арга хэмжээний талаар шинжлэх ухааны үндэслэл бүхий дүгнэлт, санал гаргах чадавх нэмэгддэг. Тухайлбал, цагдаа, хорих байгууллагын үйл ажиллагааны өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийх, хэрэгжүүлсэн арга хэмжээг үнэлэх, хууль сахиулах салбарын шинэчлэлийн талаар олон ургалч үзэл гарч, тэдгээрийг тойрсон үндэслэл бүхий хэлэлцүүлэг өрнөдөг бөгөөд шинэчлэлийн бодлогод тусгалаа олдог.

- Хууль сахиулах салбарын талаарх мэдлэг нэмэгддэг: Хөтөлбөрт цагдаагийн байгууллагын шинэчлэл, алба хаагчийн ёс зүй, цагдаагийн харьцуулсан судлал, хууль сахиулах байгууллагын орчин үеийн асуудал, олон нийтэд түшиглэсэн хууль сахиулах үйл ажиллагаа, хууль сахиулах ажиллагаанд хүний эрхийг хангах зэрэг хичээлүүд багтдаг. Энэ нь олон нийт хууль сахиулах салбарын үйл ажиллагааг ойлгож, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг.

- Хууль сахиулах салбарт шинэ соёл нэвтрүүлэхэд нөлөөлдөг: Хууль сахиулах салбар, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад манлайлах, олон улсын туршлага, шинэ хандлагыг нэвтрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Удирдлагын арга барил, байгууллагын соёл, стратеги төлөвлөлтийн талаар мэдлэг олгох замаар суралцагчдад шинэчлэлийг ойлгуулах, удирдах чадвартай болгодог.

- Хамтын ажиллагааны боломжийг бүрдүүлдэг: Их дээд сургуулиуд хууль сахиулах салбар, цагдаа, хорих байгууллага болон төрийн байгууллагуудтай байнга хамтран ажиллаж, цаг үеийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, шинэчлэлийн стратеги боловсруулахад дэмжлэг үзүүлдэг. Энэхүү хамтын ажиллагаанд дадлага хийх, хамтарсан судалгааны төсөл хэрэгжүүлэх, бодлого судалгаа боловсруулах зэрэг ажил багтаж болно.

- Олон нийтэд түшиглэсэн үйл ажиллагаа явуулах боломжийг нэмэгдүүлдэг: Хөтөлбөрт цагдаа, олон нийтийн харилцаа, нийтийн дэг журам сахиулахад олон нийтийн гүйцэтгэх үүрэг, хууль сахиулах байгууллагын үйл ажиллагааг ойлгох, олон нийтийн дэмжлэг, түүний ач холбогдлыг нэмэгдүүлэх, олон нийтийн санаа бодлыг тандан судлахад тусалдаг.

- Бодлогын нөлөөлөл: Эдгээр хөтөлбөрийн төгсөгчид нь олон улс, бүс нутаг, үндэсний хэмжээний хууль сахиулах салбарын шинэчлэлийг хэрэгжүүлэх бодлого, хууль тогтоомжийг боловсруулах ажилд оролцох, шинэчлэлийн бодлогод нөлөө үзүүлэх, харилцан туршлага солилцох ажилд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Өөрчлөлтөд дасан зохицох чадвар эзэмшдэг: Их сургуулийн хөтөлбөрөөр боловсрол эзэмшсэн хууль сахиулах салбарын алба хаагчид хууль сахиулах үйл ажиллагаа болон нийгмийн хүлээлтэд нийцүүлэн гарсан өөрчлөлтөд дасан зохицоход илүү сайн бэлтгэгдсэн байдаг нь шинэчлэлийг хүлээн авах, өөрчлөлтөд илүү үр дүнтэй, хөрвөх чадвартай ажиллах боломжийг нэмэгдүүлдэг.

6. Монгол Улсад иргэний их, дээд сургуулиудад “Гэмт хэрэг судлал”, “Цагдаа судлал” хөтөлбөрийг хэрэгжүүлэх боломж, хэрэгцээ

Дээд боловсролын тухай хуульд “Цэрэг цагдаагийн мэргэжлийн чиглэлийн сургалтын үйл ажиллагааг Боловсролын ерөнхий хуулийн 3.1.18-д заасан төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллага эрхэлнэ” (Дээд боловсролын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэг, 2023), Боловсролын ерөнхий хуулийн дээрх заалтад “Цэрэг, цагдаагийн дээд боловсролын сургалтын байгууллага" гэж зэвсэгт хүчин, тагнуул, хил хамгаалах, цагдаа, онцгой байдлын мэргэжлийн чиглэлээр сургалт эрхэлдэг хуулийн этгээдийг” ойлгоно (Энэ зохицуулалтад хууль сахиулах салбарын бүрэлдэхүүн хэсэг болсон шүүхийн шийдвэр гүйцэтгэх, шүүхийн шинжилгээний байгууллагыг орхигдуулсан байгааг залруулах шаардлагатай.) гэж заасан.

Үүнтэй холбоотойгоор “гэмт хэрэг судлал”, “Цагдаа судлал” гэсэн хууль сахиулахын боловсрол олгоход чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлэх тусгай зөвшөөрлийг иргэний их, дээд сургуульд олгодоггүй байна. Харин Их засаг олон улсын их сургуульд “Хувийн аюулгүй байдал” гэсэн хөтөлбөр хэрэгжүүлж байгаа ба энэ хөтөлбөрийг шүүмжилж хязгаарлахаас илүү сургалтын агуулга, зорилгыг оновчтой болгох нь хууль сахиулах боловсролыг дэмжих ач холбогдолтой. Тухайлбал, сургалтын хөтөлбөрт аюулгүй байдал, хувийн аюулгүй байдлын онол, хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллах стратеги, гадаад орны туршлага, нийтийн хэв журам сахиулах ажилд дэмжлэг үзүүлэх, аюулгүй байдлыг хангах техник, технологийн шийдэл, тэдгээрийг ашиглах чадварт сургахад чиглэсэн хичээлийг суулгах ёстой. Эсрэгээрээ дүрэмт хувцас хэрэглэх, цэргийн зохион байгуулалт бүхий хэв шинжийг арилгаж, бие бялдар, тусгай хэрэгсэл хэрэглэх чадварыг бие даан сургахад анхаарах шаардлагатай.

Олон улсын чиг хандлагын дагуу хууль сахиулахын боловсрол гэсэн ойлголтыг өргөн хүрээнд тодорхойлж, тухайн салбарын шинжлэх ухааны мэдлэг,


чадавхыг хөгжүүлэх зорилгоор иргэний их, дээд сургуулиудад “Гэмт хэрэг судлал” “Цагдаа судлал” хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага байгааг дараах үндэслэлээр тайлбарлаж болохоор байна.

А) Хууль сахиулах мэргэжлээр суралцах сонирхол бүхий иргэдийн тоо нэмэгдэж байна.


Хууль сахиулагчийг бэлтгэх чиг үүрэг бүхий Дотоод хэргийн их сургуулийн элсэлтийн судалгаанаас үзэхэд хууль сахиулах, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх болон шүүхийн шинжилгээний байгууллагад ажиллах сонирхолтой хүмүүсийн тоо жилээс жилд нэмэгдэх хандлагатай байгаа ч тэдгээрийн 6-20 орчим хувь нь тус сургуульд элсэн суралцаж байна.

Элсэхээр хүсэлт гаргасан иргэдийн дунд эмэгтэйчүүдийн тоо маш өндөр үзүүлэлттэй байгааг нь сонирхолтой юм. Тухайлбал, Дотоод хэргийн их сургуулийн 2024 оны 08 дугаар сарын 22-ний өдрийн П-03/1222 дугаар албан бичигт дурдаснаар 2022 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн хөтөлбөрт элсэн суралцах хүсэл гаргагчдын 379 буюу 84 хувь, шинжлэн магадлахуйн хөтөлбөрт элсэн суралцах гаргагчдын 458 буюу 93.8 хувь, 2023 онд цагдаагийн хөтөлбөрт элсэхээр хүсэлт гарагчдын 817 буюу 45 хувийг тус тус эзэлж байсан бол энэ үзүүлэлт 2024 онд Цагдаагийн хөтөлбөрт 51.6, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн хөтөлбөрт 91.2, шинжлэн магадлахуйн хөтөлбөрт 69.1 хувийг тус тус эзэлж байна. Хүсэлт гаргасан эмэгтэйчүүдээс цагдаагийн хөтөлбөрт 4.7 хувь, шүүхийн шийдвэрийн хөтөлбөрт 5.2 хувь, шинжлэн магадлахуйн хөтөлбөрт 5.1 хувь нь элссэн суралцаж байна.


Цагдаагийн алба хаагч бэлтгэх хөтөлбөр



Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн алба хаагч бэлтгэх хөтөлбөр



Шинжлэн магадлахуйн хөтөлбөрт



Дээрх статистикаас үзэхэд, хууль сахиулах чиглэлээр суралцах сонирхолтой иргэдийн 80-90 орчим хувь нь хүссэн мэргэжлээр элсэн суралцаж чаддаггүй байна. Элсэж чадаагүй иргэд бусад их, дээд сургуулийн эрх зүй болон бусад хөтөлбөрөөр суралцдаг, эсхүл дараа жил дахин элсэх сонгон шалгаруулалтад оролцдог байна. Дотоод хэргийн их сургуульд элсэн суралцах сонирхол иргэдийн дунд нэмэгдэж байгаа нь хууль сахиулах салбарын ажилтан болох хүсэл эрмэлзэл, суралцах хугацааны төлбөрийг төрөөс бүхэлд нь хариуцдаг, төгссөний дараа ажлын байраар 100 хувь хангагддаг зэрэг хүчин зүйлтэй холбон тайлбарлаж болно.

Хүний эрхийн Үндэсний Комисст (2024) Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас ирүүлсэн хүний нөөцийн мэдээллээс харахад цагдаагийн байгууллагын хүний нөөцийн 68.2 хувийг иргэний их, дээд сургууль төгссөн, үүнээс 48.9 хувь эрх зүйн боловсролтой, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн 79.2 хувийг иргэний их дээд сургууль төгссөн, үүнээс 20.7 хувь нь эрх зүйн боловсролтой алба хаагч тус тус эзэлж байна. Цагдаагийн байгууллагын хэмжээнд 551 албан тушаал /ажлын байр/ батлагдан мөрдөж байгаагаас ажлын байрны тодорхойлолтод 438 буюу 79 хувьд нь эрх зүйч мэргэжилтэй байх шаардлага тавьсан хэдий ч Дотоод хэргийн их сургуулийн төгсөгчид “эрх зүйч” мэргэжил олгохгүй байх талаар гарсан Боловсрол шинжлэх ухааны сайдын тушаалтай нийцүүлэн Цагдаагийн ерөнхий газраас ажлын байрны тодорхойлолтдоо өөрчлөлт оруулж “аюулгүй байдал, цагдаа судлал” гэсэн мэргэжлийн чиглэлийг нэмж тусгаж байна (БСШУ-ны сайдын А/343 дугаар тушаал, 2022).

Цагдаагийн байгууллага олон жилийн турш гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий албан тушаалтныг эрх зүйч мэргэжилтэй байхаар шалгуур тавьж байгаа хандлагыг олон улсын жишигт нийцүүлэн өөрчлөх шаардлага зүй ёсоор тулгарч байна. Түүнчлэн Цагдаагийн албаны тухай хуульд ч энэ хандлага хадгалагдсан хэвээр байна. Тухайлбал, Цагдаагийн албаны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт “Цагдаагийн төв байгууллагын даргаар цагдаагийн албанд 20-оос доошгүй жил ажилласан, эрх зүйч мэргэжилтэй...”, мөн зүйлийн 20.4 дэх хэсэгт ”....тэргүүн дэд дарга, дэд даргаар цагдаагийн албанд 15-аас доошгүй жил ажилласан, эрх зүйч мэргэжилтэй...” байхаар заасан. Гэтэл Дотоод хэргийн их сургууль төгсөгчдөд “эрх зүйч” мэргэжил олгохгүй байх шийдвэр хэрэгжиж эхлээд бараг 10 жил болжээ (БСШУС-ын сайдын 178 дугаар тушаалын хавсралт, 2014).

Эрх зүйч болон бусад мэргэжлээр төгссөн иргэнд хууль сахиулах боловсрол, мэргэжлийн чиг баримжааг Дотоод хэргийн их сургуулийн офицер бэлтгэх,

давтан сургалт болон Цагдаагийн ерөнхий газрын Сургалтын төвөөр дамжуулан олгож байна. Учир нь эрх зүйч бэлтгэж байгаа хууль зүйн их, дээд сургуульд хууль сахиулах салбарт ажиллахад шаардлагатай мэдлэг олгох гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцоо, цагдаа, шүүхийн шийдвэр, шүүхийн шинжилгээний байгууллагын онцлог, хөгжлийн чиг хандлага, харьцуулсан судалгаа, цагдаа олон нийтийн хамтын ажиллагаа, гэмт хэргийн ул мөртэй ажиллах, гэмт хэргийн статистик, сэтгэл зүй, криминологи гэх мэт хичээл сургалтын хөтөлбөрт бараг тусдаггүй, эсхүл сонгон судлах байдлаар явагдаж байгаа юм.

Хууль сахиулах боловсрол нь эрх зүйн боловсролоос ялгаатай бөгөөд илүү практикт суурилсан хууль хэрэглээний чадвар суулгахад чиглэгдсэн байдаг онцлогтой. Тиймээс хууль сахиулагчдад хууль зүйн мэдлэгтэй байх, түүнийг хэрэгжүүлэх чадвар олгох сургалтыг хууль сахиулах боловсролын хөтөлбөрт заавал тусгахыг шаарддаг бөгөөд хуульч гэдэг агуулгаар тус сургалтыг явуулдаггүй байна. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Боловсрол шинжлэх ухааны сайдын тушаалаар эрх зүй, хууль сахиулах (аюулгүй байдал) боловсролын ялгааг нарийвчлан тодорхойлж мэргэжлийн чиглэлийг тогтоожээ. Үүнээс харахад БСШУС-ын сайдын 2014 оны 178 дугаар тушаалаар Дотоод хэргийн их сургуулийн хэрэгжүүлдэг хөтөлбөрүүдийг “хууль сахиулах ажил” гэж нэрлэж эхэлсэн бөгөөд үндсэндээ энэ үеэс эрх зүйч мэргэжил олгохыг зогсоосон байна. Өнөөгийн байдлаар Дотоод хэргийн их сургуулийн хууль сахиулах, аюулгүй байдлын чиглэлийн хөтөлбөрөөр төгсөгчдийг хуульчийн сонгон шалгаруулалтад оролцуулахгүй, цаашилбал, шүүгч, прокурор, өмгөөлөгч болон бусад хуульчаар ажиллах боломжийг хязгаарласан, Дотоод хэргийн их сургуулийг түшиглэсэн докторын зэрэг олгох чиглэлийг “Хууль сахиулахуй, дотоод хэрэг” гэсэн чиглэлээр олгож байгаа зэрэг нь эрх зүй болон хууль сахиулах боловсролын агуулга ялгаатай гэдгийг харуулсан бодлого юм.

Хууль сахиулах чиглэлээр гадаад, дотоодод боловсрол эзэмшсэн, эрдмийн зэрэг хамгаалсан мэргэшсэн судлаачид хууль зүйн их, дээд сургуульд багшлах явдал нэмэгдсэн нь энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүний нөөц бүрдэж байгааг харуулах юм. Өнөөдрийн байдлаар Монгол Улсын Их сургууль, Шихихутуг их сургууль, Улаанбаатар олон улсын их сургууль, Отгонтэнгэр их сургууль, Идэр их сургууль, Орхон их сургуульд энэ чиглэлийн мэргэшсэн эрдэмтэн судлаачид цөөнгүй ажиллаж байна.

Хууль сахиулах салбарт ажиллах сонирхол бүхий иргэдэд зориулсан “гэмт хэрэг судлал”, “Цагдаа судлал”-ын бакалавр, магистр, докторын сургалтын хөтөлбөрийг иргэний их, дээд сургуульд хэрэгжүүлэх замаар хууль сахиулах, аюулгүй байдал, эрдэм шинжилгээний салбарт ажиллах хүний нөөцийг бэлтгэх, зохих шалгуур хангасан иргэдийг тусгай албанд сонгон шалгаруулж авах эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай.

Б) Хууль сахиулах салбарын онолын мэдлэг, судалгааны чадавхыг нэмэгдүүлж, өрсөлдөх чадварыг сайжруулах:

Хууль сахиулах салбарын судалгаа эрдэмж шинжилгээний ажлыг шинжлэх ухааны арга зүйд тулгуурлан хөгжүүлэх, гэмт явдал, цагдаа судлалын онол, харьцуулсан судалгаа төдийлөн хөгжөөгүй нь хэд хэдэн судалгаагаар дүгнэгдсэн. Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгээс “Монгол Улс дахь цагдаа судлалын төлөв байдал” суурь судалгааны ажилд 1967-2015 оны хооронд Монгол Улсын хэмжээнд цагдаа судлалын чиглэлээр бичигдсэн 5 хэлбэрийн 609 судалгааны бүтээл тухайлбал, 1/ ном, сурах бичиг, 2/ эрдмийн зэрэг горилсон бүтээл (доктор), 3/ магистрын дипломын ажил, 4/ илтгэл, эрдэм шинжилгээний өгүүлэл, 5/ суурь болон хэрэглээний судалгааны ажлуудын агуулга, судалгааны арга зүйд дүн шинжилгээ хийсэн (Б.Энхболд, 2017). Судалгааны дүнгээр, байгууллагын эрх зүйн байдал, гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зэрэг гадагш чиглэсэн судалгааны ажил нийт

бүтээлийн 30 гаруй хувийг эзэлж байгаа бол цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны мөн чанарыг нээн илрүүлэх, гадаад орны сайн туршлагыг нэвтрүүлэхэд чиглэгдсэн цагдаагийн үйл ажиллагааны онол, харьцуулсан судлал, цагдаа олон нийтийн хамтын ажиллагаа, хүний нөөц зэрэг сэдвүүд харьцангуй бага судлагдсан гэж дүгнэжээ.

Цагдаа судлалын чиглэлээр хийгдсэн судалгааны ажлуудад нийгмийн шинжлэх ухааны салбарт түгээмэл хэрэглэгддэг баримт бичигт дүн шинжилгээ хийх, санал асуулга авах, хууль тогтоомжид дүгнэлт хийх, фокус бүлгийн ярилцлага хийх зэрэг аргуудыг түгээмэл хэрэглэж байгаа бол нийгмийн шинжлэх ухааны онолын хийсвэр ойлголт, нэр томьёонуудад хэмжилт хийх, үндэслэл бүхий дүгнэлт гаргахад ач холбогдол бүхий математик, статистикийн аргачлал, дүн шинжилгээ хийх аргыг ашиглахгүй байгаа нь судалгааны үр дүнг олон улсын хэмжээнд танилцуулах, шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргахад хүндрэл учруулж байна гэж дүгнэсэн. Тус хүрээлэнгээс хийсэн "Эрдэм шинжилгээний өгүүлэл бичихэд анхаарах асуудал" судалгааны дүгнэлтэд "Судлаачдын нийтлүүлсэн өгүүлэл нь онолын үндэслэл, судалгааны арга зүйд тулгуурлаагүй, зөвхөн юмс үзэгдлийг тодорхойлон тайлбарласан танин мэдэхүйн шинжтэй байна" гэж дүгнээд олон улсын түвшинд эрдэм шинжилгээний бүтээлд тавигдах жишиг шаардлага, судалгааны арга зүйг хөгжүүлэх шаардлага тулгарч байгааг сануулжээ (Б.Энхболд С. , 2018).

Дотоод хэргийн их сургуулийн зүгээс хууль сахиулах боловсролын асуудлыг өргөн хүрээнд дүгнэж, цаашид авах арга хэмжээний талаар тодорхой санал дүгнэлт дэвшүүлж байсан ба тодорхой үр дүн гарч байгаа ч цаашид эрчимжүүлэх шаардлага байна. Тухайлбал, 2005 оноос ДХИС-ийн бүрэлдэхүүнд Эрдэм шинжилгээний хүрээлэн байгуулж, "Цагдаа судлал", "Гэмт явдал судлал", "Шүүхийн шийдвэр судлал", "Шинжлэн магадлахуйн төв", "Хууль сахиулахуйн боловсрол судлал"-ын төв", Холбогдох профессорын судалгааны багийг байгуулж сургалт судалгааны ажил хийсний үр дүнд 2017 онд "Цагдаа судлал"-ын чиглэлээр олон улсын хянан магадалгаа бүхий сэтгүүлд эрдэм шинжилгээний анхны бүтээл нийтлэгдсэн (Enkhbold.B, 2017), Цагдаагийн алба хаагчийг бэлтгэх сургалтын тогтолцоо (Э.Дашгаадан, 2023), Цагдаагийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга зүй (Б.Хулан, 2023), Цагдаагийн байгууллагаас олон нийттэй харилцах асуудал (Б.Эрдэнэбилэг, 2023) зэрэг шинэ судалгааны чиглэлүүд ахиц гарч байна. Гэсэн хэдий ч "Хууль сахиулах", "Цагдаагийн судлал"-ын чиглэлийн судалгааны ажлын үр дүн олон улсад нийтлэгдэх тохиолдолд маш цөөн хэвээр байна. Харин бусад их дээд сургуулийн профессор, эрдэмтэн судлаачдын зүгээс энэ чиглэлийн судалгаа, шинжилгээний ажилд харьцангуй бага анхаарч байна.

"Цагдаа судлал", "Гэмт хэрэг судлал", "Гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцоо"-ны талаарх онол, арга зүйг хөгжүүлэх, шинжлэх ухааны мэтгэлцээнийг бий болгох, харилцан туршлага солилцоход энэхүү хөтөлбөрийг иргэний их, дээд сургуулиудад хэрэгжүүлэхийн ач холбогдол өндөр юм.

В) Хууль сахиулах салбарын шинэчлэл, хэлэлцүүлгийн явцад хөндлөнгийн үнэлгээ хийх хараат бус судлаачдын оролцоог хангах:

Хууль сахиулах салбар, ялангуяа цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын шинэчлэлийн асуудлыг сүүлийн 30 гаруй жил хэлэлцэж зохих өөрчлөлт гарч байгаа ч Улсын их хурлын сонгууль, Засгийн газрыг шинээр байгуулах, эсхүл олон нийтийн анхаарал татсан асуудал үүссэний дараа нийгэмд шинэчлэлийн талаар хүчтэй яригддаг ч онол, судалгааны үндэслэлтэй хариулт өгөх, дүгнэлт, санал гаргах хөндлөнгийн судлаач, шинжээчдийн оролцоо хангалтгүй байгаа юм. Тухайлбал, 2008 оноос цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, гэрч хохирогчийг хамгаалах тогтолцоо, хууль сахиулах салбарын хүний нөөцийг бэлтгэх асуудлын талаар хэлэлцэж байсан ч өнөөг хүртэл тогтолцооны шинжтэй томоохон судалгаа, дүгнэлтүүд ховорхон байна.

Нээлттэй нийгэм форум төрийн бус байгууллага, Монголын Эмнести интернэшнл олон улсын байгууллагын зүгээс цагдаа, хууль сахиулах салбарын үйл ажиллагааг хүний эрхэд нийцүүлэн боловсронгуй болгоход чиглэсэн судалгаа, дүн шинжилгээний ажлыг хөндлөнгийн судлаачдаар гүйцэтгүүлж ирсэн нь энэ салбарын үйл ажиллагаа, хууль тогтоомжийг боловсронгуй болгоход чухал үүрэг гүйцэтгэж ирснийг дурдах нь зүйтэй. Тухайлбал, цагдаагийн ажил дүгнэх үзүүлэлт, олон нийтийн цагдаагийн үйл ажиллагаа, ил тод байдал, цагдаагийн хэрэглэгчийн үнэлгээ, жагсаал цуглааны үеийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, цагдаагийн хууль тогтоомжийг үнэлэх, зан үйлд нөлөөлөх сургалт явуулах, хорих ял эдлүүлэх үйл ажиллагаа, нийгэмшүүлэх асуудал гэх зэрэг судалгааны ажлыг дурдаж болно (https://forum.mn/). Мөн төрийн бус байгууллагын зүгээс энэ чиглэлийн судалгаа, дүгнэлтүүдийг хийдэг боловч тэдгээр нь тогтвортой бус, санхүүжилтээс шалтгаалан үр дүндээ хүрэхгүй байх тохиолдол цөөнгүй байна. Дотоод хэргийн их сургуулийн судлаачдын дүгнэлт, саналыг практик үйл ажиллагааг сайжруулахад ашиглаж байгаа ч Засгийн газрын харьяа байгууллага гэсэн агуулгаар улс төрийн нөлөөлөлтэй, хөндлөнгийн бус гэж үзэх хандлага ч байгааг анхаарах нь зүйтэй.

Хууль сахиулах боловсролын тогтолцоог өргөжүүлж “Гэмт хэрэг судлал”, “Цагдаа судлал” хөтөлбөрийг иргэний их, дээд сургуульд хэрэгжүүлснээр шууд үр дүн гарахгүй ч ирээдүйд төгсөгчдөөс тус салбарын мэргэшсэн хараат бус хөндлөнгийн судлаач, шинжээчид төрөн гарах, хууль сахиулах салбарын шинэчлэл, бодлогод мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх боломжтой юм. Гадаад улсын туршлагаас үзэхэд хууль сахиулах салбарын шинэчлэл, инновацад хөндлөнгийн шинжээч, профессор, судлаачдын оролцоо ихээхэн нөлөө үзүүлдэг байна.

Г) Олон нийтэд түшиглэсэн хууль сахиулах үйл ажиллагаа хөгжүүлэх, олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх:

Олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагааны стратеги нь цагдаа болон олон нийт хамтарч гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд хамтран ажиллах, асуудал шийдвэрлэх зөөлөн чадварт суурилсан хандлага юм. Уг стратегийн зорилго нь гэмт хэргийг бууруулж, цагдаа олон нийтийн хамтын ажиллагааг сайжруулах, цагдаад итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэхэд чиглэдэг (C Gill, 2014). Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой нийт өргөдөл, гомдлын 22.6 хувийг цагдаагийн алба хаагчийн харьцааны соёл, ёс зүй зөрчсөн талаар байгаа бол монголчуудын цагдаад итгэх хандлага “дунд зэрэг” гэсэн дүгнэлт гарсан байна (Б.Энхболд, 2018). Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн алба хаагч бэлтгэх сургалтын хөтөлбөрт “Олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагаа”, “Цагдаагийн алба хаагчийн ёс зүй” гэсэн хичээлүүд туссан ч харьцангуй цөөн цагаар орж байна.

Олон нийтэд түшиглэсэн хууль сахиулах үйл ажиллагаа нь өргөн хүрээтэй ойлголт бөгөөд манай улсад зөвхөн “олон нийтийн цагдаа” гэсэн агуулгаар ойлгох нь түгээмэл байна. Олон нийтэд түшиглэсэн хууль сахиулах ажиллагааны хамгийн үр нөлөөтэй, хүчтэй механизм бол цагдаа, хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаа, мөн чанарын талаар аль болох олон хүнийг гүнзгий мэдлэгтэй болгож хамтран ажиллах сэдэл төрүүлэх явдал юм. Ингэснээр Үл ойлголцол, ташаа мэдээллээс үүдэлтэй зөрчлийг бууруулахад тусалдаг.

Судалгаанаас үзэхэд иргэний их, дээд сургуулийн “Гэмт хэрэг судлал”, “Цагдаа судлал” хөтөлбөрийн агуулгад “Цагдаа олон нийтийн хамтын ажиллагаа”, “Олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагаа”, “Цагдаад итгэх олон нийтийн хандлага”, “Хэвлэл мэдээлэлтэй харилцах”, “Асуудлыг зөөлөн аргаар шийдвэрлэх арга зүй”, “Харьцуулсан цагдаа судлал” гэх мэт хичээлийг үндсэн хичээл болгон судалж байна. Эдгээр сургалтаар олж авсан мэдлэг хандлага нь олон нийтэд түшиглэсэн

цагдаагийн үйл ажиллагааг хөгжүүлж, цагдаад итгэх олон нийтийн хандлагыг хөгжүүлдэг байна.

Дүгнэлт

1.Хууль сахиулах боловсролыг өргөн болон явцуу утгаар тодорхойлж хөгжүүлэх боломжтой. Өргөн утгаар авч үзвэл, гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах, иргэдийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн шинжлэх ухааны мэдлэг бүтээх, хэрэглээнд нэвтрүүлэх, дадал, чадвар олгох цогц ойлголт. Явцуу утгаар авч үзвэл, хууль сахиулах салбар тухайлбал, цагдаагийн алба хаагч, мөрдөгч, шинжээч, ял эдлүүлэх ажиллагааг хэрэгжүүлэгч болон гэмт хэрэгтэй тэмцэх бусад салбарын хаагчдыг бэлтгэхэд чиглэгдсэн шинжлэх ухааны мэдлэг олгох, сургах үйл явц гэж үзэх боломжтой.

2.Хууль сахиулах боловсролын түүхэн хөгжлөөс үзэхэд хууль сахиулах дээд боловсрол олгох сургалтыг 1) Ихэвчлэн иргэний их, дээд сургууль хэрэгжүүлдэг АНУ-ын загвар, 2) Иргэний их, дээд сургууль болон төрийн мэдлийн цэргийн зохион байгуулалт бүхий сургууль хэрэгжүүлдэг холимог хэлбэрийн Европ-Азийн загвар, 3) Төрийн мэдлийн цэргийн зохион байгуулалт бүхий сургууль хэрэгжүүлдэг ОХУ, БНХАУ-ын загвар гэсэн гурван тогтолцоо бүрдсэн бөгөөд загвар бүр өөрийн давуу болон сул талтай байна. Монгол Улсын хувьд хууль сахиулах боловсрол олгох тогтолцооны өнөөгийн байдал нь гурав дахь буюу сүүлийн загвартай илүү төстэй байна.

3.Монгол Улсын Дотоод хэргийн их сургууль нь цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, шүүхийн шинжилгээний байгууллагын алба хаагчдыг бакалавр, магистр, докторын зэрэгтэй бэлтгэх сургалтыг олон улсын жишигт нийцсэн хөтөлбөр, орчин үеийн сургалтын анги танхим, номын сан, спорт цогцолбор, сургалт-дадлагын орчинд хэрэгжүүлж байгаа Монгол Улсын ууган сургуулийн нэг болжээ. Тус сургуулийн цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх болон шинжлэн магадлахуйн хөтөлбөрт элсэн суралцах хүсэлт гаргагчдын тоо жилээс жилд нэмэгдэж байгаа ч зөвхөн 6-20 орчим хувь нь элсэн суралцдаг бол төгсөгчд 100 хувь ажлын байраар хангагддаг байна. Энэ нөхцөл байдалтай холбоотойгоор бусад их дээд сургууль төгсөгчдөөс цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн 65 орчим бүрдүүлж байна.

4.Хууль сахиулах боловсрол олгох хөтөлбөрийг төрийн мэдлийн хууль сахиулах сургууль олгохоос гадна иргэний их, дээд сургуулиудад хэрэгжүүлэх замаар онол, практикийн нэгдлийг хангах, хууль сахиулах салбарыг хөгжүүлэх, хүний нөөцийг бүрдүүлдэг орчин үеийн чиг хандлага зонхилж байна. Монгол Улсад хууль сахиулах боловсрол олгоход чиглэсэн эрх зүйч мэргэжлээс ялгаа бүхий “Цагдаа судлал”, “Гэмт хэрэг судлал” гэсэн бакалавр, магистр, докторын сургалтын хөтөлбөрийг иргэний их, дээд сургуульд хэрэгжүүлэх замаар хүний нөөцийг бүрдүүлэх, зохих шалгуур хангасан иргэдийг тусгай албанд сонгон шалгаруулж авах эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай.

5.Иргэний их, дээд сургуулиудад хэрэгжүүлж буй хөтөлбөрийн нийтлэг болон ялгаатай байдлаас үзэхэд, иргэний их дээд сургуулиуд оюутнуудыг хууль сахиулах, аюулгүй байдал, судалгааны салбарт бэлтгэж, гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцооны талаар онол, арга зүйн гүнзгий мэдлэг олгоход чиглэдэг бол төрийн мэдлийн хууль сахиулах сургууль, академи нь практик ур чадвар, сахилга бат, хууль сахиулах үйл ажиллагааг алдаагүй хэрэгжүүлэх дадал, чадварт бэлтгэх сургалт явуулдаг онцлогтой болох нь дүгнэгдэж байна.

6.Иргэний их, дээд сургуульд “Гэмт хэрэг судлал”, “Цагдаа судлал”-ын хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь хууль сахиулах салбарын судалгаа, дүн шинжилгээний ажлыг хөгжүүлэх, салбарын мэдлэг хандлага, манлайллыг нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх, олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагаа хэрэгжүүлэх, бодлогын нөлөөлөл үзүүлэх, өөрчлөлтөд дасан зохицох чадвар зэрэг ур чадварт бэлтгэдэг байна.

Санал

1.Дээд боловсролын тухай хуульд заасан “Цэрэг, цагдаагийн мэргэжлийн чиглэлийн сургалтын үйл ажиллагааг цэрэг, цагдаагийн дээд боловсролын сургалтын байгууллага" эрхэлнэ” гэсэн зохицуулалтыг хууль сахиулах боловсролын өргөн агуулгад нийцүүлэн өөрчлөх. Энэ агуулгад шүүхийн шийдвэр гүйцэтгэх, шүүхийн шинжилгээний байгууллагыг оруулж томьёолох.

2.Иргэний их, дээд сургуульд хууль сахиулахын боловсрол олгоход чиглэсэн “Гэмт хэрэг судлал”, “Цагдаа судлал”, “гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцоо ба хууль сахиулах ажил” гэх мэт хөтөлбөрөөр бакалавр, магистр, докторын сургалт явуулах боломжийг нээх;

3.Дээрх хөтөлбөрийг хэрэгжүүлэх зөвшөөрөл олгосон иргэний их, дээд сургуулиудад дүрэмт хувцас хэрэглэх, цэргийн зохион байгуулалт бүхий сургалт, бэлтгэл хийх, тусгай хэрэгсэл ашиглах гэх мэтээр цэрэг, хууль сахиулах чиглэлийн мэргэжлийн сургуулийн хэв шинжийг дурайх, өрсөлдөхийг хязгаарлах, зөвхөн бие даалт хэлбэрээр зохион явуулах зохицуулалт хийх.

4.Хууль сахиулах боловсролыг эрх зүйн боловсролын мэргэжлийн чиглэлээс ялгаж, бие даан хөгжүүлэх хандлагыг төлөвшүүлэх,

5.Дотоод хэргийн их сургуулийн хууль сахиулах боловсрол олгож байгаа цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэл, шинжлэн магадлахуйн хөтөлбөрөөр төгсөгчдийн мэргэжлийн ур чадварын төвшинд тогтмол үнэлгээ хийх аргачлалыг нэвтрүүлэх (галт зэвсэг, бие хамгаалах, хууль хэрэгжүүлэх, стандарт мөрдөх гэх мэт),

Ашигласан материалын жагсаалт

1.Andrew Maile. (2010). Research Fellow et al. “History, Police Education in England and Wales, and the Limited Role of Professional Ethics”.

2.David L. Carter and Allen D. Sapp. (1990). The evolution of higher education in law enforcement: Preliminary findings from a national study.

3.Bradley D. Edwards. (2019). Perceived Value of Higher Education among Police Officers: Comparing County and Municipal Officers. Journal of Criminal justice education. Volume 30: 606-620.

4.Garner, R. (1999). College-educated cops: Is the time now? Yes. In J. D. Sewell (Ed.), Controversial issues in policing. Boston, MA: Allyn and Bacon, 88-102.

5.Carlan, P. & Lewis, J. (2009). Professionalism in Policing: Assessing the Professionalization Movement. Professional Issues in Criminal Justice, 4, 39-57.

6.Paoline, E. A., III, & Terrill, W. (2007). Police education, experience, and the use of force. Criminal Justice and Behavior, 34: 179-196.

7.James E. Hawdon Donna A. (2021). Sedgwick in Policing: Do Increased Education Requirements Improve Police Performance and Procedural Justice? Virginia Polytechnic Institute and State University.

8.McCracken, Donal P. (1991). "The Irish in South Africa – The Police, A Case Study (Part 20)". Irish Times. Retrieved 8 August 2009.

9.Lyman, J. L (1964). "The Metropolitan Police Act of 1829: An Analysis of Certain Events Influencing the Passage and Character of the Metropolitan Police Act in England". Journal of Criminal Law, Criminology, and Police Science. 55 (1): 141–154 – via JSTOR.

10. Berman, Jay Stuart. (1987).Police administration and progressive reform: Theodore Roosevelt as police commissioner of New York .

11. Marion, N. (1998). Police academy training: Are we teaching recruits what they need to know? Policing: An International Journal of Police Strategies and Management, 21(1), 54-79.

12. Bowlby, Chris. (1986). "Blutmai 1929: Police, Parties and Proletarians in a Berlin Confrontation". The Historical Journal. 29 (1): 137–158.

13. Jacek Dworzecki. National Police Academy as a leading component of the police education system in France”.

14. Go, Julian. (2020). "The Imperial Origins of American Policing:

Militarization and Imperial Feedback in the Early 20th Century" American Journal of Sociology 125, (5).

15. Thomas Whetstone, George L.Kelling “English and American policing in the late 19th century”.

16. Oliver, W. (2006). The Fourth Era of Policing: Homeland Security. International Review of Law Computers & Technology. 20: 49-62.

17. Wlliam G. O’neill. (2005). “*Police reform in post-conflict societies: what we know and what we still need to know*”. International Peace Academy.

18. Sherman, L. W. (1978). The quality of police education. National Advisory Commission on Higher Education for Police Officers. San Francisco, CA: Jossey-Bass6

19. Lawrence W. Sherman. (2019). (University of Cambridge, UK). "Education in Evidence-Based Policing: The Global Challenge".

20. David Weisburd. (2015). (George Mason University, USA). "Reforming Police Education: Evidence-Based Policing as a Core Element"

21. Cynthia Lum. (2017). (University of Queensland, Australia), Evidence-Based Policing: Translating Research into Practice".

22. Enkhbold Batzeveg. (2017) “Confidence in the Police among Mongolian Immigrants in Korean and Native Mongolians in the home country: A Comparative Test of Conceptual Models” International Journal of Law, Crime and Justice”. №3 (50).

23. C Gill, D Weisburd, CW Telep, Z Vitter. (2014). Community-oriented policing to reduce crime, disorder and fear and increase satisfaction and legitimacy among citizens: A systematic review. Journal of Experimental Criminology. Volume 10. 399-428.

24. С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн салбарын /Эрүүгийн эрх зүй, Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй, Гэмт явдал судлал, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн эрх зүй/ шинжлэх ухааны хөгжил, ирээдүйн чиг хандлага. Эрдэм шинжилгээний өгүүлэл, Гэм явдалтай тэмцэх асуудал сэтгүүл.

25. Ж.Долгорсүрэн. Д.Булган. (2014). Монгол Улсын цагдаагийн эрх зүйн курс. 23 дахь тал.

26. Б.Энхболд, Б.Мөнхдорж, Д.Сумьяацэрэн, Б.Мөнхсэргэлэн. (2017). Монгол Улс дахь цагдаа судлалын төлөв байдал судалгааны тойм. Гэмт явдалтай тэмцэх асуудал” онол, арга зүй сэтгүүл. №2.

27. С.Гантулга, Б.Энхболд. (2018). “Эрдэм шинжилгээний өгүүлэл бичихэд анхаарах асуудал”, Уб., Гэмт явдалтай тэмцэх асуудал сэтгүүл. №3.

28. Б.Энхболд. (2018). “Цагдаагийн байгууллагын хэрэглэгчийн үнэлгээ-2017” судалгааны тайлан.

ИРГЭНИЙ ИХ, ДЭЭД СУРГУУЛИЙН ХӨТӨЛБӨР, ОНЦЛОГ (ХАВСРАЛТ №1)

№	Улс	Их, дээд сургуулийн нэр	Хөтөлбөрийн нэр	Хөтөлбөр хэрэгжүүлэх үндэслэл	Төгсөгчийн ажлын байр
1.	АНУ	Цинциннатигийн Их сургууль	Criminal Justice	- Хууль сахиулах салбараар суралцах эрэлт хэрэгцээ - Гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцооны талаар шинжлэх ухааны олон хандлагаар (хууль зүй, социологи, сэтгэл судлал, удирдахуй) цогц байдлаар тайлбарлах хэрэгцээ шаардлага тогтмол үүсдэг; - Хууль сахиулах салбарын мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх; - Хууль сахиулах салбарын талаарх олон нийтийн мэдлэг хандлагыг нэмэгдүүлэх, - Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг хууль сахиулах байгууллага олон нийтийн оролцоотойгоор амжилттай шийдвэрлэдэг	✓ Цагдаагийн алба хаагч, мөрдөн байцаагч ✓ Олон нийтийн аюулгүй байдлын ажилтан ✓ Онцгой байдлын алба хаагч ✓ Цагдаа, онцгой байдал, аюулгүй байдлын зөвлөх ✓ Эрүүгийн эрх зүй, цагдаа судлалын багш ✓ Шинжээч, судлаач ✓ Төрийн захиргааны алба хаагч ✓ Хувийн хамгаалалтын албаны ажилтан ✓ Тагнуулын байгууллагын алба хаагч ✓ Шүүх эмнэлгийн шинжилгээ, хэргийн газрын шинжээч ✓ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч ✓ Засан хүмүүжүүлэх төвийн ажилтан, сэтгэл зүйч
		Жон Жэй Эрүүгийн хууль зүйн коллеж	Criminal justice and police administration Science in Protection Management		
		Мичиган мужийн их сургууль	Criminal Justice Law Enforcement Intelligence and Analysis		
		Зүүн хойд их сургууль	Criminal Justice Leadership		
		Мэрилэндийн их сургууль, Коллеж Парк	Criminology and Criminal Justice		
		Флорида мужийн их сургууль	Criminology and Criminal Justice		
		Аризона мужийн их сургууль	Criminal Justice and Criminology and Arts in Criminal Justice		
2.	БНСУ	Донггук Их сургууль	Police Administration		
		Кёнги Их Сургууль	Police Administration and Public Safety		
		Ханнам Их сургууль	Police Administration		
3.	ХБНГУ	Төрийн удирдлагын хэрэглээний шинжлэх ухааны их сургууль	Arts in Public Administration with a focus on Police Management.		
		Дюссельдорф дахь Хэрэглээний Шинжлэх Ухааны Их Сургууль	Public Administration with a focus on Security Management.		
4.	Их Британи Улс	Портсмутын их сургууль	Police and Criminal Justice Studies		
		Лестерийн их сургууль	Police Leadership and Management		
5.	БНФУ	Парисын их сургууль 1 Пантеон-Сорбонн	Public Administration with a specialization in Security and		

			Crisis Management.		
		Лионы их сургууль 3 Жан Мулин	Public Law and Public Administration with a focus on Security and Law Enforcement. (k, aerg)		
6.	Испани Улс	Алсын боловсролын их сургууль	Criminal Law and Criminal Justice		
		Мадридын Комплютенсийн их сургууль	Security and Police Management		
7.	БНХАУ	Бээжингийн багшийн их сургууль	Law and Public Administration		
		Зүүн Хятадын Улс төр, хуулийн их сургууль	Criminal Justice		
		Нанжингийн Шинжлэх ухаан технологийн их сургууль	Law with specializations in criminal justice and police management.		
8.	ОХУ	Москвагийн Улсын Их Сургууль	Criminal justice and law enforcement		
		Оросын ардын аж ахуй, төрийн удирдлагын академи	Security and law enforcement		
		Санкт-Петербург улсын их сургууль	Criminal law and criminology		
9	Япон Улс	Токио хотын их сургууль	Criminology and public safety		
		Васэда Их сургууль	law and criminal justice studies		
		Осакагийн Их сургууль	Policing, criminal behavior, and justice systems.		

РОЛЬ ИНОСТРАННОЙ ТЕРМИНОЛОГИИ В ПРОЦЕССЕ РЕАЛИЗАЦИИ ПРОФИЛЬНО-ОРИЕНТИРОВАННОГО ОБУЧЕНИЯ ПО ЮРИДИЧЕСКИМ СПЕЦИАЛЬНОСТЯМ

THE ROLE OF FOREIGN TERMINOLOGY IN THE PROCESS OF IMPLEMENTING PROFILE-ORIENTED TRAINING IN LEGAL SPECIALTIES

Нестерова Валерия Евгеньевна
Доцент кафедры иностранных языков Уральского юридического института МВД России, кандидат филологических наук
Nesterova Valeria Evgen'evna
Associate professor of the Department of Foreign Languages of the Ural Law Institute of the Ministry of the Interior of the Russian Federation, Candidate of Philology

*Хариуцлагатай зохиогч: e-mail: karaelan@mail.ru

Аннотация. Английские юридические термины являются важнейшей составляющей английского языка права, в которой в отличие от других терминосистем выделяются огромное количество специальных областей применения. Целью статьи является рассмотрение вопроса о важности изучения английской юридической терминологии в процессе реализации профильно-ориентированного обучения иностранному языку, которое способствует подготовке компетентных специалистов, способных успешно работать в международной юридической среде. В результате исследования автор приходит к выводу, что работа с юридической терминологией позволит развить не только коммуникативные лингвистические компетенции обучающихся, но также общие и профессиональные компетенций в бытовых и профессиональных ситуациях общения, которые выражаются в умении построения монологической и диалогической речи, в умении вести аргументированную дискуссию, в понимании профессионально-ориентированного текста по различным аспектам права и юридической проблематике.

Abstract. English legal terms are the most important component of the English language of law which unlike other terminology systems distinguishes a huge number of special areas of application. The purpose of the article is to consider the importance of studying English legal terminology in the process of implementing profile-oriented foreign language training that contributes to the mastering of competent specialists who can successfully work in the international legal environment. As a result of the study the author comes to the conclusion that working with legal terminology will allow developing not only the communicative linguistic students' competencies but also general and professional competencies in everyday and professional communication situations which are expressed in the ability to construct monologue and dialogue speech, to conduct a reasoned discussion and to understand professionally oriented text on various law and legal issues.

Ключевые слова: юридическая терминология, язык права, профессиональная компетенция, профильно-ориентированное обучение, компетентностный подход.

Keywords: legal terminology, legal language, professional competence, profile-oriented training, competency-based approach.

Introduction

With the development of international relationship and rapid scientific and technological progress language proficiency in the field of jurisprudence is becoming widely used not only in a professional environment but also in other spheres of linguistic communication. In the context of globalization, the training of highly qualified specialists requires not only professional knowledge but also proficiency in foreign languages. This is particularly crucial for specialists working at an international level, where communication with partners and

This article is published under the Creative Commons BY-NC-SA License by 4.0, ©2025 University of Internal Affairs, Mongolia

clients from different countries is the routine. Knowing foreign languages allows for more effective information exchange, understanding cultural differences and establishing solid business relationships. So, in order to master a foreign language in professional situations of real communication it is necessary to implement in practical classes an integrated approach to mastering a foreign language consisting of communicative linguistic competencies, intercultural, general and professional competencies (Guzikova, 2024).

However, training legal translation is associated with certain difficulties caused by the peculiarities of international relations, the increase in the volume of legal regulation and the expansion of the terminological apparatus (Ивакина, 2008). Therefore, the higher education system has set a course for training specialists capable of translating legal texts in both written and oral forms thereby implementing a competency-based approach to teaching foreign languages. Besides, profile-oriented training in legal specialties requires students to have not only a deep understanding of national legislation but also the ability to work with international legal norms and standards. This determines ***the relevance*** of this article.

The English language occupies a key position in international legal relations as it is widely used in international contracts, treaties and covenants, court decisions, scientific publications and business correspondence. So, knowledge of English legal terminology is an integral part of the professional competence of specialists in such specialties and areas as "Jurisprudence", "Ensuring Law and Order", "Theoretical and Historical Law Sciences", "Public Law Sciences", "Criminal Law Sciences" and many others.

The ***subject*** of the study is English legal terms used in international legal practice.

The ***purpose*** of the article is to consider the importance of studying English legal terminology in the process of implementing profile-oriented foreign language training that contributes to the mastering of competent specialists who can successfully work in the international legal environment. To achieve this goal the author solves the following ***tasks***:

- to define the concepts of "term" and "legal term";
- to consider the advantages and disadvantages of using foreign borrowings in legal language;
- to analyze methodological approaches that allow students to apply legal terminology in practice in order to work with various types of professionally oriented texts.

The author analyzed and applied in English practical classes more than 30 methodological techniques for working with English legal terminology used in both domestic and foreign methodology. At the end of the academic year students were given a questionnaire to identify the most optimal approaches to facilitate effective mastery of legal terminology.

Results of the study and discussion

A term is a word or phrase in a special (scientific, technical, legal, etc.) language used to accurately express special concepts and designate special objects (Ахмонова, 2010). The term has such characteristics as 1) the absence of an expressive component of meaning and stylistic characteristics; 2) determinologization, i.e. loss of terminological status and transition to the lexical system of the literary language; 3) reterminologization, i.e. transition from one science to another one (Баранов, 2007).

A legal term is considered to be a word or phrase that has a precise and definite meaning and is used in the text of a regulatory document to indicate a legislator's will. The legal language is generally classified as socio-political language divided into language of law including legislation, rule-making and law enforcement practice, language of justice, i.e. the language of legal doctrine. Thus, legal language is a language for specific and professional purposes which is an independent functional variety of the national language since the language of any professional communication in addition to special terminology is characterized by such functions as definitional, the function of concentrating professional-special knowledge and the function of discovering new (Акимов, 2010).

Legal terms are a terse and concentrated form of expressing knowledge and are

designed to save the language of a legislative act since they're accessible and instructional for use in legal practice (Черекаев, 2004). Due to their junction all legal terms are generalized names of law concepts (Шамсаева, 2009). Professional legal terms enable specialists from different countries and law areas to cooperate avoiding misconstructions and fatal mistakes, for instance 1) misrepresentation of the statement's meaning, for illustration, replacing the term "breach of contract" with " breaking the agreement" can lead to a misreading of the legal counteraccusations of the action; 2) the Law misapprehension that can beget significant legal mistakes, including the indecorous application of laws in judicial practice; 3) misunderstanding the requirements of law representatives such as judges, lawyers, law enforcement officers, etc. that can lead to incorrect actions or conclusions. This is especially important in transnational cases where translation accuracy is pivotal.

One of the primary challenges that students encounter when learning legal terminology is the polysemy of terms meaning that a single legal term can have multiple meanings, concrete grammatical structure and belong to the only branch of Law. Proper application of these is or that multiple meanings frequently requires interpreting the term within its specific linguistic (the surrounding words and sentences) and extra linguistic environments (historical, cultural, and social contexts). All together these environments allow to comprehend the legal system as a whole, various precedents and specific legal doctrines, the background and circumstances relevant to the term.

Profile-oriented foreign language training in the sphere of legal relationship includes the following aspects: 1) integration of professional and language training; 2) practical orientation, i. e., classes should be organized taking into account real situations that lawyers encounter in their professional activities including reading and analyzing legal texts, drafting documentation and participating in various negotiations; 3) interdisciplinarity which means a combination of knowledge from various disciplines, for example, law, linguistics and intercultural communication (Дмитриева, 2024).

In order practicing and consolidating English legal terminology it is necessary to apply a variety of methodological approaches and use active and interactive tasks that will help students learn and apply the acquired knowledge in practice:

1. Contextual training including analysis of actually existing legal documents, regulations, court decisions, claims, precedents etc., demonstrating the use of generally accepted terms and existing styles of legal English (Нестеренко, 2025).

2. Role-playing, case-methods and modeling of real legal situations, for example, court hearings, surveys or negotiations which contribute to the formation and development of legal terms usage skills in practical conditions.

3. The use of specialized online resources, applications and technologies (legal dictionaries and databases) facilitates access to the corpus of legal texts and current terminology.

4. Making reports, abstracts, presentations and projects in English on topics with a legal bias.

5. Conducting discussions and debates in English on legal issues allowing students to develop their skills in argumentation and usage of terminology in oral speech.

After integrating these methods into the educational process 71 cadets studying at the Ural Law Institute of the Ministry of Internal Affairs of Russia were surveyed. Based on the results of the questionnaire completed by the student in order to determine the most effective and optimal methodological techniques, the results shown in the diagram were obtained (Picture 1). Thus, the questionnaire results indicate that students recognize the importance of learning specialized terminology that helps them improve their language skills which are an important aspect of their professional training. They consider the most effective method for studying legal vocabulary the use of specialized online resources (32% of respondents), then comes making various reports and projects in English (25% of respondents). 19 % of respondents consider conducting discussions and debates in English

on legal issues a very productive method. 13% of respondents identified contextual training as the most effective method for studying legal terminology. An unexpected result was that role-playing and case studies ranked last in the effectiveness list (11% of respondents).



Picture 1. Questionnaire results

Conclusions

Thus, educational institutions of higher education with law specialties should pay special attention to studying legal terminology which is a complex of legal terms and concepts divided into industry-specific, inter-industry and general legal terms. Proficiency in legal language is one of the types of professional interaction that involves the formation of competencies among students related to solving translation tasks.

Therefore, higher education institutions with legal specialization should pay special attention to the study of legal terminology, which is considered to be as a set of established legal terms and concepts used in law-making practice.

Legal terminology is one of the most significant terminology systems and represents a complex aspect in teaching a foreign language. So, mastering legal language is one of the forms of professional interaction ability helping students to develop skills in solving translation tasks. That is why it is recommended to apply the interdisciplinary approach to mastering legal terminology (e.g. in the framework of such disciplines as International Law, Civil Law, Criminal Law and others) that allows a deeper understanding of the subject and its specifics.

In the process of lawyers' profile-oriented training special attention should be paid to working with various types of legal documents taking into account the linguistic aspects of terms and concepts translation as well as extralinguistic and even technical issues, to know the legal norms and law systems of different countries and the traditions of business written language.

Литература

Акимов, Ю. В. Детерминологизация английской экономической терминологии (лингвокультурный и функциональный аспект): дисс. ... канд. филол. наук / Ю. В. Акимов. – Самара, 2010. – 194 с.

Ахманова, О. С. Словарь лингвистических терминов / О. С. Ахманова. – изд. 5-е. – Москва: Книжный дом «ЛИБРОКОМ», 2010. – 576 с.

Баранов, А. Н. Введение в прикладную лингвистику / А. Н. Баранов. – Москва: Изд-во ЛКИ, 2007. – 360 с.

Дмитриева, Е. И. Некоторые аспекты профильно-ориентированного обучения иностранному языку / Е. И. Дмитриева [Электронный ресурс]. – URL: https://conference.osu.ru/assets/files/conf_info/conf5/28.pdf (дата доступа: 13.02.2024)

Ивакина, Н. Н. Профессиональная речь юриста / Н. Н. Ивакина. – Москва: Издательский центр «Норма», 2008. – 447 с.

Нестеренко, В. Г. К вопросу о профильно-ориентированном обучении иностранным языкам / В. Г. Нестеренко // Концепт, 2014. – Спецвыпуск № 21. [Электронный ресурс]. – URL: http://e-koncept.ru/2014/14757.htm (дата доступа: 18.02.2025)

Черекаев, А. В. Юридическая терминология в Российском публичном праве: проблемы применения и совершенствования: дис. ... канд. филол. наук / А. В. Черекаев. – Москва, 2004. – 172 с.

Шамсеева, Г. Х. Особенности языка законодательства / Г. Х. Шамсеева // Языковое образование для специальных целей: новые тенденции, методы и содержание обучения: сборник статей 2-й международной научно-практической конференции; отв. ред. к.п.н. И. А. Беленько. 16-17 апреля 2009. – Челябинск: ГОУ ВПО ЧЮИ МВД России, 2009. – С. 187-191.

Guzikova, V. V. Project technology as a method of forming foreign language professional competence / V. V. Guzikiva // Хууль Сахиулахуй. – Улан-Батор, 2024. – № Special (39). – P. 51-58.

МЭРГЭШСЭН ХИЛЧИН ИНЖЕНЕР БЭЛТГЭХ СУРГАЛТЫН ТОГТОЛЦООГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗАРИМ АСУУДАЛ

SOME ISSUES IN FORMING THE TRAINING SYSTEM FOR TRAINING QUALIFIED BORDER ENGINEERS

Г.Ган-Эрдэнэ
Дотоод хэргийн их сургуулийн Хил судлалын докторант, хурандаа
G.Gan-Erdene
Colonel, Ph.D. candidate in Border Studies, University of Internal Affairs

*хариуцлагатай зохиогч: ganerdene@gmail.com

Хураангуй: Монгол улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлогын баримт бичигт “Улсын хилийн халдашгүй дархан байдалд, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй ажиллагааг шинжлэх ухаан, техник технологийн ололтод тулгуурлан цогц байдлаар зохион байгуулна (УИХ, Монгол улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого, 2020).” гэж заасан нь Монгол Улсын хил хамгаалалтын процесс нь хүн төвтэй техник, технологийн аргад шилжиж байгааг харуулж байна. Иймд Монгол Улсын харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн эрэлт, нийлүүлэлт, болон байгууллагын алба хаагчдын судалгаанд үндэслэн “Мэргэшсэн хилчин инженерийг бэлтгэх тогтолцоо”-г боловсронгуй болгох талаар, санал дэвшүүлсэн.

Abstract: The Mongolian government's border policy document states that "Within the inviolability of the state border, security operations in the border area will be organized in a comprehensive manner based on scientific and technological achievements." This indicates that Mongolia's border security process is shifting to a more human-centered, technical and technological approach. Therefore, based on a study of the supply and demand for human resources in Mongolia's telecommunications and information technology sectors, as well as the organization's employees, a proposal was made to improve the "Training System for Qualified Border Engineers".

Түлхүүр үг: Мэргэшсэн хилчин инженер
Keyword: Qualified border engineer

Оршил:

Монгол Улсын хилийг хамгаалах асуудал нь үндэсний аюулгүй байдал, улсын тусгаар тогтнолыг баталгаажуулахад чухал ач холбогдолтой. Хилчдийн үүрэг бол зөвхөн хилийн харуулын үүрэг гүйцэтгэх төдийгүй, улс орны аюулгүй байдал, үндэсний эрх ашгийг хамгаалах өргөн хүрээтэй үүрэг хариуцлага байдаг. Энэ ч үүднээс хил хамгаалах байгууллага мэргэшсэн, чадварлаг хилчдийг бэлтгэх бодлогод онцгой анхаарч ирсэн. Орчин үед хил хамгаалалт нь хүн төвтэй техник, технологийн аргад шилжиж байгаа бөгөөд “Мэргэшсэн хилчин” гэдэг ойлголтод “Техник технологийн талаарх мэдлэг, чадварыг эзэмшсэн байх” гэдэг шинэ шалгуур, шаардлага нэмэгдэж байна. Үүнээс шалтгаалан холбоо, мэдээллийн технологи, кибер аюулгүй байдал, нисгэгчгүй нисэх хэрэгсэл, дохиолол хяналт, радио электрон тэмцлийн чиглэлээр мэргэшсэн алба хаагчдын хэрэгцээ өсөн нэмэгдэж байгаа бөгөөд энэ чиглэлээр мэргэжилтнүүдийг бэлтгэх, тэднийг тогтмол сургаж, хөгжүүлэх шаардлага тулгарч байна.

Үндсэн хэсэг

"Хилчин" гэж хилийн цэрэгт алба хааж байгаа цэргийн жинхэнэ алба хаагчийг хэлнэ (Хилийн тухай хууль, 2016).

“”Мэргэших” гэж нэг төрлийн шинжлэх ухааны дотроос аль нэг салбарыг нь дагнан судалж эзэмших (Монгол хэлний их тайлбар, 2025).

Монгол улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлогын баримт бичигт “Улсын хилийн халдашгүй дархан байдалд,

This article is published under the Creative Commons
BY-NC-SA License by 4.0, ©2025 University of Internal Affairs, Mongolia

хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй ажиллагааг шинжлэх ухаан, техник технологийн ололтод тулгуурлан цогц байдлаар зохион байгуулна (УИХ, Монгол улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого, 2020).” гэж заасан нь технологийн хөгжлийн эрин үед хилчдэд хил хамгаалах арга тактик, мэдлэг боловсрол, мэргэжлийн ур чадварт улам өндөр түвшний шаардлагууд тавигдаж байгааг харуулж байна.

Орчин үеийн хил хамгаалах ажиллагаанд дрон, дохиолол хяналтын систем, мэдээллийн технологи төхөөрөмжүүд зэрэг шинэлэг дэвшилтэт технологиуд нэвтэрч байгаа тул хилчид эдгээр техник, технологийг эзэмших чадвартай байх шаардлага нэн тэргүүнд тавигдаж байна.Мөн нэгэнт Улсын хил хамгаалалтын үйл ажиллагаа нь хүн төвтэй техникийн аргад шилжиж байгаа учир энэ чиглэлийн боловсон хүчнийг хэрхэн бэлтгэх, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар авч үзэх нь зүйтэй.

Холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр мэргэшсэн хүний нөөцийн эрэлт

Цахим хөгжил харилцаа холбооны яамнаас 2024 онд “Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн эрэлт, нийлүүлэлт”-ийн судалгаа хийхэд энэ чиглэлээр нийт 39 их дээд сургууль, 24 МСҮТ, политехник коллеж мэргэжилтэн бэлтгэж байсан бөгөөд нийт төгсөгчид 100 хувь мэргэжлээрээ ажилд орно гэж тооцоолбол 2030 он хүртэл энэ чиглэлийн шинээр бий болох ажлын байрнуудын 30 орчим хувь нь мэргэжлийн хүний нөөцөөр хангагдаж чадахгүй гэж дүгнэлт гарсан байдаг. Энэ үзүүлэлт өнөөгийн байдлаар өсөлттэй байгаа нь тодорхой.

Технологийн дэвшил хурдацтай хөгжиж, холбоо, мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн эрэлт өндөр түвшинд хүрч байна. Монгол Улс ч мөн адил энэ хөгжилтэй хөл нийлүүлэн алхахын тулд дараах хүчин зүйлсийг авч үзэх шаардлагатай:

-цахим шилжилт: Улс орнуудын эдийн засгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд цахим технологийг бүх салбарт нэвтрүүлэх хэрэгцээ үүсэж байна. Үүний тулд программист, системийн инженерүүд, мэдээллийн технологийн чиглэлээр чадварлаг мэргэжилтний эрэлт нэмэгдэж байна.

-инновац: Их өгөгдөл, үүлэн технологи, хиймэл оюун, биет интернэт (IoT), зэрэг технологийн хэрэгцээ нэмэгдэж, эдгээр салбарт шинэ санал санаачилга, бизнесүүд төрөн гарч байна.

-мэдээллийн аюулгүй байдал: Кибер аюулгүй байдал нь орчин үеийн мэдээллийн технологийн хамгийн чухал чиглэл болсон тул энэ салбарт мэргэшсэн мэргэжилтнүүдийг бэлтгэх шаардлага үүсэж байна.

Ажлын байр	Сарын дундаж цалин (MNT)	Хамгийн бага цалин (MNT)	Хамгийн өндөр цалин (MNT)
Программист	2,000,000 - 3,500,000	1,500,000	5,000,000
Системийн администратор	2,500,000 - 4,000,000	2,000,000	5,500,000
Мэдээллийн технологийн инженер	1,800,000 - 3,000,000	1,200,000	4,500,000
Кибер аюулгүй байдлын мэргэжилтэн	3,500,000 - 6,000,000	3,000,000	8,000,000
Холбооны инженер	1,500,000 - 2,500,000	1,000,000	3,500,000
Мэдээллийн технологийн зөвлөх	4,000,000 - 7,000,000	3,500,000	9,000,000
Мэдээллийн аюулгүй байдлын менежер	5,000,000 - 8,000,000	4,000,000	10,000,000

Хүснэгт 1.Монгол Улсад холбоо, мэдээллийн технологи, кибер аюулгүй байдлын салбарын ажилчдын цалингийн жишиг, үнэлэмж

Мэргэшсэн хүний нөөц бэлтгэх бодлого

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлсан “Алсын хараа 2050” бодлогын баримт бичгийн “Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ (УИХ, “Алсын хараа 2050” бодлогын баримт бичиг, 2020)” зорилтын хүрээнд 2021- 2030 он хүртэл энэ салбарын хүний нөөцийг хөгжүүлэх талаар дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгажээ. Үүнд:

2.1.28. Мэдээллийн технологийн болон эдийн засгийн тэргүүлэх чиглэлээр хүний нөөцийг бэлтгэж, төр, хувийн хэвшлийн дэмжлэг, хамтын ажиллагааны үр нөлөөтэй зохицуулалт бүрдүүлж, стратегийн ач холбогдол бүхий чиглэлээр гадаадад суралцагчдыг төрөөс дэмжинэ,

2.6.8. Хөдөлмөрийн зах зээл дээр эрэлттэй, ирээдүйн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох мэргэжлийн чиглэлээр хүний нөөц бэлтгэх бодлого, “Хиймэл оюун ухаан ба ирээдүй” хөтөлбөр хэрэгжүүлнэ,

7.5.5.Цахим мэдээллийг ангилах, тодорхойлох, үнэлэх, төрийн мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтцийн эмзэг, сул байдлыг илрүүлэх, эрсдэлийн үнэлгээг тогтмол хийж байх талаар холбогдох хууль, дүрэм, журамд тусган онц чухал дэд бүтэц бүхий байгууллагуудад цахим халдлагатай тэмцэх баг бий болгож мэргэшсэн хүний нөөц бэлтгэж, хөгжүүлнэ зэргээр бодлогын баримт бичгүүдэд харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийг бэлтгэх, хөгжүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг тусгасан байна. Мөн Монгол Улсын Засгийн газар, боловсролын байгууллагууд, хувийн хэвшил хамтран холбоо, мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийг бэлтгэх, хөгжүүлэх бодлогод дараах чиглэлүүдээр анхаарч байна:

-сургалт, дадлагын тогтолцоо: Технологийн салбарын хөгжлийг даган боловсролын тогтолцоонд цахим, инновацын лабораториуд байгуулах, суралцагчдад бодит дадлага дээр суралцах боломж олгох, ур чадварын сертификат олгох систем нэвтрүүлэх нь хүний нөөцийг мэргэшүүлэхэд чухал үүрэгтэй.

-төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа: Хувийн хэвшил, төрийн байгууллагууд хамтран ажиллаж, мэдлэгийг практик дээр мэргэшүүлэх хөтөлбөрүүдийг зохион байгуулах нь тустай. Мөн олон улсын техник технологийн томоохон компаниудтай хамтран ажиллах нь ч хүний нөөцийг хөгжүүлэх чухал алхам болно.

-боловсролын шинэчлэл: Энэ чиглэлээр их, дээд сургууль болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдийн сургалтын хөтөлбөрийг олон улсын стандартад нийцүүлэн боловсронгуй болгох нь маш чухал болоод байна. Онолын мэдлэгээс гадна практик ур чадвар олгох сургалтуудыг түлхүү оруулах шаардлагатай.

Олон улсын туршлага

Дэлхий дахинд холбоо, мэдээллийн технологи, кибер аюулгүй байдлын чиглэлээр хүний нөөц бэлтгэх хэд хэдэн амжилттай туршлага байна (Цахим хөгжил, 2021). Жишээлбэл:

-Финлянд улсын туршлага: Финляндын нь суралцагчдын бүтээлч ур чадварыг хөгжүүлэхийн тулд дадлагажих болон бодит төсөл дээр ажиллуулах аргын хэрэглэдэг. Энэ боловсролын арга нь шинжлэх ухаан, технологийн гүнзгий мэдлэг олгохыг зорьдог.

-Израил улсын туршлага: Тэдний боловсролын тогтолцоо, шинэ санаачилгыг дэмжих бодлоготой уялдсан байдаг. Мэдээллийн технологийн стартап экосистемийг хөгжүүлж, гарааны бизнесийн орчинд мэргэшсэн мэргэжилтнүүдийг бэлтгэхэд анхаарч байна.

Хил хамгаалах байгууллагад энэ салбарын өнөөгийн нөхцөл байдал

Хил хамгаалах байгууллага нь холбоо, мэдээллийн технологи, кибер аюулгүй байдлын чиглэлээр цэргийн удирдлагын тогтолцооны хүрээнд

удирдамж, тушаал шийдвэрийн дагуу үйл ажиллагаа явуулдаг, стратегийн болон оператив түвшинд гадаад, дотоодод бэлтгэгдсэн ажлын тодорхой туршлага бүхий хүний нөөцтэй.

Сургалт бэлтгэлийг гадаад, дотоодын их сургуулиудад явуулахаас гадна өөрийн харьяаны Мэргэжлийн сургалтын төвийг түшиглэн зохион байгуулдаг.

	Бусад их, дээд сургуульд захиалгаар хүний нөөцөө бэлтгэх	Хилийн албаны сургуульд чиглэлийн тэнхим бий болгож мэргэжилтэн бэлтгэх	Чиглэлийн мэргэжлийн сургалтын төвтэй байснаар /Хилийн цэргийн 0151 дүгээр ангийн Мэргэжлийн сургалтын тасаг/
Давуу тал	Хүний нөөцийн илүүдэлд орохгүй	- Салбарын нарын мэргэжлийн чадваргаг эрдэмтэн, судлаачидтай болох; - Судалгаа шинжилгээний материаллаг бааз үүсэх; - Чадваргаг хүний нөөцийг ажлын байранд сонгон шалгаруулалтаар авах;	- Чиглэлийн алба хаагчдыг тасралтгүй мэргэшүүлэх, чадамжид суурилсан сургалтуудыг танимаар болон онлайнаар зохион байгуулах; - Мэргэшсэн багш, мэргэжилтэнтэй болох чиглэлийн судалгаа, шинжилгээний материаллаг бааз бүрдүүлэх
Сул тал	- Ажлын байрны шаардлага хангах алба хаагчдын эрэлт - Сургалтын төлбөр буюу санхүүжилтийн асуудал	Хүний нөөцийн илүүдэлд орох	Хүний нөөцийн илүүдэлд орох

Хүснэгт 2.Хил хамгаалах байгууллага холбоо, мэдээллийн технологи, кибер аюулгүй байдлын чиглэлээр хүний нөөц бэлтгэх, мэргэжүүлэх боломж

Холбоо, мэдээллийн технологи, кибер аюулгүй байдлын чиглэлээр ажил үйлчилгээ явуулдаг тасгуудад тулгарч буй хамгийн том бэрхшээл нь Хил хамгаалах байгууллагын алба хаагчдын мэдээллийн технологийн техник, хэрэгслийн ашиглалтын мэдлэг, чадвар дутмаг байгаагаас инженер, техникчдэд шаардлагагүй ажлын ачаалал ихээр үүсгэж, кибер аюулгүй байдлын заавар зөвлөмж өгсөөр байтал хэрэгжүүлж чадахгүй байгууллагын систем, сүлжээг эрсдэлд оруулдаг. Иймд ДХИС-ийн Хилийн албаны сургуульд мэргэжил эзэмшиж байгаа, мэргэших сургалтад хамрагдаж байгаа алба хаагчдад холбоо, мэдээллийн технологи, кибер аюулгүй байдлын сургалтыг зайлшгүй явуулж энэ чиглэлээр мэдлэг, чадвар эзэмшүүлэхгүй бол байгууллагын кибер аюулгүй байдал мөн хүний нөөцийн бодлогод сөргөөр нөлөөлөх хандлагатай байна.

Хил хамгаалах байгууллага холбоо, мэдээллийн технологи, кибер аюулгүй байдлын чиглэлээр хүний нөөц бэлтгэх, мэргэжүүлэх туршлага, сургамж

Хил хамгаалах байгууллага нь 1937 оноос өнөөг хүртэл өөрийн нөөц бололцоогоор Мэргэжлийн сургалтын төвийг түшиглэн холбооны бага мэргэжилтэн бэлтгэж ирсэн бөгөөд Энэ сургалтын төгсөгчид нь зөвхөн Хил хамгаалах байгууллагад ажиллаад зогсохгүй Зэвсэгт хүчин, Дотоодын цэрэг, Онцгой байдлын байгууллагуудын хүний нөөцийн шаардлага, шалгуурыг хангаж ажиллаж байгаа бөгөөд мэргэжлийн чадамж шаардсан тэмцээн уралдаануудад амжилт гарган оролцож байна. Мөн жил ирэх тусам энэ сургалтад суралцах хүсэлт гаргагчдын тоо өсөж байгаа нь бид энэ чиглэлийн сургалт явуулах туршлага, багшлах боловсон хүчин, бааз суурь бүрдүүлж чадсаныг харуулж байна.

Сургалт явуулах явцад зарим нэг сургамжууд гарч ирж байна. Үүнд:

-технологийн хөгжил хурдацтай байгаа тул сургалтын хөтөлбөрийг цаг үеийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэх, тогтмол шинэчилж байх;

-байгууллагын хэрэгцээнд тулгуурласан шинэ мэргэжлээр чадамжид суурилсан мэргэшүүлэх сургалтууд явуулах.

Мэргэшсэн хилчин инженер бэлтгэх тогтолцоог боловсронгуй болгох

Угаас хомсдож байгаа мэргэжилтнийг Хил хамгаалах байгууллага тэр дундаа хилд үүрэг гүйцэтгүүлэхээр ажилд авахад хүндрэл тулгарна. Иймд бид холбоо, мэдээллийн технологи, кибер аюулгүй байдлын чиглэлийн хүний нөөцийн бодлогоо ирээдүйд үүсэх эрсдэлтэй уялдуулж тохирох менежментийн дагуу төлөвлөх шаардлагатай байгаагаас гадна энэ төрлийн мэргэжилтнүүдийн хувьд технологийн хөгжлийн дагуу үргэлж шинэ зүйл сурч, хөгжих шаардлагатай бөгөөд харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбар нь тогтвортой өсөлттэй, карьерын өндөр боломжуудыг санал болгодог.

Мэргэшсэн хилчин инженерийг бэлтгэх тогтолцоо гэдэг нь Хил хамгаалалтын үйл ажиллагаанд шаардагдах мэдлэг, чадварыг эзэмшүүлэхийг зорьдог сургалтын цогц систем юм. Энэ тогтолцоо нь хилчин мэргэжлийн онцлог болон орчин үеийн технологи, инженерийн шаардлагад нийцсэн мэргэжилтнүүдийг бэлтгэхэд чиглэнэ.

Хил хамгаалах байгууллагын мэргэшсэн хилчин инженерийг бэлтгэх тогтолцоо:

1) Салбарын хүний нөөц бэлтгэж байгаа тэргүүлэх байгууллагуудад гэрээгээр мөн ДХИС-д инженерийн ерөнхий суурь мэдлэг, онол, практик ур чадвар эзэмшүүлж, мэргэжилтэн бэлтгэх;

2) Байгууллага өөрийн нөөц бололцоогоор хилчдийн ажлын онцлогт тулгуурлан мэргэшсэн хилчин инженерийг бэлтгэх чадамжид суурилсан сургалт зохион байгуулж, техникч, холбоочин, оператор, бэлтгэх;

3) Салбарын хүний нөөц бэлтгэж байгаа тэргүүлэх байгууллагуудад мөн ДХИС, Мэргэжлийн сургалтын төвд инженер, техникч, холбоочин, операторыг мэргэшүүлэх;

4) Олон улсын магадлан итгэмжлэлтэй, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сургуулиудад мэргэжил эзэмшүүлж, мэргэшүүлэх.

Хил хамгаалах байгууллагад дараах хэрэгцээ үүсэж байна. Үүнд:

- алба хаагчдын холбоо, мэдээллийн технологи, кибер аюулгүй байдлын техник хэрэгслийн ашиглалтын мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх;
- холбоо, мэдээллийн технологи, кибер аюулгүй байдлын чиглэлийн хүний нөөцийн дутагдлаас хамаарч өөр мэргэжлийн алба хаагчийг энэ салбарт хурдан, чанартай сургаж, ажиллуулах.

Иймд энэ хэрэгцээнд тулгуурлаж чадамжид суурилсан сургалтыг байгууллагын онцлогт тохируулж тогтмол зохион байгуулах шаардлагатай.



Мэргэшсэн хилчин инженерийг бэлтгэх чадамжид суурилсан сургалтын тогтолцоо нь суралцагчдыг тухайн мэргэжлийн тодорхой ур чадвар, мэдлэг, хандлагаар нь үнэлж, бодит амьдралд хэрэгжүүлэх боломжтой чадамжийг олгоход чиглэсэн сургалтын хэлбэр юм. Энэ тогтолцоо нь уламжлалт сургалтаас ялгаатайгаар ур дүнд суурилсан, суралцагчийн эзэмшсэн ур чадварыг тодорхойлох, тэднийг бодит амьдралд бэлэн болгоход анхаардаг. Харилцаа холбооны чиглэлээр чадамжид суурилсан сургалтын тогтолцоо нь орчин үеийн технологийн орчинд мэргэжилтнүүдийг бэлтгэхэд хамгийн тохиромжтой арга бөгөөд бодит ур чадварт суурилсан, үр дүнтэй, ажлын байранд бэлэн төгсөгчид бэлтгэдэг.

Мэргэшүүлэх сургалтын чанарыг үнэлэх үнэлэмжүүд нь сургалтын үр дүн, сургалтын хөтөлбөрийн бүтэц, багшийн чадвар, суралцагчдын оролцоо, дадлага, бодит амьдралд хэрхэн ашиглагдах зэргээс хамааран үнэлэгддэг.

Дүгнэлт, санал:

Угаасаа хомсдож байгаа мэргэжилтнийг Хил хамгаалах байгууллага тэр дундаа хилд үүрэг гүйцэтгүүлэхээр авахад хүндрэл тулгарна. Иймд бид холбоо, мэдээллийн технологи, кибер аюулгүй байдлын чиглэлийн хүний нөөцийн бодлогоо ирээдүйд үүсэх эрсдэлтэй уялдуулж тохирох менежментийн дагуу төлөвлөх шаардлагатай нь харагдаж байна. Байгууллагын алба хаагчдаас авсан судалгааг дүгнэн Хил хамгаалах байгууллага энэ салбарын хүний нөөцийг бэхжүүлэхэд дараах арга хэмжээг авах шаардлагатай гэж үзсэн. Үүнд:

1.Байгууллага өөрийн нөөц бололцоогоор чиглэлийн хүний нөөцийг бэлтгэж, мэргэшүүлж чадварлаг мэргэжилтнүүдийг сонгон шалгаруулж албандаа нэгтгэснээр ирээдүйн хөгжлийн түүчээ болно;

2.Мэргэжлийн сургалтын тасагт одоогоор зөвхөн радист ахлагч нарыг бэлтгэн, мэргэшүүлж байгаа бөгөөд цаашид хилд үүрэг гүйцэтгэж байгаа офицер болон ахлагч нарыг “Мэдээллийн технологи”, “Кибер аюулгүй байдал”, “Электроникийн засвар, үйлчилгээ”, “Дроны удирдлага, засвар”, “Радио релейн системийн ашиглалт, засварчин” мэргэжлүүдээр чадамжид суурилсан мэргэшүүлэх сургалтуудыг хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу зохион байгуулснаар хүний нөөцийг бэхжүүлэхэд чухал нөлөөтэй;

3.Одоогийн болон ирээдүйн ур чадварын хэрэгцээг тодорхойлох, ур чадварыг урьдчилан таамаглах системд хөрөнгө оруулалт хийж, ажиллах хүчний төлөвлөлтийг оновчтой тодорхойлох;

Ашигласан эх сурвалж, бүтээлийн жагсаалт:

тайлбар, М. х. (2025 оны 10 30). *Монгол хэлний их тайлбар*. Mongolitoli.mn-ээс Гаргасан

УИХ. (2016 оны 12 28). *Хилийн тухай хууль*. legalinfo.mn-ээс Гаргасан

УИХ. (2020). Монгол улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого: www.legalinfo.mn-ээс Гаргасан

УИХ. (2020 оны 05 13). *“Алсын хараа 2050” бодлогын баримт бичиг*. www.legalinfo.mn-ээс Гаргасан

УИХ. (2020). *Монгол улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого*. Засгийн газрын 2020 оны 20 дугаар тогтоол: www.legalinfo.mn-ээс Гаргасан

Цахим хөгжил, х. х. (2021). *Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн эрэлт, нийлүүлэлтийн судалгаа*. Улаанбаатар. google.mn: www.google.mn-ээс Гаргасан

Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Хилчний гудамж, Ш/х-210332

Утас: 976 7015-5061
И-мэйл: journal@uia.gov.mn
Вэб: www.uia.gov.mn

13301 Ulaanbaatar city, Bayanzurkh district-8,
Khilchin street, P/O-210332

Tel: 976 7015-5061
E-mail: journal@uia.gov.mn
Web: www.uia.gov.mn

ДХИС ХЭВЛЭЛ

e-ISSN 2958-051X

ISSN 2312-0797